



ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫН ЭМХЭТГЭЛ

Улаанбаатар хот
2021 он

Хянан тохиолдуулсан:

Санхүүгийн зохицуулах хорооны
Ажлын албаны дарга

Т.Жамбаажамц

Санхүүгийн зохицуулах хорооны
Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах референт

Ж.Мядагноров

Эмхэтгэсэн:

Санхүүгийн зохицуулах хорооны
Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн

Б.Ням-Очир

ГАРЧИГ

№	Улсын бүртгэлийн дугаар	Хэм хэмжээний актын нэр	Хуудасны дугаар
1	3944	“Сайн дурын даатгалын хэлбэр” (Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 207 дугаар тогтоол)	5
2	3946	“Ипотекийн даатгалын үйл ажиллагааны журам” (Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 210 дугаар тогтоол)	9
3	3947	“Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журам” (Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 211 дүгээр тогтоол)	17
4	3948	“Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын мэдүүлгийн маягт, гэрээний стандарт, загвар” (Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 212 дугаар тогтоол)	23
5	3949	“Жолоочийн даатгалын сангийн данс байршуулах, санхүүжилтийг төвлөрүүлэх, сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах журам” (Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 213 дугаар тогтоол)	32
6	3992	“Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээ байгуулж чадаагүй жолооч нарыг даатгагчид хуваарилах журам” (Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 271 дүгээр тогтоол)	36
7	4220	“Даатгалын багц дүрэм” (Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоол)	41
8	4188	“Жолоочийн даатгалын сангаас болон даатгагчаас хохирогчид олгосон нөхөн төлбөрийн мэдээллийг цагдаагийн байгууллагад ирүүлэх, түүнийг ашиглах журам” (Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 30/А/14 тоот хамтарсан тушаал)	334
9	4189	“Жолоочийн даатгалын баталгааны загвар, түүнийг хэрэглэх журам” (Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 29/А/13 тоот хамтарсан тушаал)	338
10	4555	“Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай” (Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 354 дүгээр тогтоол)	340

11	4673	“Малын индексжүүлсэн даатгалын хамтын эрсдэлийн сангийн хөрөнгө, түүнийг санхүүжүүлэх, зарцуулах журам” (Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2020 оны 5/11 тоот хамтарсан тушаал)	341
12	4674	“Малын индексжүүлсэн даатгалын хураамжийн хэмжээг тооцох журам” (Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2020 оны 6/10 тоот хамтарсан тушаал)	346
13	4737	“Даатгалын зах зээлийн ёс зүйн журам” (Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 114 дүгээр тогтоол)	349

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд
2018 оны 06 сарын 25-ны өдрийн 3944 дугаарт бүртгэв.



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2018 оны 6 сарын 06 өдөр

Дугаар 207

Улаанбаатар хот

“Сайн дурын даатгалын хэлбэр”-ийг батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сайн дурын даатгалын хэлбэр”-ийг хавсралтаар баталсугай.
2. Энэ тогтоол хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрөөс эхлэн Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 356 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА

С.ДАВААСҮРЭН

*Санхүүгийн зохицуулах хорооны
 2018 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн
 207 дугаар тогтоолын хавсралт*

Сайн дурын даатгалын хэлбэр

Даатгалын ангилал	Даатгалын хэлбэр	Даатгалын хэлбэрийн тайлбар
I.Ердийн даатгал	1.1.Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	Аливаа гэнэтийн осол, гэмтлийн улмаас хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учрахад даатгагчаас даатгуулагч эсхүл даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал. Үүнд хөдөлмөрийн чадвар алдахтай холбоотой эмнэлэг, эмчилгээ, мэс заслын зэрэг зардлын даатгал хамаарна.
	1.2.Хөрөнгийн даатгал	Гал, ус, байгалийн болон бусад гэнэтийн аюул, ослын улмаас энэ жагсаалтын 1.3-1.8-д зааснаас бусад хөрөнгөнд хохирол учрахад даатгагчаас даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал. Бэлэн мөнгөний болон зээлийн барьцаа хөрөнгийн даатгал энэ хэлбэрт хамаарна. Аливаа хариуцлагын даатгал хамаарахгүй.
	1.3.Авто тээврийн хэрэгслийн даатгал	Авто тээврийн хэрэгслийг эзэмших, ашиглах үед тухайн тээврийн хэрэгсэлд хохирол учрахад даатгагчаас даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал. Тээж яваа ачаа болон аливаа хариуцлагын даатгал хамаарахгүй.
	1.4.Ачааны даатгал	Аливаа тээврийн хэрэгслээр тээвэрлэж буй ачаанд гэмтэл, хохирол учрахад даатгагчаас даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал. Аливаа хариуцлагын даатгал хамаарахгүй.
	1.5.Барилга угсралтын даатгал	Барилга угсралтын явцад гэнэтийн аюул ослын улмаас угсралт, цутгалт, өрлөгийн ажилд хохирол гарахад даатгагчаас даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал. Угсралтын ажилд ашиглагдах машин, тоног төхөөрөмж, түр сууцыг даатгуулж болох ба төсөвт өртөг дээр үнэлгээг нэмэгдүүлж даатгана. Аливаа хариуцлагын даатгал хамаарахгүй.
	1.6.Газар тариалангийн даатгал	Гал, түймэр, үерийн ус зэрэг байгалийн болон бусад эрсдэлийн улмаас газар тариалангийн даатгалын тохиолдол учрахад даатгагч даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал. Аливаа хариуцлагын даатгал хамаарахгүй.
	1.7.Мал амьтдын даатгал	Аливаа осол, эрсдэлээр мал амьтан хорогдсоны улмаас даатгагч даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал. Аливаа хариуцлагын даатгал хамаарахгүй.
	1.8.Агаарын хөлгийн даатгал	Аливаа ослын улмаас агаарын хөлгийн их биед хохирол учрахад даатгагч даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал. Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал болон бусад хариуцлагын даатгал, агаарын хөлөгт ачсан ачааны даатгал энэ хэлбэрт хамаарахгүй.

1.9.Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	Авто тээврийн хэрэгслийг эзэмших, ашиглахтай холбоотой аливаа осол, гэмтлийн улмаас бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан нөхцөлд даатгагч даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал.
1.10.Хариуцлагын даатгал	Аливаа этгээдийн санамсар болгоомжгүй буруутай үйлдлийн улмаас бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учрахад даатгагч даатгалын гэрээнд заасны дагуу эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий энэ жагсаалтын 1.9, 1.15, 1.16-д зааснаас бусад хариуцлагын даатгал. Барилга угсралтын хариуцлагын даатгал үүнд хамаарна.
1.11.Санхүүгийн даатгал	Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой хохирол учрахад даатгагч даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал. Бизнес тасалдлын даатгал үүнд хамаарна.
1.12. Зээлийн даатгал	Ипотекийн даатгалаас бусад зээлдэгчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учрахад даатгагч даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал. Үүнд өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдагдахтай холбоотой эмнэлэг, эмчилгээ, мэс заслын зэрэг зардлаас бусад буюу зөвхөн зээл төлөх нөхцөл хамаарна. Зээлдэгч төлбөрийн чадваргүй болох эрсдэлийн даатгал, худалдааны зээл, хэрэглээний зээл, автомашины зээл, бизнесийн зээл, цалингийн зээл, зэрэг зээлийн даатгал энэ хэлбэрт хамаарна. Зээлийн барьцаа хөрөнгийн даатгал үүнд хамаарахгүй.
1.13.Итгэлцлийн даатгал	Аливаа гэрээ, хэлцлээр хүлээсэн үүрэг зөрчигдсөнтэй холбоотой үүсэх алдагдал, зардлыг даатгагч даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал. Гүйцэтгэлийн баталгааны даатгал / performance insurance/, чин шударгын баталгааны /fidelity guarantee insurance/ даатгал үүнд хамаарна.
1.14. Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал	Төмөр замын ба усан замын тээврийн хэрэгслийг эзэмших, ашиглах үед тухайн тээврийн хэрэгсэлд хохирол учрахад даатгагч даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал. Тээж яваа ачаа болон аливаа хариуцлагын даатгал хамаарахгүй.
1.15. Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг эзэмших, ашиглахтай холбоотой аливаа осол, гэмтлийн улмаас бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан нөхцөлд даатгагч даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал.
1.16. Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	Агаарын тээврийн хэрэгслийг эзэмших, ашиглахтай холбоотой аливаа осол, гэмтлийн улмаас бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан нөхцөлд даатгагч даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал.

2. Урт хугацааны даатгал	2.1.Хугацаат амьдралын даатгал	Даатгуулагч зөвхөн даатгалтай хугацаанд нас барсан тохиолдолд даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд даатгагч мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал.
	2.2.Насан туршийн даатгал	Даатгуулагч зөвхөн нас барсан тохиолдолд даатгалын гэрээнд заасан эрх бүхий этгээдэд даатгагч мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал.
	2.3.Хуримтлалын даатгал	Даатгуулагч гэрээт хугацааны эцэст амьд байх болон тухайн хугацаанаас өмнө нас барах гэсэн нөхцөлүүдээр даатгуулагч, эсвэл гэрээнд заасан эрх бүхий этгээдэд даатгагч баталгаатай мөнгөн төлбөр төлөх хугацаат даатгал болон хөрөнгө оруулалтын хавсарсан даатгал. Гэрлэлтийн, сургалтын зардлын, орон сууцны хуримтлалын даатгал үүнд хамаарна.
	2.4.Тэтгэврийн даатгал	Даатгалын гэрээгээр тохиролцсон хугацаанд даатгуулагчид тэтгэвэр буюу мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал.
	2.5.Эрүүл мэндийн даатгал	Эрүүл мэндийн холбогдолтой зардлыг даатгалын гэрээгээр даатгуулагчид төлөх нөхцөл бүхий даатгал. Үүнд хөдөлмөрийн чадвар алдалтын даатгал хамаарна.
	2.6.Аннуити даатгал	Даатгагч гэрээгээр тохиролцсон хугацаанд даатгуулагчид үечилсэн байдлаар тогтмол мөнгөн төлбөр төлөх нөхцөл бүхий даатгал.

Тайлбар: Даатгалын хэлбэр нь даатгалын бүтээгдэхүүнээс бүрдэх бөгөөд Даатгалын бүтээгдэхүүн гэдэгт даатгагчаас хэрэглэгчдэд санал болгож, худалдан борлуулж байгаа даатгалын үйлчилгээг ойлгоно. Жишээлбэл: Хүүхдийн гэнэтийн ослын даатгал нь гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгалын хэлбэрт хамаарах даатгалын бүтээгдэхүүн юм.

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд
2018 оны 06 сарын 25-ны өдрийн 3946 дугаарт бүртгэв.



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2018 оны 6 сарын 06 өдөр

Дугаар 210

Улаанбаатар хот

“Ипотекийн даатгалын үйл ажиллагааны журам”-ыг
батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2016 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуралдааны 5 тоот тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ипотекийн даатгалын үйл ажиллагааны журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Тогтоол хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрөөс эхлэн Санхүүгийн зохицуулах хорооны 2017 оны 109 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА

С.ДАВААСҮРЭН

ИПОТЕКИЙН ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэ журмын зорилт нь даатгалын гэрээний дагуу даатгагч нь орон сууцны ипотекийн зээлдэгчийн амь нас, эрүүл мэнд болон орон сууцад даатгалын тохиолдол учрахад учирсан хохирол буюу хэлэлцэн тохирсон даатгалын нөхөн төлбөрийг эрх бүхий этгээдэд төлөх нөхцөл бүхий даатгал /“Ипотекийн даатгал” гэх/-ын үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2 Ипотекийн даатгалын үйл ажиллагааны журам нь Монгол улсын иргэний хууль, Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн актаас бүрдэнэ.

ХОЁР. ДААТГАЛЫН ЭРСДЭЛ

2.1 Ипотекийн даатгал нь сайн дурын даатгалын тусгайлсан бүтээгдэхүүн бөгөөд ипотекийн барьцаа хөрөнгийн даатгал болон ипотекийн зээлийн гэрээний дагуу үүрэг хүлээж зээлийн дүнг хүлээж авсан этгээдийн амь нас, эрүүл мэндийн даатгал (цаашид “зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгал” гэх) гэсэн 2 тусдаа даатгалын бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

2.2 Даатгагч нь зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгалаар дараах үндсэн эрсдэлийг даатгана:

2.2.1 Ердийн даатгагчийн хувьд үйлдвэрлэлийн, ахуйн, зам тээврийн, байгалийн үзэгдэл түүний улмаас үүссэн осол, гуравдагч этгээдийн санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдлээс үүссэн осол (цаашид “гэнэтийн осол” гэх)-ын улмаас даатгуулагч нас барах болон хөдөлмөрийн чадвараа 70 буюу түүнээс дээш хувиар алдалт;

2.2.2 Урт хугацааны даатгагчийн хувьд аливаа шалтгааны улмаас даатгуулагч нас барах болон хөдөлмөрийн чадвараа 70 буюу түүнээс дээш хувиар алдалт.

2.3 Даатгуулагч нь хөдөлмөрийн чадвараа түр алдах, ажилгүй болох болон бусад нэмэлт эрсдэлийг гэрээний үндсэн дээр даатгагчтай харилцан тохиролцож, даатгуулж болно.

2.4 Зээлдүүлэгч буюу ипотекийн зээл олгож буй банк, банк бус санхүүгийн байгууллага нь орон сууцыг дараах эрсдэлээр барьцаа хөрөнгийн даатгалд даатгуулахыг зээлдэгчээс шаардана:

2.4.1 Галын эрсдэл (гал түймэр, дэлбэрэлт);

2.4.2 Сантехникийн эрсдэл;

2.4.3 Байгалийн эрсдэл (газар хөдлөлтийн эрсдэл хамаарахгүй);

2.4.4 Цахилгаан, эрчим хүчний эрсдэл;

2.4.5 Гуравдагч этгээдээс учруулсан санаатай болон санамсаргүй үйлдэл.

2.5 Даатгуулагч нь орон сууцыг энэхүү журмын 2.4-д заасан эрсдэлээс бусад нэмэлт эрсдэлийг гэрээний үндсэн дээр даатгагчтай харилцан тохиролцож, даатгуулж болно.

ГУРАВ. ДААТГАЛЫН ҮНЭЛГЭЭ, ХУРААМЖ, НӨХӨН ТӨЛБӨР

3.1 Зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгалын үнэлгээ нь зээл олгох үед тухайн зээлийн хэмжээ, даатгалын гэрээг сунгах үед тухайн үеийн зээлийн үлдэгдэл байна.

3.2 Орон сууцны ипотекийн зээлийн гэрээнд үндсэн зээлдэгчээс гадна хамтран зээлдэгчтэй байвал зээлдэгч тус бүрийн зээлийн төлбөр хариуцах хувиар даатгалын үнэлгээг гэрээнд тусгасан байна.

3.3 Ипотекийн барьцаа хөрөнгийн даатгалын үнэлгээ нь тухайн орон сууцны зах зээлийн үнэлгээ байна. Даатгалын үнэлгээг даатгагч, даатгуулагч нар харилцан тохиролцоно.

3.4 Зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгалын хураамжийг:

3.4.1 Ердийн даатгагч нь даатгуулагчийн нас, эрсдэлийн төвшин зэрэг хүчин зүйлд үндэслэн энэхүү журмын 1 дүгээр хавсралтад заасан загварын дагуу боловсруулна;

3.4.2 Урт хугацааны даатгагч нь насжилтын хүснэгт, хүүгийн төвшин, зардлын төвшин, гэрээ цуцлалтын төвшин зэрэг үзүүлэлтүүдийг үндэслэн энэхүү журмын 2 дугаар хавсралтад заасан загварын дагуу боловсруулна;

3.4.3 Урт хугацааны даатгагч даатгалын тохиолдол бий болоход нөхөн төлбөр буюу зээлийн үлдэгдлийг нэг удаа эсхүл зээлийн үндсэн төлбөр, үндсэн хүү буюу зээлийн төлбөрийг хуваарийн дагуу төлөх нөхцөлтэйгөөр боловсруулж болно.

3.5 Даатгагч ипотекийн барьцаа хөрөнгийн даатгалын хураамжийн хувийг эрсдэл тус бүрээр тооцож боловсруулсан байна.

3.6 Даатгагч даатгалын хураамжийн хувь хэмжээнд хоёр жил тутамд өөрчлөлт оруулж болох бөгөөд тухайн хувь хэмжээнд зайлшгүй өөрчлөлт оруулахаар бол үндэслэл, тооцоололтыг Хороонд ирүүлж хянуулна.

3.7 Даатгагч даатгуулагч харилцан тохиролцож даатгалын хураамжийг сар, улирал, хагас жил, жилээр хэсэгчлэн төлж болно. Урт хугацааны даатгалын хувьд даатгалын хураамжийг нэг удаа бүрэн төлж болно.

3.8 Даатгалын нөхөн төлбөрийг дараах дүнд үндэслэн даатгалын гэрээнд тусгасан үндсэн болон хамтран зээлдэгчийн зээлийн төлбөр хариуцах хувиар олгоно:

3.8.1 Даатгуулагч нас барсан, хөдөлмөрийн чадвараа 70 буюу түүнээс дээш хувиар бүрэн алдсан бол зээлийн үлдэгдэл дүн;

3.8.2 Даатгуулагч хөдөлмөрийн чадвараа 70 буюу түүнээс дээш хувиар түр алдсан бол хөдөлмөрийн чадвар түр алдалтын хугацаанд ногдох зээлийн төлбөрийн дүн.

3.9 Даатгагч төлбөл зохих нөхөн төлбөрийг хугацаанд нь төлөөгүйгээс үүссэн нэмэгдүүлсэн хүүг төлнө.

3.10 Даатгагч нь ипотекийн даатгалын бүтээгдэхүүнийг бүртгүүлэх, энэ журмын 3.6-д заасны дагуу даатгалын хураамжийн хувь хэмжээнд өөрчлөлт оруулахаар бол даатгалын хураамжийг тооцсон тооцоолол, ашигласан мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-нд ирүүлж, хянуулсан байна.

3.11 Даатгуулагчтай даатгалын гэрээ байгуулахад зуучилсны төлөө даатгагчаас даатгалын зуучлагчид олгох даатгалын зуучлалын шимтгэлийн хувь хэмжээг даатгагч, даатгалын зуучлагч нарын хооронд байгуулах хамтран ажиллах гэрээнд тусгах бөгөөд хамтран ажиллах гэрээ болон уг гэрээнд өөрчлөлт орвол тухай бүр Хороонд ирүүлнэ.

ДӨРӨВ. ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ ЗОХИЦУУЛАЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

4.1 Даатгагч нь даатгуулагчтай байгуулах ипотекийн даатгалын гэрээнд дараах зүйлсийг заавал тусгана:

4.1.1 Даатгалын зүйл;

4.1.2 Даатгуулагч болон зээлдүүлэгчийн тухай ерөнхий мэдээлэл;

4.1.3 Даатгалын эрсдэл;

4.1.4 Даатгалын үнэлгээ, даатгалын хураамжийн хувь, даатгалын хураамжийн хэмжээ, хураамж төлөх нөхцөл;

4.1.5 Даатгалын нөхөн төлбөр олгох, нөхөн төлбөр олгохоос татгалзах нөхцөл;

4.1.6 Даатгагч, даатгуулагч харилцан тохиролцож тодорхойлсон даатгалын хугацаа, түүнийг сунгах нөхцөл;

4.1.7 Даатгагч, даатгуулагчийн эрх, үүрэг;

4.1.8 Гэрээг дүгнэх, цуцлах нөхцөл;

4.1.9 Хуульд заасан бусад.

4.2 Даатгагч даатгалын гэрээнд нөхөн төлбөр олгох, нөхөн төлбөр олгохоос татгалзах нөхцөлийг тодорхой, хоёрдмол утга санаагүй, бусдад шууд ойлгогдохоор үг хэллэгтэй байхаар тусгах бөгөөд нөхөн төлбөр олгохоос татгалзах нөхцөлөөс бусад тохиолдолд даатгалын нөхөн төлбөрийг олгохоос татгалзаж үл болно.

4.3 Даатгагч даатгуулагчид даатгалын нөхөн төлбөр олгосны дараа буруутай этгээдээс төлбөр нэхэмжлэх даатгуулагчийн эрх нь даатгуулагчид олгосон нөхөн төлбөр, түүнтэй холбогдон гарсан зардлын хэмжээгээр даатгагчид шилжих талаар гэрээнд тусгана.

4.4 Даатгалын зуучлагч ипотекийн даатгалын үйл ажиллагаа эрхлэхэд дараах шаардлага тавигдана:

4.4.1 Ипотекийн даатгалын бүтээгдэхүүнээ Хороонд бүртгүүлсэн даатгагч бүртгэй эрх тэгш хамтран ажиллах;

4.4.2 Зээлдэгчид даатгалын эрсдэл, даатгагчаа сонгох эрхийг олгох;

4.4.3 Даатгалын хураамжийг хууль, хамтран ажиллах гэрээнд заасан хугацаанд шилжүүлээгүй бол даатгалын гэрээний хариуцлагыг даатгалын зуучлагч хариуцах;

4.4.4 Даатгуулагчийн даатгалын хураамжийн төлөлт тасралтгүй байх нөхцөлийг хангаж ажиллах.

4.5 Даатгагч, даатгалын зуучлагч нь даатгалын гэрээ байгуулах үед гэрээний нөхцөл шаардлага, даатгалын хураамжийг даатгуулагчид танилцуулж, энэ журмын 3 дугаар хавсралтад заасан “Мэдүүлгийн маягтын загвар”-ийн дагуу даатгуулагчийн мэдээллийг авч, даатгуулагчаар баталгаажуулсан байна.

ТАВ. БҮРТГЭЛ, ХЯНАЛТ

5.1 Даатгагч ипотекийн даатгалын бүтээгдэхүүнийг Хорооноос баталсан тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн журамд заасны дагуу даатгалын хэлбэр бүртгүүлэхтэй нэгэн адил Хороонд бүртгүүлнэ.

5.2 Даатгагч нь энэ журмын 5.1-т заасны дагуу Хороонд бүртгүүлсэн ипотекийн даатгалын бүтээгдэхүүний гэрээ, даатгалын хураамжийн хувь хэмжээнд Хорооноос зөвшөөрөлгүй өөрчлөлт оруулахыг хориглоно.

5.3 Даатгагч болон даатгалын зуучлагч ипотекийн даатгалтай холбоотой мэдээллийг санхүүгийн тайлан, нэмэлт тайланд Хорооноос гаргасан маягтын дагуу даатгалын хэлбэрийн нэгэн адил ипотекийн даатгалын бүтээгдэхүүн тус бүрээр тусгайлан тусгаж, Хороонд ирүүлнэ.

5.4 Хороо нь энэ журмын хэрэгжилтэд хяналт тавих бөгөөд энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхээс гадна дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

5.4.1 Ипотекийн даатгалын бүтээгдэхүүний бүртгэлийг хүчингүй болгож, уг даатгалын бүтээгдэхүүнийг борлуулахыг хориглоно. Энэ тохиолдолд өмнө хийгдсэн гэрээнүүд хүчин төгөлдөр хэвээр байна;

5.4.2 Даатгагч энэ журмыг зөрчиж ипотекийн даатгалын гэрээ байгуулснаас үүдэн даатгуулагч хохирсон нөхцөлд хохирлыг даатгагчаар төлүүлэх.

“Ипотекийн даатгалын үйл ажиллагааны журам”-ын 1 дүгээр хавсралт

“..... даатгал” ХХК-ийн
 даатгалын хураамжийн хувь (жилийн)

1. Зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгал

Үндсэн эрсдэл:	
Насны бүлэг	Даатгалын хураамжийн хувь
...	
...	
Нэмэлт эрсдэл:	
...	
...	

2. Барьцаа хөрөнгийн даатгал

Үндсэн эрсдэл	Даатгалын хураамжийн хувь
Галын эрсдэл (бүх төрлийн гал түймэр, дэлбэрэлт);	
Сантехникийн эрсдэл;	
Байгалийн эрсдэл (газар хөдлөлтөөс бусад эрсдэлүүд хамаарна);	
Цахилгаан, эрчим хүчний эрсдэл;	
Гуравдагч этгээдээс учруулсан санаатай болон санамсаргүй үйлдэл.	
Нэмэлт эрсдэл	
...	
...	
...	

Боловсруулсан:

..... (албан тушаал) (гарын үсэг) (овог, нэр)

Хянасан:

Гүйцэтгэх захирал (гарын үсэг) (овог, нэр)

(тамга, тэмдэг)

“Ипотекийн даатгалын үйл ажиллагааны журам”-ын 2 дугаар хавсралт

“..... даатгал” ХХК-ийн
даатгалын хураамжийн хувь (жилийн)

1. Зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгал

Нөхөн төлбөр төлөх нөхцөл:

- o Нэг удаа бүрэн төлөх,
- o Зээлийн хуваарийн дагуу төлөх

Үндсэн эрсдэл																															
Насны бүлэг	Даатгалын гэрээний хугацаа (жилээр)																														
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	
...																															

Нэмэлт эрсдэл	Даатгалын хураамжийн хувь
...	
...	
...	

Боловруулсан:

.....
(албан тушаал) (гарын үсэг) (овог, нэр)

Хянасан:

Гүйцэтгэх захирал
(гарын үсэг) (овог, нэр)

(тамга, тэмдэг)

Мэдүүлгийн маягтын загвар

1. Даатгуулагчийн мэдээлэл

Сонгох

Үндсэн зээлдэгч

Хамтран зээлдэгч

Овог нэр

.....

Нас

.....

Регистрийн дугаар

.....

Утас, цахим хаяг

.....

Оршин суугаа хаяг

.....

2. Зээлийн мэдээлэл

Зээлийн дүн буюу үлдэгдэл (төгрөгөөр)

.....

Зээлийн төлбөр хариуцах хувь

Үндсэн зээлдэгч

.....

Хамтран зээлдэгч

.....

Хамтран зээлдэгч

.....

Зээлийн хугацаа (сараар)

.....

3. Зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгал

3.1. *Үндсэн эрсдэл сонгох*

А. Гэнэтийн ослын улмаас нас барах, хөдөлмөрийн чадвараа 70 (дал) хувь буюу түүнээс дээш хугацаагаар алдах эрсдэл

Б. Аливаа шалтгааны улмаас нас барах, хөдөлмөрийн чадвараа 70 (дал) хувь буюу түүнээс дээш хугацаагаар алдах эрсдэл

Даатгалын компани сонгох

А –г сонгосон бол дараах компаниудаас сонгох	Б –г сонгосон бол дараах компаниудаас сонгох
<input type="checkbox"/> Ердийн даатгагчийн нэр	<input type="checkbox"/> Урт хугацааны даатгагчийн нэр
<input type="checkbox"/> Ердийн даатгагчийн нэр	<input type="checkbox"/> Урт хугацааны даатгагчийн нэр
<input type="checkbox"/> Ердийн даатгагчийн нэр	<input type="checkbox"/> Урт хугацааны даатгагчийн нэр
<input type="checkbox"/> Ердийн даатгагчийн нэр	<input type="checkbox"/> Урт хугацааны даатгагчийн нэр
.....

Даатгалын гэрээний хугацаа (жилээр):

Даатгалын хураамж төлөх: Сонгох

Нэг удаа бүрэн төлөх (Урт хугацааны даатгалын хувьд боломжтой)

Жилээр Улирлаар Сараар Бусад

4. Барьцаа хөрөнгийн даатгал

Даатгалын компани сонгох

<input type="checkbox"/> Ердийн даатгагчийн нэр
<input type="checkbox"/> Ердийн даатгагчийн нэр
<input type="checkbox"/> Ердийн даатгагчийн нэр
<input type="checkbox"/> Ердийн даатгагчийн нэр
.....

МЭДҮҮЛЭГ ГАРГАСАН:

Гарын үсэг

Огноо

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд
2018 оны 06 сарын 25-ны өдрийн 3947 дугаарт бүртгэв.



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2018 оны 6 сарын 06 өдөр

Дугаар 211

Улаанбаатар хот

“Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох
итгэлцүүр хэрэглэх журам”-ыг шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Жолоочийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Тогтоол хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрөөс эхлэн Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 331, 2012 оны 29 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА

С.ДАВААСҮРЭН

ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ТООЦОХ ИТГЭЛЦҮҮР ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь Жолоочийн даатгалын тухай хуулийн дагуу даатгуулагчийн төлөх хураамжийн хэмжээг тооцохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журам нь Даатгалын тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ноос гаргасан даатгалын багц дүрмийн хүрээнд мөрдөгдөнө.

ХОЁР. ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ТООЦОХОД ХЭРЭГЛЭХ ИТГЭЛЦҮҮР

/Энэ зүйлд СЗХ-ны 2020 оны 165 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон/

2.1. Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцохдоо Жолоочийн даатгалын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан суурь хураамж, мөн хуулийн 11 дүгээр зүйлд заасан итгэлцүүрийг хэрэглэнэ.

2.2. Тээврийн хэрэгслийг ашиглах газар нутгийн байршлаас хамаарах итгэлцүүр (I_1).

2.2.1. I_1 нь дараах хэмжээтэй байна:

Тээврийн хэрэгслийг ашиглах газар нутгийн байршил	I_1
Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон аймаг	1.2
Бусад аймаг, хот	1.0

2.2.2. тээврийн хэрэгслийг ашиглах газар нутгийн байршлыг тогтоохдоо тээврийн хэрэгслийн гэрчилгээнд бичигдсэн газар нутгийн байршлыг үндэслэнэ;

2.2.3. дамжин өнгөрөх болон түр хугацаагаар Монгол Улсын нутаг дэвсгэрт орж ирж байгаа тээврийн хэрэгслийн жолоочийн даатгалын газар нутгийн байршлаас хамаарах итгэлцүүр $I_1=1.5$ байна.

2.3. Өмнөх 1 /нэг/ жилийн хугацаанд даатгуулагчийн буруугаас үүссэн даатгалын тохиолдлын тоо, олгосон нөхөн төлбөрийн хэмжээнээс хамаарах итгэлцүүр (I_2).

2.3.1. I_2 нь дараах хэмжээтэй байна:

Даатгуулагчийн 365 хоногийн өмнөх И2-ийн утга <i>/Энэ зүйлд СЗХ- ны 2020 оны 165 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон/</i>	Өмнөх 365 хоногт даатгуулагчийн буруугаас үүссэн даатгалын тохиолдлын тоо, олгосон нөхөн төлбөрийн хэмжээнээс хамаарах итгэлцүүр И ₂ <i>/Энэ зүйлд СЗХ-ны 2020 оны 165 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон/</i>												
	Нөхөн төлбөр олгоогүй	1 удаа олгосон нөхөн төлбөрийн нийт хэмжээ / мян.төг/				2 удаа олгосон нөхөн төлбөрийн нийт хэмжээ / мян.төг/				3 болон түүнээс дээш удаа олгосон нөхөн төлбөрийн нийт хэмжээ /мян.төг/			
		200.0 хүргэлх	500.0 хүргэлх	1000.0 хүргэлх	1000.0-ээс дээш	200.0 хүргэлх	500.0 хүргэлх	1000.0 хүргэлх	1000.0-с дээш	200.0 хүргэлх	500.0 хүргэлх	1000.0 хүргэлх	1000.0-с дээш
2.45	2.3	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45
2.3	1.55	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45
1.55	1.4	2.3	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45
1.4	1	1.55	2.3	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45
1	0.95	1.4	1.55	2.3	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45
0.95	0.9	1	1.4	1.55	2.3	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45
0.9	0.85	0.95	1	1.4	1.55	2.3	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45
0.85	0.8	0.9	0.95	1	1.4	1.55	2.3	2.45	2.45	2.45	2.45	2.45	2.45
0.8	0.75	0.85	0.9	0.95	1	1.4	1.55	2.3	2.45	2.45	2.45	2.45	2.45
0.75	0.7	0.8	0.85	0.9	0.95	1	1.4	1.55	2.3	2.45	2.45	2.45	2.45
0.7	0.65	0.75	0.8	0.85	0.9	0.95	1	1.4	1.55	2.3	2.45	2.45	2.45
0.65	0.6	0.7	0.75	0.8	0.85	0.9	0.95	1	1.4	1.55	2.3	2.45	2.45
0.6	0.55	0.65	0.7	0.75	0.8	0.85	0.9	0.95	1	1.4	1.55	2.3	2.45
0.55	0.5	0.6	0.65	0.7	0.75	0.8	0.85	0.9	0.95	1	1.4	1.55	2.3
0.5	0.5	0.55	0.6	0.65	0.7	0.75	0.8	0.85	0.9	0.95	1	1.4	1.55

2.3.2.И₂ итгэлцүүрийг жолоочийн даатгалын гэрээ байгуулах тухай бүрт энэ журмын 2.3.1-т заасны дагуу тооцно;

2.3.3.даатгалын тохиолдлын тоо, олгосон нөхөн төлбөрийн хэмжээг өссөн дүнгээр тооцно;

2.3.4.даатгалын тохиолдол, олгосон нөхөн төлбөрийн хэмжээг бүртгэхдээ тээврийн хэрэгслийг жолоодож явсан жолоочийн түүх дээр бүртгэнэ;

2.3.5.жолоочийн даатгалын гэрээ байгуулахад И₂ итгэлцүүрийг даатгуулагчийн 365 хоногийн өмнөх итгэлцүүр И₂ болон өмнөх 365 хоногийн даатгуулагчийн даатгалын тохиолдлын тоо, олгосон нөхөн төлбөрийн хэмжээнээс хамааруулж энэ журмын 2.3.1-т заасны дагуу тогтооно; */Энэ зүйлд СЗХ-ны 2020 оны 165 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон/*

2.3.6.жолоочийн даатгалын гэрээг анх удаа байгуулж байгаа болон тухайн тээврийн хэрэгслийг жолоодох жолоочийн тоог хязгаарлаагүй тохиолдолд даатгуулагчийн итгэлцүүр И₂=1 байна. Тээврийн хэрэгслийг хэд хэдэн жолооч ашиглах бол тэдгээрийн хамгийн өндөр итгэлцүүрийг И₂ гэж тооцно;

2.3.7.даатгуулагчийн 365 хоногийн өмнөх И₂ итгэлцүүрийг тухайн гэрээ байгуулж буй хугацаанаас 365 хоногийн өмнөх эсхүл 365 хоногийн өмнөх хугацаанаас өмнө хамгийн ойр хугацааны И₂ итгэлцүүрээр тогтооно. */Энэ зүйлд СЗХ-ны 2020 оны 165 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон/*

2.4.Даатгуулагчийн нас, тээврийн хэрэгсэл жолоодох туршлагаас хамаарах итгэлцүүр (И₃)

2.4.1.И₃ нь дараах хэмжээтэй байна:

Даатгуулагчийн нас, автогээврийн хэрэгсэл жолоодох туршлага		I_3
25 хүртэлх насны	3 жил хүртэлх туршлагатай	1.2
	3 болон түүнээс дээш жилийн туршлагатай	1.15
25 болон түүнээс дээш насны	3 жил хүртэлх туршлагатай	1.1
	3 болон түүнээс дээш жилийн туршлагатай	1.0

2.4.2. Даатгалын гэрээнд тээврийн хэрэгслийн жолоочийн тоог хязгаарлаагүй тохиолдолд $I_3=1.2$ байна.

2.4.3. даатгалын гэрээнд тээврийн хэрэгслийг хэд хэдэн жолооч ашиглах бол тэдгээрийн хамгийн өндөр итгэлцүүрийг I_3 гэж тооцно.

2.4.4. тээврийн хэрэгслийн өмчлөгч нь хуулийн этгээд бол $I_3=1.2$ байна. /Энэ заалтыг СЗХ-ны 2020 оны 165 дугаар тогтоолоор хассан/

2.5. Даатгалын гэрээний хугацаанаас хамаарах итгэлцүүр (I_4).

2.5.1. Монгол улсад бүртгэлтэй тээврийн хэрэгслийн жолоочийн даатгалын гэрээний хугацаа /1 жил/-аас хамаарах итгэлцүүр $I_4=1$ хэмжээтэй байна.

2.5.2. гадаад улсад бүртгэлтэй буюу дамжин өнгөрөх болон түр хугацаагаар Монгол Улсын нутаг дэвсгэрт орж ирж байгаа тээврийн хэрэгслийн жолоочийн даатгалын гэрээний хугацаанаас хамаарах итгэлцүүр I_4 нь дараах хэмжээтэй байна:

Гадаад улсад бүртгэлтэй тээврийн хэрэгслийн жолоочийн даатгалын гэрээний хугацаа	I_4
2 сар хүртэл	1.3
2 сараас 3 сар хүртэл	1.6
3 сараас 4 сар хүртэл	1.9
4 сараас 5 сар хүртэл	2.1
5 сараас 6 сар хүртэл	2.4

2.6. Даатгуулагч даатгалын хураамжийн хэмжээг журамд зааснаас доогуур тогтоосон, эсхүл даатгалын нөхөн төлбөрийг нэмэгдүүлэхэд нөлөөлөхүйц худал мэдүүлэг санаатай өгсөн нь тогтоогдвол тус даатгалын гэрээ дууссаны дараа байгуулсан гэрээний даатгалын хураамжийг $I_5=1.3$ итгэлцүүрээр нэмэгдүүлж тооцно.

2.7. Тээврийн хэрэгслийг ашиглах жолоочийн тооноос хамаарах итгэлцүүр (I_6)

2.7.1. I_6 нь дараах хэмжээтэй байна:

Тээврийн хэрэгсэл ашиглах жолоочийн тоог хязгаарласан эсэх	I_6
Гэрээнд жолоочийн тоог зааж, нэр дурдсан	1.0
Гэрээнд жолоочийн тоог хязгаарлаагүй	1.5

2.8. Тээврийн хэрэгслийн даац, зорчигчийн суудлын тоо, хөдөлгүүрийн хүчин чадлаас хамаарах итгэлцүүр (I_7).

2.8.1. I_7 нь дараах хэмжээтэй байна:

Тээврийн хэрэгслийн ангилал, даац, зорчигчийн суудлын тоо, хөдөлгүүрийн хүчин чадал		И ₇
<p>В ангилал Хөдөлгүүрийн багтаамж /см³/</p>	-1000 хүртэл	0.9
	-1001-2000	1.0
	-2001-3000	1.1
	-3001-4000	1.2
	-4001-с дээш	1.3
<p>С ангилал Тээврийн хэрэгслийн даац</p>	-8 тонн хүртэлх даацтай	1.0
	-8 болон түүнээс дээш тоннын даацтай	1.3
<p>Д ангилал Суудлын тоо</p>	-16 хүртэлх зорчигчийн суудалтай	1.0
	-16 болон түүнээс дээш зорчигчийн суудалтай	1.3

2.8.2.гадаад улсад бүртгэлтэй буюу дамжин өнгөрөх болон түр хугацаагаар Монгол Улсын нутаг дэвсгэрт орж ирж байгаа тээврийн хэрэгслийн даац, зорчигчийн суудлын тоо, хөдөлгүүрийн хүчин чадлаас хамаарах итгэлцүүр И₇ дараах хэмжээтэй байна:

Тээврийн хэрэгслийн ангилал, даац, зорчигчийн суудлын тоо, хөдөлгүүрийн хүчин чадал		И ₇
<p>В ангилал Хөдөлгүүрийн багтаамж /см³/</p>	-1000 хүртэл	1.0
	-1001-2000	1.3
	-2001-3000	1.6
	-3001-4000	1.9
	-4001-с дээш	2.1
<p>С ангилал Тээврийн хэрэгслийн даац</p>	-10 тонн хүртэлх даацтай	1.0
	-10-аас 20 хүртэлх тоннын даацтай	1.5
	-20-иос 40 хүртэлх тоннын даацтай	2.0
	-40 болон түүнээс дээш тоннын даацтай	3.0
<p>Д ангилал Суудлын тоо</p>	-15 хүртэлх зорчигчийн суудалтай	1.0
	-16-аас 33 хүртэлх зорчигчийн суудалтай	2.0
	-33 болон түүнээс дээш зорчигчийн суудалтай	3.0

2.8.3.И₇ итгэлцүүрийг тогтоохдоо В, С болон Д ангиллын тээврийн хэрэгслийн жолоочийн даатгалд энэхүү журмын 2.8.1, 2.8.2-т заасан хүснэгтийг үндэслэнэ.

2.8.4.“А” болон “механизм” ангиллын тээврийн хэрэгслийн хувьд И₇=1 байхаар тооцно.

2.9.Тээврийн хэрэгслийн зориулалтаас хамаарах итгэлцүүр (И₈).

2.9.1.И₈ нь дараах хэмжээтэй байна:

Тээврийн хэрэгслийн зориулалт	И ₈
Хувийн	1.0
Хуулийн этгээдийн	1.5

2.9.2. тээврийн хэрэгслийн зориулалтыг тогтоохдоо тээврийн хэрэгслийн гэрчилгээнд дурдсан өмчлөгчийн мэдээллийг үндэслэнэ.

2.10. Чиргүүлтэй эсэхээс хамаарах итгэлцүүр (I_9).

2.10.1. I_9 нь дараах хэмжээтэй байна:

Чиргүүлтэй эсэх	I_9
Чиргүүлтгүй	1.0
Чиргүүлтэй	1.2

ГУРАВ. ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ТООЦОХ

3.1. Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцохдоо дараах хүснэгтийг ашиглана:

	Даатгалын хураамжийн төрөл	Даатгалын хураамжийг тооцох томьёо
1	Мэргэшсэн болон С, D ангиллын жолоочийн даатгалын хураамж	$X = X_0 \times I_2 \times I_3 \times I_4 \times I_5$
2	Хувь хүний нэр дээр бүртгэлтэй тээврийн хэрэгслийн жолоочийн даатгалын хураамж	$X = X_0 \times I_1 \times I_2 \times I_3 \times I_4 \times I_5 \times I_6 \times I_7 \times I_8 \times I_9$
3	Хуулийн этгээдийн нэр дээр бүртгэлтэй тээврийн хэрэгслийн жолоочийн даатгалын хураамж	$X = X_0 \times I_1 \times I_3 \times I_4 \times I_5 \times I_6 \times I_7 \times I_8 \times I_9$
4	Дамжин өнгөрөх болон түр хугацаагаар Монгол Улсын нутаг дэвсгэрт орж ирж байгаа тээврийн хэрэгслийн жолоочийн даатгалын хураамж	$X = X_0 \times I_1 \times I_2 \times I_3 \times I_4 \times I_5 \times I_6 \times I_7 \times I_8 \times I_9$

3.2. Энэ журмын 3.1-д заасан X_0 нь Жолоочийн даатгалын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан даатгалын суурь хураамж байна.

3.3. Энэ журмын 3.1-д заасан $I_1, I_2, I_3, I_4, I_5, I_6, I_7, I_8, I_9$ -д энэ журмын 2.2-2.10-т заасан итгэлцүүрийг ойлгоно.

ДӨРӨВ. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

4.1. Хороо энэ журмын биелэлтэд хяналт тавих бөгөөд зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд
2018 оны 06 сарын 25-ны өдрийн 3948 дугаарт бүртгэв.



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2018 оны 6 сарын 06 өдөр

Дугаар 212

Улаанбаатар хот

“Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын мэдүүлгийн
маягт, гэрээний стандарт, загвар”-ыг шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Жолоочийн даатгалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний мэдүүлгийн маягт”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний стандарт, загвар”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Тогтоол хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрөөс эхлэн Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 332, 334 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Г.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА

С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны
2018 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн
212 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

**ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГЫН АЛБАН ЖУРМЫН
ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ МЭДҮҮЛГИЙН МАЯГТ**

Гэрээний дугаар:

Эхлэх хугацаа: 20__-__-__ : :__

Дуусах хугацаа: 20__-__-__ : :__

(Он, сар, өдөр, цаг, минут)

(Он, сар, өдөр, цаг, минут)

Даатгалын компани:

Төрөл:

/Даатгагч компанийн нэр/

Хязгаарласан эсэх:

Даатгуулагч худал мэдүүлсэн эсэх:

/Тийм / Үгүй/

/Тийм / Үгүй/

/Даатгуулагчийн бөглөх хэсэг/

1. Тээврийн хэрэгсэл (ТХ)-ийг өмчлөгч (даатгуулагч)-ийн мэдээлэл:

Хувь хүн:

Даатгуулагчийн эцэг/эх, нэр:

Регистрийн дугаар:

Жолооны үнэмлэхийн дугаар:

Мэргэшсэн жолоочийн үнэмлэх: (үнэмлэхийн дугаар)

Жолооны үнэмлэхийн ангилал:

Жолооны үнэмлэхийн хүчинтэй хугацаа: ... он ... сар ... өдөр

Жолооны туршлага: (жилээр)

Бүлэг: (Даатгуулагчийн гэрээ байгуулах үеийн бүлэг)

Нөхөн төлбөр: ..., ... (Өмнөх нэг жилийн хугацаанд авсан нөхөн төлбөрийн тоо, хэмжээ)

Хуулийн этгээд:

Байгууллагын нэр: /ТХ-ийг өмчлөгч хуулийн этгээдийн нэр/

Байгууллагын регистрийн дугаар:

Хувь хүн/Хуулийн этгээд:

Зип код: ... /Газар нутгийн зип код/

Хаяг:

Утасны дугаар:

2. Тээврийн хэрэгслийн мэдээлэл:

Улсын дугаар: Арлын дугаар: Үйлдвэр:
 Марк: Хөдөлгүүрийн багтаамж (см³): ТХ-ийн ангилал:
 Суудлын тоо: Ачааны даац (кг): Өнгө:
 Чиргүүл: (Тийм/Үгүй)

3. Тээврийн хэрэгслийг жолоодох зөвшөөрөгдсөн жолоочийн мэдээлэл:

Жолоочийн тоог хязгаарлахгүй / хязгаарлаж, дараах нэр дурдсан жолооч нар жолоодно:
 (доогуур нь зурах)

	Регистрийн дугаар	Эцэг/эх	Нэр	Жолооны үнэмлэхийн дугаар	Жолооны туршлага (жилээр)	Бүлэг	Өмнөх 365 хоногт авсан нөхөн төлбөр /Энэ заалтад СЗХ-ны 2020 оны 166 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон/	
							Тоо	Хэмжээ
1								
2								
3								
4								
*								

*Тайлбар: Тээврийн хэрэгслийг жолоодох жолоочийн тоо 4-өөс дээш байх тохиолдолд даатгуулагчийн мэдүүлгийн маягтад тусад нь хүснэгт хийж хавсаргаж болно.

4. Даатгалын хураамж: (Даатгагч нөхөж бичнэ)

Мэргэшсэн болон C, D ангиллын жолоочийн даатгалын хураамж:

$$X = X_0 x I_2 x I_3 x I_4 x I_5$$

Хувь хүний нэр дээр бүртгэлтэй тээврийн хэрэгслийн **жолоочийн** даатгалын хураамж:

$$X = X_0 x I_1 x I_2 x I_3 x I_4 x I_5 x I_6 x I_7 x I_8 x I_9$$

Хуулийн этгээдийн нэр дээр бүртгэлтэй тээврийн хэрэгслийн **жолоочийн** даатгалын хураамж:

$$X = X_0 x I_1 x I_3 x I_4 x I_5 x I_6 x I_7 x I_8 x I_9$$

Дамжин өнгөрөх болон түр хугацаагаар Монгол улсын нутаг дэвсгэрт орж ирж байгаа тээврийн хэрэгслийн жолоочийн даатгалын хураамж:

$$X = X_0 x I_1 x I_2 x I_3 x I_4 x I_5 x I_6 x I_7 x I_8 x I_9$$

Суурь хураамж X_0	Итгэлцүүрийн нэр	Хэмжээ $I_{...}$	Хураамжийн дүн X
$X_0 = \dots\dots\dots$	ТХ-ийг ашиглах газар нутгийн байршлаас хамаарах I_1	$I_1 = \dots\dots\dots$	$X = \dots\dots\dots\dots\dots\dots$
	Өмнөх 365 хоногт даатгуулагчийн буруугаас үүссэн даатгалын тохиолдлын тоо, нөхөн төлбөрийн хэмжээнээс хамаарах I_2 / <i>Энэ заалтад СЗХ-ны 2020 оны 166 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон/</i>	$I_2 = \dots\dots\dots$	
	Даатгуулагчийн нас, автотээврийн хэрэгсэл жолоодох туршлагаас хамаарах I_3	$I_3 = \dots\dots\dots$	
	Даатгалын гэрээний хугацаанаас хамаарах I_4	$I_4 = \dots\dots\dots$	
	Даатгалын хураамжийн хэмжээг журамд зааснаас доогуур тогтоосон, эсхүл даатгалын нөхөн төлбөрийг нэмэгдүүлэхэд нөлөөлөхүйц худал мэдүүлэг санаатай өгсөн эсэхээс хамаарах I_5	$I_5 = \dots\dots\dots$	
	Тээврийн хэрэгслийг ашиглах жолоочийн тооноос хамаарах I_6	$I_6 = \dots\dots\dots$	
	Тээврийн хэрэгслийн даац, зорчигчийн суудлын тоо, хөдөлгүүрийн хүчин чадлаас хамаарах I_7	$I_7 = \dots\dots\dots$	
	Тээврийн хэрэгслийн зориулалтаас хамаарах I_8	$I_8 = \dots\dots\dots$	
	Чиргүүлгэй эсэхээс хамаарах I_9	$I_9 = \dots\dots\dots$	

Хэвлэсэн огноо: 20__-__-__:__:__

Даатгуулагчийг төлөөлж:

Даатгагчийг төлөөлж:

(гарын үсэг) (нэр)

“Мэргэшсэн болон С, D ангиллын жолоочийн даатгалыг хийлгэх үү: (Тийм/Үгүй),
 Даатгалын гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж, хураамжийн буцаалт хийх тохиолдолд мөнгө хүлээн авах: Бэлэн мөнгөөр; Дансаар; Хэрэв дансаар хүлээн авах бол: Банкны нэр: ... Дансны дугаар: ... Данс эзэмшигчийн овог, нэр: ...

Энэ хэсэгт СЗХ-ны 2020 оны 166 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон/

Тайлбар: Гэрээний мэдүүлэг болон даатгалын гэрээг тус бүр 2 хувь үйлдэж, 1 хувийг даатгуулагчид өгч, 1 хувь нь даатгагчид үлдэнэ.

Мэдүүлэг, даатгалын гэрээ нэг дугаартай байна.

Санхүүгийн зохицуулах хорооны
2018 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн
212 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГЫН АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ СТАНДАРТ, ЗАГВАР

Дугаар ...

Энэхүү гэрээг нэг талаас _____ (иргэний овог, нэр) _____ (хуулийн этгээдийн нэр)

_____ /цаашид “даатгуулагч” гэх/, нөгөө талаас _____ ХХК- (регистрийн дугаар) _____ (даатгалын компанийн нэр)

ийг төлөөлж _____ ажилтай _____ /цаашид “даатгагч” гэх/ нар (албан тушаал) _____ (овог, нэр)

Жолоочийн даатгалын тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжийг үндэслэн байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү гэрээ нь даатгуулагч даатгалын зүйлээ даатгагчид даатгуулах, даатгагч нь гэрээнд заасан эрсдэл үүссэн тохиолдолд нөхөн төлбөр олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Даатгуулагч нь энэхүү даатгалын гэрээг байгуулахаас өмнө батлагдсан маягтын дагуу мэдүүлэг бөглөж даатгагчид өгнө.

1.3. Даатгалын мэдүүлэг нь гэрээний салшгүй хэсэг болно.

1.4. Даатгагч нь даатгуулагчид Жолоочийн даатгалын тухай хууль, энэ гэрээгээр талуудын хүлээх эрх, үүргийг бүрэн тайлбарлан танилцуулж, хоёр тал харилцан хүлээн зөвшөөрснийг гэрчилж энэ гэрээнд гарын үсэг зурна.

1.5. Жолоочийн даатгалын мэдээллийн сангаас олгож буй 14 орон бүхий дугаар нь даатгалын баталгаа болно.

ХОЁР. ДААТГАЛЫН ЗҮЙЛ

2.1. Энэхүү гэрээний даатгалын зүйл нь жолооч замын хөдөлгөөнд оролцох үедээ бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учруулж болзошгүй хохирлыг нөхөн төлөх зорилготой бусдын өмнө хүлээх хариуцлага байна.

ГУРАВ. ДААТГАЛЫН ЭРСДЭЛИЙН ТӨРӨЛ

3.1. Даатгуулагч нь дараах төрлийн эрсдэлийг даатгуулна. Үүнд:

3.1.1. жолооч нь автотээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцох үедээ бусдын амь насанд учруулсан хохирол;

3.1.2.жолооч нь автотээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцох үедээ бусдын эрүүл мэндэд учруулсан хохирол;

3.1.3.жолооч нь автотээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцох үедээ бусдын эд хөрөнгөд учруулсан хохирол.

ДӨРӨВ. ДААТГАЛЫН ҮНЭЛГЭЭ

4.1.Энэхүү гэрээний даатгалын үнэлгээний хэмжээ нь Жолоочийн даатгалын тухай хуулийн 9.1-д заасны дагуу дараах хэмжээтэй байна.

-	Тээврийн хэрэгслийн ангилал	Даатгалын үнэлгээ буюу нэг удаа олгох нөхөн төлбөрийн дээд хэмжээ /төгрөг/	Даатгуулсан үнэлгээ, ангиллыг тэмдэглэх +/-
1	“А” ангиллын тээврийн хэрэгсэл	5 сая хүртэл	-
2	“В” ангиллын тээврийн хэрэгсэл	5 сая хүртэл	-
3	“С” ангиллын тээврийн хэрэгсэл	10 сая хүртэл	-
4	“Д” ангиллын тээврийн хэрэгсэлд	10 сая хүртэл	-
5	“Механизм” ангиллын тээврийн хэрэгсэл	5 сая хүртэл	-

4.2.Мэргэшсэн жолооч болон С, D ангиллын тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцох жолоочийн даатгалын үнэлгээ нь тухайн даатгуулагчийн жолоодож замын хөдөлгөөнд оролцсон тээврийн хэрэгслийн ангиллын дагуу энэ журмын 4.1-д заасан хэмжээтэй байна.

ТАВ. ДААТГАЛЫН ХУРААМЖ

5.1.Даатгалын хураамжийн хэмжээг тогтоохдоо Жолоочийн даатгалын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан даатгалын суурь хураамжийн хэмжээг, тус хуулийн 11.1-д заасан итгэлцүүрээр нэмэгдүүлж буюу хорогдуулж тооцно.

5.2.Даатгуулагч нь энэхүү гэрээний 5.1-д заасны дагуу тооцсон даатгалын хураамжийг даатгагчид төлнө.

5.3.Даатгалын хураамж бүрэн төлөгдсөн он, сар, өдөр, цаг, минутаас эхлэн даатгалын гэрээ хүчин төгөлдөр болно.

5.4.Даатгагч нь даатгалын хураамжаас гадна даатгалын гэрээний хуулбарыг даатгуулагчийн хүсэлтээр дахин олгох зардлаас бусад аливаа хэлбэрээр даатгуулагчаас шимтгэл, үйлчилгээний хөлс авахыг хориглоно.

ЗУРГАА. ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА, ГЭРЭЭГ ЦУЦЛАХ

6.1.Энэхүү гэрээ нь мэдүүлэгт заасан нэг жилийн хугацаанд хүчинтэй байна. Харин дамжин өнгөрөх болон түр хугацаагаар Монгол улсын нутаг дэвсгэрт орж ирж байгаа автотээврийн хэрэгслийн жолоочийн даатгалын гэрээний хугацаа нь даатгалын мэдүүлэгт заасан хугацаанд хүчинтэй байна.

6.2.Энэ гэрээний 11.1-т заасны дагуу гэрээг цуцалсан тохиолдолд гэрээний үлдэх хугацаатай тэнцэх хэмжээний даатгалын хураамжийг хувь тэнцүүлэн даатгуулагчид буцааж олгоно. Даатгалын гэрээний хүчинтэй хугацаанд даатгагч хохирлын нөхөн төлбөр олгосон нөхцөлд даатгалын хураамжийн буцаалт хийгдэхгүй.

6.3. Даатгагч гэрээний хугацаа дуусахаас хуанлийн 14 хоногийн өмнө нөгөө талдаа мэдэгдэнэ.

6.4. Даатгагч нь энэ гэрээний 6.2-т заасан хураамжийн буцаан олголтыг жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний мэдүүлгийн маягтад бөглөсний дагуу ажлын 5 хоногийн дотор олгоно. /Энэ хэсгийг СЗХ-ны 2020 оны 166 дугаар тогтоолоор нэмсэн/

ДОЛОО. ДААТГАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

7.1. Даатгагч дараах эрх эдэлнэ:

7.1.1. даатгагч нь нөхөн төлбөр буюу хохирлын хэмжээг тогтооход шаардлагатай мэдээллийг даатгуулагч, хохирогчоос шаардах;

7.1.2. жолоочийн даатгалын тухай хуулийн 16.2-т заасны дагуу даатгалын тохиолдол болсон газар нутгийн байршлыг харгалзан даатгагч, жолоочийн даатгалын сангийн төлөөлөгч нь энэхүү гэрээний 7.2.3-т заасан хугацааг хохирогч, даатгуулагчийн зөвшөөрлийн дагуу 10 хүртэл хоногоор сунгах; /Энэ заалтад СЗХ-ны 2020 оны 166 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон/

7.1.3. даатгалын хохирлыг бодитой үнэлэхийг хохирол үнэлэгчээс шаардах;

7.2. Даатгагч дараах үүрэг хүлээнэ:

7.2.1. жолоочийн даатгалын тухай хууль тогтоомж, гэрээний нөхцөлийг даатгуулагчид танилцуулах;

7.2.2. даатгалын тохиолдол болсон үед нөхөн төлбөрийг хууль болон гэрээгээр тохиролцсон хугацаа, хэмжээнд олгох;

7.2.3. даатгуулагч өргөдөл гаргаснаас хойш 3 хоногийн дотор даатгалын тохиолдлыг шалгаж, даатгалын хохирол үнэлэгчийг томилох;

7.2.4. даатгагч даатгалын тохиолдлыг шалгах, нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох, хохирлыг үнэлэхтэй холбогдон гарах зардлыг хариуцах;

7.2.5. даатгалын гэрээний хугацаанд бий болсон уг гэрээтэй холбоотой бүхий л мэдээллийг даатгуулагчид үнэ төлбөргүй гаргаж өгөх;

7.2.6. даатгалын гэрээний хугацааны талаар жилд 2 удаа мэдээлэл өгөх, дараагийн гэрээ байгуулахад орох өөрчлөлтийн талаар даатгуулагч хүсвэл урьдчилан зөвлөгөө өгөх;

7.2.7. даатгалын гэрээний мэдүүлгийн мэдээлэл, нөхөн төлбөр, даатгалын тохиолдол, даатгуулагчийн нэмэлт өөрчлөлтийн үнэн зөвийг шалгах, жолоочийн мэдээллийн санд тухай бүр үнэн зөв оруулах;

НАЙМ. ДААТГУУЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

8.1. Даатгуулагч дараах эрх эдэлнэ:

8.1.1. даатгуулагч нь жолоочийн даатгалын гэрээний талаар мэдээлэл авах, даатгалын тохиолдол, нөхөн төлбөрийн мэдээллийг шалгуулах;

8.1.2. даатгалын тохиолдол болсон үед шуурхай албаны үйлчилгээ авах, гэрээний нөхцөлийн дагуу нөхөн төлбөр олгохыг даатгагчаас шаардах;

8.1.3. Жолоочийн даатгалын тухай хуулийн 16.4, энэхүү гэрээний 7.2.3-т заасны дагуу даатгагч нь хуульд заасан хугацаанд даатгалын хохирол үнэлэгчийг томилоогүй бол даатгуулагч нь Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 3.2.4-т заасан даатгалын хохирол үнэлэгч этгээдэд хандах.

8.2. Даатгуулагч дараах үүрэг хүлээнэ:

8.2.1.даатгалын хураамжийг хууль болон гэрээнд заасан хэмжээгээр даатгагчид бүрэн төлөх;

8.2.2.даатгал хийлгэхтэй холбоотой баримт материалыг даатгагчид үнэн зөв гаргаж өгөх;

8.2.3.жолоочийн даатгалд даатгуулсан тухайгаа хохирогчид мэдэгдэх;

8.2.4.зам тээврийн ослын үед ослын газраас хөдлөхгүйгээр даатгалын тохиолдол гарсан талаар даатгагч, цагдаагийн байгууллагад мэдэгдэх, даатгалын гэрээг шалгуулах;

8.2.5.даатгалын тохиолдол болон нөхөн төлбөрийн хэмжээг тогтооход шаардлагатай мэдээллийг даатгагчийн болон эрх бүхий этгээдийн шаардсан хугацаанд гаргаж өгөх;

8.2.6.даатгагч нь дампуурсан бол шуурхай албанд болон шаардлагатай тохиолдолд цагдаагийн байгууллагад мэдэгдэх.

8.3.Тээврийн хэрэгслийн өмчлөгчөөс бусад жолооч нь энэ гэрээний 8.2.3-8.2.6-д заасан үүргийг хүлээнэ.

8.4.Даатгалын тохиолдлын улмаас учирсан хохирлыг тухайн даатгалын тохиолдол гарсан даруйд нөхөн төлөхөөр жолооч хохирогчтой тохиролцсон бол энэ тухайгаа даатгагчид мэдэгдэх бөгөөд даатгагчаас эргэн төлүүлэхээр даатгагчийн зааврын дагуу хохирлыг жолооч барагдуулж болно.

8.5.Даатгуулагч Жолоочийн даатгалын тухай хуулийн 13.1, 13.4 болон энэ гэрээний 8.2.3-8.2.6, 8.5-д заасан үүргээ хүндэтгэх шалтгаангүйгээр биелүүлээгүйн улмаас үүсэх үр дагаврыг даатгагч хариуцахгүй бөгөөд хохирлыг даатгуулагч өөрөө хариуцна.

ЕС. ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОХ, ОЛГОХООС ТАТГАЛЗАХ НӨХЦӨЛ

9.1.Даатгагч даатгалын тохиолдлын дуудлага хүлээн авч шалгахдаа Жолоочийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасныг үндэслэнэ.

9.2.Хохирогчийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан хохирлын хэмжээг тодорхойлоход Жолоочийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлд, даатгагч нь хохирогчид олгох нөхөн төлбөрийн хэмжээг тогтоож, нөхөн төлбөр олгоход тус хуулийн 19 дүгээр зүйлд заасныг тус тус үндэслэнэ.

9.3.Даатгагч нь Жолоочийн даатгалын тухай хууль болон энэ гэрээнд заасан нөхцөлийн дагуу дараах баримтыг үндэслэн нөхөн төлбөрийг олгоно:

9.3.1.даатгалын гэрээ;

9.3.2.даатгуулагчийн өргөдөл;

9.3.3.шаардлагатай тохиолдолд эрх бүхий этгээдээс учирсан хохирлын талаар бичгээр гаргасан дүгнэлт; */Энэ заалтад СЗХ-ны 2020 оны 166 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон/*

9.3.4.холбогдох бусад баримт бичиг. */Энэ заалтад СЗХ-ны 2020 оны 166 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон/*

9.4.Дараах хохирол жолоочийн даатгалын тохиолдолд үл хамаарна гэж үзэн даатгагч нөхөн төлбөр олгохоос татгалзана:

9.4.1.сэтгэл санааны хохирол;

9.4.2.хүрээлэн байгаа орчныг бохирдуулснаас үүссэн хохирол;

9.4.3.даатгуулагчийн автотээврийн хэрэгсэл, ачаанд учирсан хохирол;

9.4.4.Жолоочийн даатгалын тухай хууль болон энэ гэрээнд заасан хэмжээнээс илүү гарсан хохирол.

АРВ. НӨХӨН ТӨЛБӨРИЙГ БУЦААН НЭХЭМЖЛЭХ ҮНДЭСЛЭЛ

10.1. Даатгагч нь дараах тохиолдолд хохирогчид олгосон нөхөн төлбөрийг буруутай этгээдээс буцаан нэхэмжлэх эрхтэй:

10.1.1. хохирогчид хохирол учирсан нь даатгуулагчийн гэм буруутай холбогдолгүй болох нь хуульд заасан эрх бүхий этгээдийн дүгнэлт, шийдвэрээр тогтоогдвол тухайн буруутай этгээдээс;

10.1.2. даатгалын тохиолдол гарсан талаар Жолоочийн даатгалын тухай хуулийн 13.1, 13.2-т заасан этгээдэд мэдэгдээгүй бол даатгуулагч, жолоочоос;

10.1.3. даатгуулагч нь даатгалын тохиолдол болсон газраас зугтаасан бол тухайн даатгуулагчаас;

10.1.4. даатгуулагч нь согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн үедээ даатгалын тохиолдол гаргасан бол даатгуулагчаас;

10.1.5. хуульд заасан бусад тохиолдолд буруутай этгээдээс.

АРВАН НЭГ. ГЭРЭЭГ ДҮГНЭХ, ЦУЦЛАХ НӨХЦӨЛ

11.1. Энэхүү гэрээ нь дараах тохиолдолд дуусгавар болно:

11.1.1. гэрээгээр тогтоосон хугацаа дуусгавар болсон;

11.1.2. даатгагч, даатгуулагчийн аль нэг нь дампуурсан, татан буугдсан;

11.1.3. талууд харилцан тохиролцож гэрээг цуцалсан.

Гэрээ байгуулсан:

Даатгагчийг төлөөлж:

Гарын үсэг: _____

(тамга, тэмдэг)

Албан тушаал: _____

Хаяг: _____

Утас: _____

Даатгуулагч:

Гарын үсэг: _____

(тамга, тэмдэг)

Албан тушаал: _____

Хаяг: _____

Утас: _____

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд
2018 оны 06 сарын 25-ны өдрийн 3949 дугаарт бүртгэв.*



**МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2018 оны 6 сарын 06 өдөр

Дугаар 213

Улаанбаатар хот

“Жолоочийн даатгалын сангийн данс байршуулах,
санхүүжилтийг төвлөрүүлэх, сангийн хөрөнгийг шилжүүлэх,
зарцуулах журам”-ыг шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Жолоочийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Жолоочийн даатгалын сангийн данс байршуулах, санхүүжилтийг төвлөрүүлэх, сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Тогтоол хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрөөс эхлэн Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 337, 2012 оны 393 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА

С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны
2018 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн
213 дугаар тогтоолын хавсралт

ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН САНГИЙН САНХҮҮЖИЛТИЙГ ТӨВЛӨРҮҮЛЭХ, ДАНС БАЙРШУУЛАХ, САНГИЙН ХӨРӨНГИЙГ ШИЛЖҮҮЛЭХ, ЗАРЦУУЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь жолоочийн даатгалын сан /цаашид “сан” гэх/-ийн санхүүжилтийг төвлөрүүлэх, данс байршуулах, сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

ХОЁР. САНГИЙН ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭР

2.1. Сангийн хөрөнгө нь Жолоочийн даатгалын тухай хууль /цаашид “Хууль” гэх/-ийн 22.1 дэх хэсэгт заасан эх үүсвэрээс бүрдэнэ.

ГУРАВ. САНГИЙН ДАНС БАЙРШУУЛАХ, САНХҮҮЖИЛТИЙГ ТӨВЛӨРҮҮЛЭХ, САНГИЙН ХӨРӨНГИЙГ ШИЛЖҮҮЛЭХ

3.1. Холбоо нь сангийн данс байршуулах, орлого төвлөрүүлэх, төлбөр тооцоог гүйцэтгэх 3-аас доошгүй харилцагч банкийг сонгож хамтран ажиллана.

3.2. Холбоо харилцагч банкийг сонгохдоо дараах шалгуур үзүүлэлтүүдийг харгалзан үзнэ:

3.2.1. Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг сүүлийн 2 жилийн байдлаар хангасан;

3.2.2. санхүүгийн хувьд тогтвортой, найдвартай үйлчилгээг тогтмол үзүүлэх боломжтой;

3.2.3. харьцангуй бага шимтгэлтэй үйлчилгээг үзүүлэх чадвартай;

3.3. Холбоо нь энэ журмын 3.2-т заасан шалгуурыг хангасан банктай хамтран ажиллах гэрээ байгуулж, сангийн дансыг байршуулж, санхүүжилтийг төвлөрүүлэх ба гэрээний хэрэгжилтийг жил тутам дүгнэнэ.

3.4. Харилцагч банкны үйлчилгээ хангалтгүй, энэ журмын 3.2-т заасан шалгуурыг хангаагүй гэж үзсэн тохиолдолд харилцагч банктай байгуулсан гэрээг цуцалж, харилцагч банкийг дахин сонгон шалгаруулна.

3.5. Холбоо нь шалгаруулалтад тэнцээгүй харилцагч банкинд данс нээхийг хориглоно.

3.6. Сангийн хөрөнгийг дараах хэлбэрээр байршуулж болно.

Заалт	Хөрөнгө байршуулах хэлбэр	Хөрөнгө байршуулах дээд хэмжээ /хувиар/	Нэгжид ногдох дээд хэмжээ /хувиар/
3.6.1	Засгийн газрын бонд	100	50
3.6.2	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	100	50
3.6.3	Банкны хадгаламжийн сертификат	20	5
3.6.4	Банкны харилцах, хадгаламж	100	33.4
3.6.5	Хорооноос зөвшөөрсөн бусад хөрөнгө оруулалт	Зөвшөөрсөн хэмжээгээр	Зөвшөөрсөн хэмжээгээр

3.7. Хөрөнгө байршуулах хэмжээг тооцохдоо нийт хөрөнгийн дүнг харгалзах хөрөнгө байршуулах хувиар үржүүлж тооцно.

ДӨРӨВ. САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

4.1. Сангийн хөрөнгийг Хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу зарцуулна.

4.2. Хуулийн 23.1.1-т заасны дагуу нөхөн төлбөр олгохдоо дараах баримтуудаар баталгаажуулсан байна.

4.2.1. даатгалгүй, даатгалын гэрээний хугацаа нь дууссан этгээд даатгалын тохиолдол гаргасан үед Холбооны жолоочийн даатгалын мэдээллийн сангийн тодорхойлолт;

4.2.2. бусдын амь нас эрүүл мэндэд хохирол учруулсан этгээд тодорхой бус үед мэргэжлийн байгууллагын тодорхойлолт, акт, шийдвэр;

4.2.3. даатгагч дампуурсан тохиолдолд Хорооноос гаргасан тодорхойлолт, мэдэгдэл;

4.2.4. хохирогчийн өргөдөл;

4.2.5. даатгалын тохиолдолд холбогдогч талуудын иргэний болон жолооны үнэмлэхний хуулбар, тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар, буруутай талын оршин суугаа газрын хаяг;

4.2.6. даатгалын тохиолдол болсныг нотолсон баримт бичиг буюу даатгалын тохиолдолд холбогдогч талууд гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн бол шуурхай албаны үзлэгийн тэмдэглэл, 2 талын тохиролцсон хүснэгт, дүгнэлтийг үндэслэж болох ба талууд харилцан зөвшилцөлд хүрч чадаагүй, хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан бол эрх бүхий этгээдийн акт, тодорхойлолт;

4.2.7. нөхөн төлбөрийн хэмжээг тогтоосон хуульд заасан эрх бүхий этгээд, эсхүл даатгалын хохирол үнэлэгчийн дүгнэлт, тодорхойлолт;

4.2.8. Холбоо нь хохирлын үнэлгээг дахин хянаж, хохирогч болон буруутай этгээдээс нэмэлт мэдээлэл шаардаж болно;

4.2.9. даатгалын хохирол үнэлэгчийн тогтоосон хохирлын үнэлгээг буруутай этгээд, хохирогч, сангийн аль нэг тал нь хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд өөр даатгалын хохирол үнэлгээний байгууллагаар өөрийн зардлаар дахин нэг удаа хийлгэж болно. Дахин хийлгэсэн үнэлгээ, анхны үнэлгээний дүн зөрүүтэй байвал аль бага үнэлгээний дүнг үндэслэн нөхөн төлбөрийг олгоно;

4.2.10. Холбоо нь сангаас хохирогчид нөхөн төлбөр олгох үндэслэлгүй гэж үзвэл албан бичгээр хариу мэдэгдэнэ;

4.2.11. шаардлагатай тохиолдолд Холбоо нь санд нөхөн төлбөрийг буцаан төлөх үүрэгтэй этгээдээс батлан даагч шаардаж болно.

4.3. Холбоо нь нөхөн төлбөр олгохдоо Хуулийн 19 дүгээр зүйлд заасныг баримтална.

4.4. Холбоо нь Хуулийн 22.1, 23.1-т тус тус заасан сангийн бүрдүүлэлт, зарцуулалт хөрөнгийн төсвийн төслийг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хороонд ирүүлж хянуулсны дараа Холбоо нь төсвийн төслийг хэлэлцэж 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор батална.

4.5. Жолоочийн даатгалын тухай хуулийн 23.1-т зааснаас өөр зориулалтаар сангаас хөрөнгө зарцуулахыг хориглоно. Сангаас гарах зардлыг санхүүжүүлэхтэй холбогдсон анхан шатны баримт нь үнэн зөв, бодит тоон мэдээнд үндэслэгдсэн байна. Санхүүгийн тайланд гарсан аливаа алдааг залруулах бол холбогдох нэмэлт баримт бүрдүүлэн залруулга хийж, зөвшөөрсөн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна.

4.6. Зарцуулалтын анхан шатны баримтын бүрдэл, үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээж авсан ажилтан хариуцна.

4.7. Даатгагч нь даатгалын гэрээний мэдээгээ жолоочийн даатгалын мэдээллийн санд ирүүлээгүйгээс сангаас нөхөн төлбөр олгосон тохиолдолд тухайн даатгагчаас нөхөн төлбөрийг буцаан нэхэмжилнэ.

ТАВ. ХОЛБООНЫ ЭРХ, ҮҮРЭГ

- 5.1. Холбоо нь сангийн бүрдүүлэлт, зарцуулалттай холбоотой дараах эрхийг хэрэгжүүлнэ:
- 5.1.1. санд татан төвлөрүүлбэл зохих хөрөнгийн гүйцэтгэлийг хангуулах, хяналт тавих;
 - 5.1.2. сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүн, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх;
 - 5.1.3. жолоочийн даатгалын тухай хуулийн 20.2-т заасны дагуу олгосон нөхөн төлбөрийг буруутай этгээдээс буцаан нэхэмжлэх, шаардлагатай бол шүүхэд нэхэмжлэл гаргах;
 - 5.1.4. даатгалын нөхөн төлбөр буюу хохирлын хэмжээг тогтооход шаардлагатай мэдээллийг даатгуулагч, хохирогчоос шаардаж авах;
 - 5.1.5. жолоочийн даатгалын үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор мэдээллийн санг бүрдүүлэх, шаардлагатай арга хэмжээг санхүүжүүлэх;
 - 5.1.6. жолоочийн даатгалын тохиолдлын мэдээлэл хүлээж авах, газар дээрх үзлэг зохион байгуулах, олгосон нөхөн төлбөрийг буцаан нэхэмжлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх;
 - 5.1.7. санг бүрдүүлэх болон зам тээврийн ослыг бууруулахад чиглэсэн сургалт, сурталчилгааг зохион байгуулах, шаардлагатай судалгааны ажлыг төлөвлөж зардлыг санхүүжүүлэх;
 - 5.1.8. хууль тогтоомжид заасан бусад эрх.
- 5.2. Холбоо нь сангийн бүрдүүлэлт, зарцуулалттай холбоотой дараах үүргийг гүйцэтгэнэ:
- 5.2.1. сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаарх тайланг жил бүр гаргах;
 - 5.2.2. санд татан төвлөрүүлсэн хөрөнгийг дансанд төвлөрүүлэх;
 - 5.2.3. сангийн үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийг хууль тогтоомжийн дагуу хөтөлж, санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг Хороонд тайлагнах;
 - 5.2.4. сангийн үйл ажиллагааг олон нийтэд ил тод явуулах;
 - 5.2.5. даатгалгүй этгээдийн буруугаас бусад учруулсан даатгалын тохиолдлын үзлэг хийх, хохирлыг үнэлүүлэх, нөхөн төлбөр олгох, түүнийг буцааж нэхэмжлэх болон мэдээллийн санг бүрдүүлэн ажиллуулах, аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослыг бууруулахад чиглэгдсэн сургалт, сурталчилгаа, даатгалын сангийн нягтлан бодох бүртгэл хөтөлх зэрэг үндсэн үйл ажиллагааг санхүүжүүлэх төсвийн төслийг боловсруулж удирдах зөвлөлөөр батлуулж хэрэгжүүлэх;
 - 5.2.6. сангийн үйл ажиллагааны үр дүнгийн талаарх мэдээллийг даатгагч нарт хүргүүлэх;
 - 5.2.7. жилийн үйл ажиллагааны тайлан болон хөндлөнгийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хороонд ирүүлэх;
 - 5.2.8. сангийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг тухай бүр арилгах;
 - 5.2.9. сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор Хороонд ирүүлэх;
 - 5.2.10. жилийн эцсийн санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийлгэх бөгөөд аудит хийх компанийг даатгалын байгууллагын аудитын эрх авсан, сүүлийн 2-оос доошгүй жилд даатгалын компанид аудит хийсэн туршлагатай 3 компаниас сонгоно;
 - 5.2.11. хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

ЗУРГАА. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

- 6.1. Сангийн хөрөнгийг бүрдүүлэлт, зарцуулалтад Хороо хяналт тавьж, энэхүү журмаар тогтоосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд
2018 оны 09 сарын 06-ны өдрийн 3992 дугаарт бүртгэв.



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2018 оны 8 сарын 29 өдөр

Дугаар 271

Улаанбаатар хот

“Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын
гэрээ байгуулж чадаагүй жолооч нарыг даатгагчид
хуваарилах журам”-ыг шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Жолоочийн даатгалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээ байгуулж чадаагүй жолооч нарыг даатгагчид хуваарилах журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Тогтоол хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрөөс эхлэн Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 336 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА

С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны
2018 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн
271 дүгээр тогтоолын хавсралт

ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГЫН АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН ГЭРЭЭ БАЙГУУЛЖ ЧАДААГҮЙ ЖОЛООЧ НАРЫГ ДААТГАГЧИД ХУВААРИЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь “Олон удаагийн давтамжтай даатгалын тохиолдол гаргадаг гэсэн үндэслэлээр даатгалын гэрээ байгуулж чадаагүй автотээврийн хэрэгслийн өмчлөгч, жолооч /цаашид “жолооч” гэх/ нарыг даатгалын компани /цаашид “даатгагч” гэх/-д хуваарилах”-тай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

ХОЁР. ОЛОН УДААГИЙН ДАВТАМЖТАЙ ДААТГАЛЫН ТОХИОЛДОЛ ГАРГАДАГ ГЭСЭН ҮНДЭСЛЭЛЭЭР ДААТГАЛЫН ГЭРЭЭ БАЙГУУЛЖ ЧАДААГҮЙ ЖОЛООЧ НАРЫГ ДААТГАГЧИД ХУВААРИЛАХ

2.1. Олон удаагийн давтамжтай даатгалын тохиолдол гаргадаг гэсэн үндэслэлээр даатгагч жолоочийг даатгахаас татгалзсан нөхцөлд тухайн этгээд уг даатгагчид даатгалын гэрээний хугацааг нэг удаа сунгах санал тавих эрхтэй бөгөөд даатгагч татгалзах эрхгүй байна.

2.2. Олон удаагийн давтамжтай даатгалын тохиолдол гаргадаг гэсэн үндэслэлээр даатгагч жолоочийг албан ёсоор даатгахаас татгалзсан нөхцөлд тухайн этгээд Санхүүгийн зохицуулах хороонд энэ журмын 1 дүгээр хавсралт маягтын дагуу хүсэлт гаргана.

2.3. Даатгагч нь жолоочийг даатгахаас татгалзсан тухай мэдэгдлээ энэ журмын 2 дугаар хавсралт маягтын дагуу гаргаж Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлнэ.

2.4. Санхүүгийн зохицуулах хороо нь даатгалын гэрээ байгуулж чадаагүй жолооч нарыг даатгагч нарт тэгш хуваарилах зарчмыг баримтлах бөгөөд хуваарилахаас өмнөх жилийн эцсийн тайлангаар жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хохирол нөхөлтийн харьцаа хамгийн бага тооцогдсон даатгагчаас эхэлж сонгоно.

2.5. Санхүүгийн зохицуулах хороо нь сонгосон даатгагчид энэ журмын 3 дугаар хавсралт маягтаар мэдэгдэл хүргүүлнэ.

2.6. Энэ журмын дагуу даатгагч жолооч нартай жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээ байгуулахдаа нэмэлт нөхцөл шаардахгүй.

ГУРАВ. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

3.1. Санхүүгийн зохицуулах хороо энэхүү журмын биелэлтэд хяналт тавих бөгөөд хуваарилагдсан жолоочийг даатгахаас татгалзсан даатгагчид холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

“Даатгалын гэрээ байгуулж чадаагүй жолооч нарыг
даатгагч нарт хуваарилах журам”-ын 1 дүгээр хавсралт

**АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ ӨМЧЛӨГЧ,
ЖОЛООЧИЙГ ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГАД
ДААТГУУЛАХЫГ ХҮССЭН ӨРГӨДӨЛ**

Огноо:

Хаана: Санхүүгийн зохицуулах хороо

Засгийн газрын IY байр, Бага тойруу-3, Улаанбаатар-46, Монгол Улс

Өргөдөл гаргагч:

Хувь хүн, хуулийн этгээд /доогуур нь зурах/

/Иргэн, хуулийн этгээдийн нэр/.....нь даатгалд хамрагдах хүсэлтэй хэдий ч олон удаагийн давтамжтай даатгалын тохиолдол гаргадаг гэсэн үндэслэлээр даатгагч даатгахаас татгалзсан тул Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээ байгуулж чадаагүй жолооч нарыг даатгагчид хуваарилах журам”-ын дагуу даатгагчид хуваарилж өгнө үү.

ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ

.....

/гарын үсэг/

/овог, нэр /

Регистрийн дугаар:

Хаяг:

Тээврийн хэрэгслийн улсын дугаар:

Тээврийн хэрэгслийн марк:.....

Даатгахаас татгалзсан даатгагчийн нэр:

Өмнөх гэрээний хугацаанд гаргасан даатгалын тохиолдлын тоо:

Даатгалын нийт нөхөн төлбөрийн хэмжээ:

“Даатгалын гэрээ байгуулж чадаагүй жолооч нарыг даатгагч нарт хуваарилах журам”-ын 2 дугаар хавсралт

**ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГЫН АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛД
ДААТГАХААС ТАТГАЛЗСАН ТУХАЙ ДААТГАГЧИЙН МЭДЭГДЭЛ**

Огноо:

Хаана: Санхүүгийн зохицуулах хороо

Засгийн газрын IY байр, Бага тойруу-3, Улаанбаатар-46

Монгол Улс

Даатгалын компанийн нэр:

Манай компани нь /иргэн, хуулийн этгээд/-г олон удаагийн давтамжтай даатгалын тохиолдол гаргадаг гэсэн үндэслэлээр даатгахаас татгалзаж байгаа тул мэдэгдлийг хүлээн авна уу.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

.....

/гарын үсэг/

.....

/овог, нэр/

Даатгуулагч иргэн, хуулийн этгээдийн регистрийн дугаар:

Хаяг:

Тээврийн хэрэгслийн улсын дугаар:

Тээврийн хэрэгслийн марк:.....

Даатгахаас татгалзсан даатгагчийн нэр:

Өмнөх гэрээний хугацаанд гаргасан даатгалын тохиолдлын тоо:

Даатгалын нийт нөхөн төлбөрийн хэмжээ:

“Даатгалын гэрээ байгуулж чадаагүй жолооч нарыг
даатгагч нарт хуваарилах журам”-ын 3 дугаар хавсралт

ДААТГАГЧИЙГ СОНГОСОН ТУХАЙ МЭДЭГДЭЛ №....

Огноо:

Хаанаас: Санхүүгийн зохицуулах хороо

Засгийн газрын IY байр, Бага тойруу-3, Улаанбаатар-46, Монгол Улс

Даатгалын компанийн нэр:

Танай компанид-г Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан
“Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээ байгуулж чадаагүй жолооч нарыг
даатгагчид хуваарилах журам”-ын 2.4-т заасны дагуу даатгалд хамруулахаар хуваарилж байгаа тул
уг этгээдийг даатгахыг мэдэгдье.

..... ДАРГА
/гарын үсэг/ /овог, нэр /

Даатгуулагч иргэн, хуулийн этгээдийн регистрийн дугаар:

Хаяг:

Тээврийн хэрэгслийн улсын дугаар:

Тээврийн хэрэгслийн марк:

Даатгахаас татгалзсан даатгагчийн нэр:

Өмнөх гэрээний хугацаанд гаргасан даатгалын тохиолдлын тоо:

Даатгалын нийт нөхөн төлбөрийн хэмжээ:

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд
2019 оны 02 сарын 04-ний өдрийн 4220 дугаарт бүртгэв.



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2019 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

“Даатгалын багц дүрэм”-ийг батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.3, 6.2.4, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3, 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Даатгалын багц дүрэм”-ийг хавсралтаар баталсугай.

2. “Даатгалын багц дүрэм” хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрөөс эхлэн Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 76, 176, 187, 190, 194 дүгээр, 2008 оны 22, 66, 80, 101, 212, 270 дугаар, 2009 оны 271, 273, 276 дугаар, 2010 оны 149, 171 дүгээр, 2012 оны 03 дугаар, 2013 оны 174, 250, 410, 411 дүгээр, 2014 оны 360 дугаар, 2015 оны 407 дугаар, 2016 оны 48, 49, 50, 70, 105 дугаар тогтоолуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /М.Өлзийбат/-нд даалгасугай.

ДАРГА

С.ДАВААСҮРЭН

*Санхүүгийн зохицуулах хорооны
 2019 оны 01 дүгээр сарын 09–ний
 өдрийн 02 дугаар тогтоолын хавсралт*

Даатгалын багц дүрэм

Хавсралт 1	Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт (Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 25 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар шинэчлэн найруулсан)
Хавсралт 2	Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам
Хавсралт 3	Даатгалын нөөц сан, албан журмын даатгалын сан болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам
Хавсралт 4	Даатгалын нөөц санд болон албан журмын даатгалын санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ, түүнийг хөрөнгө оруулалтад байршуулахад тавигдах нөхцөл, шаардлага
Хавсралт 5	Даатгалын хэмжээ, даатгалын хураамжийн хэмжээг тооцох аргачлал
Хавсралт 6	Даатгалын үнэлгээ хийх аргачлал
Хавсралт 7	Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчийн аудиторт тавигдах нөхцөл, шаардлага
Хавсралт 8	Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох, актуарын стандарт, үнэлгээ болон актуарчийн хяналт шалгалт хийх, тайлан гаргах журам
Хавсралт 9	Гадаад улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа явуулах даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах нөхцөл, шаардлага
Хавсралт 10	Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа явуулах гадаадын даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах нөхцөл, шаардлага
Хавсралт 11	Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн тайлан, мэдээ гаргах, санхүүгийн тайлангийн агуулга, маягтыг тогтоох журам
Хавсралт 12	Даатгагчаас үйл ажиллагааныхаа тодорхой хэсгийг бусдад шилжүүлэх болон нэгтгэх үед гаргах өргөдлийг хянан шийдвэрлэх журам
Хавсралт 13	Даатгагчийн давхар даатгалын төлөвлөгөөнд тавигдах шаардлага (Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 25 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар шинэчлэн найруулсан)
Хавсралт 14	Дампуурлын тухай хууль, Компанийн тухай хуулиас гадуур даатгагчийг татан буулгах, дахин хөрөнгөжүүлэх үйл ажиллагааг явуулах журам
Хавсралт 15	Даатгагчийн үйл ажиллагааг түр зогсоох нөхцөл
Хавсралт 16	Даатгалтай холбоотой үйл ажиллагааг тодорхойлох заавар
Хавсралт 17	Даатгалын тухай хуульд заасан мэдээллийг хэвлэн нийтлэх журам
Хавсралт 18	Тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт (Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 25 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар нэмсэн)

Санхүүгийн зохицуулах хорооны
2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн
25 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

“Даатгалын багц дүрэм”-ийн
нэгдүгээр хавсралт

ДААТГАГЧ БОЛОН ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ДАГАЖ МӨРДӨХ ҮЗҮҮЛЭЛТ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох, түүнд хяналт тавихтай холбоотой үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч нь Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хууль, Компанийн тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон бусад хууль тогтоомж, Хороо болон бусад холбогдох байгууллагаас баталсан дүрэм, журам, заавар, аргачлалыг үйл ажиллагаандаа дагаж мөрдөж ажиллана.

ХОЁР. ДААТГАГЧ БОЛОН ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ НИЙТЛЭГ ШААРДЛАГА

2.1. Даатгагчийн дүрмийн сан (хувь нийлүүлсэн хөрөнгө)-гийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай бүр Хороонд мэдэгдэх ба Даатгагчийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг бусдад худалдах, шилжүүлэх, өмчлөх, барьцаалахад дараах шаардлага тавигдах ба өөрчлөлт оруулах тухай бүр Хорооноос зөвшөөрөл авна. Үүнд:

2.1.1. даатгагчийн дүрмийн сан (хувь нийлүүлсэн хөрөнгө)-д оруулах мөнгөн хөрөнгө нь хууль ёсны орлогын эх үүсвэрээс бүрдсэн байх;

2.1.2. хувьцаа эзэмшигч этгээд нь Хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох шалгуурыг хангасан байна.

2.2. Даатгагч нь жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэхэд дараах шаардлага тавигдах ба Хорооноос зөвшөөрөл авна. Үүнд:

2.2.1. жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаанд ашиглах программ хангамж, мэдээллийн сангийн бүртгэл хөтлөх боловсон хүчинтэй байх;

2.2.2. даатгагч нь даатгалын тохиолдлыг шалгах шуурхай албыг ажиллуулах нөхцөлийг бүрдүүлсэн байх эсвэл цахимаар даатгалын тохиолдлын талаарх мэдээллийг хүлээн авах, мэдээллийн аюулгүй байдал, үйлчлүүлэгчид зөвлөгөө өгөх дэвшилтэт технологийн шийдэлтэй байна.

2.3. Энэ журмын 2.1-2.2-д заасан зөвшөөрлийн хүсэлтийг энэ журмын 3 дугаар хавсралтад заасан заавар болон СЗХ04003 маягтын дагуу гаргаж, энэ журмын 2 дугаар хавсралт (А, Б)-д дурдсан баримт бичгийн бүрдлийг хавсарган Хороонд ирүүлнэ.

- 2.4.Хороо энэ журмын 2.1-2.2-д заасан зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хянаж, зөвшөөрөл олгох эсэх асуудлыг баримт бичгийн бүрдэл хангагдсан өдрөөс хойш ажлын 30 өдрийн дотор шийдвэрлэнэ.
- 2.5.Хороо энэ журмын 2.5 дахь заасан мэдээллийг Хорооны цахим хуудаст байршуулж нийтэд мэдээлнэ.
- 2.6.Даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийн дүрмийн сан (хувь нийлүүлсэн хөрөнгө)-гийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай бүр Хороонд мэдэгдэж, бүртгүүлэх бөгөөд дараах шаардлага тавигдана. Үүнд:
- 2.6.1.дүрмийн сан (хувь нийлүүлсэн хөрөнгө)-д оруулах мөнгөн хөрөнгө нь хууль ёсны орлогын эх үүсвэрээс бүрдсэн байх;
 - 2.6.2.хувьцаа эзэмшигч этгээд нь Хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох шалгуурыг хангасан байна.
- 2.7.Даатгагч, даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч нь Хорооноос бичгээр өгсөн зөвшөөрлийг үндэслэн компанийн эрх бүхий албан тушаалтныг томилно. Даатгагч, даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийн томилсон эрх бүхий албан тушаалтныг Хороонд бүртгүүлнэ. Эрх бүхий албан тушаалтан нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- 2.7.1.эрх бүхий албан тушаалтан нь Хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох шалгуурыг хангасан байх;
 - 2.7.2.төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ, сертификат авсан байна.
- 2.8.Даатгагч, даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч нь эрхэлж буй сайн дурын даатгалын хэлбэрийн хүрээнд мэргэшсэн боловсон хүчинтэй байх ба эрхлэх сайн дурын даатгалын хэлбэрийг Хороонд бүртгүүлнэ.
- 2.9.Даатгалын зуучлагч нь давхар даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэхэд дараах шаардлага тавигдах ба тус үйл ажиллагааг эрхлэхээс өмнө Хороонд бүртгүүлнэ. Үүнд:
- 2.9.1.энэ журмын 4.1-4.2 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан байх;
 - 2.9.2.даатгалын андеррайтингийн чиглэлээр 1-ээс доошгүй жил ажилласан туршлагатай давхар даатгалын мэргэшсэн ажилтантай байна.
- 2.10.Даатгагч, даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч компанийн оноосон нэрийг өөрчлөх тохиолдолд Хороонд бүртгүүлнэ.
- 2.11.Энэ журмын 2.6-2.10 дэх хэсэгт заасан бүртгэлийн хүсэлтийг энэ журмын 3 дугаар хавсралтад заасан заавар болон СЗХ04004 маягтын дагуу гаргаж,энэ журмын2 дугаар хавсралт (В, Г, Д, Е, Ё)-д дурдсан баримт бичгийн бүрдлийг хавсарган Хороонд ирүүлнэ.
- 2.12.Хороо энэ журмын 2.6-2.10 дэх хэсэгт заасан бүртгэлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хянаж, баримт бичгийн бүрдэл хангагдсан өдрөөс хойш ажлын 20 өдрийн дотор бүртгэнэ.
- 2.13.Хороо энэ журмын 2.12 дахь хэсэгт заасан бүртгүүлэх хүсэлтийг хянаад, энэ талаар Хорооны цахим хуудсанд байршуулснаар бүртгэгдсэнд тооцно.
- 2.14.Хороо энэ журмын 2.1-2.2-д заасан зөвшөөрөл, 2.6-2.10 дэх хэсэгт заасан бүртгэлийн хүсэлтийг хянан шийдвэрлэх явцад даатгагч, даатгалын зуучлагч, хохирол үнэлэгчийн үйл ажиллагааны онцлогтой нь холбогдуулан нарийвчилсан нэмэлт тайлбар, тодруулга болон баримт бичиг ирүүлэхийг шаардаж болно.
- 2.15.Энэ журмын зөвшөөрөл олгох болон бүртгүүлэх үйл ажиллагаа нь энэ журам, холбогдох бусад

хууль тогтоомжийн шаардлагыг хангаагүй, хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь нотлогдсон, мөн зөвшөөрөл, бүртгэл хүсэж ирүүлсэн баримт бичгийг энэхүү журмын шаардлагад нийцүүлж бүрдүүлэх хугацаа нь хүсэлт гаргасан өдрөөс хойш 3 сарын хугацаа өнгөрсөн бол холбогдох зөвшөөрөл олгох болон бүртгэхээс татгалзах бөгөөд энэ тухай үндэслэл бүхий тайлбарыг хүсэлт гаргагчид албан бичгээр мэдэгдэнэ.

2.16. Даатгагч, даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийн хаягийн өөрчлөлт, салбар, төлөөлөгчийн газар нээх, татан буулгах, өөрчлөн байгуулах болон салбар, төлөөлөгчийн газрын удирдлага, ажлын байрны хаяг өөрчлөгдөх тухай бүр энэ журмын 3 дугаар хавсралтад заасан зааврын дагуу СЗХ04007 мэдэгдлийн маягыг бөглөж, энэ журмын 2 дугаар хавсралт (Ж)-д дурдсан баримт бичгийн бүрдлийг хавсарган Хороонд цахимаар мэдэгдэх ба Хороо өөрчлөлтийг өөрийн цахим хуудсанд байршуулна.

2.17. Хороо энэ журмын 2.16 дахь хэсэгт заасан өөрчлөлтийг өөрийн цахим хуудаст байршуулснаар өөрчлөлтийг бүртгэгдсэнд тооцно.

2.18. Даатгагч нь даатгалын бүтээгдэхүүнийг шинээр болон нөхцөл шаардлагыг шинэчлэн зах зээлд борлуулахаас өмнө тухай бүр энэ журмын 3 дугаар хавсралтад заасан зааврын дагуу СЗХ04008 мэдэгдлийн маягыг бөглөж, энэ журмын 2 дугаар хавсралт (З)-д дурдсан баримт бичгийн бүрдлийг хавсарган Хороонд цахимаар мэдэгдэх ба тус бүтээгдэхүүний мэдээллийг Хороо өөрийн цахим хуудсанд байршуулсны дараа бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулна. Хороо нь даатгалын бүтээгдэхүүний онцлог цар хүрээнээс хамааран тусгайлсан шаардлага тавьж болно.

2.19. Хороо нь даатгагчийн даатгалын бүтээгдэхүүнийг даатгагчийн төлбөрийн чадвар, нийтийн болон даатгуулагчийн ашиг сонирхолд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй гэж үзвэл, мөн даатгагч, даатгалын зуучлагч, хохирол үнэлэгчийн салбар, төлөөлөгчийн газар нь энэ журмын холбогдох шаардлага болон бусад хууль, тогтоомжийн шаардлагыг хангаж ажиллаагүй бол Хорооны цахим хуудаснаас хасаж олон нийтэд мэдээлэх ба энэ талаар тухайн этгээдэд албан бичгээр болон цахимаар мэдэгдэнэ.

2.20. Хороонд бүртгэгдсэн үйл ажиллагаа нь энэ журмын холбогдох шаардлага болон бусад хууль, тогтоомжийн шаардлагыг хангаж ажиллаагүй бол уг үйл ажиллагааг бүртгэлээс хасаж энэ тухай үндэслэл бүхий тайлбарыг тухайн этгээдэд албан бичгээр мэдэгдэнэ.

ГУРАВ. ДААТГАГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ДАГАЖ МӨРДӨХ ҮЗҮҮЛЭЛТ

3.1. Даатгагч нь дараах зарчим, нөхцөл, шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 3.1.1. Компанийн үйл ажиллагааг хэвийн явуулах материаллаг нөхцөлийг бүрдүүлсэн байх;
- 3.1.2. Даатгагчийн үйл ажиллагааг шударга, зохистой явуулах нөхцөлийг бүрдүүлсэн байх;
- 3.1.3. Зохистой засаглалын зарчим, эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлсэн байх;
- 3.1.4. Хүний нөөц, боловсон хүчнийг мэргэшүүлэх, тэдгээрийн ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байх;
- 3.1.5. Мэдээллийн үнэн бодит, ил тод байдлыг хангах;
- 3.1.6. Холбогдох байгууллага болон даатгуулагч, хэрэглэгчдийг мэдээллээр хангах.

3.2. Компанийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд дараах шаардлагыг хангаж ажиллана. Үүнд:

- 3.2.1. байнгын ажлын байртай байх;
- 3.2.2. шаардлагатай техник тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан байх;
- 3.2.3. санхүү, даатгал, бүртгэлийн программ хангамжтай байх;

3.2.4. даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгосон компанийн нэртэй ижил нэр, лого, хэвлэмэл хуудас, даатгалын гэрээ, даатгалын гэрээний баталгаа зэргийг ашиглахгүй байх;

3.2.5. компаниас гарсан шийдвэр болон компанийн өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөх дотоод журам, заавар, нягтлан бодох бүртгэлийн, даатгалын баримт бичгийг архивлан хадгална.

3.3. Даатгагчийн үйл ажиллагааг шударга, зохистой явуулах нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд дараах шаардлагыг хангаж ажиллана. Үүнд:

3.3.1. Хорооноос баталсан даатгалын зах зээлд оролцогчдын ёс зүйн журмын хэрэгжилтийг хангаж, мөрдөж ажиллах;

3.3.2. Энэ журамд заасан даатгалын бүтээгдэхүүнд тавигдах шаардлагыг хангасан, үйлчлүүлэгч, даатгуулагчийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн, судалгаа, хөгжүүлэлт, актуар тооцоолол, хяналтын үйл ажиллагааг нарийвчлан тусгасан даатгалын бүтээгдэхүүн боловсруулах журмын дагуу боловсруулсан болон Хорооны цахим хуудсанд мэдээлэл нь байршсан даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулах;

3.3.3. Компанийн гэрээ байгуулан хамтран ажиллаж буй даатгалын мэргэжлийн оролцогч нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй бол Хороонд мэдэгдэж, хамтран ажиллахаас татгалзах;

3.3.4. давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан компани нь зөвхөн тухайн үйл ажиллагааг дагнан эрхэлнэ.

3.4. Зохистой засаглалын зарчим, эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх хүрээнд дараах шаардлагыг хангаж ажиллана. Үүнд:

3.4.1. даатгагчийн бүтцэд төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, эрсдэлийн удирдлагын нэгж, үйлчлүүлэгчийн өргөдөл, гомдлыг барагдуулах эрх ашгийг хамгаалдаг нэгжтэй байх эсхүл тэдгээрийн чиг үүргийг хэрэгжүүлэх нэгжүүдийг байгуулж, нэгжүүд нь өөр хоорондоо хараат бус хяналт тавих тогтолцоог бүрдүүлсэн байна.

3.4.2. нийт таваас доошгүй гишүүн бүхий төлөөлөн удирдах зөвлөл /цаашид ТУЗ гэх/-тэй байх, тэдгээрийн нэгээс доошгүй нь хараат бус гишүүн байх ба ТУЗ нь Компанийн тухай хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллана:

3.4.2.1. даатгагчийн гүйцэтгэх удирдлагад хяналт тавих, түүний ажлын үр дүнгийн тайланг улиралд нэгээс доошгүй удаа авч хэлэлцэх, хувьцаа эзэмшигчдэд эрх тэгш хандах;

3.4.2.2. даатгагчийн тогтвортой үйл ажиллагаа, урт хугацааны зорилттой уялдсан байгууллагын бизнесийн зорилго, түүнд хүрэх бодлого стратеги болон эрсдэлийн удирдлага, дотоод аудит, хяналтын загвар бүтцийг тогтоох;

3.4.2.3. даатгагчийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагнал, эрсдэлийн удирдлага, санхүүгийн болон үйл ажиллагааны хяналт, хууль тогтоомжийн хэрэгжилт, даатгагчийн бүтцийн өөрчлөлт зэрэг гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих;

3.4.2.4. Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын стандартын шаардлагыг хангасан байгууллагыг сонгон шалгаруулж, хөндлөнгийн аудит хийлгэх;

3.4.2.5. даатгагчийн дотоод аудитын асуудал эрхэлсэн нэгжээс хийсэн шалгалтын акт материал, ажлын тайлан зэргийг тухай бүр авч хэлэлцэн, зохистой засаглал болон дотоод хяналтын тогтолцоог сайжруулах талаар Гүйцэтгэх удирдлагад үүрэг даалгавар өгөх, тэдгээрийн хэрэгжилт, авсан арга хэмжээг үнэлэх;

3.4.2.6. Хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс”-ын зарчимд нийцүүлэн дараах бодлогын баримт бичиг, дүрэм, журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллана:

3.4.2.6.а. ТУЗ-ийн үйл ажиллагааны үлгэрчилсэн журам;

3.4.2.6.б. ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн, тэдгээрийн ажиллах журмыг батлах

3.4.2.6.в. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх тэмцэхэд чиглэсэн дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр ;

3.4.2.6.г. гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны ерөнхий заавар ;

3.4.2.6.д. дотоод хяналтын бодлого ;

3.4.2.6.е. ёс зүйн дүрэм ;

3.4.2.6.ё. Хүний нөөцийг хөгжүүлэх бодлого ;

3.4.2.6.ж. Хорооноос шаардсан бусад.

3.4.3. даатгагчийн гүйцэтгэх удирдлага нь Компанийн тухай хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллана:

3.4.3.1. даатгагчийн стратеги төлөвлөгөө, бизнес төлөвлөгөө, жилийн төсөв, бүтэц зохион байгуулалт болон үйл ажиллагаанд мөрдөж ажиллах бодлого, дүрэм, журам, зааврыг боловсруулж, ТУЗ-өөр батлуулах ба дараах журам, бодлогыг заавал боловсруулсан байна. Үүнд:

3.4.3.1.а. үйлчлүүлэгч, даатгуулагчийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн, судалгаа, хөгжүүлэлт, актуар тооцоолол, дотоод хяналтын үйл ажиллагааг нарийвчлан тусгасан даатгалын бүтээгдэхүүн боловсруулах журам ;

3.4.3.1.б. технологид суурилсан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загварыг хөгжүүлэх бодлого, журам ;

3.4.3.1.в. компанийн хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөгөө ;

3.4.3.1.г. Хорооноос шаардсан бусад.

3.4.3.2. ТУЗ-өөс баталсан төлөвлөгөө, бодлого, дүрэм, журам, заавар, стандарт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, мөрдүүлэх;

3.4.3.3. компанийн ажилтныг албан үүргээ сонирхлын зөрчилгүйгээр гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэх, ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй гэж үзвэл гүйцэтгэх удирдлагад бичгээр мэдэгдэх тогтолцоог бүрдүүлэх;

3.4.3.4. даатгагчийн эрсдэлийн удирдлагыг хангах талаар тогтоосон хязгаарлалт, Хорооноос тогтоосон төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт алдагдсан тохиолдолд зохих арга, хэмжээг авч хэрэгжүүлэх;

3.4.3.5. даатгагчийн үйл ажиллагааны онцлог болон учирч болзошгүй эрсдэлийн түвшинтэй уялдуулан удирдлагын мэдээллийн системийн үйл ажиллагаа болон түүний аюулгүй байдлыг хангах хяналтын тогтолцоог бүрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

3.4.3.6. даатгагчийн хувьцаа эзэмшигч болон ТУЗ-өөс гаргасан шийдвэр нь хууль тогтоомжийг зөрчих, даатгагчийн үйл ажиллагаанд ноцтой эрсдэл учруулах магадлалтай бол уг үүргийг биелүүлэхээс татгалзах бөгөөд энэ талаар Хороонд мэдэгдэх;

3.4.3.7. үйлчлүүлэгч, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог бүрдүүлж,

хэрэгжилтэд хяналт тавих ба өргөдөл, гомдлыг цаг тухай бүрд зөв шударгаар шийдвэрлэх хариуцлага хүлээнэ.

3.4.4. ТУЗ, гүйцэтгэх удирдлага нь эрсдэлийн удирдлагын нэгжийг бие даасан хэлбэрээр зохион байгуулж, даатгагчид учирч болох эрсдэлийг удирдах, хянах тогтолцоог бүрдүүлэх ба эрсдэлийн удирдлагын нэгжийн ажилтны эрх үүрэг, шийдвэр гаргах эрх мэдэл, хариуцлагын тогтолцоо болон тайлагнах зарчмыг нарийвчлан тогтоосон байна.

3.4.5. Эрсдэлийн удирдлагын нэгж нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллана:

3.4.5.1. даатгагчид учирч болох эрсдэлийг нээн илрүүлэхэд шаардагдах зохих эрх мэдэл, даатгагчийн дотоод мэдээллийн систем дахь бүх мэдээлэлд нэвтрэх эрх, хангалттай тооны боловсон хүчин, төсөв хөрөнгө, техник хангамж, нөөцтэй байх ба үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээллээр хангагдсан байна.

3.4.5.2. даатгагчийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо, түүний хэрэгжилт болон эрсдэлийн ерөнхий түвшний талаар ТУЗ-ийн дэргэдэх эрсдэлийн хороонд тодорхой хугацаанд давтамжтайгаар тайлагнана.

3.4.5.3. эрсдэлийн удирдлагын нэгжийн удирдах албан тушаалтан тухайн эрсдэлийн даатгагчид учруулах үр дагаврыг үнэлэх, дүгнэх чадвартай байна.

3.4.5.4. учирч болох эрсдэлийг компанийн нэгдэл, охин, хараат компаниуд, салбар нэгж, даатгагчийн үйл ажиллагааны чиглэл, бүтээгдэхүүн тус бүрээр болон нэгдсэн байдлаар тогтоож, дүн шинжилгээ хийнэ.

3.5. Хүний нөөц, боловсон хүчнийг мэргэшүүлэх, тэдгээрийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд дараах шаардлагыг хангаж ажиллана. Үүнд:

3.5.1. Хорооноос актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх авсан актуарчтай байх ба актуарчийн үйл ажиллагааг эрхлэх, хяналт тавих эрх үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байх;

3.5.2. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, холбогдох журмын хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий албан тушаалтантай байх;

3.5.3. Эрхэлж буй даатгалын хэлбэрийн мэргэшсэн боловсон хүчинтэй байх;

3.5.4. Ажилтнуудаа мэргэшүүлэх талаар сургалтын хөтөлбөр, бодлоготой байх;

3.5.5. Даатгагчийн орон тооны ажилтан, эрх бүхий ажилтан нь даатгалын мэргэжлийн оролцогчийн орон тооны ажилтан, эрх бүхий ажилтнаар ажиллахгүй байх;

3.5.6. Хорооноос шаардсан бусад.

3.6. Мэдээллийн үнэн бодит, ил тод байдлыг хангах хүрээнд дараах шаардлага тавигдана. Үүнд:

3.6.1. даатгалын бүтээгдэхүүн, түүний боловсруулалт, хөгжүүлэлтийн үйл явцад ашигласан болон учирч болзошгүй эрсдэл тус бүрээр актуарын тооцоололд шаардагдах нарийвчилсан мэдээлэл, даатгуулагч, даатгалын гэрээ, зүйл, даатгалын зах зээлд холбогдох бусад мэдээллийг агуулсан мэдээллийн санг үүсгэн, тогтмол баяжуулж ажиллана.

3.6.2. даатгагч нь төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани, хувьцаат компани, гадаадын хөрөнгө оруулалттай компанитай гэрээ байгуулсных нь төлөө даатгалын төлөөлөгчид олгосон төлбөр хөлс, даатгуулагч, даатгалын гэрээний талаарх мэдээллийг улирал бүр өөрийн цахим хуудсанд олон нийтэд ил тод зарлан мэдээлнэ.

3.6.3. даатгагч нь даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхэлсэн хөлс төлбөрийг арилжааны банк дахь даатгалын төлөөлөгчийн дансанд бэлэн бусаар шилжүүлэн олгоно.

3.6.4. Даатгагч нь дараах мэдээллийг заавал агуулсан өөрийн цахим хуудастай байна:

3.6.4.1. Компанийн ерөнхий мэдээлэл /Танилцуулга, үйл ажиллагааны чиглэл, бүтэц

зохион байгуулалт, компанийн энгийн хувьцааны 10-с дээш хувийг эзэмшигчид, жилийн үйл ажиллагааны тайлан, эзэмшиж байгаа хөрөнгийн бүртгэл/

3.6.4.2. Удирдлага /Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий албан тушаалтан/

3.6.4.3. Санхүүгийн мэдээлэл /Санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, ногдол ашиг, даатгалын хураамжийн нийт орлого, нийт нөхөн төлбөр олголт/

3.6.4.4. Өргөдөл гомдол шийдвэрлэлт /Ирүүлсэн өргөдөл гомдол, шийдвэрлэсэн өргөдөл гомдол, өргөдөл гомдолтой холбоотой Хорооны шийдвэрийн хэрэгжилт/

3.6.4.5. Даатгалын бүтээгдэхүүн, цахим даатгалын бүтээгдэхүүний дэлгэрэнгүй танилцуулга /даатгалын эрсдэл, хураамж, үнэлгээ, нөхөн төлбөр, нөхөн төлбөр олгох олгохгүй нөхцөл зэргийг тусгасан/

3.6.4.6. Даатгагчийн ерөнхий захиргаа болон салбарын хаяг, холбоо барих утас, цахим шуудан

3.6.4.7. Өргөдөл, гомдол хүлээн авах нэгжийн холбоо барих утас, цахим шуудан

3.7. Холбогдох байгууллага болон даатгуулагч, хэрэглэгчдийг мэдээллээр хангах хүрээнд дараах шаардлагыг хангаж ажиллана. Үүнд:

3.7.1. даатгалын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг Хороонд тогтоосон хугацаанд ирүүлэх ба шаардлагатай тохиолдолд Хороо нь нэмэлт, нарийвчилсан мэдээллийг авч болно.

3.7.2. энэ журмын 3.6.1-д заасан мэдээллийн сангаас Хороо шаардсан тохиолдолд холбогдох мэдээллийг тухай бүр шаардсан хугацаанд ирүүлнэ.

3.7.3. даатгагч нь даатгалын залилангийн эсрэг авч хэрэгжүүлэх бодлоготой байх ба даатгалын залилангийн бүртгэлийг хөтөлж, Хорооноос шаардсан хугацаанд тухай бүр ирүүлнэ.

3.7.4. үйлчлүүлэгч, даатгуулагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн болон нөхөн төлбөр шийдвэрлэлтийн тайлан мэдээг улирал бүрийн санхүүгийн тайлангийн хамт Хороонд ирүүлнэ.

3.7.5. даатгуулагчийг энэ журмын 7 дугаар бүлэгт заасан холбогдох мэдээллээр хангаж ажиллана.

3.8. Даатгагчийн салбар нь дараах шаардлагыг хангасан байна:

3.8.1. энэ журмын 2.17-т заасны дагуу Хорооны цахим хуудсанд холбогдох мэдээлэл нь байршсан байх;

3.8.2. зөвхөн тухайн байгууллагын оноосон нэрийг хэрэглэх ба салбарын үйл ажиллагааг зохицуулах журамтай байх;

3.8.3. тодорхой хэмжээний даатгалын нөхөн төлбөрийг бие даан шуурхай шийдвэрлэдэг байх бөгөөд нөхөн төлбөр олгохтой холбогдох үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих дотоод журамтай байх;

3.8.4. санхүүгийн болон даатгалын анхан шатны баримтууд, хохирлын нөхөн төлбөрийн материалууд, мөн салбарын үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийг архивлан хадгалдаг байх;

3.8.5. үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэрийн хязгаарлалтаа тодорхойлсон, хаяг, байршил нь тодорхой, байнгын ажлын байртай байх;

3.8.6. удирдлага, ажилтан, гэрээт ажилтан нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан “нийтийн албан тушаалтан” биш байх;

- 3.8.7.үйл ажиллагааг хэвийн явуулах тоног төхөөрөмж, программ хангамжтай байх;
- 3.8.8.нэгж нь компанийн ерөнхий захиргаа болон бусад нэгжүүдтэйгээ мэдээллийн нэгдсэн нэг сүлжээнд холбогдож, мэдээлэл, тайлагнал дамжуулдаг байх;
- 3.8.9.тухайн нутаг дэвсгэрт салбар нээн ажиллуулахтай холбогдсон зах зээлийн судалгаатай байх;
- 3.8.10.эрхлэх даатгалын ангилал, төрөл, хэлбэрийг тодорхой тусгасан, салбарындотоод хяналт болон бусад үйл ажиллагааг зохицуулах журамтай байх;
- 3.8.11.арилжааны банкны салбарт данстай байх;
- 3.8.12.жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд шуурхай албыг ажиллуулах нөхцөлийг бүрдүүлсэн байх ба зам тээврийн ослын хохирлын хэмжээг газар дээр нь очиж тогтоох зориулалтын автомашинтай, түүнчлэн даатгалын тохиолдлын талаарх мэдээллийг программ хангамж ашиглан цуглуулах, нөхөн төлбөртэй холбоотой баримт бичгийг цахимаар авах боломжийг бүрдүүлж ажиллах ба даатгалын тохиолдлын талаарх мэдээлэл оруулж хадгалах, шаардлагатай мэдээг мэдээллийн санд өгч нэгтгүүлэх интернэтэд холбогдсон, программ хангамжтай байх;
- 3.8.13.шуурхай албаны үйл ажиллагааг Албан журмын даатгагчдын холбоо эсхүл дээрх шаардлагыг хангасан шуурхай албаны үйлчилгээг үзүүлдэг байгууллагатай гэрээ байгуулан гүйцэтгүүлж болно. Даатгагчтай гэрээ байгуулсан шуурхай албаны үүрэг гүйцэтгэгч байгууллага нь энэ журмын 3.18.12-д заасан шаардлагыг хангасан байх;
- 3.8.14.даатгагчийн салбар нь “Даатгалын багц дүрэм”-ийн 11 дүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчоос тайлан, мэдээ, өргөдөл гаргах заавар”-ын дагуу гаргасан тайлан мэдээг улирал бүр Санхүүгийн зохицуулах хорооны аймаг, нийслэл, дүүрэг дэх орон нутгийн төлөөлөгчид хүргүүлж байна.

3.9.Даатгагчийн төлөөлөгчийн газар нь дараах шаардлагыг хангасан байна:

- 3.9.1.энэ журмын 2.17-т заасны дагуу Хорооны цахим хуудсанд холбогдох мэдээлэл нь байршсан байх;
- 3.9.2.төлөөлөгчийн газрын үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийг архивлан хадгалдаг байх;
- 3.9.3.үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэрийн хязгаарлалтаа тодорхойлсон, хаяг, байршил нь тодорхой, байнгын ажлын байртай байх;
- 3.9.4.үйл ажиллагааг хэвийн явуулах тоног төхөөрөмж, программ хангамжтай байх;
- 3.9.5.нэгж нь компанийн ерөнхий захиргаа болон бусад нэгжүүдтэйгээ мэдээллийн нэгдсэн нэг сүлжээнд холбогдож, мэдээлэл, тайлагнал дамжуулдаг байх;
- 3.9.6.даатгагчийн төлөөлөгчийн газар нь Компанийн тухай хуулийн 7.2-т зааснаас бусад үйл ажиллагааг эрхлэхгүй.

ДӨРӨВ. ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ДАГАЖ МӨРДӨХ ҮЗҮҮЛЭЛТ

- 4.1.Ердийн болон урт хугацааны даатгалын зуучлагчийн дүрмийн сангийн мөнгөн хөрөнгийн доод хэмжээ нь 20.0 /хорин/ сая төгрөг, давхар даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд 70.0 /далан/ сая төгрөг байна.
- 4.2.Жил бүр мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулсан байх ба мэргэжлийн хариуцлагын даатгалын үнэлгээний доод хязгаар нь 100.0 /нэг зуун/ сая төгрөг, давхар даатгалын зуучлагчийн

үйл ажиллагаа эрхлэх бол 200.0 /хоёр зуун/ сая төгрөг байна.

4.3. Даатгалын зуучлагчийн үйл ажиллагааг хэвийн явуулахтай холбогдох дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

4.3.1. хаяг байршил нь тодорхой, байнгын ажлын байртай байх;

4.3.2. хоёроос доошгүй орон тооны ажилтантай байх;

4.3.3. компанийн үйл ажиллагааг хэвийн явуулах техник тоног төхөөрөмжтэй байх;

4.3.4. компанийн нягтлан бодох бүртгэл хөтлөх болон санхүүгийн тайлан тодруулга гаргах нягтлан бодогчтой байх ба нягтлан бодогч өөрчлөгдсөн тохиолдолд ажлын 5 өдрийн дотор Хороонд мэдэгдэх;

4.3.5. компаниас гаргасан шийдвэр болон компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөх дотоод дүрэм, журам, заавар, эрх зүйн баримт бичгийг архивлан хадгалах;

4.3.6. Зуучилсан даатгалын гэрээний дэлгэрэнгүй бүртгэлийг тухай бүр хөтөлж, харилцагч, үйлчлүүлэгчийн мэдээллийн сан үүсгэх;

4.3.7. Даатгалын зуучлалын гэрээ болон хамтран ажиллах гэрээг монгол хэл дээр үйлдэх, эсхүл монгол хэл дээр хөрвүүлсэн байх, мөн тэдгээрийг архивлан хадгалсан байна.

4.3.8. Даатгалын зуучлагчийн бүтэц зохион байгуулалт, удирдлага, хүний нөөцийн бодлоготой холбогдох дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

4.3.8.а. компанийн хувьцаа эзэмшигчид нь өөр аль нэг даатгалын байгууллагын ТУЗ-ийн дарга, гишүүн, хамтын гүйцэтгэх удирдлагын гишүүн, эрх бүхий албан тушаалд томилогдон ажиллаагүй байх;

4.3.8.б. ажилтнуудаа мэргэшүүлэх талаар сургалтын хөтөлбөр, бодлоготой байх ба Хороо, холбогдох мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулсан даатгалын зуучлагчийн сургалтад 2 жил тутамд хамруулсан байна.

4.4. Даатгалын зуучлагчийн үйл ажиллагааг шударга, ил тод явуулахтай холбогдох дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

4.4.1. Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 26.1 дэх хэсэгт заасны дагуу даатгалын хураамжийн орлогыг дамжуулан шилжүүлэх тохиолдолд зуучилсан даатгалын хураамжийн орлогыг компанийн бусад орлогоос тусдаа дансанд төвлөрүүлэх бөгөөд уг орлогыг холбогдох гэрээнд заасан хугацааны дотор даатгагчид шилжүүлэх;

4.4.2. Даатгалын мэргэжлийн оролцогчийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс багассан тохиолдолд Компанийн тухай хуулийн 31.3-т “Тухайн жилийн санхүүгийн тайлангаар компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс багассан тохиолдолд уг тайлан гарснаас хойш ажлын 10 өдрийн дотор төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлаж, хувь нийлүүлсэн хөрөнгөнд өөрчлөлт оруулах, компанийг дахин хөрөнгөжүүлэх, эсхүл татан буулгах асуудлыг шийдвэрлүүлэх үүрэгтэй.” гэж заасны дагуу шийдвэрлэнэ;

4.4.3. Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдлийн хэмжээ нийт активын 5 хувиас хэтрэхгүй байх;

4.4.4. Зуучилсан даатгалын гэрээнд даатгалын зуучлагч гарын үсэг зурж, тэмдэг дарсан байх;

4.4.5. Даатгалын зуучлагч нь даатгуулагчид даатгалын нөхөн төлбөрийн асуудлаар зөвлөгөө туслалцаа үзүүлж болох бөгөөд ийнхүү туслалцаа үзүүлсний хөлсийг даатгагчаас олгох даатгалын нөхөн төлбөрөөс суутган авахгүй байх;

4.4.6. Даатгалын зуучлагч нь Хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс”-ын зарчмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана;

4.4.7.даатгалын гэрээ байгуулахаас өмнө дараах мэдээллийг даатгалын зуучлагч нь үйлчлүүлэгчид өгсөн байна:

4.4.7.а. өөрийн компанийн мэдээлэл; /Тухайлбал: даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, улсын бүртгэлийн гэрчилгээ гэх мэт/

4.4.7.б. үйл ажиллагааны төрөл, чиглэл;

4.4.7.в. хамтран ажиллаж буй даатгалын компаниудын талаар мэдээлэл.

4.5.Даатгалын зуучлагчийн салбар, төлөөлөгчийн газар нь дараах шаардлагыг хангасан байна:

4.5.1.энэ журмын 2.17-т заасны дагуу Хорооны цахим хуудсанд холбогдох мэдээлэл нь байршсан байх;

4.5.2.үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэрийн хязгаарлалтаа тодорхойлсон, хаяг, байршил нь тодорхой, байнгын ажлын байртай байх;

4.5.3.салбарын удирдлага, ажилтан, гэрээт ажилтнаар ажиллах этгээд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтад заасан “нийтийн албан тушаалтан” биш байх;

4.5.4.үйл ажиллагааг хэвийн явуулах тоног төхөөрөмж, программ хангамжтай байх;

4.5.5.нэгж нь компанийн ерөнхий захиргаа болон бусад нэгжүүдтэйгээ мэдээллийн нэгдсэн нэг сүлжээнд холбогдож, мэдээлэл, тайлагнал дамжуулдаг байх;

4.5.6.эрхлэх даатгалын ангилал, төрөл, хэлбэрийг тодорхой тусгасан, салбарын дотоод хяналт болон бусад үйл ажиллагааг зохицуулах журамтай байх;

4.5.7.Хороо холбогдох мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулсан даатгалын зуучлагчийн сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэн 1-ээс доошгүй ажилтантай байх.

4.6.Даатгалын зуучлагч нь банк бол энэ журмын 4.1-4.4-т заасан шаардлагаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

4.6.1.банкны бүтцэд даатгалын зуучлагчийн үйл ажиллагааг хариуцах тусгайлсан нэгжтэй байх ба даатгалын салбарт ажиллаж байсан туршлагатай 1-ээс доошгүй ажилтантай байх;

4.6.2.Хороо, холбогдох мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулсан даатгалын зуучлагчийн сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэн ажилтнуудын бүртгэл болон даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа явуулж буй банкны нэгжийн бүртгэлийг тогтмол хөтөлж, уг бүртгэлд өөрчлөлт орсон тухай бүр Хороонд цахимаар мэдэгдэх;

4.6.3.банкны нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан хариуцсан захирал өөрчлөгдсөн тохиолдолд ажлын 5 өдрийн дотор Хороонд мэдэгдэх;

4.6.4.даатгалын зуучлагчийн үйл ажиллагааг Банкны тухай хуульд заасан банкны нэгжээр дамжуулан хийж болох бөгөөд тус нэгжийн даатгалын гэрээ байгуулах ажилтнууд нь Хороо холбогдох мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулсан даатгалын зуучлагчийн сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэн байх;

4.6.5.даатгалын зуучлагчийн үйл ажиллагаатай холбоотой гүйлгээг Хороонд бүртгүүлсэн банкны харилцах дансыг ашиглаж хийх;

4.6.6.давхар даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэхгүй;

4.6.7.Даатгалын компанитай байгуулах хамтран ажиллах гэрээнд зуучлан борлуулах даатгалын бүтээгдэхүүнийг тодорхой зааж, тусгасан байх;

4.6.8.Хороо энэ журмын 4.6.2-т заасан бүртгэлийн холбогдох хэсгийг Хорооны цахим хуудсанд

байршуулж олон нийтэд мэдээлэх ба даатгалын зуучлалын үйл ажиллагаа явуулж буй банкны нэгжийн мэдээлэл нь Хорооны цахим хуудсанд байршсан байх;

4.6.9. Даатгалын зуучлалын үйл ажиллагаа явуулж буй тухайн банкны нэгж болон Хороо холбогдох мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулсан даатгалын зуучлагчийн сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэн ажилтнуудын мэдээллийг тухайн банк нь өөрийн цахим хуудсанд байршуулсан байна.

ТАВ. ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ДАГАЖ МӨРДӨХ ҮЗҮҮЛЭЛТ

5.1. Даатгалын хохирол үнэлэгчийн дүрмийн сангийн мөнгөн хөрөнгийн доод хэмжээ нь Улаанбаатар хотод 10.0 /арван/ сая төгрөг, хөдөө орон нутагт 7.0 /долоо/ сая төгрөг байх ба дүрмийн сангийн мөнгөн хөрөнгийг зээлийн хөрөнгөөр бүрдүүлээгүй бөгөөд хууль ёсны орлогын эх үүсвэрээс бүрдүүлсэн болохыг нотолсон байх.

5.2. Жил бүр мэргэжлийн хариуцлагаа даатгуулсан байх ба мэргэжлийн хариуцлагын даатгалын үнэлгээний доод хязгаар нь 100.0 сая төгрөг байна.

5.3. Даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагааг хэвийн явуулахтай холбогдох дараах шаардлагыг хангасан байна:

5.3.1. Компанийн үйл ажиллагааг хэвийн явуулах техник тоног төхөөрөмжтэй байх;

5.3.2. Компанийн нягтлан бодох бүртгэл хөтлөх болон санхүүгийн тайлан тодруулга гаргах нягтлан бодогчтой байх ба нягтлан бодогч өөрчлөгдсөн тохиолдолд ажлын 5 өдрийн дотор Хороонд мэдэгдэх;

5.3.3. Компаниас гаргасан шийдвэр болон компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөх дотоод дүрэм, журам, заавар, хохирол үнэлгээний тайлан, бусад эрх зүйн баримт бичгийг архивлан хадгалах;

5.3.4. Даатгалын хохирол үнэлэгчийн бүтэц зохион байгуулалт, удирдлага, хүний нөөцийн бодлоготой холбогдох дараах шаардлагыг хангасан байна:

5.3.4.а. Хоёроос доошгүй орон тооны ажилтантай байх;

5.3.4.б. Компанийн хувь нийлүүлэгчид нь өөр аль нэг даатгалын байгууллагын ТУЗ-ийн дарга, гишүүн, хамтын гүйцэтгэх удирдлагын гишүүн, эрх бүхий албан тушаалд томилогдон ажиллаагүй байх.

5.4. Даатгалын хохирлын үнэлгээ хийх бэлтгэл ажил нь дараах шаардлагад нийцсэн байна:

5.4.1. хохирлын үнэлгээний стандарт, аргачлал, дүрэм, журам, норм, норматив болон шаардлагатай бусад материалыг бэлтгэсэн байх;

5.4.2. даатгалын хохирлын үнэлгээ хийхэд шаардагдах баримт бичгийг үйлчлүүлэгчээс гаргуулан авсан байх;

5.4.3. даатгалын хохирлын үнэлгээ хийхэд ашиглаж байгаа мэдээллийн сан болон үйлчлүүлэгчээс ирүүлсэн тоо, мэдээг дахин хянаж, магадлан шинжилсэн байх.

5.5. Даатгалын хохирлын үнэлгээний тайлан нь хохирлын үнэлгээг тогтоосон үндэслэл, нотолгоог агуулсан үндсэн баримт бичиг байх бөгөөд уг тайлан нь дараах шаардлагад нийцсэн байна:

5.5.1. тогтоосон даатгалын хохирлын үнэлгээ нь тодорхой үндэслэл бүхий тайлбартай байх;

5.5.2. уг тайланд даатгалын хохирлын үнэлгээ хийх явцад гарсан хохирлын үнэлгээний стандарт, дүрэм, журам, нормыг зөрчсөн аливаа үйлдлийн талаар тэмдэглэсэн байх.

5.6. Даатгалын хохирлын үнэлгээний тайланд дараах зүйлийг тусгана:

5.6.1. үнэлгээчний нэр, Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон даатгалын хохирол үнэлэгчийн тусгай зөвшөөрлийн дугаар, энэ журамд заасны дагуу мэргэжлийн хариуцлагаа даатгуулсан талаарх мэдээлэл;

5.6.2. учирсан хохирлоо үнэлүүлэх этгээдийн нэр, хаяг, регистрийн дугаар;

5.6.3. даатгалын хохирлын үнэлгээ хийсэн хугацаа болон тайлангийн он, сар, өдөр;

5.6.4. даатгалын хохирлын үнэлгээний зүйлийн төрөл, түүний тухайн үеийн шинж байдлын тодорхойлолт, даатгалын тохиолдлыг баталгаажуулсан фото зураг;

5.6.5. даатгалын хохирлын үнэлгээний зүйлийн өмчлөл, эзэмшил, ашиглалтын талаарх мэдээлэл;

5.6.6. даатгалын хохирлын үнэлгээний зүйлийн хамрах хүрээ, хязгаар;

5.6.7. даатгалын хохирлын үнэлгээ хийхэд ашигласан 3-аас доошгүй газрын үнийн судалгаа, түүнд хийсэн тооцоолол;

5.6.8. даатгалын хохирлын үнэлгээний дүн.

5.7. Даатгалын хохирлын үнэлгээний тайланд үнэлгээчин гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулсан байна.

5.8. Даатгалын хохирол үнэлэгч дараах тохиолдолд даатгалын хохирлын үнэлгээ хийхгүй байх:

5.8.1. даатгалын хохирол үнэлэгч нь өөрт болон өөрийн компанийн ажилтанд учирсан даатгалын хохиролд үнэлгээ хийх;

5.8.2. үнэлгээчин өөрийн ажилладаг компанийн даатгалын хохиролд үнэлгээ хийх;

5.8.3. төрөл, садан /эцэг, эх, нөхөр, эхнэр, хүүхэд, төрсөн ах, эгч, дүү гэх мэт/-д даатгалын хохиролд үнэлгээ хийх;

5.8.4. тухайн үнэлгээний компанийн санхүүгийн тайланд аудит хийж байгаа хуулийн этгээдийн учирсан хохиролд үнэлгээ хийх.

5.9. Даатгалын хохирлын үнэлгээний тайланд хохирлоо үнэлүүлсэн этгээд танилцаж зөвшөөрсөн гарын үсэг зурсан байна.

5.10. Даатгалын мэргэжлийн оролцогчийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс багассан тохиолдолд Компанийн тухай хуулийн 31.3-т “Тухайн жилийн санхүүгийн тайлангаар компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс багассан тохиолдолд уг тайлан гарснаас хойш ажлын 10 өдрийн дотор төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлаж, хувь нийлүүлсэн хөрөнгөнд өөрчлөлт оруулах, компанийг дахин хөрөнгөжүүлэх, эсхүл татан буулгах асуудлыг шийдвэрлүүлэх үүрэгтэй.” гэж заасны дагуу шийдвэрлэнэ.

5.11. Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдлийн хэмжээ нийт активын 5 хувиас хэтрэхгүй байна.

5.12. Эрхлэх даатгалын хэлбэрийн хүрээнд мэргэшсэн ажилтан өөрчлөгдсөн тохиолдолд ажлын 5 өдрийн дотор энэ журмын 1 дүгээр хавсралт (Е) СЗХ04006 маягтын дагуу тодорхойлолт гаргаж Хороонд мэдэгдэнэ.

5.13. Даатгалын хохирол үнэлэгчийн салбар, төлөөлөгчийн газар нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

5.13.1. энэ журмын 2.17-т заасны дагуу Хорооны цахим хуудсанд холбогдох мэдээлэл нь байршсан байх;

5.13.2. үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэрийн хязгаарлалтаа тодорхойлсон, хаяг, байршил нь тодорхой, байнгын ажлын байртай байх;

- 5.13.3.салбарын удирдлага, ажилтан, гэрээт ажилтнаар ажиллах этгээд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтад заасан “нийтийн албан тушаалтан” биш байх;
- 5.13.4.үйл ажиллагааг хэвийн явуулах тоног төхөөрөмж, программ хангамжтай байх;
- 5.13.5.нэгж нь компанийн ерөнхий захиргаа болон бусад нэгжүүдтэйгээ мэдээллийн нэгдсэн нэг сүлжээнд холбогдож, мэдээлэл, тайлагнал дамжуулдаг байх;
- 5.13.6.тухайн нутаг дэвсгэрт салбар нээн ажиллуулахтай холбогдсон зах зээлийн судалгаатай байх;
- 5.13.7.эрхлэх даатгалын ангилал, төрөл, хэлбэрийг тодорхой тусгасан, салбарын дотоод хяналт болон бусад үйл ажиллагааг зохицуулах журамтай байх;
- 5.13.8.эрхлэх даатгалын хэлбэрийн хүрээнд эд хөрөнгөнд учирсан бодит хохирлыг тогтоох тохиолдолд Хөрөнгийн үнэлгээний тусгай зөвшөөрөлтэй нэгээс доошгүй ажилтантай байх;
- 5.13.9.Хороо холбогдох мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулсан даатгалын хохирол үнэлгээний сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэн 1-ээс доошгүй ажилтантай байна.

ЗУРГАА. ДААТГАЛЫН ТӨЛӨӨЛӨГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ДАГАЖ МӨРДӨХ ҮЗҮҮЛЭЛТ

- 6.1.Хороо холбогдох мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулсан даатгалын төлөөлөгчийн сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэн байх бөгөөд даатгалын төлөөлөгч нь хэрэв хуулийн этгээд бол даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх ажилтнууд нь энэхүү шаардлагыг хангасан байна.
- 6.2.Даатгагчтай бичгээр байгуулсан хамтран ажиллах гэрээтэй байх бөгөөд тус гэрээнд даатгалын төлөөлөгчийн шимтгэл олгох нөхцөлийг хууль тогтоомжид нийцүүлэн тусгасан байна.
- 6.3.Зөвхөн энэ журмын 6.2-т заасан даатгагчийн төлөөлөгчөөр ажиллана.
- 6.4.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т заасан “нийтийн албан тушаалтан” биш байх бөгөөд даатгалын төлөөлөгч нь хэрэв хуулийн этгээд бол даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх ажилтнууд нь энэхүү шаардлагыг хангасан байна.
- 6.5.Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагааны сүүлийн 12 сарын хугацааны нийлбэр орлого нь 20.0 /хорин/ сая төгрөг ба түүнээс дээш хэмжээтэй бол даатгалын төлөөлөгч өөрийн орлогын тайлангаа “Даатгалын багц дүрэм”ийн 11 дүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчоос тайлан, мэдээ, өргөдөл гаргах заавар”-ын холбогдох хавсралтын дагуу төлөөлж буй компанидаа мөн журамд заасан хугацаанд гаргаж өгнө.
- 6.6.Даатгалын төлөөлөгч нь энэ журамд заасан даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхэлснийхээ төлөө даатгагчаас төлбөр, хөлс авах эрхтэй бөгөөд уг үйл ажиллагааг явуулаагүй тохиолдолд даатгагчаас аливаа төлбөр, хөлс авахгүй.
- 6.7.Даатгуулагч нь хуулийн этгээд бол даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа явуулсныхаа төлөө даатгагчаас хүлээн авч буй төлбөр, хөлсний талаар даатгалын төлөөлөгч нь даатгалын гэрээ байгуулагдахаас өмнө даатгуулагчийн эрх бүхий албан тушаалтанд бичгээр мэдэгдэж, танилцуулсан байна. Энэхүү төлбөр, хөлсийг даатгалын төлөөлөгчид олгохыг зөвшөөрсөн даатгуулагчийн гарын үсэг бүхий мэдэгдлийг даатгагчийн эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ.

6.8.Хорооноос тусгай зөвшөөрөл авсан даатгалын төлөөлөгч нь зөвшөөрөл авснаас хойш 2 жил тутамд нэг удаа даатгалын мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдана.

ДОЛОО. ДААТГАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮН БОЛОН ДААТГАЛЫН ГЭРЭЭНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

7.1. Даатгалын бүтээгдэхүүнд тавигдах шаардлага:

7.1.1. Даатгалын бүтээгдэхүүний бүрдэлд дараах зүйлс хамаарна:

7.1.1.а. даатгалын гэрээ

7.1.1.б. даатгалын баталгаа

7.1.1.в. даатгалын бүтээгдэхүүний судалгаа, танилцуулга

7.1.1.г. даатгалын бүтээгдэхүүний хураамжийн хувь хэмжээ, нөөц сангийн тооцоолол

7.1.2. Даатгалын гэрээ нь дараах шаардлагыг хангасан байна:

7.1.2.а. Даатгуулагчтай байгуулж байгаа даатгалын гэрээ нь монгол хэл дээр үйлдэгдсэн, утга санаа, үг хэллэг нь ойлгомжтой, тодорхой, төөрөгдүүлсэн болон хоёрдмол санаа агуулаагүй байх, бусад шууд ойлгогдохоор үг, хэллэгтэй байх бөгөөд даатгуулагчийн хүсэлтээр гадаад хэл дээр даатгалын гэрээ байгуулж байгаа тохиолдолд монгол хэл дээр тухайн даатгалын гэрээг давхар үйлдэх, маргаан гарсан нөхцөлд монгол хэл дээр хийгдсэн гэрээг баримтална.

7.1.2.б. Даатгалын гэрээнд даатгагч, даатгуулагчийн эрх үүрэг, даатгалын эрсдэл, даатгалын үнэлгээ, гэрээний эхлэх дуусах хугацаа, гэрээг сунгах, цуцлах, өөрчлөлт оруулах нөхцөл, даатгалын хураамжийн хэмжээ, хураамж төлөх хугацаа, даатгалын хураамж буцаах нөхцөл, даатгалын гэрээ ямар нөхцөлд хүчин төгөлдөр бус болох, нөхөн төлбөр олгохоос татгалзах заалт зэргийг тодорхой зааж тусгасан байна.

7.1.3. Үйлчлүүлэгчийн санаачилга хүсэлтийн дагуу тусгайлан боловсруулагдсан даатгалын бүтээгдэхүүнээс бусад олон нийтэд түгээмэл нөхцөлөөр нийлүүлж буй даатгалын бүтээгдэхүүнд холбогдох даатгалын баталгаа нь дараах шаардлагыг хангасан байна:

7.1.3.а. хураангуй, хамгийн ихдээ 2-3 хуудас бие даасан бичиг баримт байх;

7.1.3.б. ойлгомжтой үг хэллэгтэй, төөрөгдүүлсэн болон хоёрдмол утга санаа агуулаагүй, уншигдахуйц үсгийн хэмжээгээр бичигдсэн, уншихад хялбар байх;

7.1.3.в. эх хувь нь өнгөт хувилбараар бэлтгэгдсэн ч хар цагаанаар хувилах, хэвлэх тохиолдолд ялгаагүй ойлгомжтой, уншигдахуйц байх;

7.1.3.г. эхний хуудасны дээд талд даатгалын баталгаа гэж бичигдсэн байх;

7.1.3.д. гэрээ байгуулахаас өмнө танилцах шаардлагатай болон гэрээтэй холбогдох бүтээгдэхүүний талаарх бүрэн мэдээлэл бусад баримт бичгүүдэд агуулагдаж байгаа тухай мэдэгдлийг багтаасан байх.

7.1.4. Даатгалын баталгаанд дараах мэдээлэл тусгагдсан байна:

7.1.4.а. даатгалын компанийн талаар мэдээлэл; /Тухайлбал: ХК/ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр Монгол Улсын хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна гэх мэт/

7.1.4.б. даатгалын хэлбэр, бүтээгдэхүүний нэр;

7.1.4.в. даатгалын хамрах хүрээ, даатгалын үндсэн эрсдэл, нэмэлт эрсдэл, хамгаалагдаагүй эрсдэл болон шаардлагатай бол даатгалын хамгаалалт үйлчлэх газарзүйн хамрах хүрээ;

7.1.4.г. даатгалын үнэлгээ, даатгалын хураамжийн хэмжээ болон даатгалын хураамжийг төлөх арга хэлбэр, төлөлтийн график, хугацаа;

7.1.4.д. даатгалын нөхөн төлбөр олгогдохгүй нөхцөл ;

7.1.4.е. гэрээ байгуулах үед хүлээх үүрэг;

7.1.4.ё. гэрээний хугацаанд хүлээх үүрэг;

7.1.4.ж. даатгалын тохиолдол бий болж, нэхэмжлэл гаргах үед хүлээх үүрэг;

7.1.4.з. даатгалын тохиолдол бий болоход хэрхэн мэдэгдэх, баталгаажуулах талаар;

7.1.4.з. гэрээ хүчин төгөлдөр болох, дуусгавар болох огноо бүхий гэрээний хугацаа;

7.1.4.и. гэрээг цуцлах арга хэлбэр;

7.1.4.й. даатгуулагчийн овог, нэр, нас, хүйс, регистрийн дугаар;

7.1.4.к. даатгагчийн хаяг, холбоо барих утас;

7.1.4.л. даатгагчийн гарын үсэг.

7.1.5. Даатгагч нь тухайн бүтээгдэхүүнтэй холбоотойгоор даатгалын гэрээ байгуулах, даатгалын нөхөн төлбөр олгохтой холбоотой харилцааг нарийвчлан зохицуулсан журамтай байна.

7.1.6. Даатгалын бүтээгдэхүүнүүдийг боловсруулж, зах зээлд борлуулахдаа хэрэглэгчийн эрх ашгийг харгалзан үзсэн байна.

7.1.7. Даатгалын бүтээгдэхүүний Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээ хийгдсэн байна.

7.1.8. Даатгалын бүтээгдэхүүний хураамжийн хувь хэмжээ нь эрсдэлийн түвшинтэй уялдаатай байх, мөн “Даатгалын багц дүрэм”-ийн тавдугаар хавсралтын дагуу боловсруулсан байх бөгөөд даатгалын бүтээгдэхүүн тус бүрийн хувьд даатгалын хураамжийн хэмжээг тооцоолоходоо ашигласан тоон мэдээлэл, аргачлал, эрсдэл тус бүрийн түвшин, хувь хэмжээ, түүнийг тооцоолсон аргачлал, цэвэр хураамжийн хувь, нийт хураамжийн хувийн талаарх мэдээллийг агуулсан актуарын тайлан, танилцуулгатай байна.

7.1.9. Бага дунд орлоготой иргэдийн хэрэгцээ, худалдан авах чадварт нийцсэн, энгийн хялбар сайн дурын даатгалын бүтээгдэхүүнийг хүртээмжтэй даатгал гэж ойлгох бөгөөд Хүртээмжтэй даатгалын бүтээгдэхүүнд Хороо дараах нэмэлт шаардлагыг тавина:

7.1.9.а. даатгалын гэрээний үг хэллэг нь энгийн, ойлгомжтой, хоёрдмол утга санаагүй, даатгуулагчийг төөрөгдүүлэхээргүй байх;

7.1.9.б. даатгалын үнэлгээ, хураамжийн дүн бага дунд орлоготой иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн байх;

7.1.9.в. даатгалын гэрээнд тусгасан даатгалын нөхөн төлбөр олгохоос татгалзах нөхцөлийн тоо нь 5-аас хэтрэхгүй бөгөөд даатгуулагчид ойлгомжтой байх;

7.1.9.г. даатгалын тохиолдол болсон нь холбогдох баримтаар нотлогдсон нөхцөлд даатгуулагчид хүндрэл учруулалгүйгээр даатгалын нөхөн төлбөрийг хуанлийн 10 хоногийн дотор олгодог байхаар гэрээнд тусгагдсан байх.

7.2. Даатгалын гэрээ байгуулахад тавигдах шаардлага:

7.2.1. Даатгалын гэрээг байгуулахдаа “Даатгалын зах зээлийн ёс зүйн журам”-ыг баримтална.

7.2.2. Даатгагч, даатгалын зуучлагч, төлөөлөгч нь үйлчлүүлэгчтэй даатгалын гэрээг байгуулахаас өмнө дараах үйл ажиллагааг дагаж мөрдөнө. Үүнд:

7.2.2.а. үйлчлүүлэгчийг төөрөгдүүлэхээргүй, өөрт нь тохирсон даатгалын эрсдэл бүхий

даатгалын бүтээгдэхүүнийг санал болгох;

7.2.2.б. Даатгагч болон даатгалын зуучлагч, төлөөлөгч нь санал болгож буй даатгалын харилцаатай холбогдуулан мэдээлэлд суурилсан шийдвэрийг гаргах боломжийг үйлчлүүлэгчид олгох үүднээс тухайн даатгалын талаарх мэдээллийг зохистой үед нь, ойлгомжтой хэлбэрээр хүргэх тал дээр зохих арга хэмжээ авах үүргийг хүлээх бөгөөд үйлчлүүлэгчийг энэ журмын 7.2.3-д заасан мэдээллээр хангах;

7.2.2.в. үйлчлүүлэгчээс даатгалын гэрээний эрх үүрэг, нөхөн төлбөр олгох болон олгохгүй нөхцөл, хязгаарлалт, ямар төрлийн даатгалын эрсдэлээс хамгаалагдах, даатгалын тохиолдол үүссэн үед хэрхэн арга хэмжээ авах, даатгалын гэрээний хугацаа дуусах, сунгах, цуцлах нөхцөл зэргийг ойлгосон эсэхийг тодруулсан асуулгын хуудсыг бөглүүлж, баримтжуулан хадгалах;

7.2.2.г. даатгагч эсхүл түүний төлөөлөгч, даатгалын зуучлагч нь бүлгийн хэлбэртэй даатгалын гэрээ байгуулахаас өмнө даатгуулагч нэг бүрд тухайн даатгалын бүтээгдэхүүний талаар танилцуулж, зөвшөөрлийг авсан байх;

7.2.2.д. даатгуулагч нь даатгалын гэрээ байгуулахын тулд бүлэг байгуулж болохгүй;

7.2.2.е. Даатгагч нь өөрийн ажилтан болон Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэй даатгалын зуучлагч, даатгалын төлөөлөгчөөр дамжуулан даатгалын гэрээг байгуулна.

7.2.3. Даатгагч, даатгалын зуучлагч, төлөөлөгч нь үйлчлүүлэгчтэй даатгалын гэрээг байгуулахаас өмнө даатгуулагчийг дараах мэдээллээр хангана:

7.2.3.а. Даатгагчийн нэр, хуулийн этгээдийн төрөл, хамааралтай бол харьяалагдаж буй группийн нэр;

7.2.3.б. даатгалын хураамжийн хэмжээ, түүнийг төлөх хугацаа, түүнчлэн хураамж хоцроосноос болон төлөөгүйгээс гарах үр дагавар, хожимдуулж төлсөн хураамжид авах арга хэмжээ, даатгалын хураамжид нэмэгдэх, хасагдах үнийн дүнгүүд болон даатгуулагчаас шууд төлөгдөх аливаа төлбөр, хураамжийн талаарх мэдээлэл;

7.2.3.в. даатгалын хамгаалалт хэзээ эхлэх, дуусах тухай мэдээлэл;

7.2.3.г. даатгалын гэрээгээр ямар эрсдэлийн тохиолдлуудыг хамруулах ба эс хамруулах талаарх мэдээлэл;

7.2.3.д. даатгалын гэрээний ач холбогдол бүхий эсхүл хэвийн бус хязгаарлалтуудын талаарх мэдээлэл./ Ач холбогдол бүхий хязгаарлалт гэж хэрэглэгч тухайн бүтээгдэхүүнийг худалдан авах эсэхэд нөлөөлөх хязгаарлалт, үл хамруулалтыг хэлнэ. Хэвийн бус хязгаарлалт гэж ижил төстэй гэрээнүүдэд түгээмлээр тусгагдаагүй зохицуулалтыг хэлнэ. Жишээлбэл: зарим нөхцөл байдал, өвчин, эрүүл мэндийн суурь нөхцөл байдлыг хамруулахгүй байх, даатгалын нөхөн төлбөрийн үнийн дүнд хамаарах хязгаарлалтууд, нөхөн төлбөр төлөгдөж болох хугацааг хязгаарлах, нас, оршин суугаа газар, ажил эрхлэлт зэрэг шалтгаанаар нэхэмжлэх эрхийг хязгаарлах/

7.2.3.е. даатгалын гэрээний ерөнхий зүйл /гэрээнд хэрэглэх хууль, тогтоомжийн талаарх мэдээлэл үүнд багтана/;

7.2.3.ё. Материаллаг ач холбогдолтой баримтуудыг ил тод болгох үүрэг /материаллаг ач холбогдолтой баримтуудыг ил тодоор мэдээлэх үйлчлүүлэгчийн үүргийн талаарх дэлгэрэнгүй бөгөөд ойлгомжтой тодорхой мэдээлэл үүнд хамаарна. Үйлчлүүлэгч юуг мэдүүлэх талаар тодорхой ойлголттой болгох асуудалд тухайн даатгалын хүрээнд хамааралтай бүх материаллаг мэдээллийг өгөх үүрэг, чухам ямар мэдээллийг олгох шаардлагатай болон мэдээллийг олгоогүйгээс гаргах үр дагаврын талаарх тайлбар багтана/;

7.2.3.ж.даатгалын гэрээ байгуулагдахаас өмнө болон гэрээний хугацаа хүчин төгөлдөр байх үед биелүүлэх үүрэг, түүнийг дагаж мөрдөхгүйгээс үүдэх эрх зүйн үр дагаврын талаарх мэдээлэл;

7.2.3.з.нөхөн төлбөр олгох нөхцөлийн талаар мэдээлэл- даатгуулагч ямар нөхцөлд нөхөн төлбөр нэхэмжлэх боломжтой талаарх мэдээлэл болон холбоо барих хаягийн мэдээлэл;

7.2.3.и.даатгалын гэрээнээс үүдэх маргаан шийдвэрлэлтийн мэдээлэл- даатгуулагчийн гомдлыг шийдвэрлэх арга зам, тухайлбал даатгагчийн гомдол барагдуулах дотоод механизм, Санхүүгийн зохицуулах хороо болон шүүхэд хандах эрхийн талаарх мэдээлэл;

7.2.3.й.даатгалын гэрээг цуцлах эрхийн талаар мэдээлэл- цуцлах эрхийг эдлэх эсэх, цуцлах боломжтой хугацаа, цуцлахад шаардагдах нөхцөлүүдийн талаарх мэдээлэл. Хугацаанаас өмнө цуцалсантай холбогдуулан аливаа төлбөр хураамж авах бол энэ талаар дэлгэрэнгүй тайлбарлана.

7.2.4.Даатгагч, даатгалын зуучлагч нь даатгуулагчтай даатгалын гэрээ байгуулагдсаны дараа дараах үйл ажиллагааг дагаж мөрдөнө:

7.2.4.а.даатгагч нь даатгуулагчид энэ журмын 7.1.3-т заасан даатгалын баталгааг олгоно;

7.2.4.б.даатгалын гэрээг шинэчлэх, гэрээний хугацааг сунгах тухай мэдэгдлийг даатгуулагчид хангалттай хугацаа олгох байдлаар урьдчилан хүргүүлнэ. Даатгуулагч гэрээг сунгах хүсэлгүй бол шинээр даатгагчийг олох хүртэл хангалттай хугацааг олгож ажиллана;

7.2.4.в. Гэрээний үнийн дүн, нөхцөл, болзлуудыг даатгагч өөрчлөх хүсэлтэй бөгөөд өөрчлөх тухай гэрээнд тодорхой заагаагүй бол энэ талаарх мэдэгдлийг хүргүүлэх, гэрээг өөрчлөх зөвшөөрлийг даатгуулагчаас авах үүргийг даатгагч хүлээнэ;

7.2.4.г.даатгалын гэрээ дуусгавар болох хугацаанаас өмнө даатгалын гэрээ цуцлагдсан тохиолдолд даатгалын хураамжийн буцаалтыг даатгуулагч бичгээр хүсэлт гаргаснаас хойш ажлын 5 өдрийн дотор даатгуулагчид олгоно;

7.2.4.д.бүлгийн хэлбэртэй даатгалын гэрээ байгуулагдсан /даатгалын гэрээнд ажилтнуудыг ажил олгогч төлөөлж, оршин суугчдыг сууц өмчлөгчдийн холбоо төлөөлж гэх мэт/ тохиолдолд тухайн бүлэгт хамаарах даатгуулагч бүрд энэ журмын 7.1.3-т заасан даатгалын баталгааг өгнө. Даатгалын баталгааг цахимаар хүргүүлж болно.

7.2.5.Даатгалын гэрээг цахимаар болон аливаа техник, технологийн дэвшлийг ашиглаж байгуулах тохиолдолд дараах шаардлагыг дагаж мөрдөнө:

7.2.5.а. даатгагч, даатгалын зуучлагч цахимаар болон аливаа техник, технологийн дэвшлийг ашиглан хийх даатгалын үйл ажиллагааны талаарх мэдээлэл, заавар, аргачлалыг боловсруулж өөрийн цахим хуудаст байршуулсан байх;

7.2.5.б. даатгагч, даатгалын зуучлагч үйлчлүүлэгчийг цахимаар болон аливаа техник, технологийн дэвшлийг ашиглаж даатгуулах боломжийг энгийн нөхцөл байдлаар бүрдүүлсэн байх ба даатгуулагчид өөрийн даатгалын гэрээ болон холбогдох мэдээллээ хянах нөхцөл боломжийг бүрдүүлж өгсөн байх;

7.2.5.в. цахимаар болон аливаа техник, технологийн дэвшлийг ашиглаж хийгдсэн даатгалын гэрээний хүчин төгөлдөр болох нөхцөл, хугацааг тодорхой зааж өгнө. Даатгагч, даатгалын зуучлагч цахим хэлбэрээр хийгдсэн даатгалын гэрээний баталгааг даатгуулагчийн цахим хаягаар ажлын 3 өдрийн дотор хүргүүлнэ;

7.2.5.г. цахимаар болон аливаа техник, технологийн дэвшлийг ашиглаж борлуулах даатгалын бүтээгдэхүүний тухай Хороонд мэдэгдэх, өөрийн цахим хуудаст

бүтээгдэхүүний нэрсийг тодорхой зааж, тухайн даатгалын бүтээгдэхүүний гэрээг байршуулах, мөн даатгалын хураамж төлөх банк, дансны дугаарыг тодорхой зааж өгсөн байх;

7.2.5.д. Даатгагч, даатгалын зуучлагч цахим даатгалын үйл ажиллагааны программ хангамж, системийн аюулгүй найдвартай ажиллагааг хангасан байх;

7.2.5.ё. Даатгагч, даатгалын зуучлагч албан журмын даатгалыг цахимаар болон аливаа техник, технологийн дэвшлийг ашиглаж хийх тохиолдолд даатгуулагчид өнгөрсөн хугацааны даатгалын хураамж, нөхөн төлбөр авсан эсэх, хураамжийг тооцоолдог итгэлцүүрийн мэдээлэл зэргийг гарган өгч, даатгалын гэрээ байгуулах, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр хангадаг байна.

НАЙМ. ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОХОД ТАВИГДАХ ШААРДЛАГА

8.1. Даатгагч даатгалын нөхөн төлбөр олгохдоо даатгуулагчид хүндрэл учруулахгүй, шуурхай олгох зарчмыг баримтлах.

8.2. Даатгагч хууль хяналтын болон мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг даатгуулагчаас шаардах тохиолдолд уг дүгнэлт гараагүй байхад даатгалын гэрээнд заасан хугацаа өнгөрсөн шалтгаанаар даатгалын нөхөн төлбөр олгохоос татгалзахгүй байх.

8.3. Даатгагч даатгуулагч харилцан тохиролцож даатгалын гэрээнд заасны дагуу даатгалын хураамжийг даатгуулагч төлбөрийн хуваарийн зөрчилгүйгээр хэсэгчлэн, үе шаттай төлж байгаа үед даатгалын тохиолдол учирвал даатгагч даатгалын нөхөн төлбөрийг даатгуулагчийн төлсөн хураамжтай хувь тэнцүүлэн бууруулахгүй байх.

8.4. Нэхэмжлэл гаргах үед даатгуулагч зарим мэдээллийг ирүүлээгүй нь илэрсэн тохиолдолд уг мэдээлэл нь нэхэмжлэл гаргах үндэслэлд нөлөөлөхөөргүй, материаллаг бус шинжтэй бол нөхөн төлбөр олгохоос татгалзах, эсвэл бууруулахгүй байх.

8.5. Урт хугацааны даатгалын гэрээ эзэмших эрх бүхий этгээд тухайн гэрээнд заагдсан даатгуулагч гэрээний эрхийн талаар бичгээр мэдэгдэх бөгөөд даатгуулагч байхгүй, эсхүл энэ эрхээс татгалзсан, эсхүл нас барсан тохиолдолд даатгуулагчийн хууль ёсны өв залгамжлагчид даатгалын нөхөн төлбөрийг олгоно.

8.6. Ердийн даатгагч даатгалын нөхөн төлбөр олгохдоо дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

8.6.а. даатгагч даатгалын тохиолдлын талаарх мэдээллийг авсан даруйдаа даатгуулагчид хариу өгч, даатгуулагчаас авах арга хэмжээний талаар тодорхой мэдээлэл өгөх үүрэгтэй бөгөөд даатгагч 72 цагийн дотор даатгалын тохиолдлыг шалгаж баримтжуулах өөрийн ажилтныг эсхүл даатгалын хохирол үнэлэгчийг томилно;

8.6.б. Даатгагч нь гэрээнд заасан хугацаанд багтаан даатгалын нөхөн төлбөр олгох эсэх асуудлыг шийдвэрлэсэн байна. Хэрэв нөхөн төлбөрийг олгох боломжгүй бол Даатгалын тухай хуульд заасны дагуу бичгээр мэдэгдэнэ.

8.7. Урт хугацааны даатгагч нөхөн төлбөр олгохдоо дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

8.7.а. даатгалын тохиолдлын нэхэмжлэл авсан даруйдаа бүртгэж, 7 хоногийн дотор даатгуулагчаас нэмэлт материалыг багцаар нь шаардаж болно;

8.7.б. шаардагдах бүх материалыг авснаас хойш 30 хоногт багтаан нэхэмжлэлийг барагдуулах эсхүл олгохгүй байх нөхцөл шалтгааныг дурдаж даатгуулагчид бичгээр мэдэгдэнэ.

8.8. Даатгагч даатгалын гэрээ болон холбогдох журамд заасан хугацаанд даатгалын нөхөн төлбөр олгоогүй бол Иргэний хуулийн 232.6 дахь хэсэгт заасны дагуу хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн

үнийн дүнгийн 0,5 хувиар алданги тооцох заалтыг даатгалын гэрээнд тусгасан байна.

8.9.Энэ журмын 8.2-8.8 дах заалтууд нь Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамаарахгүй.

ЕС. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

9.1.Хороо энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах бөгөөд журмын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй этгээдийн бүртгэлийг хөтөлж, холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

9.2.Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогч нь энэхүү журамд заасан зөвшөөрөл, бүртгэлийн хүсэлтийн болон мэдэгдлийн маягтыг хуурамчаар бөглөсөн, мөн энэхүү журмын 2.20-д заасан буюу бүртгэлгүй, хүчин төгөлдөр бус үйл ажиллагааг явуулсан тохиолдолд журмын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй гэх үндэслэл болох бөгөөд Хороо холбогдох хууль тогтоомжийн дагуу албадлагын арга хэмжээ авна.

Маягт СЗХ04003

ЗӨВШӨӨРЛИЙН ХҮСЭЛТ

1	Хүсэлт гаргасан огноо	Он		Сар		Өдөр	
2	Хүсэлт гаргагчийн оноосон нэр						
3	Регистрийн дугаар						
Зөвшөөрлийн төрлийг сонгоно уу.							
4	<input type="checkbox"/> Даатгагчийн дүрмийн сангийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах /5-р хэсгийг бөглөх/ <input type="checkbox"/> Албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх /6-7-г бөглөх/						
Даатгагчийн дүрмийн сангийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах							
5	Оноосон нэр /Овог, нэр	Регистрийн дугаар	Одоогийн ХНХ хэмжээ (₮)	Нэмэгдсэн (₮)	Хорогдсон (₮)	Өөрчлөлтийн дараа	
						ХНХ хэмжээ (₮)	ХНХ-д эзлэх хувь (%)
Албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх							
6	Албан журмын даатгалын хэлбэрийн нэр						
7	Сонгосон албан журмын даатгалын хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэх шийдвэр			Шийдвэрийн нэр	Огноо	Дугаар	

Даатгалын тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Даатгалын багц дүрэмд нийцүүлэн зөвшөөрөл авахад шаардагдах баримт бичгийг үнэн зөв бүрдүүлж, хүргүүлэв. Бүрдүүлсэн баримт бичигт ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Манай хүсэлт, баримт бичгийг хүлээн авч, хянан шийдвэрлэж, зөвшөөрлийг олгоно уу.

Хүсэлт гаргасан:

Овог, нэр албан тушаал гарын үсэг огноо

Тамга:



“Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 1 дүгээр хавсралт (Б)

Маягт СЗХ04004

БҮРТГЭЛИЙН ХҮСЭЛТ

1	Хүсэлт гаргасан огноо	Он		Сар		Өдөр	
2	Хүсэлт гаргагчийн оноосон нэр						
3	Регистрийн дугаар						

Бүртгүүлэх үйл ажиллагааны төрлийг сонгоно уу.

4	<input type="checkbox"/> Даатгагч, даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийн дүрмийн сангийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах /5-р хэсгийг бөглөх/
	<input type="checkbox"/> Даатгалын хэлбэр /6-г бөглөх/
	<input type="checkbox"/> Давхар даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх /7-г бөглөх/
	<input type="checkbox"/> Даатгагч, даатгалын зуучлагч, хохирол үнэлэгчийн эрх бүхий албан тушаалтны өөрчлөлт /8-г бөглөх/
	<input type="checkbox"/> Оноосон нэр өөрчлөх /9-11-г бөглөх/

Даатгагч, даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийн дүрмийн сангийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах

5	Оноосон нэр /овог нэр/	Регистрийн дугаар	Одоогийн ХНХ хэмжээ (₮)	Нэмэгдсэн (₮)	Хорогдсон (₮)	Өөрчлөлтийн дараа	
						ХНХ хэмжээ (₮)	ХНХ-д эзлэх хувь (%)

Даатгалын хэлбэр

6	№	Даатгалын хэлбэр	Даатгалын бүтээгдэхүүний нэр /Даатгагч бол бөглөх/

Давхар даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх

7	Давхар даатгалын зуучлагчийн үйл ажиллагааг эрхлэх тухай шийдвэр	Шийдвэрийн нэр	Огноо	Дугаар
---	--	----------------	-------	--------

Даатгагч, даатгалын зуучлагч, хохирол үнэлэгчийн эрх бүхий албан тушаалтан

8	Албан тушаал	Овог	Нэр	Харьяалал	Регистрийн дугаар	Утасны дугаар

Оноосон нэр өөрчлөх

9	Даатгалын байгууллагын хуучин нэр	
10	Даатгалын байгууллагын шинэчилсэн нэр	
11	Оноосон нэрийг өөрчлөх болсон шалтгаан	

Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Даатгалын багц дүрэмд нийцүүлэн бүртгэлд шаардагдах баримт бичгийг үнэн зөв бүрдүүлж, хүргүүлэв. Бүрдүүлсэн баримт бичигт ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Манай хүсэлт, баримт бичгийг хүлээн авч, хянан шийдвэрлэж, бүртгэж өгнө үү.

Хүсэлт гаргасан:

_____ Овог, нэр _____ албан тушаал _____ гарын үсэг _____ огноо

Тамга:

“Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 1 дүгээр хавсралт (B)

Маягт СЗХ04005

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1	Хүсэлт гаргагч хуулийн этгээдийн нэр				
2	Хувьцаа эзэмшигч нь	<input type="checkbox"/> Хуулийн этгээд /3-17,28-г бөглөх/ <input type="checkbox"/> Иргэн /18-28-г бөглөх/			
Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн мэдээлэл					
3	Хуулийн этгээдийн нэр	Монгол			
		Англи (Хуулийн этгээдийн нэрийг латин үсгээр галиглан бичих)			
4	Үүсгэн байгуулагдсан огноо	Он	Сар	Өдөр	
	Үүсгэн байгуулагдсан улс				
5	Хуулийн этгээдийн хэлбэр	<input type="checkbox"/> Хувьцаат компани		<input type="checkbox"/> Хязгаарлагдмал хариуцлагатай компани	
6	Хөрөнгө оруулалтын хэлбэр	<input type="checkbox"/> Дотоодын хөрөнгө оруулалттай	<input type="checkbox"/> Гадаадын хөрөнгө оруулалттай <input type="checkbox"/> Гадаадын ХО-ын хувь		
7	Улсын бүртгэлийн дугаар				
8	Регистрийн дугаар				
9	Үйл ажиллагааны чиглэл				
10	Эцсийн өмчлөгч	Овог, нэр	Харьяалал	Регистрийн дугаар	
11	Хуулийн этгээдэд оруулах хувь нийлүүлсэн хөрөнгө ₮				
12	Хаяг байршил	Улс			
		Аймаг/ хот			
		Сум/дүүрэг			
		Баг/хороо			
		Гудамж, байр Тоот			
13	Холбоо барих утас	Суурин	Гар утас	Факс	
14	Цахим хуудас:				
	Цахим шуудангийн хаяг:				
15	Удирдлага	Овог	Нэр	Регистрийн дугаар	Утасны дугаар
	Гүйцэтгэх захирал				
16	Компанийн нэгдлийн оролцогч эсэх		Тийм <input type="checkbox"/> /17-г бөглөх/		Үгүй <input type="checkbox"/> /17-г бөглөх шаардлагагүй/
17	Компанийн нэгдлийн оролцогч компанийн оноосон нэр	Регистрийн дугаар	Үйл ажиллагааны төрөл		Тусгай зөвшөөрөл хүсэгчтэй ямар холбоотой болох
Хувьцаа эзэмшигч иргэний мэдээлэл					
18	Овог				
19	Нэр				
20	Харьяалал				
21	Регистрийн дугаар				
22	Албан ёсны хаяг байршил				
23	Эрхэлж байгаа ажил, албан тушаал				
24	Ажлын хаяг				
25	Эзэмшсэн мэргэжил				

26	Холбоо барих утасны дугаар		
27	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ ₮		
28	Хувь нийлүүлсэн хөрөнгийн эх үүсвэр	Эх үүсвэр	Мөнгөн дүн ₮

(Этгээдийн нэр)..... нь (даатгалын компани, давхар даатгалын компани, зуучлагч компани, хохирол үнэлэгч компани)-ийн хувьцаа эзэмшигч болж, тус компанийн дүрмийн санд оруулж байгаа (үсгээр) төгрөг нь хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагаанаас олсон цэвэр ашиг, орлогоос бүрдэж байгаа бөгөөд холбогдох материалыг үнэн зөвөөр хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэн Хороонд хүргүүлсэн болохоо нотлохын зэрэгцээ үүнээс үүсэх аливаа эрсдэлийг хууль тогтоомжийн дагуу бүрэн хариуцахаа илэрхийлж байна.

Тодорхойлолт гаргасан:

Овог нэр гарын үсэг албан тушаал оноосон нэр огноо

Тамга

Маягт СЗХ04006

**ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН БОЛОН
БУСАД БОЛОВСОН ХҮЧНИЙ ТОДОРХОЙЛОЛТ**

Ургийн овог:		
Овог нэр:		
Регистрийн дугаар:		
Иргэний харьяалал:		
Эрхлэх албан тушаал:		
Албан тушаалд томилохоор шийдвэрлэсэн	Огноо	
	Шийдвэрийн нэр	
	Шийдвэрийн дугаар	
Оршин суугаа газрын хаяг		
Гар утасны дугаар		
Цахим хаяг		
Одоо эрхэлж байгаа ажил		
Албан тушаал		
Ажлын хаяг		
Ажлын цахим хаяг		

Зураг

1. Ерөнхий мэдээлэл

2. Боловсролын талаар /Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ/

№	Төгссөн сургууль, сургалтын байгууллага	Эзэмшсэн мэргэжил/ боловсролын зэрэг	Элссэн он /огноо	Төгссөн он /огноо	Диплом, гэрчилгээ, мэргэшлийн үнэмлэхийн дугаар

3. Ажлын туршлагын талаар:

№	Ажиллаж байсан байгууллага	Албан тушаал	Ажилд орсон огноо	Ажлаас гарсан огноо	Шалтгаан

4. Эрх бүхий албан тушаалтан болон бусад боловсон хүчний холбогдох этгээдийн байдал:

№	Таны хэн болох	Овог, нэр /Хуулийн этгээдийн нэр/	Регистрийн дугаар	Эрхэлж буй ажил	Албан тушаал

Тодорхойлолт гаргасан:

Овог нэр

гарын үсэг

огноо



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

“Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 1 дүгээр хавсралт (Д)

Маягт СЗХ04007

**САЛБАР, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР НЭЭХ, ТАТАН БУУЛГАХ, ӨӨРЧЛӨН
БАЙГУУЛАХ БОЛОН САЛБАР, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫН УДИРДЛАГА,
ХАЯГИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН МЭДЭГДЛИЙН МАЯГТ**

1	Мэдэгдсэн огноо	Он	Сар	Өдөр
2	Мэдэгдэл гаргагчийн төрөл	<input type="checkbox"/> Даатгагч <input type="checkbox"/> Даатгалын зуучлагч <input type="checkbox"/> Даатгалын хохирол үнэлэгч		
3	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр ХК/ХХК		
Мэдэгдлийн төрлийг сонгоно уу.				
4	<input type="checkbox"/> Салбар, төлөөлөгчийн газар нээх, татан буулгах, өөрчлөн байгуулах /5-7-р хэсгийг бөглөх/ <input type="checkbox"/> Салбар төлөөлөгчийн газрын удирдлагын өөрчлөлт /8-г бөглөх/ <input type="checkbox"/> Ерөнхий захиргаа болон салбар төлөөлөгчийн газрын хаягийн өөрчлөлт /9-г бөглөх/			
Салбар, төлөөлөгчийн газар нээх тохиолдолд				
5	Салбар, төлөөлөгчийн газрыг байгуулах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр:			
	Салбар, төлөөлөгчийн газрын удирдлага (овог, нэр)		
	Салбар, төлөөлөгчийн газрын албан ёсны хаяг, байршил:			
	Салбар, төлөөлөгчийн газрын холбоо барих утасны дугаар:			
Салбар, төлөөлөгчийн газрыг татан буулгах тохиолдолд				
6	Салбар, төлөөлөгчийн газрыг татан буулгах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр:	Шийдвэрийн нэр	Огноо	Дугаар
Салбар, төлөөлөгчийн газрыг өөрчлөн байгуулах				
7	Салбар, төлөөлөгчийн газрыг өөрчлөн байгуулах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр:	Шийдвэрийн нэр	Огноо	Дугаар
Салбар, төлөөлөгчийн газрын удирдлагын өөрчлөлт				
8	Шинэ удирдлага томилогдсон тухай эрх бүхий этгээдийн шийдвэр	Шийдвэрийн нэр	Огноо	Дугаар
	Шинэ удирдлага	Овог		Нэр
Ерөнхий захиргаа болон салбар төлөөлөгчийн газрын хаягийн өөрчлөлт				
9	Хуучин хаяг:	Шинэ хаяг:		

Компанийн тухай хууль, Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Даатгалын багц дүрэмд нийцүүлэн мэдэгдлийг үнэн зөв бөглөж, хүргүүлэв. Дээрх мэдэгдэлд ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Мэдэгдэл гаргасан:

Овог, нэр

албан тушаал

гарын үсэг

огноо

Тамга:

ДААТГАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ МЭДЭГДЛИЙН МАЯГТ

1	Мэдэгдэл огноо	Он		Сар		Өдөр	
2	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр ХХ/ХХХ					
3	Даатгалын бүтээгдэхүүний нэр						
4	Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр						
5	Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр	Шийдвэрийн нэр	Огноо		Дугаар		
6	Цахимаар борлуулах эсэх	<input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй					
7	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Овог			Нэр		
Мэдээллийн төрлийг сонгоно уу.							
8	<input type="checkbox"/> Даатгалын бүтээгдэхүүнийг шинээр борлуулах						
	<input type="checkbox"/> Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэх						
Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл							
9	Даатгалын зүйл						
	Даатгалын үндсэн эрсдэл						
	Даатгалын нэмэлт эрсдэл						
	Даатгалын хураамжийн хувь, хэмжээ						

Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Даатгалын багц дүрэмд нийцүүлэн мэдэгдлийг үнэн зөв бөглөж, хүргүүлэв. Дээр мэдэгдсэн зүйл нь ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Мэдэгдэл гаргасан:

Овог, нэр

албан тушаал

гарын үсэг

огноо

Тамга:

“Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 2 дугаар хавсралт (А)

ДААТГАГЧИЙН ДҮРМИЙН САНГИЙН ХЭМЖЭЭ, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЦЭД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЗӨВШӨӨРЛИЙН ХҮСЭЛТЭД (МАЯГТ СЗХ04003) ХАВСАРГАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо	Албан хэрэгцээнд
1	Даатгагчийн дүрмийн сангийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, эрх бүхий этгээдийн шийдвэр		
2	Компанийн шинэчилсэн дүрмийн төсөл		
3	Хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгийг хууль ёсны орлогын эх үүсвэрээс бүрдсэнийг нотлох баримт /дүрмийн сангийн хэмжээг нэмэгдүүлэх, бүтцэд өөрчлөлт орсон тохиолдолд/		
4	СЗХ04005 маягтын дагуу бөглөсөн шинэ хувьцаа эзэмшигчийн тодорхойлолт, түүнд хавсаргах баримт бичгүүд /хувьцаа эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд/		
5	Хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох шалгуурыг хангасан эсэхийг тодорхойлох баримт бичгийн бүрдэл		
	Нийт		

“Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 2 дугаар хавсралт (Б)

АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ХҮСЭЛТЭД (МАЯГТ СЗХ04003) ХАВСАРГАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо	Албан хэрэгцээнд
1	Албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, эрх бүхий этгээдийн шийдвэр		
2	Албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотойгоор өөрчлөлт оруулсан бизнес төлөвлөгөө		
3	СЗХ04006 маягтын дагуу гаргасан Албан журмын даатгалын тухайн хэлбэрийн үйл ажиллагааг эрхлэх боловсон хүчний тодорхойлолт		
Даатгалын компани нь Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд 1-3 дугаартай баримт бичгүүдээс гадна дараах баримт бичгийг хавсаргана:			
4	Шуурхай албаны бүтэц бүрэлдэхүүн, зохион байгуулалтын талаарх танилцуулга эсхүл шуурхай албаны үйл ажиллагааг гүйцэтгүүлэхээр гэрээ хийсэн байгууллагын шуурхай албаны танилцуулга		
5	Шуурхай албаны эсхүл шуурхай албаны үйл ажиллагааг гүйцэтгүүлэхээр гэрээ хийсэн байгууллагын дуудлагын зориулалтын автомашины гэрчилгээний хуулбар		
6	Шуурхай албаны үйл ажиллагааг гүйцэтгүүлэх тухай гэрээ /шуурхай албаны үйл ажиллагааг гүйцэтгүүлэхээр гэрээ хийсэн тохиолдолд/		
7	Цахимаар даатгалын тохиолдлын талаарх мэдээллийг хүлээн авах, мэдээллийн аюулгүй байдал, үйлчлүүлэгчид зөвлөгөө өгөх дэвшилтэт технологийн шийдлийг ашиглах тохиолдолд уг технологийн дэлгэрэнгүй танилцуулга		
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаанаас бусад албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд 1-3 дугаартай баримт бичгүүдээс гадна дараах баримт бичгийг хавсаргана:			
8	Хууль тогтоомжид заасан бусад шаардлагатай баримт бичиг		
	Нийт		

“Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 2 дугаар хавсралт (В)

**ДААТГАГЧ, ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ, ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧИЙН
ДҮРМИЙН САНГИЙН ХЭМЖЭЭ, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ
БҮРЭЛДЭХҮҮНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ БҮРТГЭЛИЙН ХҮСЭЛТЭД (МАЯГТ СЗХ04004)
ХАВСАРГАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо	Албан хэрэгцээнд
1	Дүрмийн сангийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, эрх бүхий этгээдийн шийдвэр		
2	Компанийн шинэчилсэн дүрмийн төсөл		
3	Хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгийг хууль ёсны орлогын эх үүсвэрээс бүрдсэнийг нотлох баримт		
4	СЗХ04005 маягтын дагуу бөглөсөн шинэ хувьцаа эзэмшигчийн тодорхойлолт, түүнд хавсаргах баримт бичгүүд /хувьцаа эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд/		
5	Хорооноос баталсан тохиромжтой этгээдийн шалгуурыг хангасан эсхийг тодорхойлох баримт бичгийн бүрдэл		
	Нийт		

“Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 2 дугаар хавсралт (Г)

**ДААТГАЛЫН ХЭЛБЭР БҮРТГҮҮЛЭХ ХҮСЭЛТЭД (МАЯГТ СЗХ04004) ХАВСАРГАХ
БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо	Албан хэрэгцээнд
Даатгалын зуучлагч, хохирол үнэлэгч эрхлэх даатгалын хэлбэрийг бүртгүүлэхэд 1-3 дугаартай баримт бичгүүдийг хавсаргана:			
1	Тухайн даатгалын хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэх тухай эрх бүхий этгээдийн шийдвэр		
2	Даатгалын байгууллагын боловсон хүчин нь тухайн даатгалын хэлбэрээр мэргэшсэнийг нотлох баримт, СЗХ04006 маягтын дагуу гаргасан боловсон хүчний тодорхойлолт		
3	Бүртгүүлэх даатгалын хэлбэртэй холбогдуулан өөрчилсөн бизнес төлөвлөгөө болон эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө		
Даатгалын компани эрхлэх даатгалын хэлбэрийг бүртгүүлэх тохиолдолд 1-3 дугаартай баримт бичгүүдээс гадна дараах баримт бичгүүдийг хавсаргана:			
4	СЗХ04008 маягтын дагуу бөглөсөн 2-оос доошгүй даатгалын бүтээгдэхүүний мэдээлэл		
5	Даатгалын бүтээгдэхүүний судалгаа, ерөнхий танилцуулга		
	Нийт		

“Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 2 дугаар хавсралт (Д)

ДАВХАР ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ БҮРТГЭЛИЙН ХҮСЭЛТЭД (МАЯГТ СЗХ04004) ХАВСАРГАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо	Албан хэрэгцээнд
1	Давхар даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, шийдвэр эсхүл эрх бүхий этгээдийн шийдвэр		
2	Даатгалын зуучлагчийн боловсон хүчин нь давхар даатгалын зуучлагчийн чиглэлээр мэргэшсэнийг нотлох баримт, СЗХ04006 маягтын дагуу гаргасан боловсон хүчний тодорхойлолт		
3	Мэргэжлийн хариуцлагын даатгалын гэрээний төсөл		
	Нийт		

“Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 2 дугаар хавсралт (Е)

ДААТГАГЧ, ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ, ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ӨӨРЧЛӨЛТИЙГ БҮРТГҮҮЛЭХ ХҮСЭЛТЭД (МАЯГТ СЗХ04004) ХАВСАРГАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

1

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо	Албан хэрэгцээнд
1	Шинээр томилогдож буй эрх бүхий албан тушаалтны иргэний цахим үнэмлэх, мэргэжлийн дипломын хуулбар, нийгмийн даатгалын дэвтрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар		
2	Хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан эрх бүхий албан тушаалтны асуулгын хуудас		
3	СЗХ04006 маягтын дагуу гаргасан шинээр томилогдож буй эрх бүхий албан тушаалтны тодорхойлолт		
	Нийт		

“Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 2 дугаар хавсралт (Ё)

**ДААТГАГЧ, ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ, ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧИЙН
ОНООСОН НЭР ӨӨРЧЛӨХӨӨР ИРҮҮЛСЭН ХҮСЭЛТЭД (МАЯГТ СЗХ04004)
ХАВСАРГАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо	Албан хэрэгцээнд
1	Хуулийн этгээдийн оноосон нэрийг өөрчлөх тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, эрх бүхий этгээдийн шийдвэр		
2	Улсын бүртгэлийн албанаас авсан шинэ оноосон нэрийн баталгаажуулалт		
3	Өөрчлөлт оруулсан компанийн дүрэм		
	Нийт		

“Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 2 дугаар хавсралт (Ж)

СЗХ04007 МЭДЭГДЛИЙН МАЯГТАД ХАВСАРГАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо	Албан хэрэгцээнд
Даатгагч, даатгалын зуучлагч, хохирол үнэлэгч нь салбар, төлөөлөгчийн газар нээх тохиолдолд дараах 1-6 дугаартай баримт бичгүүдийг бүрдүүлж, мэдэгдлийн маягтад хавсаргана:			
1	Нэгж нээх тухай эрх бүхий этгээдийн шийдвэр		
2	Ажлын байрны үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, эсхүл түрээсийн гэрээний хуулбар		
3	СЗХ04006 маягтын дагуу гаргасан нэгжийн удирдлага, боловсон хүчний тодорхойлолт		
4	Нэгжийн удирдлага болон мэргэжлийн боловсон хүчний иргэний цахим үнэмлэх, мэргэжлийн дипломын хуулбар, нийгмийн даатгалын дэвтрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар		
5	Салбар, төлөөлөгчийн газрын дотоод үйл ажиллагааны журмын төсөл		
6	Салбарын удирдлага эсхүл мэргэжлийн боловсон хүчин нь Хороо, холбогдох мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулсан сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэнийг нотлох баримт		
Даатгалын компани салбар нээх тохиолдолд 1-6 дугаартай баримт бичгүүдээс гадна дараах баримт бичгийг хавсаргана:			
7	Салбарын арилжааны банкин дахь дансны хуулга		
Даатгалын хохирол үнэлэгч салбар, төлөөлөгчийн газар нээх тохиолдолд 1-6 дугаартай баримт бичгүүдээс гадна дараах баримт бичгүүдийг хавсаргана:			
8	Хөрөнгийн үнэлгээний тусгай зөвшөөрлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар / эрхлэх даатгалын хэлбэрийн хүрээнд эд хөрөнгөд учирсан бодит хохирлыг тогтоох тохиолдолд/		
Даатгалын компанийн салбар нь Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд 1-7 дугаартай баримт бичгүүдээс гадна дараах баримт бичгүүдийг хавсаргана:			
9	Салбарын шуурхай албаны бүтэц бүрэлдэхүүн, зохион байгуулалтын талаарх танилцуулга эсхүл шуурхай албаны үйл ажиллагааг гүйцэтгүүлэхээр гэрээ хийсэн байгууллагын шуурхай албаны танилцуулга		
10	Шуурхай албаны эсхүл шуурхай албаны үйл ажиллагааг гүйцэтгүүлэхээр гэрээ хийсэн байгууллагын дуудлагын зориулалтын автомашины гэрчилгээний хуулбар		
11	Шуурхай албаны үйл ажиллагааг гүйцэтгүүлэх тухай гэрээ /шуурхай албаны үйл ажиллагааг гүйцэтгүүлэхээр гэрээ хийсэн тохиолдолд/		
	Нийт		

“Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 2 дугаар хавсралт (3)

СЗХ04008 МЭДЭГДЛИЙН МАЯГТАД ХАВСАРГАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо	Албан хэрэгцээнд
1	Тухайн даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр		
2	Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий танилцуулга		
3	Энэ журамд заасан даатгагчийн ТУЗ-өөр батлуулсан даатгалын бүтээгдэхүүн боловсруулах журам		
Хорооноос даатгалын бүтээгдэхүүний онцлог цар хүрэнээс хамааран тусгайлсан шаардлага тавьсан тохиолдолд			
4	Хорооноос шаардсан бусад баримт бичиг		
	Нийт		

“Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 3 дугаар хавсралт

ДААТГАЛЫН БОЛОН ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ, БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН МАЯГТЫГ БӨГЛӨХ, БАРИМТ БИЧГИЙГ БҮРДҮҮЛЭХ ЗААВАР

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү зааврын зорилго нь даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, бүртгэл, мэдэгдлийн маягтыг бөглөх, тэдгээрт хавсаргах баримт бичигт тавигдах шаардлагыг тодорхойлоход оршино.

1.2. Зөвшөөрөл, бүртгэл, мэдэгдлийн маягтыг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид "Хороо" гэх/-ны цахим хуудас дахь (www.frc.mn) “зөвшөөрлийн цахим систем”-д хандаж бөглөнө. Маягтыг цаасан хэлбэрээр бөглөхдөө Хорооны цахим хуудаснаас маягтыг татаж авна.

1.3. Маягтыг бөглөхдөө техникийн үзүүлэлт, компанийн хэлбэрээс бусад тохиолдолд товчлол хэрэглэхгүй, овог нэр, оноосон нэр, он сар өдрийг бүтэн бичиж, хариулт сонголттой тохиолдолд тохирох нүдэнд “√” тэмдгийг тавина.

1.4. Гадаад улсад үүсгэн байгуулагдсан /гадаад улсад бүртгэлтэй/ хуулийн этгээдийн оноосон нэрийг түүний албан ёсны латин үсгээр бичигдсэн нэр болон Монгол үсгээр галиглан бичсэн нэрээр, регистрийн дугаарыг тухайн улсын бүртгэлийн албанаас олгосон бүртгэлийн дугаараар бичнэ.

1.5. Гадаад улсын иргэний талаарх мэдээллийг оруулахдаа овог нэрийг латин үсгээр бичиж, регистрийн дугаар хэсэгт гадаад паспортын дугаарыг бөглөнө.

1.6. Маягтыг бөглөхдөө шаардлагатай тохиолдолд хүснэгтийн тохирох хэсэгт үндсэн маягтын бүтцийн хүрээнд мөр, багана нэмж болно.

1.7. Маягтад дурдсан мэдээлэл тус бүрийн мөрийн дугаар болон хавсаргах баримт бичгийн жагсаалт дахь харгалзах дугаарын дагуу зааварчилгааг тусгасан болно.

1.8. Хүсэлт, мэдэгдэл, тодорхойлолт гаргагч нь хуулийн этгээд бол тухайн хүсэлт, мэдэгдэл, тодорхойлолт гаргагчийн эрх бүхий албан тушаалтан хүсэлт, мэдэгдэл, тодорхойлолтод овог нэр, албан тушаал, хүсэлт, , мэдэгдэл, тодорхойлолт гаргасан огноог бичиж, гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулна. Иргэн бол өөрийн овог нэр, хүсэлт, мэдэгдэл, , тодорхойлолт гаргасан огноог бичиж, гарын үсэг зурж баталгаажуулна.

1.9. Хүсэлт, мэдэгдэл, тодорхойлолтын маягтад гадаад валютыг хүсэлт, мэдэгдэл, тодорхойлолт гаргаж буй өдрийн Монголбанкны албан ханшаар төгрөгт шилжүүлэн илэрхийлнэ.

1.10. Бизнес төлөвлөгөө, дотоод үйл ажиллагааны журам болон эхлэлтийн тайланг “Даатгалын багц дүрэм”-ийн арван наймдугаар хавсралтад заасан холбогдох зөвлөмжийн дагуу боловсруулна.

ХОЁР. ЗӨВШӨӨРЛИЙН ХҮСЭЛТИЙН МАЯГТЫГ БӨГЛӨХ, БАРИМТ БИЧГИЙГ БҮРДҮҮЛЭХ

2.1. Зөвшөөрлийн хүсэлтийн СЗХ04003 маягтыг бөглөх

1) Хүсэлт гаргасан огноо: Он, сар, өдөр гэсэн дарааллаар тоогоор бичнэ.

2) Хүсэлт гаргагчийн нэр: Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн улсын бүртгэлийн гэрчилгээн

дэх оноосон нэрийг бичнэ.

3) Регистрийн дугаар: Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн улсын бүртгэлийн гэрчилгээн дэх регистрийн дугаарыг бичнэ.

4) Зөвшөөрлийн төрлийг сонгох: Маягтад дурдсан 3 төрлөөс зөвшөөрлийн хүсэлт гаргаж буй төрлийг сонгох бөгөөд сонгосон төрөлтэй холбогдуулан дараах байдлаар мэдээллийг бөглөнө.

- “Даатгагчийн дүрмийн сангийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах” төрлийг сонгосон нөхцөлд маягтын 5 дугаар мөрийг бөглөнө.
- “Албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх” төрлийг сонгосон нөхцөлд маягтын 6-7 дугаар мөрийг бөглөнө.

Даатгагчийн дүрмийн сангийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах

5) Даатгагчийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг бусдад худалдах, шилжүүлэх, өмчлөх, барьцаалахад даатгагчийн өмнөх болон шинэ хувьцаа эзэмшигч тус бүрийн хувьд мэдээллийг дараах байдлаар бөглөнө.

- Хувьцаа эзэмшигч: Хувьцаа эзэмшигч иргэн бол иргэний цахим үнэмлэх дэх овог нэр, хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээн дэх оноосон нэрийг бичнэ.
- Регистрийн дугаар: Хувьцаа эзэмшигч иргэн бол иргэний цахим үнэмлэх дэх регистрийн дугаар, хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээн дэх регистрийн дугаарыг бичнэ.
- Одоогийн ХНХ хэмжээ: Хороонд бүртгүүлсэн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хувьцаа эзэмшигч тус бүрээр төгрөгөөр илэрхийлж бичнэ.
- Нэмэгдсэн: Одоогийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээ нэмэгдүүлж байгаа тохиолдолд нэмэгдүүлж буй дүнг төгрөгөөр илэрхийлж бичнэ.
- Хорогдсон: Одоогийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээ бууруулж байгаа тохиолдолд бууруулж буй дүнг төгрөгөөр илэрхийлж бичнэ.
- Өөрчлөлтийн дараа ХНХ хэмжээ: Одоогийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээн дээр нэмэгдүүлж буй дүнг нэмээд, бууруулж буй дүнг хасаад гарсан дүнг төгрөгөөр илэрхийлж бичнэ.
- Өөрчлөлтийн дараа ХНХ-д эзлэх хувь: Дүрмийн сангийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэцэд өөрчлөлт орсны дараагаар дүрмийн санд хувьцаа эзэмшигч тус бүрийн эзлэх хувийг гаргаж бичнэ. (Нийт дүрмийн санг 100% гэж үзнэ)

Албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх

6) Эрхлэх албан журмын даатгалын хэлбэрийн нэрийг бичнэ.

7) Эрх бүхий этгээдийн гаргасан сонгосон албан журмын даатгалын хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэх шийдвэрийн нэр, шийдвэр гаргасан огноо, шийдвэрийн дугаарыг бичнэ.

2.2. СЗХ04003 маягтын дагуу гаргасан хүсэлтэд хавсаргах баримт бичиг, тавигдах шаардлага

2.2.1. Даатгагчийн дүрмийн сангийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэцэд өөрчлөлт оруулах хүсэлтэд хавсаргах баримт бичиг, тавигдах шаардлага

1. Даатгагчийн дүрмийн сангийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл /хувьцаа эзэмшигчийн шийдвэр/-ийн хүчин төгөлдөр эх хувь.
2. Дүрмийн санд өөрчлөлт орохтой холбоотойгоор шинэчлэн боловсруулсан компанийн дүрмийн

төсөл;

3. Дүрмийн сангийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн өөрчлөгдсөн бол дүрмийн санд оруулсан мөнгөн хөрөнгийн эх үүсвэр нь зээлийн хөрөнгөөр бүрдээгүй, мөн хууль бус үйл ажиллагаанаас орсон орлого биш гэдгийг батлахуйц баримт, бичгийг бүрдүүлнэ. Тухайлбал, хуримтлагдсан ашгаас дүрмийн санг бүрдүүлж байгаа нөхцөлд хувьцаа эзэмшигчдийн ногдол ашиг хуваарилах шийдвэр, хөрөнгийн орлогын албан татварын баримт, хөрөнгө худалдан борлуулсны орлогоор дүрмийн санг бүрдүүлэх нөхцөлд тухайн хөрөнгө хувьцаа эзэмшигчийн эзэмшлийн хөрөнгө мөн эсэхийг нотлох баримт бичиг, хөрөнгө худалдах худалдан авах гэрээ, төлбөр хийгдсэнийг нотлох баримт бичиг, хөрөнгө борлуулсны орлогын албан татвар төлсөн баримт, хувьцаа эзэмшигч нь хувь хүн бөгөөд хувийн харилцах, хадгаламжийн дансан дахь мөнгөн хөрөнгөөсөө дүрмийн санг бүрдүүлэх нөхцөлд харилцах хадгаламжийн дансны хуулга гэх мэт.
4. Хувьцаа эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд СЗХ04005 маягтын дагуу шинэ хувьцаа эзэмшигч тодорхойлолт гаргана. Тодорхойлолтод хувьцаа эзэмшигчийн иргэний цахим үнэмлэх (хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ), эрхэлж буй ажил, албан тушаалыг нотлох баримтыг хавсаргана. (тухайлбал нийгмийн даатгалын дэвтэр, албан байгууллагын тодорхойлолт гэх мэт...)
5. Хувьцаа эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд Хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан хувь хүн, хуулийн этгээд бүрийн бүрдүүлсэн баримт бичиг.

2.2.2. Албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хүсэлтэд хавсаргах баримт бичиг, тавигдах шаардлага

1. Албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх тухай удирдлагын шийдвэр /Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол гэх мэт/-ийн эх хувь эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбар.
2. Албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдуулан даатгагчийн бизнес төлөвлөгөөнд оруулсан өөрчлөлт
3. Албан журмын даатгалын үйл ажиллагааны мэдээллийн сангийн бүртгэл хөтлөх болон тухайн даатгалын чиглэлийн мэргэжлийн боловсон хүчний СЗХ04006 маягтын дагуу гаргасан тодорхойлолт.
4. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын тохиолдлыг шалгах шуурхай албаны бүтэц, бүрэлдэхүүн, зохион байгуулалтын талаарх танилцуулга. Хэрвээ даатгалын компани нь шуурхай албаны үйл ажиллагааг Албан журмын даатгагчдын холбоо болон хууль тогтоомжид заасан бусад байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх тохиолдолд гэрээ хийсэн байгууллагын шуурхай албаны бүтэц, бүрэлдэхүүн, зохион байгуулалтын талаарх танилцуулгыг хавсаргана.
5. Шуурхай албаны эсхүл шуурхай албаны үйл ажиллагааг гүйцэтгүүлэхээр гэрээ хийсэн байгууллагын дуудлагын зориулалтын автомашины гэрчилгээний хуулбар
6. Шуурхай албаны үйл ажиллагааг бусад байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх тохиолдолд тухайн гэрээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар.
7. Албан журмын даатгалын хэлбэрээс хамааран хууль тогтоомжид заасан бусад шаардлагатай баримт бичиг.

ГУРАВ. БҮРТГЭЛИЙН ХҮСЭЛТИЙН МАЯГТЫГ БӨГЛӨХ, БАРИМТ БИЧГИЙГ БҮРДҮҮЛЭХ

3.1 Бүртгэлийн хүсэлтийн СЗХ04004 маягтыг бөглөх

- 1) Хүсэлт гаргасан огноо: Он, сар, өдөр гэсэн дарааллаар тоогоор бичнэ.
- 2) Хүсэлт гаргагч даатгалын байгууллагын нэр: Даатгалын байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээн дэх оноосон нэрийг бичнэ.
- 3) Регистрийн дугаар: Даатгалын байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээн дэх регистрийн дугаарыг бичнэ..
- 4) Бүртгүүлэх мэдээллийн төрлийг сонгох: Маягтад дурдсан 5 төрлөөс бүртгүүлэхээр хүсэлт гаргаж буй төрлийг сонгох бөгөөд сонгосон төрөлтэй холбогдуулан дараах байдлаар мэдээллийг бөглөнө.
 - “Даатгагч, даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийн дүрмийн сангийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах” төрлийг сонгосон нөхцөлд маягтын 5 дугаар хэсгийг бөглөнө.
 - “Даатгалын хэлбэр бүртгүүлэх” төрлийг сонгосон нөхцөлд маягтын 6 дугаар хэсгийг бөглөнө.
 - “Давхар даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх” төрлийг сонгосон нөхцөлд маягтын 7 дугаар хэсгийг бөглөнө.
 - “Даатгалын зуучлагч, хохирол үнэлэгчийн эрх бүхий албан тушаалтан” төрлийг сонгосон нөхцөлд маягтын 8 дугаар хэсгийг бөглөнө.
 - “Оноосон нэр өөрчлөх” төрлийг сонгосон нөхцөлд маягтын 9-11 дүгээр хэсгийг бөглөнө.

Даатгагч, даатгалын зуучлагч, хохирол үнэлэгчийн дүрмийн сангийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах

- 5) Даатгагч, даатгалын зуучлагч, хохирол үнэлэгчийн өмнөх болон шинэ хувьцаа эзэмшигч тус бүрийн хувьд мэдээллийг дараах байдлаар бөглөнө.
 - Хувьцаа эзэмшигч: Хувьцаа эзэмшигч иргэн бол иргэний цахим үнэмлэх дэх овог нэр, хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээн дэх оноосон нэрийг бичнэ.
 - Регистрийн дугаар: Хувьцаа эзэмшигч иргэн бол иргэний цахим үнэмлэх дэх регистрийн дугаар, хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээн дэх регистрийн дугаарыг бичнэ.
 - Одоогийн ХНХ хэмжээ: Хороонд бүртгүүлсэн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хувьцаа эзэмшигч тус бүрээр төгрөгөөр илэрхийлж бичнэ.
 - Нэмэгдсэн: Одоогийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээ нэмэгдүүлж байгаа тохиолдолд нэмэгдүүлж буй дүнг төгрөгөөр илэрхийлж бичнэ.
 - Хорогдсон: Одоогийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээ бууруулж байгаа тохиолдолд бууруулж буй дүнг төгрөгөөр илэрхийлж бичнэ.
 - Өөрчлөлтийн дараа ХНХ хэмжээ: Одоогийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээн дээр нэмэгдүүлж буй дүнг нэмээд, бууруулж буй дүнг хасаад гарсан дүнг төгрөгөөр илэрхийлж бичнэ.
 - Өөрчлөлтийн дараа ХНХ-д эзлэх хувь: Дүрмийн сангийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орсны дараагаар дүрмийн санд хувьцаа эзэмшигч тус

бүрийн эзлэх хувийг гаргаж бичнэ. (Нийт дүрмийн санг 100% гэж үзнэ)

Даатгалын хэлбэр бүртгүүлэх

6) Бүртгүүлэх хүсэлт гаргаж буй даатгалын хэлбэр, түүнд хамаарах бүтээгдэхүүний нэрийг бичнэ.

Давхар даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх

7) Давхар даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, шийдвэр эсхүл эрх бүхий этгээдийн шийдвэрийн нэр, огноо, тушаал, шийдвэрийн дугаарыг харгалзах баганад тохируулан бичнэ.

Даатгагч, даатгалын зуучлагчийн, хохирол үнэлэгчийн эрх бүхий албан тушаалтны өөрчлөлт

8) Даатгалын зуучлагч, хохирол үнэлэгчийн эрх бүхий албан тушаалтныг бүртгүүлэхдээ дараах мэдээллийг бөглөнө:

- Албан тушаал: Тухайн байгууллагад эрхлэх албан тушаалыг бичнэ.
- Овог, нэр, харьяалал, регистрийн дугаар: Тухайн албан тушаалтны иргэний цахим үнэмлэх дэх овог, нэр, харьяалал, регистрийн дугаарыг бичнэ.
- Утасны дугаар: Тухайн албан тушаалтны гэрийн болон гар утасны дугаарыг бичнэ.

Оноосон нэр өөрчлөх

9) Даатгалын байгууллагын хуучин оноосон нэрийг бичнэ.

10) Даатгалын байгууллагын шинэ оноосон нэрийг бичнэ.

11) Оноосон нэрийг өөрчлөх болсон шалтгааныг товч, тодорхой бичнэ.

3.2. СЗХ04004 маягтын дагуу гаргасан хүсэлтэд хавсаргах баримт бичиг, тавигдах шаардлага

3.2.1. Даатгагчийн энгийн хувьцааны 10-с доош хувийг бусдад шилжүүлэх, худалдах, өмчлөх, барьцаалахад болон даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийн дүрмийн сангийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах хүсэлтэд хавсаргах баримт бичиг, тавигдах шаардлага

1. Даатгагч, даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийн дүрмийн сангийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл /хувьцаа эзэмшигчийн шийдвэр/-ийн хүчин төгөлдөр эх хувь.
2. Дүрмийн санд өөрчлөлт орохтой холбоотойгоор шинэчлэн боловсруулсан компанийн дүрмийн төсөл;
3. Дүрмийн сангийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөн бол дүрмийн санд оруулсан мөнгөн хөрөнгийн эх үүсвэр нь зээлийн хөрөнгөөр бүрдээгүй, мөн хууль бус үйл ажиллагаанаас орсон орлого биш гэдгийг батлахуйц баримт, бичгийг бүрдүүлнэ. Тухайлбал, хуримтлагдсан ашгаас дүрмийн санг бүрдүүлж байгаа нөхцөлд хувьцаа эзэмшигчдийн ногдол ашиг хуваарилах шийдвэр, хөрөнгийн орлогын албан татварын баримт, хөрөнгө худалдан борлуулсны орлогоор дүрмийн санг бүрдүүлэх нөхцөлд тухайн хөрөнгө хувьцаа эзэмшигчийн эзэмшлийн хөрөнгө мөн эсэхийг нотлох баримт бичиг, хөрөнгө худалдах худалдан авах гэрээ, төлбөр хийгдсэнийг нотлох баримт бичиг, хөрөнгө борлуулсны орлогын албан татвар төлсөн баримт, хувьцаа эзэмшигч нь хувь хүн бөгөөд хувийн харилцах, хадгаламжийн дансан дахь мөнгөн хөрөнгөөсөө дүрмийн санг бүрдүүлэх нөхцөлд харилцах хадгаламжийн дансны хуулга гэх мэт.
4. Хувьцаа эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд СЗХ04005 маягтын дагуу шинэ хувьцаа

эзэмшигч тодорхойлолт гаргана. Тодорхойлолтод хувьцаа эзэмшигчийн иргэний цахим үнэмлэх (хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ), эрхэлж буй ажил, албан тушаалыг нотлох баримтыг хавсаргана. (тухайлбал нийгмийн даатгалын дэвтэр, албан байгууллагын тодорхойлолт гэх мэт...)

5. Хувьцаа эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд Хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-д заасан хувь хүн, хуулийн этгээд бүрийн бүрдүүлсэн баримт бичиг.

3.2.2. Даатгалын хэлбэр бүртгүүлэх хүсэлтэд хавсаргах баримт бичиг, тавигдах шаардлага

1. Компанийн дүрэмд заасан эрх хэмжээний хүрээнд тухайн даатгалын хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэх тухай Хувьцаа эзэмшигчдийн хурал эсвэл Төлөөлөн удирдах зөвлөлийн тэмдэглэл, хүчин төгөлдөр шийдвэрийн эх хувь;
2. Даатгалын байгууллагын боловсон хүчний мэргэжлийн диплом, холбогдох сургалтад хамрагдсаныг нотлох гэрчилгээ, сертификат болон сургалтын хөтөлбөрт тухайн чиглэлээр хичээл орсон эсэхийг нотлох баримт бичиг, тодорхойлолтын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, СЗХ04006 маягтын дагуу гаргасан тодорхойлолт.
3. Даатгалын хэлбэр эрхлэхтэй холбоотойгоор компанийн бизнес төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсны дагуу шинэчлэн боловсруулсан бизнес төлөвлөгөө.
4. Даатгалын хэлбэр, бүтээгдэхүүнийг борлуулах шаардлага, хэрэгцээ, зах зээлийн багтаамж, ашигт ажиллагаа, борлуулалтын суваг, давхар даатгуулах эсэх зэрэг мэдээллийг багтаасан судалгаа, танилцуулга.
5. Даатгалын гэрээ, баталгааны загвар: “Даатгалын багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралтад заасан заасан нөхцөлийг тусгасан, Даатгалын тухай хууль болон даатгалын багц дүрмээр тавигдсан шаардлагыг хангасан даатгалын бүтээгдэхүүний гэрээний болон баталгааны загвар;
6. Даатгалын хэлбэр, бүтээгдэхүүний журам: Тухайн даатгалын хэлбэр, бүтээгдэхүүнтэй холбоотойгоор даатгалын гэрээ байгуулах, даатгалын нөхөн төлбөр олгохтой холбоотой харилцааг нарийвчлан зохицуулсан журам, заавар;
7. Даатгалын хэлбэрт хамаарах бүтээгдэхүүн тус бүрийн хураамжийн хувь хэмжээ, нөөц сангийн тооцоолол, танилцуулга: Даатгалын бүтээгдэхүүн тус бүрийн хувьд даатгалын хураамжийн хэмжээг тооцоолохдоо ашигласан тоон мэдээлэл, аргачлал, эрсдэл тус бүрийн түвшин, хувь хэмжээ, түүнийг тооцоолсон аргачлал, цэвэр хураамжийн хувь, нийт хураамжийн хувийн талаарх мэдээллийг агуулсан актуарын тайлан, танилцуулга. Актуарын тайланг тухайн компанийн актуарч гарын үсэг зурж, баталгаажуулсан байна.

3.2.3. Давхар даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх хүсэлтэд хавсаргах баримт бичиг, тавигдах шаардлага

1. Давхар даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, шийдвэр эсхүл эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хувь;
2. Даатгалын зуучлагчийн боловсон хүчин нь давхар даатгалын зуучлалын чиглэлээр мэргэшсэнийг нотлох баримт, СЗХ04006 маягтын дагуу гаргасан боловсон хүчний тодорхойлолт;
3. “Даатгалын багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралтад заасан мэргэжлийн хариуцлагын даатгалын гэрээний төсөл.

3.2.4. Даатгагч, даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийн эрх бүхий албан тушаалтны өөрчлөлтийг бүртгүүлэх хүсэлтэд хавсаргах баримт бичиг, тавигдах шаардлага

1. Шинээр томилогдож буй эрх бүхий албан тушаалтны иргэний цахим үнэмлэх, мэргэжлийн диплом, эрхэлж байсан болон эрхэлж буй ажил, албан тушаалыг нотлох баримт бичиг (нийгмийн даатгалын дэвтэр, албан байгууллагын тодорхойлолт гэх мэт...)-ийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар.
2. Хорооноос баталсан Тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан баримт бичиг
3. СЗХ04006 маягтын дагуу гаргасан шинээр томилогдож буй эрх бүхий албан тушаалтны тодорхойлолт.

3.2.5. Оноосон нэр өөрчлөхөөр ирүүлсэн хүсэлтэд хавсаргах баримт бичиг, тавигдах шаардлага

1. Хуулийн этгээдийн оноосон нэрийг өөрчлөх тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хувь, нотариатаар гэрчлүүлсэн хуулбар.
2. Улсын бүртгэлийн албанаас авсан шинэ оноосон нэрийн баталгаажуулалт.
3. Хуулийн этгээдийн оноосон нэр өөрчлөгдөж байгаатай холбогдуулан шинэчилсэн компанийн дүрмийн төсөл.

ДӨРӨВ. ТОДОРХОЙЛОЛТ БӨГЛӨХ

4.1. Хувьцаа эзэмшигчийн тодорхойлолт СЗХ04005 маягтыг бөглөх

- 1) Хороонд өргөдөл гаргаж буй хуулийн этгээдийн оноосон нэрийг бичнэ.
- 2) Хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд, иргэн аль нь болохыг сонгоно. Хуулийн этгээд бол 3-17, 28 дугаар мөрүүдийг бөглөнө. Иргэн бол 18-28 дугаар мөрүүдийг бөглөнө.

Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн мэдээлэл

- 3) Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн оноосон нэрийг бичнэ:
Монгол – хуулийн этгээдийн оноосон нэрийг кирилл үсгээр;
Англи – хуулийн этгээдийн нэрийг латин үсгээр галиглан бичнэ.
- 4) Хуулийн этгээдийн үүсгэн байгуулсан хурлын огноог он, сар, өдөр гэсэн дарааллаар бичнэ.
- 5) Хуулийн этгээдийн хэлбэр: ХК-хувьцаат компани, ХХК- Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн аль нь болохыг сонгоно.
- 6) Хөрөнгө оруулалтын хэлбэрээс тохирох нүдийг сонгож, гадаадын хөрөнгө оруулалттай бол нийт хувьцааны хэдэн хувийг гадаадын хөрөнгө оруулагч

Дотоодын хөрөнгө оруулалттай компани гэдэгт нийт хувьцааг /100 хувь/ Монгол улсын иргэн, Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээд эзэмшдэг,

Гадаадын хөрөнгө оруулалттай компани гэдэгт нийт гаргасан хувьцааны 25 буюу түүнээс дээш хувийг гадаадын хөрөнгө оруулагч эзэмшиж байгаа бөгөөд гадаадын хөрөнгө оруулагч тус бүрийн оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ 100 мянган ам.доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс дээш байх аж ахуй нэгжийг тус тус ойлгоно.

- 7) Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээн дэх улсын бүртгэлийн дугаарыг бичнэ.
- 8) Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээн дэх регистрийн дугаарыг бичнэ.
- 9) Хуулийн этгээдийн эрхэлж буй үйл ажиллагааны чиглэлийг бичнэ.
- 10) Эцсийн өмчлөгчийн овог, нэр, харьяалал, регистрийн дугаарыг харгалзах мөр бүрд

тохируулан бичнэ.

- 11) Өргөдөл гаргагч хуулийн этгээдэд оруулах хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг төгрөгөөр илэрхийлэн бичнэ.
 - 12) Хаяг байршил: Хуулийн этгээдийн хаягийг хүснэгтийн дагуу дэлгэрэнгүй бичнэ.
 - 13) Холбоо барих утас: Хуулийн этгээдийн холбоо барих суурин, гар утас, факсын дугаарыг бичнэ.
 - 14) Цахим хуудас: Хуулийн этгээдийн албан ёсны цахим хуудсыг бичнэ.
- Цахим шуудангийн хаяг: Хуулийн этгээдийн цахим шуудангийн хаягийг бичнэ
- 15) Хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын овог, нэр, регистрийн дугаар, холбоо барих утасны дугаарыг бичнэ.
 - 16) Компанийн нэгдлийн оролцогч эсэхийг сонгоно.
 - 17) Компанийн нэгдлийн оролцогчийн регистрийн дугаар, үйл ажиллагааны төрөл, хувьцаа эзэмшигчтэй ямар холбоотой болохыг бичнэ.

Хувьцаа эзэмшигч иргэний мэдээлэл

- 18) Хувьцаа эзэмшигч иргэний овог буюу иргэний цахим үнэмлэх дээрх эцэг/эх/-ийн нэрийг бичнэ.
- 19) Хувьцаа эзэмшигч иргэний нэрийг бичнэ.
- 20) Хувьцаа эзэмшигч иргэний харьяаллыг бичнэ.
- 21) Иргэний регистрийн дугаарыг бичнэ.
- 22) Иргэний оршин суугаа газрын хаягийг улс, аймаг/хот, сум/дүүрэг, баг/хороо, гудамж/байр, тоот гэсэн дарааллаар бичнэ.
- 23) Тодорхойлолт гаргаж буй өдрийн байдлаар эрхэлж байгаа ажил, ажиллаж буй газар, албан тушаалын талаар бичнэ.
- 24) Ажил эрхэлдэг бол ажлын газрын хаягийг улс, аймаг/хот, сум/дүүрэг, баг/хороо, гудамж/байр, тоот гэсэн дарааллаар бичнэ.
- 25) Хувьцаа эзэмшигч нь мэргэжил эзэмшсэн бол эзэмшсэн мэргэжлийн нэрийг бичнэ.
- 26) Хувьцаа эзэмшигч иргэнтэй холбоо барих утасны дугаарыг бичнэ.
- 27) Хүсэлт гаргагч хуулийн этгээдэд оруулах хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг төгрөгөөр илэрхийлэн бичнэ.
- 28) Хувь нийлүүлсэн хөрөнгийн эх үүсвэрийн нэрийг, тухайн эх үүсвэрийн мөнгөн дүнг төгрөгөөр илэрхийлэн бичнэ. /Компанийн ногдол ашиг, тээврийн хэрэгсэл, үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого, бизнес, хадгаламж, түрээсийн орлого, менежментийн урамшуулал гэх мэт/

4.2. Эрх бүхий албан тушаалтан болон бусад боловсон хүчний тодорхойлолт СЗХ04006 маягтыг бөглөх

- 1) Ерөнхий мэдээлэл хэсэгт Компанийн тухай хуульд заасан эрх бүхий албан тушаалтан болон боловсон хүчин нь өөрийн мэдээллийг хүснэгтийн дагуу оруулна.
 - Эрхлэх албан тушаал мөрөнд даатгалын байгууллагад эрхлэх албан тушаалын нэрийг бичнэ. Дараагийн мөрөнд тухайн албан тушаалд сонгогдсон огноо, шийдвэрийн нэр/ ТУЗ-ын тогтоол, гүйцэтгэх захирлын тушаал гэх мэт/, шийдвэрийн дугаарыг бичнэ.

- Өөр байгууллагад давхар ажил эрхэлдэггүй тохиолдолд “Одоо эрхэлж байгаа ажил, Албан тушаал, Ажлын хаяг, Ажлын цахим хаяг” гэсэн удаах мөрүүдийг бөглөх шаардлагагүй. Өөр байгууллагад давхар ажил эрхэлж байгаа тохиолдолд дээрх мөрүүдийг бөглөнө.
 - Маягтад сүүлийн 3 сарын дотор авхуулсан 3*4 хэмжээтэй цээж зургийг оруулна.
- 2) Боловсролын талаарх мэдээллийг хүснэгтүүдийн дагуу оруулна. Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан боловсрол эзэмшсэн их дээд сургуулиудын нэрс, эзэмшсэн мэргэжил, тухайн сургуульд элссэн, төгссөн он, диплом, гэрчилгээний дугаарыг бичнэ. Мөн санхүүгийн болон даатгалын чиглэлээр мэргэшил олгох сургалтад хамрагдсан бол тухайн мэргэшил олгосон сургалтын байгууллагын нэр, эзэмшсэн мэргэжил хэсэгт мэргэшлийн нэр, тухайн сургалтад элсэн орсон, төгссөн огноо, гэрчилгээ, мэргэшлийн үнэмлэхийн дугаарыг бичнэ.
 - 3) Ажлын туршлагын талаарх мэдээллийг хүснэгтүүдийн дагуу оруулна. Ажиллаж байсан байгууллага хэсэгт ажиллаж байсан байгууллагын нэр, тухайн байгууллагад эрхэлж байсан албан тушаал, ажилд орсон огноо, ажлаас гарсан огноо, ажлаас гарсан шалтгааныг товч тодорхой бичнэ.
 - 4) Холбогдох этгээд гэдэгт Компанийн тухай хуулийн 89.2-т заасан нэгдмэл сонирхолтой этгээдийг ойлгоно. Холбогдох этгээд нь эрх бүхий албан тушаалтан болон бусад боловсон хүчний Компанийн тухай хуулийн 89.2-т заасан этгээдийн аль нь болохыг тодорхойлж “таны хэн болох” хэсэгт бичнэ. Холбогдох этгээд нь иргэн бол түүний овог, нэр, регистрийн дугаар, эрхэлж буй ажил эсхүл ажиллаж буй байгууллагын нэр, албан тушаалыг бичнэ. Холбогдох этгээд нь хуулийн этгээд бол хуулийн этгээдийн оноосон нэр, регистрийн дугаарыг бичнэ.

ТАВ. МЭДЭГДЛИЙН МАЯГТЫГ БӨГЛӨХ

5.1.Салбар, төлөөлөгчийн газар нээх, татан буулгах, өөрчлөн байгуулах болон салбар, төлөөлөгчийн газрын удирдлага, хаягийн өөрчлөлтийн мэдэгдлийн СЗХ04007 маягтыг бөглөх

- 1) Хороонд мэдэгдлийг ирүүлсэн огноог бөглөнө.
- 2) Мэдэгдэл ирүүлж буй хуулийн этгээдийн төрлийг сонгоно
- 3) Мэдэгдэл ирүүлж буй хуулийн этгээдийн оноосон нэрийг бичнэ
Монгол – хуулийн этгээдийн оноосон нэрийг кирилл үсгээр;
Англи – хуулийн этгээдийн нэрийг латин үсгээр галиглан бичнэ.

Хуулийн этгээдийн хэлбэр: ХК-хувьцаат компани, ХХК- Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн аль нь болохыг сонгоно.

- 4) Мэдэгдлийн төрлийг сонгож бөглөнө.
- 5) Салбар, төлөөлөгчийн газрыг байгуулах тухай эрх бүхий этгээдийн шийдвэрийн он, сар, өдөр, шийдвэрийн дугаар, газрын удирдлагын овог, нэр, албан ёсны хаяг байршил, холбоо барих утасны дугаарыг харгалзах мөрүүдэд тодорхой бичнэ.
- 6) Салбар, төлөөлөгчийн газрыг татан буулгах тухай эрх бүхий этгээдийн шийдвэрийн нэр, огноо, дугаарыг харгалзах баганад тохируулан бичнэ.
- 7) Салбар, төлөөлөгчийн газрыг өөрчлөн байгуулах тухай эрх бүхий этгээдийн шийдвэрийн нэр, огноо, дугаарыг харгалзах баганад тохируулан бичнэ.
- 8) Салбар, төлөөлөгчийн газрын шинэ удирдлагыг томилсон тухай эрх бүхий этгээдийн шийдвэрийн нэр, огноо, дугаарыг харгалзах баганад тохируулан бичнэ. Мөн шинэ удирдлагын овог, нэрийг харгалзах баганад кирилл үсгээр бичнэ.
- 9) Хуучин хаяг болон шинэ хаягийг харгалзах баганад тохируулан бичнэ.

5.2. Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн СЗХ04008 маягтыг бөглөх

- 1) Хороонд мэдэгдлийг ирүүлсэн огноог бөглөнө.
- 2) Мэдэгдэл ирүүлж буй хуулийн этгээдийн оноосон нэрийг бичнэ
Монгол – хуулийн этгээдийн оноосон нэрийг кирилл үсгээр;
Англи – хуулийн этгээдийн нэрийг латин үсгээр галиглан бичнэ.

Хуулийн этгээдийн хэлбэр: ХК-хувьцаат компани, ХХК- Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн аль нь болохыг сонгоно.

- 3) Даатгалын бүтээгдэхүүний нэрийг бичнэ.
- 4) Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэрийг бичнэ.
- 5) Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэрийн нэр, огноо, шийдвэрийн дугаарыг харгалзах баганад тохируулан бичнэ.
- 6) Цахимаар борлуулах эсхийг сонгож, бөглөнө.
- 7) Даатгалын хураамжийн тооцооллыг боловсруулсан актуарчийн овог, нэрийг харгалзах баганад тохируулан бичнэ
- 8) Даатгалын бүтээгдэхүүнийг шинээр болон шинэчлэн борлуулж байгаа эсхийг бөглөнө.
- 9) Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээллийг харгалзах мөрийн дагуу дэлгэрэнгүй бичнэ.

5.3. Салбар, төлөөлөгчийн газар нээх, татан буулгах, өөрчлөн байгуулах болон салбар, төлөөлөгчийн газрын удирдлага, хаягийн өөрчлөлтийн мэдэгдлийн маягтад хавсаргах баримт бичиг, тавигдах шаардлага

1. Салбар, төлөөлөгчийн газар нээх тухай удирдлагын шийдвэрийн эх хувь эсхүл шийдвэрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар /хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, хувьцаа эзэмшигчийн шийдвэр, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тогтоол гэх мэт/
2. Ажлын байрыг худалдан авсан бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбар, түрээсэлсэн бол түрээсийн гэрээний хуулбар.
3. СЗХ04006 маягтын дагуу гаргасан салбар, төлөөлөгчийн газрын удирдлага, мэргэжлийн боловсон хүчин бүрийн бөглөсөн тодорхойлолт.
4. Салбар, төлөөлөгчийн газрын удирдлага болон мэргэжлийн /даатгалын борлуулалтын ажилтан, даатгалын менежер, даатгалын нөхөн төлбөрийн ахлах ажилтан/ боловсон хүчний иргэний цахим үнэмлэхийн хуулбар, мэргэжлийн /даатгал, санхүү, эдийн засаг болон бусад/ дипломын хуулбар, мэргэшлийн үнэмлэх, гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, өмнө нь даатгалын байгууллагад ажиллаж байсан бол тус байгууллагын гаргасан тодорхойлолт, нийгмийн даатгалын дэвтрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар.
5. Салбар, төлөөлөгчийн газрын эрхлэх үйл ажиллагааны чиглэл, дотоод үйл ажиллагаанд баримтлах зарчим, дүрмийг тодорхойлсон дотоод үйл ажиллагааны журмын төсөл.
6. Салбарын удирдлага эсхүл боловсон хүчин нь Хороо, холбогдох мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулсан даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцээнийг нотлох баримт.
7. Даатгалын компани салбар нээх тохиолдолд тухайн салбарын арилжааны банкин дахь дансны хуулга.
8. Даатгалын хохирол үнэлэгч салбар, төлөөлөгчийн газар нээх тохиолдолд дээр дурдсан 1-6 дугаартай баримт бичгүүдээс гадна эрхлэх даатгалын хэлбэрээс хамааран эд хөрөнгөнд

учирсан бодит хохирлыг тогтоох бол салбарын 1-ээс доошгүй ажилтны Хөрөнгийн үнэлгээний тусгай зөвшөөрлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг хавсаргана.

9. Даатгалын компанийн салбар нь Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд салбарын шуурхай албаны эсхүл шуурхай албаны үйл ажиллагааг гүйцэтгүүлэхээр гэрээ хийсэн байгууллагын шуурхай албаны бүтэц бүрэлдэхүүн, зохион байгуулалтын талаарх танилцуулга.
10. Шуурхай албаны эсхүл шуурхай албаны үйл ажиллагааг гүйцэтгүүлэхээр гэрээ хийсэн байгууллагын дуудлагын зориулалтын автомашины гэрчилгээний хуулбар.
11. Даатгалын компани нь тухайн салбарын шуурхай албаны үйл ажиллагааг гүйцэтгүүлэхээр бусад хуулийн этгээдтэй байгуулсан гэрээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар.
- 5.4. Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягтад хавсаргах баримт бичиг тавигдах шаардлага
 1. Даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тэмдэглэл, хүчин төгөлдөр шийдвэрийн эх хувь;
 2. Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий танилцуулга;
 3. Энэ журмын 3.4.3.1.а-д заасан ТУЗ-өөр батлуулсан даатгалын бүтээгдэхүүн боловсруулах журмын хуулбар
 4. Хорооноос даатгалын бүтээгдэхүүний онцлог цар хүрээнээс хамааран тусгайлсан шаардлага тавьсан тохиолдолд Хорооноос шаардсан баримт бичиг

ЗУРГАА. БУСАД

6.1. Энэ зааврын дагуу даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, мэдэгдэл, бүртгэлийн маягтыг бөглөөгүй, баримт бичгийг бүрдүүлээгүй тохиолдолд даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, бүртгэлийн, мэдэгдлийн баримт бичгийг бүрэн гүйцэд бүрдүүлээгүй гэж үзэх үндэслэл болно.

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 01 дүгээр сарын
09-ний өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан
“Даатгалын багц дүрэм”-ийн хоёрдугаар хавсралт

ДААТГАГЧИЙН ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэ журмын зорилго нь даатгагч даатгуулагчийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлэхэд хүрэлцэхүйц хэмжээний хөрөнгөтэй эсэхийг тодорхойлох, төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ноос хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2 Даатгагч нийт хөрөнгөөс хөрөнгө оруулалт хийхийн өмнө төлбөрийн чадварт нөлөөлөх дараах үзүүлэлтүүдийг авч үзнэ. Үүнд:

- 1.2.1 Гэнэтийн хүлээж болзошгүй эрсдэл;
- 1.2.2 Төлбөрийн чадварт нөлөөлөх эрсдэл;
- 1.2.3 Даатгуулагчаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн байдал;
- 1.2.4 Хөрөнгө оруулалтаас авсан өгөөж;
- 1.2.5 Эргэлтийн хөрөнгөөр төлбөр түргэн гүйцэтгэх чадвар;
- 1.2.6 Бусад шаардлагатай үзүүлэлтүүд.

1.3 Даатгагч төлбөрийн чадварыг тооцохдоо холбогдох эрх бүхий ажилтнаар баталгаажсан санхүүгийн тайлан, тэнцлийн үзүүлэлтүүдийг ашиглана.

1.4 Даатгагч энэ журмын 2.4 болон 3.4-т заасны дагуу хөрөнгөө байршуулахад Даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан хязгаарлалтыг харгалзахаас гадна дараах этгээдээс бусад этгээдэд хөрөнгө оруулалт байршуулж болно.

- 1.4.1 даатгалын тухай хуулийн 4.1.12-т заасан холбогдох этгээд;
- 1.4.2 барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэлгээ нь зээлийн үндсэн өр болон хүүгийн төлбөрийг барагдуулахад хүрэлцэхгүй байгаа иргэн, хуулийн этгээд;
- 1.4.3 холбогдох этгээдтэй хэрэг, маргаан үүссэний улмаас эрх бүхий байгууллагаар хянагдаж, шалгагдаж байгаа этгээд;
- 1.4.4 даатгалын компани өөрөө холбогдох этгээд гэж үзсэн бусад этгээд.

ХОЁР. ЕРДИЙН БОЛОН ДАВХАР ДААТГАГЧИЙН ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

2.1 Даатгагчийн төлбөрийн чадварын байдлыг төлбөрийн чадварын зохистой харьцаагаар тодорхойлно.

2.2 Төлбөрийн чадварын зохистой харьцааг даатгагчийн зөвшөөрөгдөх хөрөнгийн дүнг өр төлбөрийн дүн ба зайлшгүй байх хөрөнгийн нийлбэр дүнд хуваах замаар буюу дараах томъёогоор тооцно.

$$TЧЗХ = 3X / (ЗБХ + \Theta T) * 100\%$$

, Үүнд:

TЧЗХ – төлбөрийн чадварын зохистой харьцаа

3X – зөвшөөрөгдөх хөрөнгийн дүн

ЗБХ – зайлшгүй байх хөрөнгийн дүн

\Theta T – өр төлбөрийн дүн

2.3 Зөвшөөрөгдөх хөрөнгийн дүнг даатгагчийн нийт хөрөнгөөс зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн дүнг хасах замаар буюу дараах томъёогоор тооцно.

$$3X = НХ - 3qX$$

, Үүнд:

3X – зөвшөөрөгдөх хөрөнгийн дүн

НХ – нийт хөрөнгийн дүн /Даатгагчийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүнгээс давхар даатгалын хойшлогдсон хураамж, нөхөн төлбөрийн нөөцийн сангийн давхар даатгагчид ногдох хэсгийг хассан дүн/

3qX – зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн дүн

2.4 Даатгагч нь дараах хүснэгтэд заасны дагуу хөрөнгийг ангилан, зөвшөөрөгдөх хөрөнгийн дүнг тооцох бөгөөд энэ журмын 3 дугаар хавсралтад заасан дансны жагсаалтыг ашиглана:

№	Хөрөнгийн ангилал	Хөрөнгө байршуулах дээд хувь	Нэгжид ногдох хөрөнгийн дээд хувь	Зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн хувь
	Баганын дүн	1	2	3
2.4.1	Банкны харилцах, хадгаламж /Монгол банкнаас банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөлтэй холбоотой аль нэг албадлагын арга хэмжээнд ороогүй, холбогдох этгээдэд үл хамаарах Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2-д заасан шаардлагыг хангасан банкинд байршуулсан/ <u>/Энэ заалтад СЗХ-ны 2021 оны 64 дүгээр тогтоолоор нэмэлт оруулсан./</u>	90% /Энэ заалтад СЗХ-ны 2021 оны 64 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан./	35%	0%
2.4.2	Гадаадын банкин дахь харилцах, хадгаламж, хадгаламжийн сертификат /Тухайн улсынхаа эрх бүхий байгууллагаас банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөлтэй холбоотой аль нэг албадлагын арга хэмжээнд ороогүй, холбогдох этгээдэд үл хамаарах “Стандарт энд Пурс” (Standard&Poor’s) компанийн ВВВ болон түүнтэй адилтгах зэрэглэлээс дээш зэрэглэлтэй банкинд байгаа харилцах, хадгаламж, тус банкнаас гаргасан хадгаламжийн сертификат/	2%	1%	0%
2.4.3	Дотоодын банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулсан мөнгөн хөрөнгө /Хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөлтэй холбоотой аль нэг албадлагын арга хэмжээнд ороогүй, холбогдох этгээдэд үл хамаарах Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийг хангасан банк бус санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгө/ <u>/Энэ заалтад СЗХ-ны 2021 оны 64 дүгээр тогтоолоор нэмэлт оруулсан./</u>	20%	5%	5%
2.4.4	Бэлэн мөнгө	2%	2%	0%

2.4.5	Хэвийн авлага	<i>/Санхүүгийн байдлын тайлангийн даатгалын авлага, бусад авлага, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага, аж ахуй нэгжийн орлогын албан татварын авлага, бусад татварын авлага болон мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөнд тооцсон хүүний авлага, Банкинд байриуулсан 3 сараас дээш хугацаатай хадгаламж, хадгаламжийн сертификатын хүүний авлагын дүн/</i>	20%	20%	0%
	Хугацаа хэтэрсэн авлага		15%	15%	25%
	Хэвийн бус авлага		10%	10%	50%
	Эргэлзээтэй авлага		0%	0%	100%
	Муу авлага		0%	0%	100%
2.4.6	Банкны хадгаламжийн сертификат /Монгол банкаас банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөлтэй холбоотой аль нэг албалагын арга хэмжээнд ороогүй, холбогдох этгээдэд үл хамаарах Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2-д заасан шаардлагыг хангасан банкаас олгосон Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үнэт цаас/ <u>/Энэ заалтад СЗХ-ны 2021 оны 64 дүгээр тогтоолоор нэмэлт оруулсан./</u>		50%	20%	0%
2.4.7	Засгийн газраас гаргасан өрийн хэрэгсэл		100%	100%	0%
2.4.8	Төв банкны үнэт цаас /Монголбанкны мөнгөний бодлогын нээлттэй захын хэрэгсэл бөгөөд хямруулсан хэлбэрээр арилжигдаж, тогтоосон хугацааны дараа нэрлэсэн үнээр эргэн төлөгдөх үнэт цаас/		60%	60%	0%
2.4.9	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас /Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан үнэт цаас/		60%	20%	Хэвийн үнэт цаас 0%
2.4.10	Аймаг нийслэлийн гаргасан өрийн хэрэгсэл	<i>/Үнэт цаасны зах зээлд арилжаалагддаг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.9-т заасан/ <u>/Энэ заалтад СЗХ-ны 2021 оны 64 дүгээр тогтоолоор нэмэлт оруулсан./</u></i>	60%	20%	Хугацаа хэтэрсэн үнэт цаас 25% Хэвийн бус үнэт цаас 50% Эргэлзээтэй үнэт цаас 75% Муу үнэт цаас 100%
2.4.11	Компанийн өрийн хэрэгсэл				
2.4.12	Монголын хөрөнгийн биржийн хувьцаат компанийн хувьцаа – 1 ангилал		20%	5%	20%
2.4.13	Монголын хөрөнгийн биржийн хувьцаат компанийн хувьцаа – 2 ангилал		5%	5%	30%
2.4.14	Хөрөнгө оруулалтын нээлттэй сан	<i>/Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 6.2.1-д заасан/</i>	20%	10%	5%
2.4.15	Хөрөнгө оруулалтын хаалттай сан		20%	10%	10%
2.4.16	Гадаадын Засгийн газраас гаргасан өрийн хэрэгсэл	<i>/Хороонос баталсан Ердийн даатгалын компанийн даатгалын нөөц сангаас хөрөнгө оруулалт хийх талаарх харилцааг зохируулсан эрх зүйн актад заасан олон улсын хөрөнгийн биржүүд дээр арилжаалагдаж байгаа “Стандарт энд Пурс” (Standard&Poor’s) компанийн BVB болон түүнтэй адилтгах зэрэглэлээс дээш зэрэглэлтэй Гадаадын засгийн газраас гаргасан өрийн хэрэгсэл, Гадаадын Төв банкны үнэт цаас, түүнчлэн тус зэрэглэл болон түүнтэй адилтгах зэрэглэлээс дээш зэрэглэлтэй, холбогдох этгээдэд үл хамаарах Гадаадын компанийн хувьцаа, Гадаадын компанийн өрийн хэрэгсэл/</i>	2%	1%	0%
2.4.17	Гадаадын Төв банкны үнэт цаас		2%	1%	0%
2.4.18	Гадаадын компанийн өрийн хэрэгсэл		1%	0,5%	30%
2.4.19	Гадаадын компанийн хувьцаа		1%	0,5%	50%

2.4.20	Давхар даатгалын хойшлогдсон хураамж /Хорооноос баталсан даатгагч даатгалын гэрээгээр хүлээсэн эрсдэлээ давхар даатгуулах талаарх харилцааг зохицуулсан журамд заасан “зөвшөөрөгдөх давхар даатгагч”-тай байгуулсан давхар даатгалын гэрээний дагуу төлөх ёстой хойшлогдсон давхар даатгалын хураамж/	100%	100%	0%
2.4.21	Нөхөн төлбөрийн нөөцийн давхар даатгагчид ногдох хэсэг	100%	100%	0%
2.4.22	Даатгалын орлогын шимтгэлийн хойшлогдсон зардал	10%	5%	80%
2.4.23	Хэвийн өмчлөх бусад хөрөнгө	10%	5%	0%
	Хугацаа хэтэрсэн өмчлөх бусад хөрөнгө	5%	2,5%	25%
	Хэвийн бус өмчлөх бусад хөрөнгө	2,5%	2,5%	50%
	Эргэлзээтэй өмчлөх бусад хөрөнгө	0%	0%	100%
	Муу өмчлөх бусад хөрөнгө	0%	0%	100%
2.4.24	Санхүүгийн түрээс /Санхүүгийн түрээсийн тухай хуулийн 3.1, 3.2-т заасан/	10%	5%	5%
2.4.25	Үл хөдлөх хөрөнгө /Даатгагчийн үндсэн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа Иргэний хуулийн 84.3 дахь хэсэгт заасан, холбогдох хууль, журмын дагуу баталгаажсан эрхийн гэрчилгээтэй үл хөдлөх хөрөнгө (Аливаа зээлийн барьцаанд тавьсан, эсхүл төлбөрийн баталгаа болгосон хөрөнгийг үл хөдлөх хөрөнгөнд оруулж тооцохгүй)/	25%	25%	5%
2.4.26	Хөдлөх хөрөнгө /Даатгагчийн үндсэн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа биет үндсэн хөрөнгө буюу машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил, компьютер дагалдах хэрэгсэл/	10%	5%	70%
2.4.27	Даатгалын үндсэн үйл ажиллагаанд зориулан авсан биет бус хөрөнгө	10%	10%	70%
2.4.28	Бусад хөрөнгө /Даатгагчийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүнгээс энэ журмын 2.4.1-2.4.27-д заасан хөрөнгийн дүнг хасч тооцсон дүн/	0%	0%	100%
	Нийт хөрөнгийн дүн			

2.5 Зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн дүнг хөрөнгийн ангилал бүрээр байршуулах дээд хэмжээнээс хэтрүүлэн байршуулсан хөрөнгийн дүн, нэгжид ногдох дээд хэмжээнээс хэтрүүлэн байршуулсан хөрөнгийн дүн болон байршуулсан хөрөнгийн эрсдэлтэйд тооцсон хэсэг буюу зөвшөөрөгдөх хөрөнгийг бууруулах дүнгүүдийн нийлбэрээр дараах томъёогоор тооцож гаргана:

$$3qX = NX3q + X3q_{\text{н}} + 3XB$$

, Үүнд:

3qX – зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн дүн

NX3q – нийт хөрөнгөнд ногдох зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн дүн

X3q_н – нэгжид ногдох тухайн хөрөнгийн зөвшөөрөгдөхгүй дүн

3XB – зөвшөөрөгдөх хөрөнгийг бууруулах дүн

2.6 Энэ журмын 2.4.5 “Эргэлзээтэй авлага”, “Муу авлага”, 2.4.23 “Эргэлзээтэй өмчлөх бусад хөрөнгө”, “Муу өмчлөх бусад хөрөнгө”, 2.4.28 “Бусад хөрөнгө”-ийн зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн дүн нь зөвхөн эдгээр хөрөнгийн ангилал тус бүрээр байршуулах дээд хэмжээнээс хэтрүүлэн байршуулсан хөрөнгийн дүнтэй тэнцүү байх бөгөөд эдгээр хөрөнгийн ангиллын дагуу

зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн хэмжээг тооцоход энэ журмын 2.5 дахь хэсэг хамаарахгүй.

2.7 Нийт хөрөнгөнд ногдох зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн дүнг энэ журмын 2.4-т заасан хөрөнгийн ангилал тус бүрээр тооцсон зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрүүлэн байршуулсан хөрөнгийн нийлбэрээр буюу дараах томъёогоор тооцно:

$$HX3q = \sum_{i=1}^n [XX]$$

$HX3q$ – нийт хөрөнгөнд ногдох зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн дүн

XX – зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрүүлэн байршуулсан хөрөнгө

n – энэ журмын 2.4-т заасан хөрөнгийн ангиллын тоо

i – энэ журмын 2.4-т заасан хөрөнгийн ангиллын дугаар

2.7.1 Энэ журмын 2.4.1-2.4.19, 2.4.22-2.4.28-д заасан ангиллаарх нийт хөрөнгөнд ногдох зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрүүлэн байршуулсан дүнг тухайн хөрөнгө байршуулах дээд хувийг нийт хөрөнгийн дүнгээр үржиж, үржвэрийг санхүүгийн байдлын тайлан дахь тухайн хөрөнгийн дүнгээс хасах замаар буюу дараах томъёогоор тооцно:

$$XX = (X_i - HX * \max_i) \geq 0$$
 , Үүнд:

X_i – санхүүгийн байдлын тайлан дахь тухайн хөрөнгийн дүн

HX – нийт хөрөнгө

\max_i – тухайн хөрөнгийг байршуулах дээд хувь

n – энэ журмын 2.4-т заасан хөрөнгийн ангиллын тоо

i – энэ журмын 2.4-т заасан хөрөнгийн ангиллын дугаар

2.7.2 Энэ журмын 2.4.20, 2.4.21-д заасан хөрөнгийн ангиллаарх нийт хөрөнгөнд ногдох зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрүүлэн байршуулсан дүнг тухайн хөрөнгө байршуулах дээд хувийг санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүнгээр үржиж, үржвэрийг санхүүгийн байдлын тайлан дахь тухайн хөрөнгийн дүнгээс хасах замаар тооцож гаргана.

2.8 Нэгжид ногдох зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн дүнг энэ журмын 2.4-т заасан хөрөнгийн ангилал бүрээр тооцсон нэгжид ногдох зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрүүлэн байршуулсан хөрөнгийн нийлбэрээр буюу дараах томъёогоор тооцно:

$$HX3^Hq = \sum_{i=1}^n [XX^H]$$
 , Үүнд:

$HX3^Hq$ – нэгжид ногдох зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн дүн

XX^H – нэгжид зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрүүлэн байршуулсан хөрөнгө

n – энэ журмын 2.4-т заасан хөрөнгийн ангиллын тоо

i – энэ журмын 2.4-т заасан хөрөнгийн ангиллын дугаар

2.8.1 Энэ журмын 2.4.1-2.4.19, 2.4.22-2.4.28-д заасан ангиллаарх нэгжид ногдох зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрүүлэн байршуулсан дүнг тухайн хөрөнгөнд байршуулах нэгжид ногдох дээд хувийг нийт хөрөнгийн дүнгээр үржиж, үржвэрийг тухайн нэгжид байршуулсан хөрөнгийн дүнгээс хасах замаар буюу дараах томъёогоор тооцно:

$$XX^H = (X_i^H - HX * \max_i^H) \geq 0$$
 , Үүнд:

X_i^n – тухайн нэгжид ногдох хөрөнгийн дүн

NX – нийт хөрөнгийн дүн

\max_i^n – нэгжид ногдох хөрөнгийн дээд хувь

i – энэ журмын 2.4-т заасан хөрөнгийн ангиллын дугаар

2.8.2 Энэ журмын 2.4.20, 2.4.21-т заасан хөрөнгийн ангиллаарх нэгжид ногдох зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрүүлэн байршуулсан дүнг тухайн хөрөнгөнд байршуулах нэгжид ногдох дээд хувийг санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүнгээр үржиж, үржвэрийг тухайн нэгжид байршуулсан хөрөнгийн дүнгээс хасах замаар тооцож гаргана.

2.9 Зөвшөөрөгдөх хөрөнгийг бууруулах дүнг энэ журмын 2.4.1-2.4.8, 2.4.12-2.4.28-д заасан хөрөнгийн зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа дүнг энэ журмын 2.4-т заасан зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн харгалзах хувиар үржүүлж, Аймаг нийслэлийн гаргасан өрийн хэрэгсэл, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, Компанийн өрийн хэрэгслийн энэ журмын 2.11-д заасан ангиллаарх хөрөнгийн дүнг энэ журмын 2.4-т заасан тухайн ангилалд харгалзах зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн хувиар үржүүлэн, эдгээр үржвэрүүдийг нэмэх замаар буюу дараах томъёогоор тооцно:

$$\text{ЗХБ} = \sum_{i=1}^n (AX_i * \text{ЗqXX}_i) , \text{ Үүнд:}$$

ЗХБ – зөвшөөрөгдөх хөрөнгийг бууруулах дүн

AX_i – энэ журмын 2.4.1-2.4.8, 2.4.12-2.4.28-д ангиллаарх заасан хөрөнгийн зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа хөрөнгийн дүн, Аймаг нийслэлийн гаргасан өрийн хэрэгсэл, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, Компанийн өрийн хэрэгслийн хувьд энэ журмын 2.10.3-т заасан ангиллаарх хөрөнгийн дүн

ЗqXX_i – энэ журмын 2.4-т заасан зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн хувь

n – хөрөнгийн ангиллын тоо

i – хөрөнгийн ангиллын дугаар

2.10 Даатгагчийн хөрөнгөөс авлага, үнэт цаас, өмчлөх бусад хөрөнгө хэлбэрээр үүссэн хөрөнгийг хугацааны үзүүлэлтээр нь ангилж даатгагчийн төлбөрийн чадварыг үнэлэхэд ашиглана.

2.11 Даатгалын компани нь үнэт цаас (Гадаад улсын үнэт цаас, Банкны хадгаламжийн сертификат, Төв банкны үнэт цаас, Засгийн газрын үнэт цааснаас бусад), өмчлөх бусад хөрөнгө, авлагыг дор дурдсан байдлаар тухай бүр ангилна:

2.11.1 Хэвийн

2.11.2 Хугацаа хэтэрсэн

2.11.3 Чанаргүй, үүнээс:

2.11.3.а Хэвийн бус

2.11.3.б Эргэлзээтэй

2.11.3.в Муу

2.12 Энэ журмын 2.11-д заасан активын ангиллыг хугацааны үзүүлэлтээр нь дор дурдсан байдлаар дүгнэнэ:

2.12.1 Дараах хүснэгтийн дагуу авлагыг төлөхөөр тохиролцсон огноо буюу бичгээр хийсэн хэлцэлд тусгагдсан төлөгдөх хугацаа дууссанаас хойших хугацаанаас эхлэн хугацааг тооцож дүгнэн, авлагыг ангилна: (авлагын төлөгдөх хугацааг 1 удаа 120 хүртэлх хоногоор сунгасан тохиолдолд тухайн авлагыг хэвийн авлагаар, 1 удаа 121-ээс дээш хоногоор сунгасан тохиолдолд эргэлзээтэй авлагаар, 2 ба түүнээс дээш удаа авлагын төлөгдөх хугацааг сунгасан тохиолдолд тухайн

авлагыг эргэлзээтэй авлагаар тооцно. Эргэлзээтэй авлагаар тооцож эхэлснээс хойш 30 хоногийн дотор төлөгдөөгүй бол тухайн авлагыг муу авлагаар тооцно):

Ангилал	Хэвийн	Хугацаа хэтэрсэн	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу
Хугацааны үзүүлэлт	30 хүртэл хоногийн дотор байгаа	31-60 хоногийн дотор төлөгдөөгүй	61-90 хоногийн дотор төлөгдөөгүй	91-120 хоногийн дотор төлөгдөөгүй	121-ээс дээш хоногоор төлөгдөөгүй буюу гэмт хэргийн улмаас бий болсон авлага

2.12.2 Дараах хүснэгтийн дагуу үнэт цаас, үнэт цаасны хүүгийн эргэн төлөлтийн хуваарьт заасан хугацаанаас эхлэн хугацааг тооцож дүгнэн, Гадаад улсын үнэт цаас, Банкны хадгаламжийн сертификат, Төв банкны үнэт цаас, Засгийн газрын үнэт цаас, Хөрөнгө оруулалтын сан болон хөрөнгийн биржийн хувьцаанаас бусад үнэт цаасыг ангилна:

Ангилал	Хэвийн	Хугацаа хэтэрсэн	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу
Хугацааны үзүүлэлт	Үнэт цаас, үнэт цаасны хүүгийн эргэн төлөлт, хуваарьт заасан хугаандаа төлөгдөж байгаа	Үнэт цаас, үнэт цаасны хүүгийн эргэн төлөлт хийгдэлгүй хуваарьт заасан хугацаанаас 30 хүртэл хоног хэтэрсэн	Үнэт цаас, үнэт цаасны хүүгийн эргэн төлөлт хийгдэлгүй хуваарьт заасан хугацаанаас 31-60 хоног хэтэрсэн.	Үнэт цаас, үнэт цаасны хүүгийн эргэн төлөлт хийгдэлгүй хуваарьт заасан хугацаанаас 61-90 хоног хэтэрсэн.	Үнэт цаас, үнэт цаасны хүүгийн эргэн төлөлт хийгдэлгүй хуваарьт заасан хугацаанаас 91-ээс дээш хоног хэтэрсэн.

2.12.3 Дараах хүснэгтийн дагуу өмчлөлд авснаас хойшхи хугацаанаас эхлэн хугацааг тооцон дүгнэж, өмчлөх бусад хөрөнгийг ангилна:

Ангилал	Хэвийн	Хугацаа хэтэрсэн	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу
Хугацааны үзүүлэлт	Өмчлөлд авснаас хойш 30 хүртэл хоногийн дотор борлогдоогүй	Өмчлөлд авснаас хойш 31-60 хүртэл хоногийн дотор борлогдоогүй	Өмчлөлд авснаас хойш 61-90 хүртэл хоногийн дотор борлогдоогүй	Өмчлөлд авснаас хойш 91-120 хүртэл хоногийн дотор борлогдоогүй	Өмчлөлд авснаас хойш 121 хоногоос дээш хоногийн хугацаанд борлогдоогүй

2.13 Ердийн даатгагчийн өр төлбөрийн дүнг даатгагчийн нийт өр төлбөрийг даатгагчид ногдох орлогод тооцоогүй хураамжийн нөөц, давхар даатгалын хойшлогдсон шимтгэлийн орлогын дүнг тус бүр 10 хувиар бууруулах замаар буюу дараах томъёогоор тооцно.

$$\text{ӨТ} = \text{НӨТ} - (\text{ОТХН} + \text{ДДХШО}) * 10\%$$

, Үүнд:

ӨТ – өр төлбөрийн дүн

НӨТ – нийт өр төлбөрийн дүн /Санхүүгийн байдлын тайлангийн нийт өр төлбөрийн дүнгээс даатгалын нөөц сан дахь давхар даатгагчид ногдох хэсгийг хассан дүн/

ОТХН – даатгагчид ногдох орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн дүн /Санхүүгийн байдлын тайлангийн орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн дүнгээс давхар даатгалын хойшлогдсон хураамжийг хассан дүн/

ДДХШО- давхар даатгалын хойшлогдсон шимтгэлийн орлогын дүн

2.14 Давхар даатгагчийн өр төлбөрийн дүнг даатгагчийн нийт өр төлбөрийг даатгагчид

ногдох орлогод тооцоогүй хураамжийн нөөц, алдагдлаас хамгаалах санг тус тус 10 хувиар бууруулах замаар буюу дараах томъёогоор тооцно.

$$\Theta T = \text{H}\Theta T - (\text{O}\text{T}\text{X}\text{H} + \text{A}\text{X}\text{C}) * 10\%$$

, Үүнд:

AXC- Алдагдлаас хамгаалах сан.

2.15 Даатгагч даатгуулагчийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь зохих түвшинд биелүүлэхэд шаардлагатай хөрөнгө буюу зайлшгүй байх хөрөнгийн хэмжээг тооцохдоо энэ журмын 4 дүгээр хавсралтын дагуу дараах 3 үзүүлэлтийн хамгийн их дүнг үндэслэн тогтоох буюу дараах томъёогоор тооцно:

$$\text{ЗБХ} = \max (\text{O}\text{T}\text{X}\text{x}; \text{H}\text{X}\text{Д}\text{x}; \text{Д}\text{С}\text{Д}\text{X})$$

, Үүнд:

ЗБХ – зайлшгүй байх хөрөнгийн хэмжээ

OТХx – энэ журмын 2.15.1-д заасан дүн

HХДx – энэ журмын 2.15.2-д заасан дүн

ДСДХ – энэ журмын 2.15.3-д заасан дүн

2.15.1 Хураамжийн аргаар зайлшгүй байх хөрөнгийн хэмжээг тайлант хугацааны агаарын хөлгийн, автотээврийн хэрэгслийн, бүх төрлийн хариуцлагын даатгалын хэлбэрийн орлогод тооцсон хураамжийн 40 хувь, бусад даатгалын хэлбэрийн орлогод тооцсон хураамжийн 20 хувийн нийлбэр дүнгээр буюу дараах томъёогоор тооцно;

$$\text{O}\text{T}\text{X}\text{x} = \text{O}\text{T}\text{X}^1 * 40\% + (\text{H}\text{O}\text{T}\text{X} - \text{O}\text{T}\text{X}^1) * 20\%$$

, Үүнд:

OТХ¹ – Агаарын хөлгийн, автотээврийн хэрэгслийн, бүх төрлийн хариуцлагын даатгалын хэлбэрийн тайлант хугацаанд орлогод тооцсон хураамжийн дүн

HOTX – Тайлант хугацааны нийт орлогод тооцсон хураамжийн дүн

2.15.2 Агаарын хөлгийн, автотээврийн хэрэгслийн, бүх төрлийн хариуцлагын даатгалын хэлбэрийн сүүлийн 3 жилд нэхэмжилсэн хохирлын дундаж дүнгийн 50 хувь дээр бусад хэлбэрийн сүүлийн 3 жилд нэхэмжилсэн хохирлын дундаж дүнгийн 20 хувийг нэмсэн дүн. Тус дүнг дараах томъёогоор тооцно;

$$\text{H}\text{X}\text{Д}\text{x} = \frac{\text{H}\text{X}_t^1 + \text{H}\text{X}_{t-1}^1 + \text{H}\text{X}_{t-2}^1}{3} * 50\% + \frac{((\text{H}\text{N}\text{X}_t - \text{H}\text{X}_t^1) + (\text{H}\text{N}\text{X}_{t-1} - \text{H}\text{X}_{t-1}^1) + (\text{H}\text{N}\text{X}_{t-2} - \text{H}\text{X}_{t-2}^1))}{3} * 20\%$$

Үүнд:

HX_t¹ - Агаарын хөлгийн, автотээврийн хэрэгслийн, бүх төрлийн хариуцлагын даатгалын хэлбэрийн тухайн жилийн тайлант хугацаанд нэхэмжилсэн хохирлын дүн

HX_{t-1}¹ - Агаарын хөлгийн, автотээврийн хэрэгслийн, бүх төрлийн хариуцлагын даатгалын хэлбэрийн өмнөх жилийн тайлант хугацаанд нэхэмжилсэн хохирлын дүн

HX_{t-2}¹ - Агаарын хөлгийн, автотээврийн хэрэгслийн, бүх төрлийн хариуцлагын даатгалын хэлбэрийн 2 жилийн өмнөх тайлант хугацаанд нэхэмжилсэн хохирлын дүн

HNX_t - Тухайн жилийн тайлант хугацаанд нийт нэхэмжилсэн хохирлын дүн

HNX_{t-1} - Өмнөх жилийн тайлант хугацаанд нийт нэхэмжилсэн хохирлын дүн

ННХ_{1,2} - 2 жилийн өмнөх тайлант хугацаанд нийт нэхэмжилсэн хохирлын дүн

2.15.3 Хорооноос тогтоосон дүрмийн сангийн доод хэмжээ

2.16 Нэхэмжилсэн хохирлын дүнг тухайн жилийн тайлант хугацаанд олгосон нөхөн төлбөрийн цэвэр зардал ба нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлтийн дүнгийн нийлбэрээс нөхөн төлбөрийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлтийг хасч тооцно.

2.17 Даатгагч нь 3-аас доош жил даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа тохиолдолд (даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгогдсоноос хойш 3 жил хүрэхгүй хугацаа өнгөрсөн) энэ журмын 2.15.2-т заасан үзүүлэлтийг тооцоолохгүй.

2.18 Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцаа нь 110 хувь буюу түүнээс илүү байвал зохино.

2.19 Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцаа 100–аас 110 хувийн хооронд байвал тухайн даатгагчийг төлбөрийн чадваргүй болж болзошгүй гэж үзнэ.

2.20 Хэрэв даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцаа 100 хувиас доош байвал даатгагчийг төлбөрийн чадваргүй болсонд тооцно.

ГУРАВ.УРТ ХУГАЦААНЫ ДААТГАГЧИЙН ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

3.1 Урт хугацааны даатгагчийн төлбөрийн чадварын байдлыг төлбөрийн чадварын зохистой харьцаа, төлбөрийн чадварын хязгаар гэсэн 2 үзүүлэлтээр тодорхойлно.

3.2 Төлбөрийн чадварын зохистой харьцааг тооцохдоо даатгагчийн зөвшөөрөгдөх хөрөнгийн дүнг өр төлбөрийн дүнд харьцуулах замаар буюу дараах томъёогоор тооцно.

$$ТЧЗХ = \frac{ЗХ}{ӨТ} * 100\%$$

, Үүнд:

ТЧЗХ – төлбөрийн чадварын зохистой харьцаа

ЗХ – зөвшөөрөгдөх хөрөнгийн дүн

ӨТ – өр төлбөрийн дүн

3.3 Зөвшөөрөгдөх хөрөнгийг даатгагчийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүнгээс зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн дүнг хасч тодорхойлно.

3.4 Зөвшөөрөгдөхгүй хөрөнгө гэж даатгалын компанийн төлбөрийн чадварын үзүүлэлтэд сөргөөр нөлөөлж болохуйц хөрөнгийг хэлнэ. Зөвшөөрөгдөхгүй хөрөнгийг тухайн хөрөнгийн дүнгээс дараах хувиар тооцно:

3.4.1	Банкны харилцах, хадгаламж /Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2-д заасан шаардлагыг хангасан/ <i>/Энэ заалтад СЗХ-ны 2021 оны 64 дүгээр тогтоолоор нэмэлт оруулсан./</i>	0%
3.4.2	Банкны хадгаламжийн сертификат /Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2-д заасан шаардлагыг хангасан/ <i>/Энэ заалтад СЗХ-ны 2021 оны 64 дүгээр тогтоолоор нэмэлт оруулсан./</i>	0%
3.4.3	Касс	0%
3.4.4	Засгийн газрын бонд	0%
3.4.5	Төв банкны үнэт цаас	0%
3.4.6	Давхар даатгалын авлага	0%

3.4.7	90 хоногоос доош хугацаанд төлөгдөөгүй байгаа авлага	0%
3.4.8	Тухайн даатгалын компанийн холбогдох этгээдэд үл хамаарах банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулах мөнгөн хөрөнгө /Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийг хангасан банк бус санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгө/ <i>/Энэ заалтад СЗХ-ны 2021 оны 64 дүгээр тогтоолоор нэмэлт оруулсан./</i>	5%
3.4.9	Санхүүгийн болон үйл ажиллагааны лизинг	5%
3.4.10	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	8%
3.4.11	Үл хөдлөх хөрөнгө	8%
3.4.12	Хөрөнгө оруулалтын сан /Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 6.2.1-д заасан нээлттэй, эсхүл хаалттай санг ойлгоно./	
	3.4.12.а Нээлттэй сан: 5%	
	3.4.12.б Хаалттай сан: 10%	
3.4.13	Орон нутгийн засаг захиргааны бонд	10%
3.4.14	Компанийн бонд /Үнэт цаасны зах зээлд арилжаалагддаг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.9-т заасан/ <i>/Энэ заалтад СЗХ-ны 2021 оны 64 дүгээр тогтоолоор нэмэлт оруулсан./</i>	10%
3.4.15	Хуримтлал барьцаалсан зээл	10%
3.4.16	МХБ-ийн хувьцаат компанийн хувьцаа	
	3.4.16.а I ангилал	20%
	3.4.16.б II ангилал	30%
3.4.17	Бусад авлага	100%
3.4.18	Биет бус хөрөнгө	100%
3.4.19	Бараа, материал, тоног төхөөрөмж	100%
3.4.20	Урьдчилж төлсөн зардал	100%
3.4.21	Бусад хөрөнгө (даатгагчийн хөрөнгийн	
3.4.1-3.4.20-д зааснаас бусад хөрөнгө)		100%

3.5 Өр төлбөрийн дүнг даатгагчийн санхүүгийн байдлын тайлангийн Өр төлбөр хэсэгт бичсэн дүнгээр тодорхойлно.

3.6 Төлбөрийн чадварын хязгаарыг тооцохдоо даатгагчийн зөвшөөрөгдөх хөрөнгийн дүнгээс өр төлбөрийн дүнг хасч тогтооно.

$$ТЧХ = (ЗХ - \Theta Т) * 100\%$$

, Үүнд:

ТЧХ- Төлбөрийн чадварын хязгаар

3.7 Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцааг энэ журмын 2.18-2.20-д заасны дагуу үнэлнэ.

3.8 Даатгагчийн төлбөрийн чадварын хязгаар нь даатгагчийн төлбөрийн чадварын хамгийн бага үзүүлэлттэй тэнцүү буюу түүнээс дээш байна.

3.9 Хэрэв даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцаа болон төлбөрийн чадварын хязгаарын аль нэг нь шаардлага хангаагүй бол тухайн даатгагчийг төлбөрийн чадваргүй болсонд тооцно.

3.10 Төлбөрийн чадварын хамгийн бага үзүүлэлт нь нөөцийн сангийн актуар тооцооллын хувь (3.10.1) ба даатгалын гэрээний эрсдэлтэй хэсгийн үнэлгээний хувь (3.10.2)-ийн нийлбэртэй

тэнцүү байх бөгөөд хэрэв энэ нийлбэр нь зайлшгүй байх хөрөнгийн хэмжээ (3.10.3)-нд хүрэхгүй тохиолдолд зайлшгүй байх хөрөнгийн хэмжээ (3.10.3)-ээр тооцож байна. Үүнд:

3.10.1 Нөөц сангийн актуар тооцооллын хувь. Үүнийг өмнөх санхүүгийн жилийн эцсийн байдлаарх дараах үзүүлэлтүүдийн нийлбэрээр тодорхойлно:

3.10.1.а Гэрээний үргэлжлэх хугацаанд даатгуулагч нь даатгалын компанийн ашгаас ногдол ашиг авах талаар гэрээнд заагаагүй урт хугацааны даатгалын гэрээ буюу хувь оролцоогүй гэрээний нөөц сангийн 3 хувь;

3.10.1.б Гэрээний үргэлжлэх хугацаанд даатгуулагч нь даатгалын компанийн ашгаас ногдол ашиг авах нөхцөл бүхий урт хугацааны даатгалын гэрээ буюу хувь оролцоотой гэрээний нөөц сангийн 2 хувь;

3.10.1.в Даатгалын хураамжийн зохих хэсэг нь даатгуулагчийн хүсэл сонирхол болон тодорхой гэрээнд заасан нөхцөлийн дагуу хөрөнгө оруулалтад байршдаг урт хугацааны даатгалын гэрээ буюу хөрөнгө оруулалттай холбоотой гэрээний нөөц сангийн 1 хувь.

3.10.2 Даатгалын гэрээний эрсдэлтэй хэсгийн үнэлгээний хувь (өмнөх санхүүгийн жилийн төгсгөл дэх нийт даатгалын гэрээний эрсдэлтэй хэсгийн үнэлгээний 0.2 хувиар тооцно. Энэ нь давхар даатгалд шилжүүлсэн гэрээг хасаж тооцно);

3.10.3 Зайлшгүй байх хөрөнгийн хэмжээг Хорооноос тогтоосон даатгагчийн дүрмийн сангийн доод хэмжээгээр тооцно.

ДӨРӨВ. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

4.1 Даатгагч нь энэ журмын 2.4 болон 3.4-т заасан хөрөнгийг гадаад улсад байршуулахаар бол Хороонд хүсэлтээ бичгээр тавих ба Хорооны хяналт шалгалтын асуудал эрхэлсэн газар зөвшөөрөл олгох эсэхийг даатгагч албан бичиг ирүүлсэн өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор шийдвэрлэж, хариуг даатгагчид албан бичгээр хүргүүлнэ.

4.2 Ердийн болон давхар даатгагч нь энэ журмын нэгдүгээр хавсралт “СЗХ04144” маягт болон хоёрдугаар хавсралт “СЗХ04145” маягтын дагуу өөрийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг тооцоолон гаргаж, улирал бүр санхүүгийн тайлангийн хамт цаасаар болон цахимаар Хороонд хүргүүлнэ.

4.3 Урт хугацааны даатгагч нь энэ журмын тавдугаар хавсралт “СЗХ04146” маягтын дагуу өөрийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг тооцоолон гаргаж, улирал бүр санхүүгийн тайлангийн хамт цаасаар болон цахимаар Хороонд хүргүүлнэ.

4.4 Даатгагч нь сар бүр, шаардлагатай гэж үзвэл тухайн бүрд төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг тооцох боломжтой байх шаардлагатай.

4.5 Хороонд хүргүүлсэн төлбөрийн чадварын зохистой харьцааг үнэн зөв тооцоолсон эсэхэд Хорооны хяналт шалгалтын асуудал эрхэлсэн газар хяналт тавьж, баталгаажуулах бөгөөд Даатгагчаас ирүүлсэн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийн тайлантай холбогдуулан шаардлагатай гэж үзвэл Хороо нэмэлт мэдээлэл, материал шаардаж болно.

4.6 Энэ журамд заасны дагуу даатгагч төлбөрийн чадваргүй болж болзошгүй болсон тохиолдолд Хорооноос тогтоосон хугацаанд энэхүү нөхцөл байдалд хүргэсэн хүчин зүйлүүдийг тодорхойлж, тэдгээрийн нөлөөллийг үе шаттайгаар бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан Хороонд хүргүүлнэ.

4.7 Хороо энэ журмын 4.6-д заасан төлөвлөгөөг хянаж, шаардлагатай тохиолдолд даатгагчид зөвлөмж хүргүүлэн, тус төлөвлөгөөний дагуу ажиллаж буй эсэхэд хяналт тавина.

4.8 Хороо энэ журмын хэрэгжилтэд байнга хяналт тавих бөгөөд зөрчсөн этгээдэд Даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

“Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт,
 түүнд хяналт тавих журам”-ын 1 дүгээр хавсралт

МАЯГТСЗХ04144. “..... “ ХХК-ийн 20.... оны дүгээр улирлын Зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн дүн

д/д	Хөрөнгийн ангилал	Хөрөнгө байршуулах дээд хувь	Зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа дүн	Нийт хөрөнгөнд ногдох зөвшөөрөгдөхгүй дүн	Нэгжид ногдох хөрөнгийн дээд хувь	Нэгжид ногдох зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа дүн	Нэгжид ногдох тухайн хөрөнгийн зөвшөөрөгдөхгүй дүн	Зөвшөөрөгдөх хөрөнгийг бууруулах дүн	8	9
	Багаанын дүн	90%								
	Банкны харилцах, хадгаламж	<i>Энэ заалтад СЗХ-ны 2021 оны 64 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан!</i>		35%				0%		
1	Банкны харилцах, хадгаламж	2%		1%				0%		
2	Гадаад банкнд харилцах, хадгаламж, хадгаламжийн сертификат	20%		5%				5%		
3	Дотоодын банк бус санхүүгийн байгууллагад итгэлцээр байршуулсан мөнгөн хөрөнгө	2%		2%				0%		
4	Бэлэн мөнгө	20%		20%				0%		
	Хэвийн авлага	15%		15%				0%		
	Хугацаа хэтэрсэн авлага	10%		10%				25%		
5	Хэвийн бус авлага	0%		0%				50%		
	Эргэлзээгүй авлага	0%		0%				100%		
	Муу авлага	0%		0%				100%		
6	Банкны хадгаламжийн сертификат	50%		20%				0%		
7	Засгийн газраас гаргасан өрийн хэрэгсэл	100%		100%				0%		
8	Төв банкны үнэт цаас	60%		60%				0%		
								0%		
								25%		
								50%		
								75%		
								100%		
9	Хөрөнгөөр багалгаажсан үнэт цаас	60%		20%						

10	Аймаг нийслэлийн гаргасан өрийн хэрэгсэл	60%			20%			0% 25% 50% 75% 100%
11	Компанийн өрийн хэрэгсэл	30% <i>Энэ заалтад СЗХ-ны 2021 оны 64 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан.</i>			10%			0% 25% 50% 75% 100%
12	Монголын хөрөнгийн биржийн хувьцаат компанийн хувьцаа – 1 ангилал	20% <i>Энэ заалтад СЗХ-ны 2021 оны 64 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан.</i>			5%			20%
13	Монголын хөрөнгийн биржийн хувьцаат компанийн хувьцаа – 2 ангилал	5%			5%			30%
14	Хөрөнгө оруулалтын нээлттэй сан	20%			10%			5%
15	Хөрөнгө оруулалтын хаалттай сан	20%			10%			10%
16	Гадаадын Засгийн газраас гаргасан өрийн хэрэгсэл	2%			1%			0%
17	Гадаадын Төв банкны үнэг цаас	2%			1%			0%
18	Гадаадын компанийн өрийн хэрэгсэл	1%			0,5%			30%
19	Гадаадын компанийн хувьцаа	1%			0,5%			50%
20	Давхар даатгалын хойшлогдсон хураамж	100%			100%			0%
21	Нөхөн төлбөрийн нөөцийн давхар даатгагчид ногдох хэсэг	100%			100%			0%
22	Даатгалын орлогын шимтгэлийн хойшлогдсон зардал	10%			5%			80%
	Хэвийн өмчлөх бусад хөрөнгө	10%			5%			0%
	Хугацаа хэтэрсэн өмчлөх бусад хөрөнгө	5%			2,5%			25%
23	Хэвийн бус өмчлөх бусад хөрөнгө	2,5%			2,5%			50%
	Эргэлзээтэй өмчлөх бусад хөрөнгө	0%			0%			100%
	Муу өмчлөх бусад хөрөнгө	0%			0%			100%
24	Санхүүгийн гүрээс	10%			5%			5%
25	Ул хөдлөх хөрөнгө	25%			25%			5%
26	Хөдлөх хөрөнгө	10%			5%			80%
27	Даатгалын үндсэн үйл ажиллагаанд зориулан авсан биет бус хөрөнгө	10%			10%			70%
28	Бусад хөрөнгө	0%			0%			100%
	Нийт хөрөнгийн дүн							

“Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт,
түүнд хяналт тавих журам”-ын 2 дугаар хавсралт

**МАЯГТСЗХ04145. “..... “ ХХК-ийн 20... оны дүгээр
улирлын төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт**

Үзүүлэлт	Дүн	Тооцох хувь	Тооцсон дүн
1	2	3	4
<i>1. Зайлиггүй байх хөрөнгө / $1 = \max(1.1, 1.2, 1.3)$ /</i>			
1.1 Даатгалын хураамжид үндэслэх /Тухай тайлант хугацааны нийт орлогод тооцсон хураамж / $(1.1.1 (4)+1.1.2 (4))$			
1.1.1 Агаарын хөлөг, авто тээврийн хэрэгсэл, бүх төрлийн хариуцлагын даатгалын хэлбэрийн орлогод тооцсон хураамж		40%	
1.1.2 Бусад хэлбэрийн орлогод тооцсон хураамж		20%	
1.2 Даатгалын нэхэмжлэлд үндэслэх /Сүүлийн 3 жилийн дундаж үндэслэн/ $(1.2.1 (4)+1.2.2 (4))$			
1.2.1 Агаарын хөлөг, авто тээврийн хэрэгсэл, бүх төрлийн хариуцлагын даатгалын хэлбэрийн нэхэмжилсэн хохирлын дундаж дүн		50%	
1.2.2 Бусад хэлбэрийн нэхэмжилсэн хохирлын дундаж дүн		20%	
1.3 Хорооноос тогтоосон дүрмийн сангийн доод хэмжээ			
2. Нийт хөрөнгө			
3. Зөвшөөрөгдөхгүй хөрөнгө			
4. Зөвшөөрөгдөх хөрөнгө / $4 = (2) - (3)$ /			
5. Өр төлбөр / $5 = \text{Нийт өр төлбөр} - \text{ОТХН} * 10\%$ /			
6. Төлбөрийн чадварын зохистой харьцаа / $6 = 4 / (1+5) \geq 100\%$ /			

“Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт,
түүнд хяналт тавих журам”-ын 3 дугаар хавсралт

ХӨРӨНГИЙН АНГИЛАЛ, ДАНСНЫ ЖАГСААЛТААР

Хөрөнгийн ангилал	Дансны дугаар, тайлбар
Банкны харилцах, хадгаламж	1110, 1111, 1120, 1121, 1140, 1141, 1310, 1317 эдгээр дансанд тусгагдсан Монгол банкнаас банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөлтэй холбоотой аль нэг албадлагын арга хэмжээнд ороогүй, холбогдох этгээдэд үл хамаарах банкинд байгаа харилцах, хадгаламжийн дүн
Гадаадын банкин дахь харилцах, хадгаламж, хадгаламжийн сертификат	1112, 1142, 1312 эдгээр дансанд тусгагдсан Гадаад улсын эрх бүхий байгууллагаас банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөлтэй холбоотой аль нэг албадлагын арга хэмжээнд ороогүй, холбогдох этгээдэд үл хамаарах “Стандарт энд Пурс” (Standard&Poor’s) компанийн ВВВ болон түүнтэй адилтгах зэрэглэлээс дээш зэрэглэлтэй банкинд байгаа харилцах, хадгаламж, тус банкнаас гаргасан хадгаламжийн сертификатын дүн
Дотоодын банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулсан мөнгөн хөрөнгө	1130, 1131, 1313 эдгээр дансанд тусгагдсан Хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөлтэй холбоотой аль нэг албадлагын арга хэмжээнд ороогүй, холбогдох этгээдэд үл хамаарах банк бус санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн дүн
Бэлэн мөнгө	1010, 1020, 1030
Хэвийн авлага	
Хугацаа хэтэрсэн авлага	1160 - 1162, 1170, 1171, 1210, 1220, 1230, 1240, 1250, 1260, 1270, 1280, 1318, 1319, 1328, 2910 эдгээр дансанд тусгагдсан тохирох ангилал дахь авлагын
Хэвийн бус авлага	дүн. 1219, 1229, 1239, 1249, 1259, 1269 дансдын дүн хэвийн авлагын дүнд тооцогдоно.
Эргэлзээтэй авлага	
Муу авлага	
Банкны хадгаламжийн сертификат	1140, 1141, 1310, 1311 эдгээр дансанд тусгагдсан Монгол банкнаас банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөлтэй холбоотой аль нэг албадлагын арга хэмжээнд ороогүй, холбогдох этгээдэд үл хамаарах банкнаас олгосон Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үнэт цаасны дүн
Засгийн газраас гаргасан өрийн хэрэгсэл	115001, 115101, 132001, 132101, 132201, 132301, 132601, 132701, 132901 эдгээр дансанд тусгагдсан Монгол Улсын засгийн газрын өрийн хэрэгслийн дүн
Төв банкны үнэт цаас	115002, 115102, 132002, 132102, 132202, 132302, 132602, 132702, 132901 эдгээр дансанд тусгагдсан Монголбанкны мөнгөний бодлогын нээлттэй захын хэрэгсэл бөгөөд хямдруулса хэлбэрээр арилжигдаж, тогтоосон хугацааны дараа нэрлэсэн үнээр эргэн төлөгдөх үнэт цаасны дүн
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	132003, 132103, 132203, 132303, 132603, 132703, 132901 эдгээр дансанд тусгагдсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан хөрөнгийн дүн
Аймаг нийслэлийн гаргасан өрийн хэрэгсэл	132004, 132104, 132204, 132304, 132604, 132704, 132901 эдгээр дансанд тусгагдсан аймаг нийслэлийн гаргасан өрийн хэрэгслийн дүн
Компанийн өрийн хэрэгсэл	132005, 132105, 132205, 132305, 132605, 132705, 132805, 132901 эдгээр дансанд тусгагдсан Хорооноос тусгай зөвшөөрөл авсан даатгагчийн холбогдох этгээдээс бусад компанийн өрийн хэрэгслийн дүн
Монголын хөрөнгийн биржийн хувьцаат компанийн хувьцаа – 1 ангилал	132106, 132206, 132306, 132606, 132706, 132806, 132901 эдгээр дансанд тусгагдсан уг ангиллаарх хөрөнгийн дүн
Монголын хөрөнгийн биржийн хувьцаат компанийн хувьцаа – 2 ангилал	132107, 132207, 132307, 132607, 132707, 132807, 132901 эдгээр дансанд тусгагдсан уг ангиллаарх хөрөнгийн дүн
Хөрөнгө оруулалтын нээлттэй сан	132009, 132109, 132209, 132309, 132609, 132709, 132901 эдгээр дансанд тусгагдсан уг ангиллаарх хөрөнгийн дүн

Хөрөнгө оруулалтын хаалттай сан	132009, 132109, 132209, 132309, 132609, 132709, 132809, 132901 эдгээр дансанд тусгагдсан уг ангиллаарх хөрөнгийн дүн
Гадаадын Засгийн газраас гаргасан өрийн хэрэгсэл	115001, 115101, 132201, 132301, 132601, 132701, 132901 эдгээр дансанд тусгагдсан олон улсын хөрөнгийн биржүүд дээр арилжаалагдаж байгаа “Стандарт энд Пурс” (Standard&Poog’s) компанийн ВВВ болон түүнтэй адилтгах зэрэглэлээс дээш зэрэглэлтэй Гадаадын засгийн газраас гаргасан өрийн хэрэгслийн дүн
Гадаадын Төв банкны үнэт цаас	132202, 132302, 132602, 132702, 132901 эдгээр дансанд тусгагдсан олон улсын хөрөнгийн биржүүд дээр арилжаалагдаж байгаа “Стандарт энд Пурс” (Standard&Poog’s) компанийн ВВВ болон түүнтэй адилтгах зэрэглэлээс дээш зэрэглэлтэй Гадаадын Төв банкны үнэт цаасны дүн
Гадаадын компанийн өрийн хэрэгсэл	132205, 132305, 132605, 132705, 132901 эдгээр дансанд тусгагдсан Хорооноос баталсан Ердийн даатгалын компанийн даатгалын нөөц сангаас хөрөнгө оруулалт хийх талаарх харилцааг зохицуулсан эрх зүйн актад заасан олон улсын хөрөнгийн биржүүд дээр арилжаалагдаж байгаа “Стандарт энд Пурс” (Standard&Poog’s) компанийн ВВВ болон түүнтэй адилтгах зэрэглэлээс дээш зэрэглэлтэй холбогдох этгээдэд үл хамаарах Гадаадын компанийн өрийн хэрэгслийн дүн
Гадаадын компанийн хувьцаа	132210, 132310, 132610, 132710, 132901 эдгээр дансанд тусгагдсан 132205, 132305, 132605, 132705, 132901 эдгээр дансанд тусгагдсан Хорооноос баталсан Ердийн даатгалын компанийн даатгалын нөөц сангаас хөрөнгө оруулалт хийх талаарх харилцааг зохицуулсан эрх зүйн актад заасан олон улсын хөрөнгийн биржүүд дээр арилжаалагдаж байгаа “Стандарт энд Пурс” (Standard&Poog’s) компанийн ВВВ болон түүнтэй адилтгах зэрэглэлээс дээш зэрэглэлтэй холбогдох этгээдэд үл хамаарах Гадаадын компанийн хувьцааны дүн
Давхар даатгалын хойшлогдсон хураамж	1810
Нөхөн төлбөрийн нөөцийн давхар даатгагчид ногдох хэсэг	1820, 1821
Даатгалын орлогын шимтгэлийн хойшлогдсон зардал	1830, 1840, 1850
Хэвийн өмчлөх бусад хөрөнгө	1610 дансны тус ангилалд тохирох өмчлөх бусад хөрөнгийн дүн, 1619 дансны дүн нь хэвийн өмчлөх бусад хөрөнгийн дүнд тооцогдоно.
Хугацаа хэтэрсэн өмчлөх бусад хөрөнгө	
Хэвийн бус өмчлөх бусад хөрөнгө	
Эргэлзээтэй өмчлөх бусад хөрөнгө	
Муу өмчлөх бусад хөрөнгө	
Санхүүгийн түрээс	2070, 2071
Үл70, 2071 түрээсх	2010, 2011, 2020, 2021
Хөдлөх хөрөнгө	2030, 2031, 2040, 2041, 2050, 2051, 2060, 2061
Даатгалын үндсэн үйл ажиллагаанд зориулан авсан биет бус хөрөнгө	2110, 2111, 2112, 2120, 2121, 2122, 2130, 2131, 2132, 2140, 2141, 2142, 2150, 2151, 2152, 2160, 2161, 2162, 2610 дансдын даатгалын үндсэн үйл ажиллагаанд зориулан авсан биет бус хөрөнгөнд хамаарах дүн.

“Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын 4 дүгээр хавсралт

ЗАЙЛШГҮЙ БАЙХ ХӨРӨНГИЙН АНГИЛАЛ, ДАНСНЫ ЖАГСААЛТААР

Даатгалын хэлбэр	Дансны дугаар	
	Орлогод тооцсон хураамж	Нэхэмжилсэн хохирлын дүн*
Автогээврийн хэрэгслийн даатгал	[511003]-[512003]-[601003]-[602103]-[611003]+[621003]	[631003]-[522003]-[523003] +[642003]+[643003]-[671003]-[672003]
Агаарын хөлгийн даатгал	[511008]-[512008]-[601008]-[602108]-[611008]+[621008]	[631008]-[522008]-[523008] +[642008]+[643008]-[671008]-[672008]
Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	[511009]-[512009]-[601009]-[602109]-[611009]+[621009]	[631009]-[522009]-[523009] +[642009]+[643009]-[671009]-[672009]
Хариуцлагын даатгал	[511010]-[512010]-[601010]-[602110]-[611010]+[621010]	[631010]-[522010]-[523010] +[642010]+[643010]-[671010]-[672010]
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	[511012]-[512012]-[601012]-[602112]-[611012]+[621012]	[631012]-[522012]-[523012] +[642012]+[643012]-[671012]-[672012]
Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	[511016]-[512016]-[601016]-[602116]-[611016]+[621016]	[631016]-[522016]-[523016] +[642016]+[643016]-[671016]-[672016]
Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	[511017]-[512017]-[601017]-[602117]-[611017]+[621017]	[631017]-[522017]-[523017] +[642017]+[643017]-[671017]-[672017]
Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	[511001]-[512001]-[601001]-[602101]-[611001]+[621001]	[631001]-[522001]-[523001] +[642001]+[643001]-[671001]-[672001]
Хөрөнгийн даатгал	[511002]-[512002]-[601002]-[602102]-[611002]+[621002]	[631002]-[522002]-[523002] +[642002]+[643002]-[671002]-[672002]
Ачааны даатгал	[511004]-[512004]-[601004]-[602104]-[611004]+[621004]	[631004]-[522004]-[523004] +[642004]+[643004]-[671004]-[672004]
Барилга угсралтын даатгал	[511005]-[512005]-[601005]-[602105]-[611005]+[621005]	[631005]-[522005]-[523005] +[642005]+[643005]-[671005]-[672005]
Газар тариалангийн даатгал	[511006]-[512006]-[601006]-[602106]-[611006]+[621006]	[631006]-[522006]-[523006] +[642006]+[643006]-[671006]-[672006]
Мал амьтдын даатгал	[511007]-[512007]-[601007]-[602107]-[611007]+[621007]	[631007]-[522007]-[523007] +[642007]+[643007]-[671007]-[672007]
Санхүүгийн даатгал	[511011]-[512011]-[601011]-[602111]-[611011]+[621011]	[631011]-[522011]-[523011] +[642011]+[643011]-[671011]-[672011]
Зээлийн даатгал	[511013]-[512013]-[601013]-[602113]-[611013]+[621013]	[631013]-[522013]-[523013] +[642013]+[643013]-[671013]-[672013]
Итгэлцлийн даатгал	[511014]-[512014]-[601014]-[602114]-[611014]+[621014]	[631014]-[522014]-[523014] +[642014]+[643014]-[671014]-[672014]
Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал	[511015]-[512015]-[601015]-[602115]-[611015]+[621015]	[631015]-[522015]-[523015] +[642015]+[643015]-[671015]-[672015]

“Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт,
түүнд хяналт тавих журам”-ын 5 дугаар хавсралт

**МАЯГТСЭХ04146. “.....” “ХХК-ийн 20... оны дүгээр
улирлын төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт**

/мянган төгрөгөөр/

1. Төлбөрийн чадварын хамгийн бага үзүүлэлт / $I = \max(a)+(b); (c)$			
Зүйл	Дүн	Тооцох хувь	Нийт дүн
(a) Нөөцийн сангийн актуар тооцоолол			
Хувь оролцоогүй гэрээний нөөцийн сангийн		3%	0.0
Хувь оролцоотой гэрээний нөөцийн сангийн		2%	0.0
Хөрөнгө оруулалттай холбоотой гэрээний нөөцийн сан		1%	
(b) Эрсдэлд байгаа даатгалын гэрээний үнэлгээ			
Өмнөх санхүүгийн жилийн төгсгөл дэх нийт эрсдэлд байгаа даатгалын гэрээний үнэлгээний		0.2%	0.0
(c) Зайлшгүй байх хөрөнгө /дүрмийн сангийн доод хэмжээ/			
2. Нийт хөрөнгө			
	Дүн	Бууруулах хувь	Тохиргоо хийгдсэн дүн
3. Зөвшөөрөгдөхгүй хөрөнгө			
Банкны харилцах, хадгаламж		0%	
Банкны хадгаламжийн сертификат		0%	
Касс		0%	
Засгийн газрын бонд		0%	
Төв банкны үнэт цаас		0%	
Давхар даатгалын авлага		0%	
90 хоногоос доош хугацаанд төлөгдөөгүй байгаа авлага		0%	
Тухайн даатгалын компанийн холбогдох этгээдэд үл хамаарах банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулах мөнгөн хөрөнгө		5%	
Санхүүгийн болон үйл ажиллагааны лизинг		5%	
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас		8%	
Үл хөдлөх хөрөнгө		8%	
Хөрөнгө оруулалтын сан	Нээлттэй сан	5%	
	Хаалттай сан	10%	
Орон нутгийн засаг захиргааны бонд		10%	
Компанийн бонд		10%	
Хуримтлал барьцаалсан зээл		10%	
МХБ-ийн хувьцаат компанийн хувьцаа	I ангилал	20%	
	II ангилал	30%	
Бусад авлага		100%	
Биет бус хөрөнгө		100%	
Бараа материал, тоног төхөөрөмж		100%	
Урьдчилж төлсөн зардал, тооцоо		100%	
Бусад хөрөнгө		100%	
4. Зөвшөөрөгдөх хөрөнгө / $4=(2)-(3)/$			
5. Өр төлбөр / $5=урт хугацаат өр төлбөр+богино хугацаат өр төлбөр/$			
6. Төлбөрийн чадварын зохистой харьцаа / $6=(4)/(5) \geq 110\%$			
7. Төлбөрийн чадварын хязгаар / $7=(4)-(5) \geq (1) /$			

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 01 дүгээр сарын
09-ний өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан
“Даатгалын багц дүрэм”-ийн гуравдугаар хавсралт

**ДААТГАЛЫН НӨӨЦ САН, АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН САН БОЛОН
БУСАД САНГ БҮРДҮҮЛЭХ, ХУВААРИЛАХ,
ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэ журмын зорилго нь даатгагч даатгалын нөөц сан, албан журмын даатгалын сан болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ноос хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2 Даатгагч энэ журмаар зөвшөөрөгдсөн ангилал болон аргачлалаар даатгалын нөөц сан, бусад санг бүрдүүлэх бөгөөд энэ нь даатгуулагчтай байгуулсан даатгалын гэрээнээс үүсэх хариуцлагыг байнга хангахуйц хэмжээнд байна.

1.3 Даатгагч ямар ч цаг хугацаанд даатгалын нөөц санг тооцох боломжийг бүрдүүлсэн байна.

**ХОЁР. ЕРДИЙН ДААТГАЛЫН НӨӨЦ САН БОЛОН
БУСАД САНГ БҮРДҮҮЛЭХ, ХУВААРИЛАХ**

2.1 Ердийн даатгагчийн бүрдүүлэх даатгалын нөөц санг дараах байдлаар ангилна:

2.1.1 Тайлагналын өдөр болон түүнээс өмнөх хугацаанд даатгалын тохиолдол нь болсон боловч даатгагчид мэдэгдээгүй байгаа даатгалын тохиолдлын улмаас үүсэх даатгагчийн хүлээх хариуцлагын дүн буюу Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан (УБМХНС буюу англиар Incurred but not reported-IBNR);

2.1.2 Даатгалын тохиолдол болсон тухай даатгагчид мэдэгдсэн бөгөөд даатгалын нөхөн төлбөр олгоогүй байгаа даатгалын нэхэмжлэлтэй холбогдох даатгагчийн хүлээх хариуцлагын дүн буюу Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан (МБТХНС буюу англиар Reported but not Paid-RBNP);

2.1.3 Даатгагчийн хүчин төгөлдөр даатгалын гэрээтэй холбогдон тайлант хугацаанаас хойш гарах нийт нөхөн төлбөр ба зардлын орлогод тооцоогүй хураамжаас давсан хэсгийг нөхөн төлөх даатгагчийн хүлээх хариуцлагын дүн буюу Учирч болзошгүй хохирлын нөөц сан (УБХНС буюу Unexpired risk reserve-URR);

2.1.4 Тусгай нөөц сан.

2.2 Даатгагчийн нэхэмжлэлийн нөөц сан нь тайлагналын өдөр хүртэл мэдсэн боловч төлөөгүй эсхүл учирсан боловч мэдэгдээгүй нэхэмжлэлтэй холбоотой, энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь заалтад дурдсан нөөц сангуудын нийлбэртэй тэнцүү ба дараах аргачлалаар бүрдүүлж, хуваарилна:

2.2.1 Даатгагч тайлагналын өдөр шийдвэрлэгдээгүй үлдсэн болон тайлагналын өдрөөс өмнөх хугацаанд үүссэн бөгөөд даатгагчид мэдэгдэхээр хүлээгдэж байгаа бүх нэхэмжлэлийг барагдуулахтай холбоотой нийт хариуцлагыг тооцсон байна.

2.2.2 Энэ журмын 2.2.1-д дурдсан бүх нэхэмжлэлийг барагдуулах зардалд даатгуулагчид төлөхөөр тооцоолсон нөхөн төлбөрөөс гадна нөхөн төлбөрийн үнэлгээний зардал мөн хамаарна.

2.3 Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц санг дараах аргачлалаар бүрдүүлж, хуваарилна:

2.3.1 Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц санд тайлангийн хугацаанд даатгуулагч эсхүл даатгалын гэрээнд заагдсан холбогдох бусад этгээдээс даатгагчид тухайн гэрээнд заасан аливаа хэлбэрээр /бичгээр, утсаар, емэйлээр болон бусад/ мэдэгдсэн даатгалын тохиолдлоос үүсэх даатгагчийн урьдчилан тооцоолсон хариуцлагын хэмжээ болон тайлангийн хугацаанд төлөгдөөгүй үлдсэн нэхэмжлэлийн хэмжээ хамаарна.

2.3.2 Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сангийн нийт хэмжээг дараах томъёогоор тооцно:

$$\text{МБТХНС} = (A + B - B + \Gamma)$$

, Үүнд:

МБТХНС = даатгалын гэрээ тус бүрээр тооцсон мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан.

A = тайлангийн үеэс /сар, улирал, жил байж болох/ өмнөх үед даатгалын тохиолдол нь учирсан бөгөөд нэхэмжилсэн эсэхээс үл хамааран даатгагчид мэдэгдсэн даатгалын өр төлбөрийн дүн /өмнөх тайлант үеийн Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сангийн тухайн гэрээгээрх үлдэгдэл буюу тухайн хугацаанд хамаарах даатгалын нэхэмжилсэн хохирлын дүн дээр даатгагчид мэдэгдсэн боловч нэхэмжлээгүй хохирлыг нэмсэн дүнтэй тэнцэнэ/.

B = тайлангийн үед даатгалын тохиолдол нь учирсан бөгөөд нэхэмжилсэн эсэхээс үл хамааран даатгагч мэдсэн даатгалын өр төлбөрийн дүн, эдгээр нь компанийн нэхэмжлэлийн бүртгэлд орсон байна /даатгалын нэхэмжилсэн хохирлын дүн дээр даатгагч мэдсэн боловч нэхэмжлээгүй хохирлыг нэмсэн дүнтэй тэнцэнэ/.

B = тайлангийн хугацаанд /зөвхөн тухайн улиралд/ барагдуулсан нэхэмжлэл.

Г = даатгалын хохирол үнэлгээний зардал, энэ нь дараах зүйлүүдийн нийлбэрээс бүрдэнэ:

(а) тайлангийн хугацааны эцэст шийдвэрлэгдээгүй байгаа нэхэмжлэлийн хохирол үнэлгээний зардлын дүн

(б) шаардлагатай бол хөндлөнгийн шинжээчийн зардлын дүнг нэмж тооцох.

2.3.3 Энэ журмын 2.3.2-т заасан “Б”-ийн хувьд мэдсэн боловч нэхэмжлээгүй хохирлын дүнг тооцоход хүндрэлтэй тохиолдолд тооцоолол хийж буй өдрөөс өмнөх 2-оос дээш жилд ижил даатгалын зүйлд ижил төстэй тохиолдлуудаас ойролцоо хэмжээтэй учирсан хохирлуудын арифметик дундаж дүнгээр тухайн гэрээний даатгалын нийт үнэлгээнээс хэтрэхгүйгээр, мөн хохирол үнэлгээний хамгийн оновчтой тооцоолсон дүнгээр нэмэгдүүлэн тооцно.

2.3.4 Шүүхийн маргаантай байгаа нэхэмжлэлийн хувьд Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц санг нэхэмжлэгчийн шаардлагын дүнгээр, даатгалын үнэлгээнээс хэтрэхгүйгээр тооцож нөөц байгуулна. Ийнхүү байгуулсан нөөцийг шүүхийн эцсийн шийдвэр гарах хүртэл нөөцөд хэвээр үлдэнэ. Нэмж байгуулах шаардлагатай гэж хэрэв даатгагч үзсэн бол мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөцийг нэмэгдүүлж болно.

2.3.5 Даатгагч нэхэмжлэл ирсэн огнооноос эхлэн нэхэмжлэлийг барагдуулах хүртэлх бүхий л мэдээллийг агуулсан Нэхэмжлэлийн бүртгэлийг үүсгэж, хөтөлнө.

2.3.6 Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц санг даатгалын тохиолдол болсноор нэмэгдүүлэх эсвэл нөхөн төлбөрийг төлснөөр бууруулах бол тайлагналын өдөр Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сангийн өөрчлөлт дансаар тус нөөц санг нэмэгдүүлж эсхүл бууруулна.

2.3.7 Даатгагч анхан шатны мэдээлэл дээр үндэслэн Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц санг байгуулсан бөгөөд нэмэлт мэдээлэл болон хөндлөнгийн байгууллагын шинжилгээг

үндэслэн нөхөн төлбөрийн дүнг эцэслэн гарахад өмнөх байгуулсан нөөц сангийн дүнгээс их эсвэл бага байвал мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сангийн өөрчлөлт дансаар тус санг нэмэгдүүлж эсхүл бууруулж болно.

2.4 Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц санг дараах аргачлалаар бүрдүүлж, зарцуулна:

2.4.1 Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц санг даатгагч даатгалын хэлбэр тус бүрээр үнэн зөв бөгөөд бодитой статистикт тулгуурлан актуар аргачлалаар тооцоолсон даатгагчийн хамгийн сайн төсөөлөлд үндэслэн тооцно. Тухайн нөөцийг тайлант хугацааны эцсийн байдлаар учирсан боловч мэдэгдээгүй байгаа хохиролд зориулан байгуулна.

2.4.2 Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөцийг тооцоход даатгагч хохирлын гурвалжны хөгжлийн аргуудыг ашиглана. Эдгээр арга нь актуар төсөөлөл, аргачлалд суурилах ба дараах шаардлагуудыг хангасан байна:

2.4.2.а Хохирлын хөгжлийн гурвалжинг улирлын статистик тоон өгөгдлийг ашиглан үнэн зөв, бодитой тоон мэдээлэлд үндэслэн гаргах ба дор хаяж өмнөх 12 улирлын төлсөн нийт нөхөн төлбөр ба нөөц сангийн тоон мэдээллийг ашигласан байна.

2.4.2.б Хохирол үнэлгээний зардлыг учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөцийн нийт дүнд оруулан тооцно.

2.4.2.в Жигд бус тархалттай, их хэмжээний хохирлыг актуарч актуар тооцооллын шаардлагаар тохируулга хийж болох бөгөөд энэ талаар журмын 1 дүгээр хавсралтад тусгасан байна.

2.4.3 Тооцоололд актуарчийн хийсэн тохируулга ихээхэн нөлөө үзүүлдэг учир актуарч уг нөөц сангийн тооцооллыг хийхэд ашиглагдсан таамаглал төсөөлөл, урьдчилсан нөхцөл болон бусад тохиргоог тодруулж энэ журмын 1 дүгээр хавсралтад заавал тусгана.

2.4.4 Тайлагналын өдрөөр даатгалын хариуцлага гэрээний дагуу дууссан, шинээр даатгалын хариуцлага нэмэгдсэн эсвэл даатгалын тохиолдол болсныг даатгуулагч мэдэгдсэн зэрэг нөлөөг актуар тооцооллоор тооцсоноор Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц санг өмнөх тайлант хугацааны дүнгээс нэмэгдүүлэх эсвэл бууруулах шаардлагатай бол Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сангийн өөрчлөлт дансаар тус нөөц санг нэмэгдүүлж эсвэл бууруулна.

2.4.5 Даатгагч санхүүгийн нэг жилд учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц санг тооцоолохдоо зөвхөн нэг аргачлалыг ашиглах ба ашигласан аргачлалаа өөрчлөх тохиолдолд тухайн аргачлалыг ашиглахаас 30-аас доошгүй хоногийн өмнө даатгагчийн хүсэлт ба актуарчийн саналыг Хороонд ирүүлж, мэдэгдэнэ. Өмнөх тайлант үед ашиглагдсан хохирлын гурвалжны мэдээллийг зөвхөн Хорооны зөвшөөрөлтэйгөөр өөрчилж болно.

2.5 Учирч болзошгүй хохирлын нөөц санг дараах аргачлалаар бүрдүүлж, хуваарилна:

2.5.1 Учирч болзошгүй хохирлын нөөц санг даатгагчийн хүчин төгөлдөр даатгалын гэрээнүүдийн хувьд өмнөх тайлант хугацааны эцэс дэх учирч болох хохирол болон үйл ажиллагааны зардлын нийлбэр нь орлогод тооцоогүй хураамжийн нөөцөөс давсан тохиолдолд тухайн нэмэгдэл хариуцлагын хэмжээгээр тооцно.

2.5.2 Учирч болзошгүй хохирлын нөөц санг /УБНХС/ даатгалын хэлбэр тус бүрийн хувьд дараах томъёо ашиглан байгуулна. Хаалтнаас гарах үр дүн сөрөг байвал энэхүү нөөцийг нэмэгдүүлэхгүй:

$$УБХНС_i = \left(\frac{НТ_i + YAЗ_i}{ЦХ_i - \Delta OTX_i} - 1.00 \right) * OTX_i$$

Үүнд:

НТ_i – i дугаар даатгалын хэлбэрийн даатгалын нөхөн төлбөрийн цэвэр зардал/давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр орохгүй/ ба нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлтийн нийлбэр/давхар даатгалын хэсэг орохгүй/,

YAЗ_i – i дугаар даатгалын хэлбэрийн /хэлбэрээр задлах эсэх/ үйл ажиллагааны зардал, үүнд: даатгалын гэрээний зардал, ерөнхий ба удирдлагын зардал, борлуулалт маркетингийн зардал, санхүүгийн зардал, бусад зардал хамаарна. Зардлуудыг хэлбэрээр задлах боломжгүй бол хэлбэр тус бүрийн орлогод тооцсон хураамжийг нийт орлогод тооцсон хураамжид харьцуулсан хувийн жинг үйл ажиллагааны зардлын дүнгээр үржүүлэн даатгалын хэлбэр тус бүрээрх зардлын задаргааг тооцож болно. Орлогод тооцсон хураамж гэж тайлант хугацаанд орлогод хүлээн зөвшөөрөгдсөн хураамжийн орлого буюу даатгалын хураамжийн цэвэр орлогоос орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлтийг хасч хойшлогдсон давхар даатгалын хураамжийн өөрчлөлтийг нэмж тооцсон дүнг. /Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн дансны тайлант үеийн үлдэгдлээс эхний үлдэгдлийг хасч Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлтийг тодорхойлно. Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн давхар даатгагчид ногдох хэсэг дансны тайлант үеийн үлдэгдлээс эхний үлдэгдлийг хасч хойшлогдсон давхар даатгалын хураамжийн өөрчлөлтийг тодорхойлно/

ЦХ_i – i дугаар даатгалын хэлбэрийн даатгалын хураамжийн цэвэр орлого; /Даатгалын хураамжийн цэвэр орлого гэж даатгалын хураамжийн нийт орлогоос даатгалын хураамжийн буцаалт болон давхар даатгалын хураамжийн зардлыг хассан дүнг хэлнэ. Даатгалын хураамжийн буцаалт гэж даатгалын гэрээ цуцлагдахад тухайн гэрээнд заасны дагуу даатгуулагчид буцаан төлөх даатгалын хураамжийг, Давхар даатгалын хураамжийн зардал гэж даатгагч нь даатгуулагчийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн буюу хэсэгчлэн дахин даатгуулсны үндсэн дээр төлсөн ба төлөхөөр тооцсон төлбөрийг ойлгоно./,

ΔOTX_i – i дугаар даатгалын хэлбэрийн даатгалын орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн нийт өөрчлөлт /хойшлуулсан давхар даатгалын хураамжийн өөрчлөлтийг хасна/,

OTX_i – i дугаар даатгалын хэлбэрийн даатгалын Орлогод тооцоогүй хураамжийн нөөц /хойшлуулсан давхар даатгалын хураамжийн дүнг хасна/.

2.5.3 Учирч болзошгүй хохирлын нөөц сангийн нийт хэмжээ нь даатгалын хэлбэр тус бүрээр байгуулсан учирч болзошгүй хохирлын нөөц сангуудийн нийлбэртэй тэнцүү бөгөөд дараах томъёогоор тооцно:

$$УБХНС_t = \sum_{i=1}^n УБХНС_i \quad , \text{Үүнд:}$$

УБХНС_t - учирч болзошгүй хохирлын нөөц сангийн нийт дүн.

2.5.4 Даатгагч энэ журмын 2.5.2-т дурдсан томъёоны хувьсагчдын ирээдүйн төсөөллийг тооцох статистик суурь мэдээлэл хангалттай бөгөөд тооцох боломжтой гэж үзвэл тэдгээрийг томъёоны харгалзах хэсгүүдэд орлуулан тооцоолж болно.

2.5.5 Даатгагч энэ журмын 2.1.4-т заасан тусгай нөөц сангаас зарцуулалт хийхээр бол Хороонд хүсэлтээ бичгээр тавих ба хүсэлтэд тусгай нөөц санг зарцуулах үндэслэл, хэмжээ, тооцоолол, тайлбарыг тодорхой тусгасан байна.

2.5.6 Даатгагч энэ журмын 2.5.5-д заасны дагуу тусгай нөөц сангаас зарцуулалт хийх хүсэлт ирүүлсэн тохиолдолд Хороо хүсэлтийг хянаж, хариуг даатгагчид албан бичгээр хүргүүлнэ.

2.5.7 Даатгагч энэ журмын 2.1-д заасан даатгалын нөөц сангаас гадна даатгагчийн даатгалын хариуцлага дуусаагүй байгаа даатгалын гэрээ бүрийн хувьд “хувь тэнцүүлсэн арга”-аар буюу тайлагналын өдрөөр даатгалын гэрээний хүчинтэй үлдэх хугацаанд хувь тэнцүүлэн тооцсон даатгалын хураамжийн хэсгүүдийн нийлбэрээр орлогод тооцоогүй хураамжийн нөөцийг байгуулна.

2.5.8 Даатгалын гэрээний хувьд орлогод тооцоогүй хураамжийн нөөцийг “хувь тэнцүүлсэн арга”-аар дараах томъёог ашиглан тооцно:

$$OTXHi = (ДНХi - ДБи) * \frac{Xi}{Hi}, \text{ Үүнд:}$$

$OTXHi$ = i дугаар даатгалын гэрээний орлогод тооцоогүй хураамжийн нөөц;

$ДНХi$ = i дугаар даатгалын гэрээний нийт хураамжийн орлого;

$ДБи$ = i дугаар даатгалын гэрээний даатгалын хураамжийн буцаалт

Xi = i дугаар даатгалын гэрээний хүчинтэй байх үлдсэн хугацаа/өдрөөр/ бөгөөд үүнийг гэрээний нийт хугацаанаас тухайн гэрээний тайлагналын өдөр хүртэл үргэлжилсэн хугацааг хасч тооцно;

Hi = i дугаар даатгалын гэрээний нийт үргэлжлэх хугацаа.

i - орлогод тооцоогүй хураамжийн нөөц тооцогдсон даатгалын гэрээний дугаар

2.5.9 Нийт орлогод тооцоогүй хураамжийн нөөц нь даатгалын гэрээ тус бүрээр байгуулсан орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн нийлбэртэй тэнцүү бөгөөд дараахь томъёогоор тооцно.

$$OTXHt = \sum_{i=1}^n OTXHi, \text{ Үүнд:}$$

$OTXHi$ - t хугацаан дахь нийт орлогод тооцоогүй хураамжийн нөөц

n - орлогод тооцоогүй хураамжийн нөөц тооцсон даатгалын гэрээний нийт тоо

2.5.10 Буцаасан даатгалын хураамжийг хууль тогтоомжийн дагуу даатгалын гэрээний хугацаа дуусахаас өмнө даатгагчаас даатгуулагчид тухайн гэрээний үлдэх хугацаанд ногдуулан буцаан олгосон хураамжаар тодорхойлно.

2.5.11 Тайлагналын өдрөөр даатгалын хариуцлага гэрээний дагуу дууссан, эсхүл шинээр даатгалын хариуцлага нэмэгдсэн зэрэг шалтгаанаар Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн үлдэгдлийг тооцоолсны дараа тус нөөцийг өмнөх тайлант хугацааны дүнгээс бууруулах эсвэл нэмэгдүүлэх бол Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт дансаар тус нөөцийг нэмэгдүүлж эсвэл бууруулна.

2.5.12 Даатгагчийн бүрдүүлсэн орлогод тооцоогүй хураамжийн нөөцийг бэлэн мөнгө, банкны харилцах, хадгаламж, хадгаламжийн сертификат болон даатгалын хураамжийн авлага хэлбэрээр байршуулж болох бөгөөд бэлэн мөнгөнд уг нөөцийн 2 хүртэл хувиар байршуулна.

2.6 Даатгагч нь нийт нөөц сангаас давхар даатгагчид ногдох хэсгийг дараах байдлаар тодорхойлно:

2.6.1 Даатгалын нөөц сан дахь давхар даатгагчид ногдох хэсгийг даатгагч энэ журамд заасан харгалзах нөөц сантай адил аргачлалаар эсхүл давхар даатгалын гэрээний хэлбэр /хувь тэнцүүлсэн, хувь тэнцүүлээгүй, сайн дурын, албан журмын гэх мэт/, нөхцөлөөс хамааруулан өөрөөр тооцож болно.

2.6.2 Даатгагч нь давхар даатгагчид ногдох нөөц сангийн хэсгийг тооцохдоо даатгагчийн давхар даатгалын нэхэмжлэлийг барагдуулах чадавхи, давхар даатгагчаас буцаан төлүүлэх боломж зэргийг харгалзан үзнэ. Актуарч эдгээр үйл ажиллагаанд эрсдэл байгаа эсэхийг судалж, тооцох бөгөөд даатгалын нөөц сан байгуулахад давхар даатгалын эрсдэлийг хэрхэн тооцсон талаар актуарын тайланд тодруулан тусгасан байна.

2.6.3 Даатгагч, давхар даатгагч, дахин буюу ретро давхар даатгагчдын хооронд хийгдэж буй хөрөнгийн аливаа гүйлгээ нь бодитой, нотлогдсон байна.

2.6.4 Хойшлогдсон давхар даатгалын хураамж буюу давхар даатгагчид ногдох орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн тооцооллыг энэ журмаар заасан орлогод тооцоогүй хураамж тооцох аргачлалтай нэгэн адил аргачлалаар эсхүл хэрэв давхар даатгалын гэрээнд заасан бол тухайн нөхцөлөөр тус тус тооцоолно.

2.6.5 Даатгалын нөөцийн давхар даатгагчид ногдох УБМХНСангийн хэсэг буюу давхар даатгагчид ногдох учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөцийг давхар даатгуулсан даатгалын зүйлд учирсан даатгалын тохиолдолд хамаарах даатгалын гэрээ бүрийн хувьд байгуулна. Энэ нь давхар даатгалын гэрээнд заагдсан, давхар даатгагчаас олгох боломж бүхий мөнгөн дүнтэй тэнцүү байна.

2.6.6 Давхар даатгагчид ногдох учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөцийг даатгалын хэлбэр тус бүрээр давхар даатгалд шилжүүлсэн нөхөн төлбөрийн статистик мэдээлэлд тулгуурлан хэлбэр тус бүрийн хувьд дараах томъёогоор тооцно:

$$ДД_i = УБМХНС_t * \frac{HT_{re}}{HT_t}$$

, Үүнд:

ДД_i – даатгалын “i” хэлбэрээр учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсгийн дүн;

УБМХНС_t – даатгалын “i” хэлбэрээр байгуулсан учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нийт нөөцийн хэмжээ;

HT_{re} – даатгалын “i” хэлбэрийн хувьд давхар даатгалаас төлөгдсөн нөхөн төлбөр;

HT_t – даатгалын “i” хэлбэрийн хувьд тайлангийн хугацаанд төлөгдсөн нийт нөхөн төлбөрийн хэмжээ.

Бүх хэлбэрээр давхар даатгагчид ногдох учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сангуудын нийлбэрээр давхар даатгагчид ногдох учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц санг тооцно.

$$ДД_t = \sum_{i=1}^n ДД_i$$

, Үүнд:

ДД_t = Бүх хэлбэрээр давхар даатгагчид ногдох учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сангийн хэмжээ

2.7 Даатгалын нөөц санг бүрдүүлэхэд дараах шаардлага тавигдана:

2.7.1 Даатгагч бүр даатгалын нөөц сан тооцож, бүрдүүлэх Дотоод журамтай байна.

2.7.2 Энэхүү журмыг актуарч хянаж, даатгагчийн гүйцэтгэх удирдлага баталгаажуулна. Ийнхүү баталснаас хойш 10 хоногт, хүчин төгөлдөр болохоос 10-аас багагүй хоногийн өмнө Хороонд хүргүүлнэ.

2.7.3 Хороо шаардлагатай гэж үзвэл Дотоод журамд өөрчлөлт оруулахыг шаардаж болно.

2.7.4 Даатгалын нөөц сан тооцож, бүрдүүлэх дотоод журамд дараах нөхцөлүүдийг заавал тусгасан байна:

2.7.4.а Даатгалын нөөц сан тооцох суурь зарчим ба агуулга (нэр томъёоны тайлбар ба тодорхойлолт);

2.7.4.б Дараах агуулгыг багтаасан даатгалын бүтээгдэхүүнүүдийн талаарх ерөнхий чиглэл:

2.7.4.б.1. даатгалын гэрээнүүдтэй холбогдох даатгалын эрсдэлүүд;

2.7.4.б.2. даатгалын хугацаа, даатгалын хураамж болон нөхөн төлбөр төлөх хугацаа;

2.7.4.б.3. даатгалын хураамжийн төлбөрийн зохицуулалт (жилээр, хагас жилээр, улирлаар, сараар, хуваарийн дагуу);

2.7.4.б.4. даатгалын буцаалтыг төлөх аргачлал;

2.7.4.б.5. даатгагчийн зардлын түвшин;

2.7.4.б.6. даатгалын нөөц сан тооцоолоход ашиглах нэмэлт арга, аргачлал, томъёо;

2.7.4.б.7. давхар даатгалын нөөц сан тооцоолох арга, аргачлал, томъёо.

2.7.5 Даатгагч даатгалын эрсдэлийн багцаа шилжүүлэх, эсхүл Хорооны өгсөн үүрэг даалгаврын дагуу үйл ажиллагааг нь түр зогсоох, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох зэрэг нөхцөлд даатгуулагчийн өмнө хүлээх эрсдэлийг бүрэн тайлагнах нөхцөлийг хангах зорилгоор календарийн аливаа өдрөөр даатгалын нөөц сангийн тайлан гаргах боломжийг бүрдүүлсэн байна.

2.7.6 Даатгагч дараах мэдээлэлд суурилан даатгалын нөөц санг бүрдүүлнэ:

2.7.6.а даатгуулагчидтай байгуулсан даатгалын гэрээний бүртгэл;

2.7.6.б даатгалын нөхөн төлбөрийн бүртгэл;

2.7.6.в давхар даатгагчид даатгуулсан даатгалын гэрээний бүртгэл;

2.7.6.г давхар даатгагчид даатгуулсан даатгалын гэрээний нөхөн төлбөрийн бүртгэл.

2.7.7 Энэ журмын 2.7.6 дахь заалтад дурдсан бүртгэлд дараах заалтуудыг дор хаяж тусгана:

(а) даатгалын гэрээний (даатгалын баталгааны) дугаар;

(б) даатгуулагчийн овог, нэр, регистр;

(в) даатгуулагчийн нас, хүйс, даатгалын хураамжид нөлөөлж болох бусад үзүүлэлт;

(г) гэрээ байгуулсан огноо, даатгалын хамгаалалт эхэлсэн ба дуусах огноо,

(д) даатгалын хугацаа, даатгалын гэрээний нөхцөл өөрчлөгдсөн огноо;

(е) даатгалын эрсдэлүүд;

(ё) даатгалын үнэлгээ;

(ж) даатгалын нийт хураамж;

(з) хүлээж авсан даатгалын хураамжийн хэмжээ, огноо, хуваарь;

- (и) даатгалын гэрээ цуцалснаар буцаан төлсөн даатгалын хураамж, огноо;
- (й) нөхөн төлбөрийн нэхэмжлэлийн өргөдлийн огноо, нэхэмжилсэн хэмжээ;
- (к) даатгалын тохиолдлын огноо, даатгалын эрсдэл;
- (л) мэдэгдсэн нэхэмжлэлийн өөрчлөлт, огноо;
- (м) даатгалын нөхөн төлбөр олгосон огноо;
- (н) даатгалын нөхөн төлбөр олгохоос татгалзсан бол татгалзсан огноо.

ГУРАВ. УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН НӨӨЦ САНГ БҮРДҮҮЛЭХ, ХУВААРИЛАХ

3.1 Урт хугацааны даатгагчийн бүрдүүлэх даатгалын нөөц санг дараах байдлаар ангилна:

3.1.1 Гэрээний үргэлжлэх хугацаанд даатгуулагч нь даатгалын компанийн ашгаас ноогдол ашиг авах нөхцөл бүхий урт хугацааны даатгалын гэрээнд зориулсан Хувь оролцоотой гэрээний нөөц сан;

3.1.2 Гэрээний үргэлжлэх хугацаанд даатгуулагч нь даатгалын компанийн ашгаас ноогдол ашиг авах талаар гэрээнд заагаагүй урт хугацааны даатгалын гэрээнд зориулсан Хувь оролцоогүй гэрээний нөөц сан;

3.1.3 Даатгалын хураамжийн зохих хэсэг нь тодорхой хөрөнгө оруулалтад даатгуулагчийн хүсэл сонирхол болон гэрээнд заасан нөхцөлийн дагуу байршдаг урт хугацааны даатгалын гэрээнд зориулсан Хөрөнгө оруулалттай холбоотой гэрээний нөөц сан.

3.2 Даатгагчийн даатгалын нөөц сан нь даатгалын бүтээгдэхүүн тус бүрийн нөөц сангаас бүрдэх ба ирээдүйд төлөх нөхөн төлбөр болон зардлын өнөөгийн үнэ цэнийн нийлбэрээс даатгуулагчийн төлөх даатгалын нийт хураамжийн өнөөгийн үнэ цэнийг хассан зөрүүгээр тодорхойлогдоно.

3.3 Даатгагч нь даатгалын нөөц санг цэвэр хураамжийн орлого болон хөрөнгө оруулалтын орлогоос бүрдүүлэх бөгөөд цэвэр хураамжийн орлогыг даатгалын нийт хураамжийн орлогоос давхар даатгалд төлсөн хураамжийг хасч тооцно.

3.4 Даатгалын багц бүтээгдэхүүнийг нөхцөл тус бүрээр задалж даатгалын нөөц сангийн тооцооллыг хийнэ.

3.5 Даатгалын бүтээгдэхүүн тус бүрийн ирээдүйд төлөх нөхөн төлбөрийн өнөөгийн үнэ цэнийг тооцохдоо даатгагчийн мөрдөж байгаа насжилтын хүснэгтэд үндэслэнэ. Даатгалын хураамжийн хүүгийн түвшинг энэ журмын 3.6.2-т зааснаар тооцно.

3.6 Урт хугацааны даатгагч энэ журмын 2.7-д заасан даатгалын нөөц санг бүрдүүлэхэд тавигдах шаардлагыг хангаж ажиллахаас гадна даатгалын актуар тооцоололд дараах шаардлагыг хангаж ажиллана:

3.6.1 Хорооноос эрх авсан урт хугацааны даатгалын актуарч нь нөөц сангийн актуар тооцооллыг хийх бөгөөд хүүгийн түвшин, нас баралтын түвшин, гэрээ цуцлалтын түвшин, зардлын түвшинг тус тус харгалзаж үзсэн байна.

3.6.2 Хүүгийн түвшинг тогтооход эрсдэлгүй хүүгийн түвшин, инфляци, эрсдэлийн хураамжийг үндэслэж дараах байдлаар тооцно:

3.6.2.а Эрсдэлгүй хүүгийн түвшинг Засгийн газрын бондын хүүгийн түвшинтэй ижлээр тооцно;

3.6.2.б Инфляцийг Монголбанкнаас тухайн жилд зарласан зорилтот түвшинтэй ижлээр тооцно;

3.6.2.в Эрсдэлийн хураамжийг даатгалын актуарч тооцоолно.

3.6.3 Нас баралтын түвшинг Үндэсний статистикийн хорооноос гаргасан нас баралтын хүснэгтийг (mortality table) ашиглан тооцоолно.

3.6.3.а Нас баралтын хүснэгтэд наслалтын тохируулгыг тооцно. Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн амьдрах хугацаа нь өөр өөр байдагт үндэслэн даатгалын гэрээнд эмэгтэй хүний төлөх даатгалын хураамж нь даатгалын ижил нөхцөлтэй гэрээтэй 3-5 насаар залуу эрэгтэй хүний төлөх хураамжтай адилаар тооцогдоно.

3.6.4 Гэрээ цуцлалтын түвшинг нь даатгагч, даатгуулагчийн аль нэгний саналын дагуу даатгалын гэрээ дуусахаас өмнө цуцлах хэмжээг харгалзан тооцно.\

3.6.5 Зардлын түвшинг тухайн даатгалын гэрээний хүчинтэй хугацаанд гарч болох бүхий л зардлуудын хүрээнд тооцоолж тогтооно.

3.6.6 Даатгагч нь дээрх үзүүлэлтүүдийг анх тогтоох ба өөрчлөлт оруулах тухай бүрд болон нөөц сангийн тооцоололд албан ёсоор ашиглахаасаа өмнө Хороонд мэдэгдэнэ.

3.7 Урт хугацааны даатгалын нөөц санг дараах байдлаар зарцуулна:

3.7.1 Даатгалын тохиолдол болсон үед хувь оролцоотой гэрээ, хувь оролцоогүй гэрээ, хөрөнгө оруулалтын гэрээ тус бүрд холбогдох нөөц сангаас нь даатгалын нөхөн төлбөрийг олгоно.

3.7.2 Даатгалын нөөц санг зөвхөн тухайн сангийн зориулалтын дагуу зарцуулах бөгөөд нөөц сангийн хөрөнгийг хооронд нь шилжүүлэх, сольж зарцуулахыг хориглоно.

ДӨРӨВ. ДАВХАР ДААТГАГЧИЙН АЛДАГДЛААС ХАМГААЛАХ САНГ БҮРДҮҮЛЭХ, ХУВААРИЛАХ

4.1 Давхар даатгагч даатгалын хохирлыг нөхөн төлөх нөөц сан хүрэлцэхгүй болсон тохиолдолд ашиглах зориулалт бүхий алдагдлаас хамгаалах санг мөнгөн хөрөнгөөр бүрдүүлэх бөгөөд түүний доод хэмжээ нь 15 тэрбум төгрөг байна. Алдагдлаас хамгаалах санг зээлийн хөрөнгөөр бүрдүүлж болохгүй.

4.2 Даатгагч Хорооноос тогтоосон алдагдлаас хамгаалах сангийн доод хэмжээний 1/3 хэсгийг эхний давхар даатгалын гэрээ байгуулахаас өмнө энэ журмын 4.3-т заасны дагуу байршуулж, 1/3 хэсгийг Хорооноос тусгай зөвшөөрөл авснаас хойш 1 жилийн дотор, үлдсэн 1/3 хэсгийг 3 жилийн дотор тус тус бүрдүүлж энэ журмын 4.4-т заасны дагуу байршуулна.

4.3 Даатгагч алдагдлаас хамгаалах сангийн 1/3 хэсгийг Монголбанкнаас тусгай зөвшөөрөл авсан, Даатгалын тухай хуулийн 4.1.12-т заасан холбогдох этгээдэд хамаарах банкнаас бусад банкинд байршуулах бөгөөд нэг банкинд байршуулах мөнгөн хөрөнгийн дээд хязгаар нь дээрх мөнгөн дүнгийн 25 хувиас хэтрэхгүй байна.

4.4 Алдагдлаас хамгаалах сангийн үлдэх 2/3 хэсгийг дор дурдсан хувь хэмжээгээр хөрөнгө оруулалтад байршуулж болно:

4.4.1 Банкны хадгаламж: 100 хүртэл хувь (нэг банкинд 20 хүртэл хувь);

4.4.2 Банкны харилцах дансанд байршуулах: 100 хүртэл хувь (нэг банкинд 20 хүртэл хувь);

4.4.3 Засгийн газрын өрийн бичиг: 100 хүртэл хувь;

4.4.4 Төв банкны үнэт цаас: 60 хүртэл хувь;

4.4.5 Орон нутгийн засаг захиргааны бонд: 20 хүртэл хувь;

4.4.6 Үл хөдлөх хөрөнгөөр барьцаалсан үнэт цаас 20 хүртэл хувь;

4.4.7 Банкны хадгаламжийн сертификат: 10 хүртэл хувь;

4.4.8 Компанийн бонд: 10 хүртэл хувь (нэг компанид 5 хүртэл хувь);

4.4.9 Санхүүгийн болон үйл ажиллагааны лизинг: 5 хүртэл хувь;

4.4.10 Даатгалын тухайн хуулийн 4.1.12-т заасан “холбогдох этгээд”-ээс бусад этгээдэд үл хөдлөх хөрөнгө барьцаалсан арилжааны богино хугацаат (нэг жил хүртэл) зээл 5 хүртэл хувь;

4.4.11 Үл хөдлөх хөрөнгө: 10 хүртэл хувь (үндсэн үйл ажиллагаа явуулдаг ажлын байрнаас бусад).

4.5 Энэ журмын 4.4.11-д заасны дагуу үл хөдлөх хөрөнгөнд хөрөнгө оруулсан нөхцөлд хөрөнгийн үнэлгээг Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн дагуу хийлгэсэн байна.

4.6 Даатгагч нь гадаад улсад хөрөнгө оруулалт хийхээр бол Хороонд хүсэлтээ бичгээр тавих ба Хорооны хяналт шалгалт, зохицуулалтын асуудал эрхэлсэн газар зөвшөөрөл олгох эсэхийг даатгагч албан бичиг ирүүлсэн өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор шийдвэрлэж, хариуг даатгагчид албан бичгээр хүргүүлнэ.

4.7 Давхар даатгуулагчаас даатгалын гэрээний дагуу нэхэмжилсэн даатгалын нөхөн төлбөрийг давхар даатгагчийн хохирол төлөх нөөц сангаас төлж хүрэлцэхгүй болсон тохиолдолд зөрүүг алдагдлаас хамгаалах сангаас олгоно.

4.8 Алдагдлаас хамгаалах санг энэ журмын 4.3, 4.4 болон 4.7-д зааснаас өөрөөр зарцуулж болохгүй.

4.9 Алдагдлаас хамгаалах сангаас нөхөн төлбөрийг олгосон тохиолдолд нөхөн төлсөн төлбөрийн дүнтэй уялдуулан алдагдлаас хамгаалах сангийн хөрөнгийн дахин бүрдүүлэлтийг дараах байдлаар хийнэ:

4.9.1 Алдагдлаас хамгаалах сангаас олгосон нөхөн төлбөрийн дүн уг сангийн 1/3 хэсэг хүртэл бол уг хөрөнгийг 1 жилийн дотор;

4.9.2 Алдагдлаас хамгаалах сангаас олгосон нөхөн төлбөрийн дүн уг сангийн 1/3-2/3 хүртэл бол 2 жилийн дотор, үүнээс 1/3 хэсгийг эхний нэг жилийн дотор, үлдэх хэсгийг дараагийн нэг жилийн дотор;

4.9.3 Алдагдлаас хамгаалах сангаас олгосон нөхөн төлбөрийн дүн уг сангийн 2/3 хэсгээс дээш бол 2 жилийн дотор, үүнээс эхний 1/3 хэсгийг 1 сарын дотор, үлдэх хэсгийг энэ журмын 4.9.2-т заасны дагуу тус тус дахин бүрдүүлнэ.

4.10 Алдагдлаас хамгаалах сангаас нөхөн төлбөр олгох болсон тохиолдолд Санхүүгийн зохицуулах хороонд 7 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.

ТАВ. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

5.1 Даатгагч татан буугдсан, дампуурсан тохиолдолд даатгалын бүх нөхөн төлбөр, хураамжийн буцаалт хийгдсэний дараах нөөц сангийн үлдэгдлээс Хорооноос томилсон актуарчийн актуар тооцооллын дагуу тохирох хэсгийг даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор Даатгагчдын холбооны тусгайлсан дансанд байршуулна.

5.2 Энэ журмын 5.1-д заасан тусгайлсан дансанд нөөц сангийн мөнгөн хөрөнгийг байршуулах болон зарцуулах үйл ажиллагааг холбогдох журмаар зохицуулах бөгөөд хэрэгжилтэд Хороо байнгын хяналт тавина.

5.3 Энэ журмын 2.1.1, 2.1.2-т заасан даатгалын нөөц сангууд болон урт хугацааны даатгалын нөөц санг Хорооноос актуарын эрх авсан актуарч тооцоолох бөгөөд Хороо түүнд хяналт тавьж ажиллана.

5.4 Даатгагч нь жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан даатгалын нөөц сангийн

үлдэгдлийг Хорооноос олгосон эрх бүхий актуарч эсхүл олон улсын мэргэжлийн холбоодоос олгосон Associate ба түүнтэй адилтгах түвшний болон түүнээс дээш эрхтэй актуарчаар баталгаажуулсан байна.

5.5 Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөцийг тооцоход ашиглах хохирлын гурвалжны суурь мэдээллийг үнэн зөв бүрдүүлсэн эсэх, актуарын тооцоололд ашиглахад тохиромжтой эсэхэд Хороо хяналт тавьж ажиллана.

5.6 Даатгагч нь дараах тайлан, мэдээллийг заасан хугацаанд Хороонд ирүүлнэ:

5.6.1 Ердийн болон урт хугацааны даатгагч энэ журмын 1 дүгээр хавсралтад заасны дагуу “Даатгалын нөөц сангийн актуар тайлан”-г жилийн эцсийн санхүүгийн тайлангийн хамт;

5.6.2 Ердийн даатгагч энэ журмын 2 дугаар хавсралтад заасны дагуу “Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн хөрөнгийн байршлын тайлан”-г санхүүгийн тайлангийн хамт улирал бүр;

5.6.3 Урт хугацааны даатгагч энэ журмын 3 дугаар хавсралтад заасны дагуу “Даатгалын нөөц сангийн тооцооллын тайлан”, 4 дүгээр хавсралтад заасны дагуу “Даатгалын нөөц сангийн бүрдүүлэлтийн тайлан”-г тус тус санхүүгийн тайлангийн хамт улирал бүр;

5.6.4 Давхар даатгагч энэ журмын 5 дугаар хавсралтад заасны дагуу “Алдагдлаас хамгаалах сангийн хөрөнгийн байршлын тайлан”-г санхүүгийн тайлангийн хамт улирал бүр.

5.7 Энэ журмын 5.6-д заасан тайлан, мэдээллийг шаардлагатай тохиолдолд Хороо хэдийд ч шаардаж авч болохоос гадна тайлантай холбогдуулан нэмэлт мэдээлэл, материал шаардаж болно.

5.8 Энэхүү журмын хэрэгжилтэд Хороо хяналт тавих бөгөөд зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

“Даатгалын нөөц сан, албан журмын даатгалын сан болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам”-ын 1 дүгээр хавсралт

МАЯГТ СЗХ04147. Даатгалын нөөц сангийн актуар тайлан

Даатгалын нөөц сангийн актуар тайлан нь техник тооцоолол болон холбогдох тайлбарыг агуулсан байх бөгөөд хөндлөнгийн актуарч, хянан шалгагч тооцооллыг үнэн зөв эсэхийг дүгнэхэд хангалттай мэдээлэл агуулсан байна.

Актуар тайлангийн агуулга дараах байдалтай байна. Үүнд:

1. Тайлангийн зорилго, хамрах хүрээ, хязгаарлалт:
 - Зорилго
 - Тайлангийн хамрах хугацаа, даатгалын бүтээгдэхүүн ба хэлбэрийн мэдээлэл
 - Тайлан гаргах цаг хугацааны болон бусад хязгаарлалт, бусад мэдээлэл
2. Үндэслэл:
 - Тооцоололд тавигдах нийтлэг үндэслэл болон өмнөх үеийн тооцооллоос өөрчлөгдсөн болон нэмэгдсэн зүйлийн талаарх мэдээлэл.
3. Ашиглагдсан мэдээлэл:
 - Даатгалын нөөц санг тооцоолоход ашиглагдсан компанийн түүхэн мэдээлэл, мэдээллийн эх үүсвэр, хэрхэн баталгаажуулсан болон ямар хугацааны мэдээлэл ашиглагдсан талаарх тайлбарыг тусгах.
4. Аргачлалууд:
 - Даатгалын нөөц санг тооцоолох үндсэн аргачлалуудаас сонгосон аргачлал, уг аргачлалыг сонгох шалтгаан, үндэслэлийн хамт тусгах. Аргачлалуудыг хавсарч ашиглах тохиолдолд мөн үндэслэлээ тайлбарлах.
5. Дүн шинжилгээ, хэлэлцүүлэг:
 - Бүх ашиглагдсан тооцоолол, мэдээллийн тохируулга болон бусад зүйл дээр ашиглагдсан таамаглал, тохиргоо, өөрчлөлтүүдийн тайлбарыг дэлгэрэнгүй тусгах. Жишээ нь, инфляцийн нөлөөг тооцоололдоо оруулж байгаа тохиолдолд ашиглагдах инфляцийн мэдээллийг эх үүсвэрийн хамт дурдаж, хэрхэн тооцсоноо харуулах.
6. Хавсралт, бусад файлуудтай холбогдох дугаарлалт
 - Актуарч тайландаа тооцоололд ашиглагдсан түүхэн мэдээлэл болон бусад холбогдох файлуудаа хавсаргах бөгөөд эдгээрийг ойлгомжтой хэлбэрээр тайланд тусгасан байх.

“Даатгалын нөөц сан, албан журмын даатгалын сан болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам”-ын 2 дугаар хавсралт

МАЯГТ СЗХ04148. Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн хөрөнгийн байршлын тайлан

Даатгагчийн нэр.....

20...оны ... сарын ...-ны өдөр
(*төгрөгөөр*)

	Үзүүлэлт	Мөрийн дугаар	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	Хөрөнгө оруулалт	Дүн	Эзлэх хувь
A	Б	В	1	2	3	4
1	Бэлэн мөнгө	1				
2	Банкны харилцах (=мөр(3+4+5))	2				
2.1банк (дансны дугаар, валют)	3				
2.2банк (дансны дугаар, валют)	4				
2.3банк (дансны дугаар, валют)	5				
3	Банкны хугацаагүй хадгаламж (=мөр(7+8))	6				
3.1банк (дансны дугаар, валют)	7				
3.2банк (дансны дугаар, валют)	8				
4	Банкны хугацаатай хадгаламж (=мөр(10+11))	9				
4.1банк (дансны дугаар, валют)	10				
4.2банк (дансны дугаар, валют)	11				
5	Банкны хадгаламжийн сертификат (мөр12=мөр(13+14+15))	12				
5.1банк (дансны дугаар, валют)	13				
5.2банк (дансны дугаар, валют)	14				
5.3банк (дансны дугаар, валют)	15				
6	Даатгалын хураамжийн авлага	16				
7	НИЙТ ДҮН (=мөр(1+2+6+9+12+16))	17				100%

ТАЙЛАН ГАРГАСАН:
(албан тушаал) (гарын үсэг) (овог нэр)

тамга тэмдэг

ТАЙЛАН ГАРГАСАН ХУГАЦАА: 20...оны...сарын... өдөр

“Даатгалын нөөц сан, албан журмын даатгалын сан болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам”-ын 3 дугаар хавсралт

МАЯГТ СЗХ04149. Урт хугацааны даатгалын компанийн (.....)* нөөц сангийн тооцооллын тайлан

Даатгалын хураамжийн хүүгийн түвшин

Даатгагчийн нэр.....

20...оны ... сарын ...-ны өдөр
(төгрөгөөр)

Даатгалын хэлбэр	Даатгалын бүтээгдэхүүн	Даатгуулагчийн тоо	Ирээдүйн нөхөн төлбөрийн өнөөгийн үнэ цэнэ	Ирээдүйн даатгалын хураамжийн өнөөгийн үнэ цэнэ	Нөөц сан
1. Хугацаат амьдралын даатгал	1.1. ...				
	1.2. ...				
	ГЭХ МЭТ				
Дүн					
2. Насан туршийн даатгал	2.1. ...				
	2.2. ...				
	ГЭХ МЭТ				
Дүн					
...					
ГЭХ МЭТ					
Нийт дүн					

*- Хувь оролцоотой гэрээний, Хувь оролцоогүй гэрээний, Хөрөнгө оруулалттай гэрээний нөөц сан тус бүрээр гаргана.

ТАНИЛЦСАН:

“.....” ХХК-ийн

гүйцэтгэх захирал

тамга тэмдэг

(гарын үсэг)

(овог нэр)

ТООЦООЛОЛТ ХИЙСЭН

Эрх бүхий актуарч

(гарын үсэг)

(овог нэр)

Насжилтын хүснэгтийг хавсаргана.

“Даатгалын нөөц сан, албан журмын даатгалын сан болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам”-ын 4 дүгээр хавсралт

МАЯГТ СЗХ04150. Урт хугацааны даатгалын компанийн (.....) * нөөц сангийн бүрдүүлэлтийн дэлгэрэнгүй тайлан

Даатгалын хураамжийн хүүгийн түвшин

Даатгагчийн нэр

20...оны ... сарын ...-ны өдөр
(*төгрөгөөр*)

Даатгалын хэлбэр	Даатгалын бүтээгдэхүүн	Нөөцийн сангийн эхний үлдэгдэл	Нөхөн төлбөр		Давхар даатгагчаар төлүүлсэн нөхөн төлбөр	Даатгалын цэвэр хураамжаас нэмэгдсэн	Хөрөнгө оруулалтын орлогоос нэмэгдсэн	Нөөц сангийн эцсийн үлдэгдэл /9=3-4+5+6+7+8/
			Даатгуулагчид олгосон нөхөн төлбөр	Гэрээ цуцлалтын хураамжийн буцаалт				
1	2	3	4	5	6	7	8	9
1. Хугацаат амьдралын даатгал	1.1. ...							
	1.2. ...							
Дүн								
2. Насан туршийн даатгал	2.1. ...							
	2.2. ...							
Дүн								
ГЭХ МЭГ								
Нийт дүн								

* - Хувь оролцоогой гэрээний, Хувь оролцоогүй гэрээний, Хөрөнгө оруулалттай гэрээний нөөц сан тус бүрээр гаргана.

ТАНИЛЦСАН

“.....” ХХК-ийн

гүйцэтгэх захирал

_____ (гарын үсэг)

_____ (овог нэр)

тамга тэмдэг

ТООЦООЛЛОЛТ ХИЙСЭН

Эрх бүхий актуарч

_____ (гарын үсэг)

_____ (овог нэр)

“Даатгалын нөөц сан, албан журмын даатгалын сан болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам”-ын 5 дугаар хавсралт

**МАЯГТ СЗХ04151. Алдагдлаас хамгаалах сангийн хөрөнгийн
 байршлын тайлан**

Даатгагчийн нэр.....

20...оны ... сарын ...-ны өдөр
(төгрөгөөр)

№	Зүйл	Хөрөнгийн хэмжээ	Хувь
1	Заавал байршуулах нөөц (Алдагдлаас хамгаалах сангийн 1/3)		
1.1	“..... банк”		
1.2	“..... банк”		
2	Хөрөнгө оруулалт хийж болох мөнгөн хөрөнгө (Алдагдлаас хамгаалах сангийн 2/3)		
2.1	Банкны хадгаламж: 100 хүртэл хувь		
2.1.1	“..... банк”		
2.1.2	“..... банк”		
2.2	Банкны харилцах дансанд байршуулах: 100 хүртэл хувь		
2.2.1	“..... банк”		
2.2.2	“..... банк”		
2.3	Засгийн газрын өрийн бичиг: 100 хүртэл хувь;		
2.4	Төв банкны үнэт цаас: 60 хүртэл хувь;		
2.5	Орон нутгийн засаг захиргааны бонд: 20 хүртэл хувь;		
2.6	Үл хөдлөх хөрөнгөөр барьцаалсан үнэт цаас 20 хүртэл хувь;		
2.7	Банкны хадгаламжийн сертификат: 10 хүртэл хувь;		
2.8	Компанийн бонд: 10 хүртэл хувь;		
2.8.1	“.....” ХК, ХХК		
2.8.2	“.....” ХК, ХХК		
2.9	Санхүүгийн болон үйл ажиллагааны лизинг: 5 хүртэл хувь		
2.10	Үл хөдлөх хөрөнгө барьцаалсан арилжааны богино хугацаат (нэг жил хүртэл) зээл 5 хүртэл хувь		
2.11	Үл хөдлөх хөрөнгө: 5 хүртэл хувь (Үндсэн үйл ажиллагаа явуулдаг ажлын байрнаас бусад)		
3	НИЙТ ДҮН		

ТАЙЛАН ГАРГАСАН:
 (албан тушаал) (гарын үсэг) (овог нэр)

тамга тэмдэг

ТАЙЛАН ГАРГАСАН ХУГАЦАА: 20...оны...сарын... өдөр

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 01 дүгээр сарын
09-ний өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан
“Даатгалын багц дүрэм”-ийн дөрөвдүгээр хавсралт

**ДААТГАЛЫН НӨӨЦ САНД БОЛОН АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН САНД
ТӨВЛӨРҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, ТҮҮНИЙГ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАД
БАЙРШУУЛАХАД ТАВИГДАХ НӨХЦӨЛ, ШААРДЛАГА**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэ журмын зорилго нь даатгагч даатгалын нөөц санг болон албан журмын даатгалын санг хөрөнгө оруулалтад байршуулахад тавигдах нөхцөл, шаардлага, түүнд хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2 Ердийн даатгагч даатгалын нөөц санг Учирч болзошгүй хохирлын нөөц сан, Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан, Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан“, Тусгай нөөц сан тус бүрийн санхүүгийн байдлын тайлангийн харгалзах дүнгүүдийн нийлбэрээс даатгалын нөөц сан тус бүр дэх давхар даатгагчид ногдох хэсгийг хассан дүнгээр тодорхойлно.

/Энэ заалтад СЗХ-ны 2021 оны 64 дүгээр тогтоолоор нэмэлт оруулсан./

1.3 Урт хугацааны даатгагч даатгалын нөөц санг хувь оролцоотой гэрээний нөөц сан, хувь оролцоогүй гэрээний нөөц сан, хөрөнгө оруулалттай холбоотой гэрээний нөөц сан тус бүрийн санхүүгийн байдлын тайлангийн харгалзах дүнгүүдийн нийлбэрээс нөөц сан тус бүр дэх давхар даатгагчид ногдох хэсгийг хассан дүнгээр тодорхойлно.

**ХОЁР. ДААТГАЛЫН НӨӨЦ САНГ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАД БАЙРШУУЛАХАД
ТАВИГДАХ НӨХЦӨЛ, ШААРДЛАГА**

2.1 Даатгагч нь төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх) эсвэл хувьцаа эзэмшигч/хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан даатгалын нөөц санг хөрөнгө оруулалтад байршуулах төлөвлөгөөтэй байх бөгөөд уг төлөвлөгөө нь дараах шаардлагыг хангасан байна:

2.1.1 Даатгагч даатгалын нөөц санг хөрөнгө оруулалтад байршуулахдаа дараах хөрөнгийн ангилал, хөрөнгө оруулах дээд хувьд нийцүүлсэн байна. Хөрөнгийн ангилал тус бүрийг Даатгалын багц дүрмийн 2 дугаар хавсралт “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын 2.4-т заасны дагуу ойлгоно:

Хөрөнгийн ангилал	Хөрөнгө оруулах дээд хувь
Баганын дүн	1
2.1.1.а Банкны хадгаламж /Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2-д заасан шаардлагыг хангасан банканд байршуулсан/ <i>/Энэ заалтад СЗХ-ны 2021 оны 64 дүгээр тогтоолоор нэмэлт оруулсан./</i>	100%
2.1.1.б Банкны хадгаламжийн сертификат /Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2-д заасан шаардлагыг хангасан банканд байршуулсан/ <i>/Энэ заалтад СЗХ-ны 2021 оны 64 дүгээр тогтоолоор нэмэлт оруулсан./</i>	80%
2.1.1.в Засгийн газрын өрийн хэрэгсэл	100%
2.1.1.г Төв банкны үнэт цаас	60%
2.1.1.д Санхүүгийн түрээс	10%
2.1.1.е Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	60%
2.1.1.ж Хөрөнгө оруулалтын сан	20%
2.1.1.з Аймаг нийслэлийн гаргасан өрийн хэрэгсэл	60%
2.1.1.и Компанийн өрийн хэрэгсэл /Үнэт цаасны зах зээлд арилжаалагддаг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.9-т заасан/ <i>/Энэ заалтад СЗХ-ны 2021 оны 64 дүгээр тогтоолоор нэмэлт оруулсан./</i>	30% <i>/Энэ заалтад СЗХ-ны 2021 оны 64 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан./</i>

2.1.1.к МХБ-ийн хувьцаат компанийн хувьцаа	I ангилал	20% <i>Энэ заалтад СЗХ-ны 2021 оны 64 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан.</i>
	II ангилал	5%
2.1.1.л Тухайн даатгалын компанийн холбогдох этгээдэд үл хамаарах банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулах мөнгөн хөрөнгө /Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийг хангасан банк бус санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгө/ <i>Энэ заалтад СЗХ-ны 2021 оны 64 дүгээр тогтоолоор нэмэлт оруулсан.</i>		20%
2.1.1.м Хуримтлал барьцаалсан зээл /Зөвхөн урт хугацааны даатгагчид хамаарна/		30%

Тайлбар: Хөрөнгө оруулах дээд хэмжээг тооцохдоо даатгалын нөөц сангийн дүнг харгалзах хөрөнгө байршуулах дээд хувиар үржүүлж тодорхойлно.

2.1.2 Даатгагч даатгалын нөөц сангаас энэ журмын 2.1.1-д заасны дагуу хөрөнгө оруулалтад байршуулахаас гадна банкны харилцах, хадгаламж /Үүнд: Хугацаагүй хадгаламж болон 3 сараас доош хугацаатай хадгаламж орно./, бэлэн мөнгө хэлбэрээр байршуулж болох бөгөөд бэлэн мөнгөнд даатгалын нөөц сангийн 2 хүртэл хувиар байршуулна.

2.1.3 Дараах эрсдэлүүдийг тооцоолж, хэрхэн удирдах бодлого, стратегийг тусгасан байна:

2.1.3.а Үнэт цаас гаргагч, зээлдэгч, зуучлагч, даатгуулагч, давхар даатгагч болон баталгаа гаргагч зэрэг гуравдагч тал буюу харилцагчид төлбөрийн чадваргүй болох, гэрээний хариуцлагаа биелүүлэх боломжгүй болсны улмаас даатгагчид учирч болох эрсдэл буюу “Зээлийн эрсдэл”;

2.1.3.б Зах зээлийн үнэ ба түвшинд өөрчлөлт орсноос үүдэн санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ болон ирээдүйн мөнгөн гүйлгээ хэлбэлзэх эрсдэл буюу “Ханш ба үнийн эрсдэл”. Үүнд хүүгийн түвшний эрсдэл, валютын ханшийн эрсдэл болон бусад үнийн эрсдэл хамаарна.

2.1.3.в Даатгалын бүтээгдэхүүний загвар ба үнэ тогтоолтын эрсдэл болон андеррайтинг ба хариуцлагын эрсдэл буюу “Даатгалын эрсдэл”. Даатгалын бүтээгдэхүүний загвар ба үнэ тогтоолтын эрсдэл нь даатгалын үнэ тогтооход таамаглаж байсан хүлээлтээс даатгалын өртөг зардал, хариуцлага хэтрэх тохиолдол зэрэг даатгалын үйл ажиллагааны улмаас даатгагч санхүүгийн хохирол үүсэхэд бий болдог. Андеррайтинг ба хариуцлагын эрсдэл нь даатгагчийн эрсдэлийг сонгох, хүлээж авах, бууруулах, авч үлдэх, шилжүүлэх болон даатгалын бүтээгдэхүүний удирдлагатай холбоотойгоор даатгагчид санхүүгийн хохирол учрах эрсдэл юм.

2.1.3.г Бизнесийн үйл ажиллагааны зохион байгуулалт болон байгууллагын чиг үүргээс шалтгаалан бий болох эрсдэл буюу “Үйл ажиллагааны эрсдэл”. Үүнд дотоод хяналтын үйл ажиллагааны дутагдал, технологийн уналт, хувь хүн, ажилтнуудын алдаа болон үндэсний хэмжээний гамшиг сүйрэл хамаарна.

2.1.3.д Даатгагч Даатгалын тухай хуулийн 2.1-д заасан даатгалын тухай хууль тогтоомжийг мөрдөөгүйн улмаас үүдэн гарах эрсдэл буюу “Хууль, зохицуулалтын хүрээний эрсдэл”.

2.1.3.е Даатгагчийн бизнес төлөвлөгөө, стратеги төлөвлөгөө, шийдвэр гаргалт, нөөцийн хуваарилалтыг тохиромжтой байдлаар хэрэгжүүлээгүй болон бизнесийн орчинд гарсан өөрчлөлтөд дасан зохицох боломжгүй болсон тохиолдолд үүсэх эрсдэл буюу “Стратегийн эрсдэл”.

2.1.3.ж Компанийн нэгдэлд багтах компаниуд төлбөрийн чадваргүй болох, даатгагчтай хийгдсэн гүйлгээнүүд нь төлөгдөх боломжгүй болсноос үүдэн гарах эрсдэл буюу “Холбоотой талуудын эрсдэл”.

2.1.4 Даатгалын нөөц санг хөрөнгө оруулалтад байршуулах төлөвлөгөөг үнэлэх, хянах, тайлагнах зохицуулалтыг тусгасан байна.

2.1.5 Даатгалын нөөц санг хөрөнгө оруулалтад байршуулахад Даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан хязгаарлалтыг харгалзахаас гадна дараах этгээдээс бусад этгээдэд хөрөнгө оруулалт байршуулж болно.

2.1.5.а даатгалын тухай хуулийн 4.1.12-т заасан холбогдох этгээд;

2.1.5.б барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэлгээ нь зээлийн үндсэн өр болон хүүгийн төлбөрийг барагдуулахад хүрэлцэхгүй байгаа иргэн, хуулийн этгээд;

2.1.5.в холбогдох этгээдтэй хэрэг, маргаан үүссэний улмаас эрх бүхий байгууллагаар хянагдаж, шалгагдаж байгаа этгээд;

2.1.5.д даатгагч өөрөө холбогдох этгээд гэж үзсэн бусад этгээд.

2.2 Даатгагч нь энэ журмын 2.1-д заасан шаардлагыг хангасан даатгалын нөөц санг хөрөнгө оруулалтад байршуулах төлөвлөгөөгөө жил бүрийн 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Хороонд ирүүлнэ.

2.3 Даатгагч нь Хороонд ирүүлсэн даатгалын нөөц санг хөрөнгө оруулалтад байршуулах төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулах бөгөөд уг төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд энэ тухай хүсэлтээ Хороонд бичгээр мэдэгдэж, шинэчилсэн төлөвлөгөөг энэ журмын 2.1-д заасан эрх бүхий этгээд баталснаас хойш ажлын 5 хоногийн дотор Хороонд ирүүлнэ.

2.4 Энэ журмын 2.1-д заасны дагуу даатгалын нөөц санг хөрөнгө оруулалтад байршуулах төлөвлөгөөг баталсан этгээд нь даатгалын холбогдох хууль, журмын биелэлт болон уг төлөвлөгөөний гүйцэтгэл, эрсдэлийн удирдлага, мэдээлэл, дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл болон хөндлөнгийн аудитын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллана.

ГУРАВ. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

3.1 Даатгагч даатгалын нөөц санг хөрөнгө оруулалтад байршуулсан тайланг энэ журмын 1 дүгээр хавсралтаар улирал бүр гаргаж, санхүүгийн тайлангийн хамт Хороонд ирүүлнэ.

3.2 Даатгагчаас ирүүлсэн даатгалын нөөц санг хөрөнгө оруулалтад байршуулах төлөвлөгөө, энэ журмын 3.1-д заасан тайлантай холбогдуулан шаардлагатай гэж үзвэл Хороо нэмэлт мэдээлэл, материал шаардаж болно.

3.3 Хороо энэ журмын хэрэгжилтэд хяналт тавих бөгөөд зөрчсөн этгээдэд Даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

“Даатгалын нөөц санд болон албан журмын даатгалын санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ, түүнийг хөрөнгө оруулалтад байршуулахад тавигдах нөхцөл, шаардлага”-ын 1 дүгээр хавсралт

МАЯГТСЗХ04152. Даатгалын нөөц санг хөрөнгө оруулалтад байршуулсан тайлан

Даатгагчийн нэр..... 20...оны ... сарын ...-ны өдөр

А	Б	В	1	2	3	4
1	Бэлэн мөнгө	1				
2	Банкны харилцах (=мөр(3+4+5))	2				
2.1банк (дансны дугаар, валют)	3				
3	Банкны хугацаагүй хадгаламж (=мөр(7+8))	4				
3.1банк (дансны дугаар, валют)	5				
4	Банкны хугацаатай хадгаламж (=мөр(10+11))	6				
4.1банк (дансны дугаар, валют)	7				
5	Банкны хадгаламжийн сертификат (мөр12=мөр(13+14+15))	8				
5.1банк (дансны дугаар, валют)	9				
6	Үнэт цаас (мөр16=мөр(17+18+...25))	10				
6.1	Засгийн газрын өрийн хэрэгсэл	11				
6.2	Төв банкны үнэт цаас	12				
6.3	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	13				
6.4	Аймаг, нийслэлийн засаг даргын гаргасан өрийн хэрэгсэл	14				
6.5	Компанийн бонд	15				
6.6	ХБ-ийн I ангиллын хувьцаа	16				
6.7	ХБ-ийн II ангиллын хувьцаа	17				
6.8	Хөрөнгө оруулалтын сан	18				
7	Санхүүгийн түрээс	19				
8	Банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулах мөнгөн хөрөнгө	20				
8.1 ББСБ	21				
9	Хуримтлал барьцаалсан зээл	22				
10	НИЙТ ДҮН (=мөр(1+2+4+6+8+10+19+20+22))	23				100%

(төгрөгөөр)

ТАЙЛАН ГАРГАСАН:
 (албан тушаал) (гарын үсэг) (овог нэр)

тамга тэмдэг

ТАЙЛАН ГАРГАСАН ХУГАЦАА: 20...оны...сарын... өдөр

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 01 дүгээр сарын
09-ний өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан
“Даатгалын багц дүрэм”-ийн тавдугаар хавсралт

ДААТГАЛЫН ХЭМЖЭЭ, ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ТООЦОХ АРГАЧЛАЛ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэ журмаар даатгалын хураамжийн хэмжээг тогтоох аргачлал, түүнд хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

ХОЁР. ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ

2.1. Даатгалын хураамжийн хэмжээ нь даатгалын нөхөн төлбөр олгоход зориулагдсан даатгалын цэвэр хураамж болон даатгагч даатгалын үйл ажиллагаа явуулахтай холбогдсон зардал, ашгийг багтаасан даатгалын нэмэлт хураамжаас тус тус бүрдэнэ.

2.2. Даатгалын хураамжийн хэмжээг тогтоохдоо дараах зарчмыг баримтална:

2.2.1. Даатгалын хураамжийн хэмжээ нь даатгагч, даатгуулагч нарын эрх ашигт нийцсэн байх;

2.2.2. Даатгалын хураамжийн хэмжээ тогтвортой байх;

2.2.3. Даатгалын нөхөн төлбөр төлөхөд хүрэлцээтэй, үйл ажиллагааны зардлыг бүрэн нөхөхүйц байх;

2.2.4. Даатгалын бүтээгдэхүүний гэрээний нөхцөлтэй уялдсан байх.

2.3. Даатгалын хураамжийн хэмжээ нь даатгалын бүтээгдэхүүний эрсдэл тус бүрээр тооцох бөгөөд хувиар илэрхийлж болно.

2.4. Даатгалын хураамжийг нэг удаа бүрэн төлөх, эсвэл даатгалын гэрээний хугацаанд үе шаттайгаар хэсэгчлэн төлөх хэлбэртэй байж болно.

2.5. Даатгалын хураамжийн хэмжээг эрсдэлд өртөж болзошгүй объект, өртөх магадлал, нутаг дэвсгэрийн нэгж тус бүрээр ялгавартай тооцож болно.

ГУРАВ. ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ТООЦОХ

3.1. Даатгалын хураамжийн хэмжээг даатгалын эрсдэл тус бүрийн учирч болох хохирлын судалгаа, мэдээнд үндэслэн оновчтой актуарын арга, аргачлалуудыг сонгон ашиглан тооцно.

3.2. Урт хугацааны даатгагч нь даатгалын хураамжийн хэмжээг “Хүн амын насжилтын хүснэгт”, “Хүн амын нас баралтын түвшин”, “Даатгалын хураамжийн хүүгийн түвшин” болон бусад эрсдэлийн түвшинд зэрэгт үндэслэн тооцно.

3.2.1. Хүн амын насжилтын хүснэгт (цаашид “насжилтын хүснэгт” гэх) болон хүн амын нас баралтын түвшин (цаашид “нас баралтын түвшин” гэх)-г Үндэсний статистикийн хорооноос гаргасан хүн амын насны ангилал, наслалт, нас баралтын олон жилийн статистик судалгаа болон Эрүүл мэндийн хөгжлийн хүрээлэнгээс гаргасан хүн амын өвчлөл, нас баралтын шалтгааныг судалсан мэдээллийг үндэслэн тогтооно. Хэрэв манай орны насжилтын хүснэгтийг гаргахад мэдээлэл дутагдах тохиолдолд бүс нутгийн ижил төстэй бусад орны насжилтын хүснэгтийг өөрийн

нөхцөлд тохируулан ашиглаж болно.

3.2.2. Насжилтын хүснэгтийг тухайн даатгалын гэрээ байгуулсны дараах 5 жилийн хугацаанд өөрчлөхгүй тогтвортой мөрдөх зарчмыг баримталж боловсруулна.

3.2.3. Даатгагч насжилтын хүснэгтийг зайлшгүй өөрчлөлт оруулах тохиолдолд үндэслэл, тооцооллыг Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-нд ирүүлж хянуулна.

3.2.4. Даатгагч нь Хорооноос үндэслэлтэй гэж үзсэн буюу шинэчлэгдсэн насжилтын хүснэгтийг ашиглан хураамжийн болон нөөц сангийн тооцооллыг хийнэ

3.2.5. Шинэчлэгдсэн насжилтын хүснэгт нь зөвхөн шинээр байгуулах гэрээний хувьд үйлчилж эхлэх бөгөөд өмнө нь байгуулсан даатгалын гэрээний хураамжид өөрчлөлт орохгүй.

3.2.6. Даатгалын цэвэр хураамжийн тооцоонд нас баралтын түвшний өөрчлөлтийг хүйсээр болон бусад төрлийн ангиллаар судлан гаргаж тусгана.

3.2.7. Даатгалын хураамжийн хүүгийн түвшинг даатгагчаас даатгуулагчид санал болгож байгаа даатгалын хураамжийн баталгаат хүү болон даатгагчийн мөнгөн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийж олох хүүгийн тооцоолол дээр үндэслэн тогтооно.

3.2.8. Даатгагч даатгалын бүтээгдэхүүн тус бүрийн нөөц сан тооцох актуар тооцооллын аргачлал, томъёоллыг Хороонд ирүүлсэн байна.

3.3. Даатгалын хураамжийн хэмжээг “Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох болон актуарын стандарт, үнэлгээ болон актуарчийн хяналт шалгалт хийх, тайлан гаргах журам”-д заасан эрх бүхий актуарч тооцож, баталгаажуулсан байна.

3.4. Даатгалын хураамжийн хэмжээг тооцсон даатгалын эрсдэл тус бүрийн учирч болох хохирлын судалгаа, мэдээ, болон сонгосон актуарын арга, аргачлалуудыг Хороонд ирүүлж хянуулна.

3.5. Энэхүү журмын 3.4-д заасан судалгаа, мэдээнд ашигласан мэдээллийн бодит үнэнийг холбогдох байгууллагаас авсан баримтаар баталгаажуулсан байна.

3.6. Хороо даатгагчаас ирүүлсэн даатгалын хураамжийн тооцоолол, даатгалын хураамжийн хэмжээг тооцоход үндэслэсэн мэдээ, судалгаа болон сонгосон арга, аргачлал нь шаардлага хангахгүй гэж үзвэл энэ тухай тайлбар, үндэслэлийг албан бичгээр даатгагчид хүргүүлнэ.

3.7. Хороо шаардлагатай гэж үзвэл нэмэлт мэдээлэл, судалгаа тооцоолол, үндэслэлийг даатгагчаас шаардаж, тодруулга тайлбар авч болно.

3.8. Даатгагч даатгалын хураамжийн хэмжээг өөрчлөх тохиолдолд Хороонд албан бичгээр мэдэгдэж, энэхүү журмын дагуу шинэчлэн тооцоолсон даатгалын хураамжийн үндэслэл тооцоолол, тайлбарыг ирүүлнэ.

ДӨРӨВ. ХЯНАЛТ ТАВИХ

4.1. Даатгагч нь Хорооноос зөвшөөрөл авсан даатгалын бүтээгдэхүүний хураамжийн хэмжээг үндэслэн үйл ажиллагаагаа явуулна.

4.2. Тухайн даатгалын бүтээгдэхүүний даатгалын хураамжийн хэмжээг өөрчлөх тухай даатгагчийн хүсэлтийг Хорооноос хянаж шийдвэр гаргал өмнөх даатгалын хураамжийн хэмжээ хүчинтэй байна.

4.3. Хороо нь энэ журмын биелэлтэд хяналт тавих бөгөөд зөрчсөн этгээдэд Даатгалын тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 01 дүгээр сарын
09-ний өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан
“Даатгалын багц дүрэм”-ийн зургаадугаар хавсралт

ДААТГАЛЫН ҮНЭЛГЭЭ ХИЙХ АРГАЧЛАЛ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү аргачлалаар даатгагч, даатгуулагч даатгалын үнэлгээг тогтоохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.

ХОЁР. ДААТГАЛЫН ҮНЭЛГЭЭ ХИЙХ АРГАЧЛАЛ

2.1. Эд хөрөнгийн даатгалын үнэлгээг тухайн эд хөрөнгийн өөрийн өртөг, зах зээлийн үнийг баримтлан даатгагч, даатгуулагч нар харилцан тохирч тогтооно.

2.2. Иргэд өөрийн амь нас, эрүүл мэндээ мөнгөн дүнгээр үнэлж, даатгагчтай харилцан тохиролцсоны үндсэн дээр даатгалын үнэлгээг тогтооно.

2.3. Иргэд, байгууллага бусдын өмнө хүлээх өөрийн хариуцлагаа үнэлж даатгагчтай харилцан тохиролцож даатгуулна. Даатгагч нь иргэд, байгууллагатай хийх хариуцлагын даатгалын гэрээнд хариуцлагын даатгалын үнэлгээний дээд, доод хязгаарыг зааж болно.

2.4. Санхүүгийн даатгалын үнэлгээг үндсэн үйл ажиллагааны зардалд үндэслэн даатгагч, даатгуулагч нар даатгалын үнэлгээг харилцан тохиролцож тогтооно. Зардалд оруулж тооцохгүй зүйлийг даатгалын гэрээнд тодорхой зааж болно.

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 01 дүгээр сарын
09-ний өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан
“Даатгалын багц дүрэм”-ийн долоодугаар хавсралт

ДААТГАГЧ, ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН АУДИТОРТ ТАВИГДАХ НӨХЦӨЛ, ШААРДЛАГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн (*цаашид хамтад нь “даатгалын байгууллага” гэх*) үйл ажиллагаанд аудит хийх аудиторт тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлох, аудитын үйл ажиллагаа эрхлэх эрх олгох, түүнд хяналт тавихтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

ХОЁР. ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГАД АУДИТ ХИЙХ АУДИТОРТ ТАВИГДАХ НӨХЦӨЛ, ШААРДЛАГА

2.1. Даатгалын байгууллага нь Даатгалын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д тус тус заасны дагуу дараах шаардлагыг хангасан аудиторыг томилно:

2.1.1. санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл болон Хорооноос олгосон даатгалын байгууллагад аудит хийх эрхтэй аудитын байгууллагад ажилладаг байх;

2.1.2. даатгалын байгууллагад аудит хийх үйл ажиллагааны төрөлжсөн сургалтад хамрагдаж, үнэмлэх авсан байх

2.1.3. Хорооноос шаардлагатай гэж үзсэн бусад шаардлагыг хангасан байх.

2.2. Аудитор бие даан даатгалын байгууллагад аудитын үйл ажиллагаа явуулахгүй бөгөөд даатгалын байгууллагад аудит хийсэн аудитын тайлан, дүгнэлтийн хариуцлагыг Хорооноос даатгалын байгууллагад аудит хийх эрх олгосон аудитын байгууллага хүлээнэ.

2.3. Хороо энэ журмын 2.2-д заасан даатгалын байгууллагад аудит хийх эрхийг Аудитын тухай хуульд зааснаас гадна дараах шаардлага хангасан аудитын байгууллагад олгоно:

2.3.1. санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нь хүчинтэй байх;

2.3.2. даатгалын байгууллагад аудит хийх үйл ажиллагааны төрөлжсөн сургалтад хамрагдаж, үнэмлэх авсан хоёроос доошгүй аудитортой байх;

2.3.3. Хорооноос шаардлагатай гэж үзсэн бусад шаардлагыг хангасан байх.

2.4. Дээрх шаардлагыг хангасан аудитын байгууллага дор дурдсан баримт бичгийг Хороонд ирүүлнэ:

2.4.1. эрх олгохыг хүссэн өргөдлийг энэ журмын нэгдүгээр хавсралтын дагуу;

2.4.2. аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн болон аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээг нотариатаар баталгаажуулсан хуулбарын хамт;

2.4.3. аудитын байгууллага, түүний удирдлагын талаарх тодорхойлолтыг энэ журмын хоёрдугаар хавсралтаар, аудитын байгууллагын аудиторуудын тодорхойлолтыг энэ журмын гуравдугаар хавсралтаар тус тус;

2.4.4. компанийн танилцуулга болон дүрэм;

2.4.5. даатгалын байгууллагад аудит хийх дотоод стандарт;

2.4.6. Хорооноос олгосон аудиторуудын үнэмлэхний хуулбар;

2.4.7. даатгалын байгууллагад аудит хийх эрх бүхий аудиторууд нь ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй, эсхүл зөрчилгүйд тооцогдох хугацаа нь дууссан эсэх талаар Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтээс гаргасан тодорхойлолт.

2.5. Даатгалын байгууллагад аудит хийх эрх олгох эсэхийг аудитын байгууллагаас эрх хүссэн өргөдөл, холбогдох баримт бичгийг бүрэн гүйцэд бүрдүүлж Хороонд ирүүлсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хянаж шийдвэрлэнэ.

2.6. Хороо аудитын байгууллагыг шаардлага хангасан гэж үзвэл даатгалын байгууллагад аудит хийх эрхийн гэрчилгээ олгоно. Гэрчилгээний загварыг энэхүү журмын дөрөвдүгээр хавсралтын дагуу хэвлэнэ.

2.7. Хороо эрх олгохоос татгалзсан тохиолдолд энэ тухай үндэслэл бүхий мэдэгдлийг хүсэлт гаргасан аудитын байгууллагад албан бичгээр хүргүүлнэ.

2.8. Эрх авсан аудитын байгууллага дараах зөрчил дутагдал гаргасан тохиолдолд нэг жилийн хугацаагаар эрхийг түдгэлзүүлнэ.

2.8.1. даатгалын байгууллагын санхүүгийн тайланг санаатай буруу баталгаажуулсан, аудитын үйл ажиллагааны зарчмыг зөрчсөн, үйлчлүүлэгчийн болон нийтийн ашиг сонирхолд хохирол учруулсан, түүнтэй адилтгах нөхцөл байдал үүсгэсэн;

2.8.2. Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй;

2.8.3. даатгалын зах зээлийн нэр хүнд, тогтвортой байдалд хохирол учруулахуйц ёс зүйн болон үйл ажиллагааны ноцтой алдаа гаргасан;

2.8.4 Хороо ашиг сонирхлын зөрчил бүхий нөхцөл байдал бий болсон гэж үзсэн;

2.8.5 энэ журмын 4.1, 4.2-т заасныг хангаагүй;

2.8.6. холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн нь тогтоогдсон.

2.9. Хороо аудитын байгууллага гаргасан зөрчлөө түдгэлзүүлсэн хугацаанд бүрэн арилгасан нөхцөлд даатгалын байгууллагад аудит хийх эрхийг сэргээнэ.

2.10. Хороо дор дурдсан үндэслэлээр аудитын байгууллагын даатгалын байгууллагад аудит хийх эрхийг хүчингүй болгоно:

2.10.1. аудитын байгууллага өөрөө хүсэлт гаргасан;

2.10.2. эрхийг түдгэлзүүлсэн хугацаанд Хорооноос тавьсан шаардлага, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй;

2.10.3. даатгалын байгууллагад аудит хийх эрхийг хуурамч баримт бичиг бүрдүүлэн авсан нь тогтоогдсон;

2.10.4. холбогдох хууль тогтоомж болон энэ журмыг удаа дараа болон ноцтой зөрчсөн;

2.10.5. даатгалын байгууллагын нууцтай холбогдсон мэдээллийг бусдад задруулсан, дамжуулсан нь тогтоогдсон;

2.10.6. хуурамч дүгнэлт гаргасан;

2.10.7. Хорооноос даатгалын байгууллагад аудит хийх үнэмлэх авсан аудиторын тоо энэ журамд заасан хэмжээнд хүрэхээ больсон;

2.10.8. санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.

2.11. Хорооны тусгай зөвшөөрөл, эрхийн нэгдсэн бүртгэл хариуцсан ажилтан даатгалын байгууллагад аудит хийх эрх олгосон болон эрхийг нь түдгэлзүүлсэн, сэргээсэн хүчингүй болгосон талаарх дэлгэрэнгүй бүртгэлийг хөтөлж Ажлын албанд тухай бүр мэдэгдэж байна.

2.12. Даатгалын байгууллагад аудит хийх эрхийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон тухай Хорооны шийдвэрийг Ажлын алба ажлын 10 өдөрт багтаан даатгалын байгууллагуудад албан бичгээр, олон нийтэд цахим сүлжээгээр мэдээлнэ.

2.13. Журмын 2.10.2-2.10.6-д заасан үндэслэлээр эрх нь хүчингүй болсон аудитын компани 2 жилийн хугацаанд Хороонд дахин хандах эрхгүй.

ГУРАВ. ХОРОО АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫГ ТОМИЛОХ

3.1. Даатгалын байгууллага нь даатгалын байгууллагад аудит хийх эрхгүй аудитын байгууллагаар аудит хийлгэсэн тохиолдолд Хороо даатгалын байгууллагын оролцоогүйгээр эрх бүхий аудитын байгууллагыг сонгон томилж, санхүүгийн тайланд дахин аудит хийлгэнэ.

3.2. Хороо аудитын байгууллагыг энэхүү журмын 3.1-т заасны дагуу томилохдоо тухайн тайлангийн жилд хамгийн олон даатгалын байгууллагад аудит хийсэн аудитын байгууллагыг эхний ээлжид сонгох зарчмыг баримтална.

3.3. Тухайн сонгогдсон аудитын байгууллага уг ажлыг гүйцэтгэх боломжгүй тухайгаа мэдэгдсэн тохиолдолд Хороо дараагийн эрх бүхий аудитын байгууллагыг сонгоно.

3.4. Хорооноос даатгалын байгууллагад аудит хийх эрх аваагүй аудитын байгууллагаас аливаа даатгалын байгууллагын үйл ажиллагааны талаар гаргасан тайлан, дүгнэлт нь хүчин төгөлдөр бус байна.

3.5. Энэ журмын 3.1-т заасны дагуу Хорооноос сонгож томилсон аудитын байгууллагын ажил, үйлчилгээтэй холбогдох бүхий л зардлыг тухайн даатгалын байгууллага бүрэн хариуцна.

ДӨРӨВ. ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГАД АУДИТ ХИЙХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

4.1. Аудитын байгууллага нь даатгалын байгууллагад аудит хийхдээ дараах нөхцөлүүдийг бий болгосон байна.

4.1.1. даатгалын аудитын ажлын багт үнэмлэхтэй аудиторууд ажилласан байх;

4.1.2. даатгалын байгууллагад аудит хийхэд аливаа ашиг сонирхлын зөрчилгүй байх.

4.2. Аудитор нь Аудитын тухай хуулийн 9, Даатгалын тухай хуулийн 36, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 22 дугаар зүйлд зааснаас гадна даатгалын байгууллагын санхүүгийн тайлангийн дор дурдсан зүйлсийг шалган дүгнэлт өгсөн байна.

4.2.1. даатгалын байгууллагын санхүүгийн тайлангийн нэмэлт мэдээллийн үнэн зөвийг холбогдох орлого, зарлага, мөнгөн гүйлгээ, бусад шаардлагатай санхүүгийн баримт, бичгийг үндэслэн шалгаж баталгаажуулах;

4.2.2. Даатгалын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, заавар, журмын дагуу нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэн хөтлөх, олон улсын стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхэд нь даатгагчид туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх, стандартын хэрэгжилтийг шалгах;

4.2.3. давхар даатгалын үйл ажиллагаа нь Хорооноос баталсан холбогдох шаардлагын дагуу явагдаж буй эсэх, даатгагчийн давхар даатгалын гэрээ, тайлан, давхар даатгалын нөхөн олговрын төлөгдсөн байдал, хураамж, давхар даатгагч компанийн санхүүгийн болон төлбөрийн чадварын байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх;

4.2.4. мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж буй эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх;

4.2.5. даатгалын нөхөн олговор олголт болон баримт бүрдүүлэлтийн байдалд үнэлгээ өгөх;

4.2.6. даатгагчийн төлбөрийн чадвар, хөрөнгө оруулалт, санхүүгийн чадавхид үнэлэлт дүгнэлт өгөх;

4.2.7. даатгагчийн эд хөрөнгийн чанар, хөрөнгө оруулалт, хөрөнгө санхүүгийн эх үүсвэр, компанийн хувьцаа, ногдол ашиг хуваарилалт, зээл олголтын байдлыг хянаж, үнэлэлт дүгнэлт өгөх;

4.2.8. даатгалын нөөц сангийн бүрдүүлэлт, хуваарилалт нь зохих журмын дагуу явагдаж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх;

4.2.9. даатгалын нөөц сангуудын байршлыг шалгаж баталгаажуулах;

4.2.10. даатгагчийн гэрээгээр хүлээсэн эрх үүрэг, хариуцлага болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааг тогтоож, дүгнэлт гаргах.

4.3. Аудитор нь Даатгалын байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Даатгалын тухай хуулийн 36, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан нөхцөл байдал бий болсон тухай болон хязгаарлалттай дүгнэлт өгсөн эсхүл дүгнэлт өгөхөөс татгалзсан тохиолдолд Хороонд нэн даруй мэдэгдэнэ.

ТАВ. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

5.1. Хороо энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах бөгөөд зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

“Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчийн аудиторт тавигдах нөхцөл, шаардлага”-ын 1 дүгээр хавсралт

Маягт СЗХ04007

**ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГАД АУДИТ ХИЙХ АУДИТЫН
БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ХҮССЭН ӨРГӨДӨЛ**

Огноо:

Хаана: Санхүүгийн зохицуулах хороо,
 Засгийн газрын IV байр Бага тойруу-6,
 Улаанбаатар-46,
 Монгол Улс

Хэнээс:

(өргөдөл гаргагч хуулийн этгээдийн хаяг, байршил, утас, факс, электрон шуудангийн хаягийг бүрэн дэс дарааллаар нь бичнэ үү.

/хуулийн этгээдийн нэр/

Аудитын байгууллагын үндсэн үйл ажиллагаа болон нэмэлт үйл ажиллагааны талаар бичих:

- 1/
- 2/
- 3/
- 4/
- 5/

/байгууллагын үйл ажиллагааны төрөл/

Аудитын байгууллагын үүсгэн байгуулагч иргэд, хуулийн этгээд нь дараах мэдээллийг үнэн зөв бичнэ үү. Үүнд:

№	Овог, нэр /Хуулийн этгээдийн нэр/	Регистрийн дугаар	Иргэний үнэмлэхийн дугаар /Хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар/	Хаяг	Хувь нийлүүлэх хөрөнгийн хэмжээ (мянган төгрөгөөр)

Аудитын байгууллагын үүсгэн байгуулагч /үүсгэн байгуулагчид/ нь өөрийн хууль ёсны өмчлөлд байгаа мөнгөн хөрөнгөөр хувь нийлүүлсэн болно.

Аудитын байгууллагын захирал, аудиторууд нь Аудитын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан дараах хүмүүс ажиллаж байгаа болно. Үүнд:

№	Овог, нэр	Одоогийн эрхэлж байгаа ажил	Регистрийн дугаар	Иргэний үнэмлэхийн дугаар	Аудитын байгууллагад эрхлэх албан тушаал

Даатгалын байгууллагад аудит хийх эрх хүссэн Хороонд бүрдүүлж хүргүүлсэн баримт бичгүүдийг Компанийн тухай хууль, Аудитын тухай хууль, Даатгалын тухай хууль, Даатгалын багц дүрэм, холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн үнэн зөв бүрдүүлсэн болно. Бүрдүүлсэн баримт бичигт ямарваа худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Өргөдөл, баримт бичгүүдийг хүлээн авч, хянан шийдвэрлэж даатгалын байгууллагад аудит хийх эрх олгоно уу.

Даатгалын байгууллагад аудит хийх эрх авсан тохиолдолд Аудитын тухай хууль, Даатгалын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажиллах болно.

ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ:

/тамга/

/...../

/хуулийн этгээдийн нэр/

/...../

/албан тушаал/

/...../

/гарын үсэг/

/...../

/овог, нэр/

“Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчийн аудиторт тавигдах
нөхцөл, шаардлага”-ын 2 дугаар хавсралт

Маягт СЗХ04008

АУДИТЫН БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТОДОРХОЙЛОЛТ

А. Аудитын байгууллагад ямар албан тушаал эрхэлдэг талаар тэмдэглэнэ:

- Байгууллагын дарга
- Орлогч дарга
- Бусад

/Албан тушаалыг тодорхой бичих/

Б. Аудитын байгууллага, түүний удирдлага нь дараах мэдээллийг үнэн зөв бичиж ирүүлнэ үү. Үүнд:


1. Аудитын байгууллага:

- Оноосон нэр:
- Байгуулагдсан он, сар, өдөр:
- Үйл ажиллагаа эрхлэх хугацаа:
- Байршил буюу хаяг:
- Улсын бүртгэлийн дугаар:
- Регистрийн дугаар:
- Аудитын байгууллагын удирдлагын овог, нэр:
- Аудитын байгууллагын үйл ажиллагаатай холбогдсон танилцуулга:

/эрхэлж ирсэн үйл ажиллагаа тус бүрийг эрхэлсэн хугацаагаар нь, хараат буюу охин компанитай эсхүл нэгжтэй эсэх, тэдгээрийн болон тухайн байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн ур дун, байршил, өмчлөлийн байдал, бусад байгууллагад хувь нийлүүлсэн хөрөнгө зэргийг хамруулан бичнэ/.

2. Удирдлага:

- Овог, нэр:
- Эрхлэж буй албан тушаал:
- Иргэний харьяалал:
- Иргэний үнэмлэхний дугаар:
- Регистрийн дугаар:
- Нийгмийн гарал:
- Гэр бүлийн байдал:
- Гэрийн хаяг:
- Утасны дугаар:



■ Боловсролын талаар /Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ/

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он	Диплом, гэрчилгээний дугаар

• Ажлын туршлагын талаар:

№	Хаана ажиллаж байсан	Албан тушаал	Ажилд орсон он, сар, өдөр	Ажлаас гарсан он, сар, өдөр	Шалтгаан

“_____ - Аудит” ХХК нь аудитын байгууллагын хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа явуулах бөгөөд холбогдох материалуудыг үнэн зөв, хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэн танайд хүргүүлсэн болохоо нотлохын зэрэгцээ үүнээс үүсэх аливаа эрсдлийг хууль тогтоомжийн дагуу бүрэн хариуцахаа илэрхийлж байна.

/...../

/хуулийн этгээдийн нэр/

/...../

/албан тушаал/

/...../

/гарын үсэг/

/...../

/овог, нэр

“Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчийн
аудитор тавигдах нөхцөл, шаардлага”-ын 3 дугаар хавсралт

Маягт СЗХ04009

АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН АУДИТОРЫН ТОДОРХОЙЛОЛТ

А. Аудитын байгууллагад ямар албан тушаал эрхэлдэг талаар тэмдэглэнэ:

- Үндсэн аудитор
- Бусад

/Тодорхой бичих/

Б. Аудитын байгууллагын аудитор нь дараах мэдээллийг үнэн зөв бичиж ирүүлнэ үү.

Үүнд:

1. Аудитор:

- Овог, нэр:
- Иргэний харьяалал:
- Иргэний үнэмлэхний дугаар:
- Регистрийн дугаар:
- Нийгмийн гарал:
- Гэр бүлийн байдал:
- Гэрийн хаяг:
- Утасны дугаар:
- Төрөл төрөгсөд болон ам бүлийн тоо:

Зураг

Товч намтар түүх:

(Урьд өмнө эрхэлж байсан ажил, төрлийн байдал, аль нэг хуулийн этгээдийг төлөөлдөг эсэх, түүний үйл ажиллагаа, байршил, даатгалын байгууллагатай харьцаж байсан түүх, даатгалын байгууллагын хувь нийлүүлэгч эсэх, Аудитын болон бусад холбогдох хууль тогтоомж зөрчиж хариуцлага хүлээж байсан эсэх, одоо хууль хяналтын байгууллагад хэрэг үүсгэгдсэн эсэх зэрэг тухайн үйл ажиллагааг эрхлэхэд аливаа сонирхлын зөрчил бүхий нөхцөл байдал байгаа эсэхийг тодорхой гаргацтай, үнэн зөв бичнэ):

• Боловсролын талаар (Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ):

№	Хаана ямар сургууль	Элссэн он сар	Төгссөн он сар	Эзэмшсэн мэргэжил	Диплом № Гэрчилгээ №

• Ажил, мэргэшлийн туршлагын талаар:

№	Хаана ажиллаж байсан (албан газар тухайн үеийн нэрээр бичнэ)	Албан тушаалд ажилласан	Ажилд орсон он, сар, өдөр	Ажлаас гарсан он, сар, өдөр	Шалтгаан

ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ

/...../

/гарын усэг/

/...../

/овог, нэр/

Он, сар, өдөр

“Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчийн
аудитор тавигдах нөхцөл, шаардлага”-ын 4 дүгээр
хавсралт



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГАД АУДИТ
ХИЙХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар . . .

. . . оны . . . сарын . . . өдөр

Улаанбаатар хот

Монгол улсын Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, болон бусад хууль тогтоомж, Хорооноос баталсан “Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчийн аудитор тавигдах нөхцөл, шаардлага”-д заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны ___ оны ___ сарын ___ өдрийн ___ дугаар тогтоолыг үндэслэн _____ хот, _____ аймаг _____ дахь, _____ регистрийн дугаартай, _____ улсын бүртгэлийн гэрчилгээний дугаартай _____-д энэхүү эрхийн гэрчилгээг олгов.

ДАРГА

(Гарын үсэг)

(Нэр)

Тамга

(Энэхүү гэрчилгээ нь хавсралтын хамт хүчинтэй болно.)



**МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО**

**_____ ТООТ
ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ
ХАВСРАЛТ**

/Даатгалын байгууллагад аудит хийх аудитын
байгууллагын гэмдэглэлүүд/

Тэмдэг

(Энэхүү хавсралт нь эрхийн гэрчилгээний хамт хүчинтэй болно.)

НЭГ. Хуулийн этгээдийн оноосон нэр:

ХОЁР. Хуулийн этгээдийн хаяг, хаягийн өөрчлөлтийн тэмдэглэл:

Д/д	Хаяг	Утас, факс, и-мэйл хаяг	Тэмдэглэл хийсэн огноо, тэмдэг

ГУРАВ. Аудиторын тэмдэглэл:

Д/д	Аудиторын овог, нэр	Эрх олгосон огноо, тушаалын дугаар	Эрхийн үнэмлэхний дугаар	Эрх сунгасан огноо, тушаалын дугаар	Шилжилт хөдөлгөөн

ДӨРӨВ. Бусад өөрчлөлтийн тэмдэглэл:

№	Өөрчлөлтийн тэмдэглэл	Өөрчлөлтийг бүртгэсэн огноо, тэмдэг, гарын үсэг

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 01 дүгээр сарын
09-ний өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан
“Даатгалын багц дүрэм”-ийн наймдугаар хавсралт

АКТУАРЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЭРХ ОЛГОХ, АКТУАРЫН СТАНДАРТ, ҮНЭЛГЭЭ БОЛОН АКТУАРЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ, ТАЙЛАН ГАРГАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь даатгалын актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх (цаашид “актуарчийн эрх” гэх) олгох актуарын стандарт, үнэлгээ болон актуарчийн хяналт шалгалт хийх, тайлан гаргахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журмыг хэрэгжүүлэхэд Даатгалын тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ноос баталсан даатгалын багц дүрмийг мөрдлөг болгоно.

ХОЁР. АКТУАРЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЭРХ ОЛГОХ

2.1. Хороо нь Даатгалын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх заалтын дагуу дараах шаардлагыг хангасан Монгол Улсын болон гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн (цаашид “этгээд” гэх)-ийг сонгон шалгаруулж актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг олгоно:

2.1.1. Эдийн засагч, статистикч, санхүүч, математикч, эдийн засгийн математик загварчлал зэрэг мэргэжлээр их дээд сургуулийн хөтөлбөрийг хангасан;

2.1.2. Олон улсын актуарчдын холбоо, түүний жинхэнэ гишүүн болон мэргэжлийн сургалтын байгууллагаас гадаад болон Монгол Улсад зохион байгуулсан актуарчийн мэргэжлийн дараах шалгалттай дүйцэхүйц шалгалтыг өгч тэнцсэн; Үүнд:

2.1.2.1 Урт хугацааны даатгалын актуарч (Санхүүгийн математик /Financial mathematics/, Магадлалын онол болон математикийн статистик /Probability and mathematical statistics/, Санамсаргүй тохиолдлын актуар математик /Contingencies/);

2.1.2.2 Ердийн даатгалын актуарч (Санхүүгийн математик /Financial mathematics/, Магадлалын болон математикийн статистик /Probability and mathematical statistics/, Статистик загварчлал /Statistical models/);

2.2. Монгол Улсын даатгалын тухай хууль тогтоомжийн талаар Хорооноос зохион байгуулсан шалгалтад тэнцсэн олон улсын актуарчийн эрхтэй этгээдэд актуарчийн эрхийг олгоно.

2.3. Актуарчийн эрхийг нь энэхүү журмын 2.12.4-т заасан үндэслэлээр хүчингүй болгосноос хойш 6 сар, бусад үндэслэлээр хүчингүй болгосноос хойш 1 жилийн хугацаа өнгөрсний дараагаар актуарчийн эрх шинээр авахыг хүсч өргөдлөө ирүүлсэн этгээдэд Хороо актуарчийн эрхийг сэргээж болно.

2.4. Хороо актуарчийн эрхийг Даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан даатгалын ангиллын дагуу олгоно:

2.4.1. Урт хугацааны даатгалын;

2.4.2. Ердийн даатгалын;

2.5. Актуарчийн эрх авахыг хүссэн этгээд өргөдлөө Хороонд энэхүү журмын 2.1-д заасан

шаардлагыг хангасныг нотлох баримт бичгийн нотариатаар баталгаажсан хуулбарын хамт ирүүлнэ.

2.6. Хороо актуарчийн эрх авахыг хүссэн этгээдийн талаарх мэдээллийг холбогдох байгууллагаас тодруулж, лавлагаа авч болно.

2.7. Шаардлагатай гэж үзвэл Хороо нэмэлт материалыг шаардаж болно.

2.8. Актуарчийн эрх авсан этгээд тухайн компанид тасралтгүй 9 сар актуарчаар ажиллаагүй тохиолдолд санхүүгийн жилийн эцэст даатгалын нөөц санг тооцоолох, хяналт шалгалт хийх, актуарын хяналт шалгалтын тайлан (цаашид “актуарын тайлан” гэх)-г боловсруулах бол энэ тухай Хороонд бичгээр мэдэгдэж, зөвшөөрөл авна.

2.9. Актуарчийн эрх авсан этгээд 2 жилд нэгээс доошгүй удаа актуарчийн мэргэжлийн түвшин дээшлүүлэх сургалтад хамрагдана.

2.10 Хороо актуарчийн эрхийг дараах үндэслэлээр түдгэлзүүлнэ:

2.10.1. Актуарчийн эрх авахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлсэн болох нь тогтоогдсон;

2.10.2. Актуарч нь актуарын хяналт шалгалтын тайлан, дүгнэлт боловсруулахдаа зах зээлийн болон даатгагчийн үнэн зөв мэдээлэл, тоо баримтад тулгуурлаагүй, тоон мэдээллийн өгөгдөхүүнийг өөрчилж мэргэжлийн ёс зүйн алдаа гаргасан болох нь тогтоогдсон;

2.10.3. Актуарын тайлан нь хангалттай мэдээлэл, дүгнэлт агуулаагүй, актуарын хяналт шалгалтын тайлангийн стандарт загварт нийцээгүй, ашигласан мэдээллийн эх үүсвэрийг үнэн зөв заагаагүй, актуарын стандарт, үнэлгээг бүрэн хэрэгжүүлээгүй, актуарчийн үүргээ хангалтгүй биелүүлж гаргасан алдаа, зөрчлийг арилгах талаар Хорооны улсын байцаагчаас тухайн актуарчид өгсөн үүрэг, даалгавар, албан шаардлагыг 2-3 удаа биелүүлээгүй;

2.10.4. Даатгалын компанийн актуарч нь эрх авснаас хойш мэргэжлээрээ тасралтгүй 9 сарын хугацаанд ажиллаагүй.

2.11. Актуарчийн эрхийг дараах хугацаагаар түдгэлзүүлнэ:

2.11.1. Хорооноос тогтоосон 6 сар хүртэл хугацаагаар;

2.11.2. Хорооноос өгсөн хугацаатай үүрэг, даалгавар, албан шаардлагыг биелүүлэх хүртэл.

2.12. Хороо актуарчийн эрхийг дараах үндэслэлээр хүчингүй болгоно:

2.12.1. Актуарчийн эрх авсан этгээд өөрөө хүсэлтээ гаргасан;

2.12.2. Актуарчийн үйл ажиллагаагаа хангалтгүй хэрэгжүүлж, Даатгалын тухай хууль, даатгалын багц дүрэм болон холбогдох бусад хууль тогтоомжийг ноцтойгоор зөрчсөн;

2.12.3. Актуарчийн эрхийг түдгэлзүүлсэн хугацаанд алдаа, зөрчлийг арилгах талаар Хорооноос өгсөн үүрэг, даалгавар, албан шаардлагыг биелүүлээгүй;

2.12.4. Энэхүү журмын 2.10.4-т заасан үндэслэлээр актуарчийн эрхийг нь түдгэлзүүлснээс хойш 6 сарын хугацаанд уг этгээд дотоодын аль нэг даатгалын компани эсхүл төрийн байгууллагад актуарчийн албан тушаалд томилогдоогүй.

2.13. Актуарчийн эрхийг нь түдгэлзүүлсэн хугацаанд Хорооноос өгсөн үүрэг, даалгавар, албан шаардлагыг бүрэн биелүүлж, гаргасан алдаа, зөрчлийг арилгасан талаар бичгээр тайлагнаж, актуарчийн эрхээ сэргээлгэх хүсэлтээ ирүүлсэн этгээдийн актуарчийн эрхийг Хороо хянаж, сэргээж болно.

ГУРАВ. АКТУАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТАНДАРТ, ҮНЭЛГЭЭ

3.1. Актуарчийн эрх авсан этгээд нь актуарын дараах стандарт, үнэлгээг гүйцэтгэнэ:

3.1.1. Хороонд бүртгүүлсэн даатгалын бүтээгдэхүүн бүрээр зах зээлийн үнэлгээний өөрчлөлт, эрсдэлийн тооцоололд үндэслэн даатгалын хураамжийн хувь хэмжээг шинэчлэн тооцоолох;

3.1.2. Зах зээлд нийлүүлэх даатгалын шинэ бүтээгдэхүүний хураамжийн хувь хэмжээг тооцоолох;

3.1.3. Даатгагчийн даатгалын нөөц сан, төлбөрийн чадварын үзүүлэлтийг улирал бүрээр тооцож, үр дүнг зохих хугацаанд нь Хороонд ирүүлж хянуулах;

3.1.4. Санхүүгийн жилд тухай бүр даатгалын гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу үүссэн даатгагчийн хариуцлага, нөхөн төлбөрийн хэмжээг тооцоолох;

3.1.5. Даатгалын нөөц сан байгуулахтай холбоотой даатгагчийн хүлээсэн үүрэгт тухайн оны явцад гарсан өөрчлөлт болон холбогдох санхүүгийн үзүүлэлтийг тооцоолж үнэлэлт дүгнэлт өгөх;

3.1.6. Төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтэд үндэслэн даатгагчийн санхүүгийн тогтвортой байдалд дүгнэлт өгөх, учирч болзошгүй эрсдэлийг үнэлэх, эдийн засаг, математикийн тооцоо, судалгаанд суурилсан дүн шинжилгээ хийх;

3.1.7. Даатгалын эрсдэлийг үнэлж, даатгагчийн өөрийн хөрөнгийн хүрэлцээг тооцоолсны үндсэн дээр давхар даатгагчид даатгуулах шаардлагатай эрсдэлийн хэмжээг тооцох;

3.1.8. Даатгагчийн хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлоход шаардлагатай актуарчийн үнэлгээ, зөвлөмж боловсруулах; (урт хугацаат даатгалын актуарчид хамаарна)

3.1.9. Даатгалын хураамж, нөөц сангийн тооцоололтой холбоотой статистик мэдээлэл бүрдүүлэх, мэдээллийн баазын баяжуулалтын үнэн зөв байдалд хяналт тавих;

ДӨРӨВ. АКТУАРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ, ТАЙЛАН ГАРГАХ

4.1. Даатгагч нь энэхүү журмын 3.1.4-3.1.9-д заасан актуарын стандарт, үнэлгээ болон хяналт шалгалтыг Даатгалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.4 дэх заалтын дагуу томилсон актуарчаар гүйцэтгүүлнэ.

4.2. Энэхүү журмын 4.1-д заасан актуарч нь актуарын хяналт шалгалтын тайланг тус журмын хавсралтаар батлагдсан “Актуарын тайлангийн стандарт загвар”-ын дагуу боловсруулна.

4.3. Даатгалын тухай хуулийн дагуу томилогдсон актуарч нь энэхүү журмын 4.1-д заасан актуарын хяналт шалгалтыг даатгагчийн жилийн эцсийн санхүүгийн тайлан гарснаас хойш ажлын 15 өдрийн дотор гүйцэтгэж, үр дүнг компанийн удирдлагад танилцуулах бөгөөд актуарын хяналт шалгалтын тайланг дараа оны 3 дугаар сарын 5-ны өдрийн дотор Хороонд ирүүлнэ.

4.4. Хороо нь актуарчаас ирүүлсэн даатгагчийн актуарын хяналт шалгалтын тайлантай танилцаж, хариу өгөх бөгөөд шаардлагатай тохиолдолд актуарчийн дүгнэлт, тооцооллын талаар тайлбар, тодруулга авна.

ТАВ. БУСАД

5.1. Актуарчийн эрх авсан этгээд актуарчаар томилогдох, чөлөөлөгдөх, шилжин ажиллах болсон тохиолдол бүрт энэ тухай холбогдох эрх бүхий албан тушаалтны гаргасан шийдвэр болон нийгмийн даатгалын дэвтэрт бичилт хийж баталгаажуулсан хуулбарыг ажлын 5 хоногийн дотор Хороонд ирүүлнэ.

5.2. Актуарч нь ажлаасаа чөлөөлөгдөж гадаад болон Монгол Улсад 1 сараас дээш хугацаагаар мэдлэг, мэргэшлээ дээшлүүлэх сургалтанд хамрагдах болсон тохиолдолд энэ тухай Хороонд бичгээр мэдэгдэнэ. Хороо актуарчийн эрхийг сургалтын хугацаанд хүчинтэйд тооцно.

5.3. Актуарчийн эрх авсан этгээд нь актуарын стандарт, үнэлгээ болон хяналт шалгалтыг гүйцэтгэх явцад ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл бий болсон тохиолдолд энэ тухай Хороонд даруй мэдэгдэх үүрэгтэй. Энэ тохиолдолд Хороо тухайн актуарчийн оронд актуарын хяналт шалгалтыг өөрийн томилсон актуарчаар гүйцэтгүүлнэ.

ЗУРГАА. ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

6.1. Хороо энэ журмын хэрэгжилтэд хяналт тавих бөгөөд зөрчил гаргасан этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6.2. Актуарч нь тухайн даатгалын компанид актуарчаар ажиллахгүй болсон тохиолдолд энэ тухайгаа ажлын 5 өдрийн дотор Хороонд мэдэгдэнэ.

“Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох, актуарын стандарт, үнэлгээ болон актуарчийн хяналт шалгалт хийх, тайлан гаргах журам”-ын хавсралт

АКТУАРЫН ТАЙЛАНГИЙН СТАНДАРТ ЗАГВАР

1. Актуарч нь даатгагчийн актуарын хяналт шалгалтын тайланг энэхүү стандарт загварын дагуу боловсруулж, үр дүнг даатгалын компанийн удирдлагад танилцуулах бөгөөд актуарын тайланг Хороонд ирүүлнэ.

2. Актуарын тайлан нь дараах агуулгатай байна.

Дугаар	Сэдвийн нэр
1	Тайлангийн зорилго, хамрах хүрээ
2	Тайлангийн агуулга
2.1	<ul style="list-style-type: none"> Хамралтын хугацаа
2.2	<ul style="list-style-type: none"> Актуарын тооцоололд нөлөөлсөн хууль эрх зүйн шаардлага
2.3	<ul style="list-style-type: none"> Актуарын тооцоололд нөлөөлсөн компанийн дотоод хүчин зүйл
3	Таамаглалууд
3.1	<ul style="list-style-type: none"> Актуарын таамаглал
3.2	<ul style="list-style-type: none"> Санхүүгийн таамаглал <ul style="list-style-type: none"> Инфляци Хүүгийн өөрчлөлт Хөрөнгийн өөрчлөлт Хүн ам, тээврийн хэрэгслийн болон нөлөө үзүүлэх бусад хүчин зүйлийн тоон үзүүлэлтийн таамаглал
4	Аргачлал болон үр дүн
4.1	<ul style="list-style-type: none"> Тооцооллын зорилго
4.2	<ul style="list-style-type: none"> Тооцоололд ашигласан аргачлал
4.3	<ul style="list-style-type: none"> Өмнөх тайлангаар өгсөн актуарчийн зөвлөмжийн биелэлт
4.4	<ul style="list-style-type: none"> Нөөц сангийн тооцооллын үр дүн
4.5	<ul style="list-style-type: none"> Үр дүн болон тооцооллын загварын баталгаажуулалт, тест
5	Эрсдэлийн үнэлгээ
5.1	<ul style="list-style-type: none"> Төсөөллийн мэдрэмтгий байдлын тест (Sensitivity test to assumptions)
5.2	<ul style="list-style-type: none"> Зах зээлийн өөрчлөлтийн мэдрэмтгий байдлын тест (Sensitivity test to market changes)
5.3	<ul style="list-style-type: none"> Холбогдох бусад эрсдэлүүд
5.4	<ul style="list-style-type: none"> Эрсдэлийн удирдлага
6	Холбогдох зүйлс
6.1	<ul style="list-style-type: none"> Зөвлөмж
6.2	<ul style="list-style-type: none"> Дүгнэлт
7	Тайлангийн найдвартай болон хязгаарлагдмал байдал
7.1	<ul style="list-style-type: none"> Найдвартай байдал
7.2	<ul style="list-style-type: none"> Хязгаарлагдмал байдал
8	Хавсралтууд

(Урт хугацааны даатгагчийн хувьд компанийн өөрийн үйл ажиллагаа болон даатгалын бүтээгдэхүүний онцлогт тохирсон холбогдох мэдээллийг тайлагнана.)

3. Актуарын тайлангийн загварт орсон нэр томъёог дараах утгаар ойлгоно. Үүнд:
 - 3.1. Зорилго гэдэгт тухайн актуарын тайлангийн зорилгыг тодорхойлж, тайлангийн захиалагч, хяналт шалгалтыг гүйцэтгэж тайланг боловсруулсан актуарчдын нэр, туршлага зэрэг мэдээллийг оруулна;
 - 3.2. Хамрах хүрээ гэдэгт актуарын тайланг хэрэглэх хүрээг дурдана;
 - 3.3. Актуарын тооцоололд нөлөөлсөн хууль эрх зүйн шаардлага гэдэгт актуарын тайлангийн стандарт загвар болон даатгалын багц дүрэмд харшлаагүй заавар, зөвлөмжийг дагаж мөрдсөн тухай бичнэ;
 - 3.4. Тооцоололд ашигласан тоон мэдээлэл гэдэгт актуарчийн авч ашигласан өгөгдөхүүнд итгэж болох байдал, хамрах хугацаа, мэдээллийн бодит эх сурвалж, мэдээллийн харьцуулалтын тухай бичнэ;
 - 3.5. Таамаглал гэдэгт актуарын тооцооллын таамаглал болон тооцооллын үр дүнд нөлөөлөх, загварчлалд ашигласан хүчин зүйлсийн үнэлгээ, өөрчлөлтийн талаарх таамаглалыг ойлгоно;
 - 3.6. Тооцоололд ашигласан аргачлал гэдэгт гинжин шатны арга (Chain ladder method), Борнхуэттер-Фергюсоны арга (Bornhuetter-Ferguson method) болон актуар тооцооллын бусад аддитив аргаас тодорхой 2-3 аргыг сонгож тооцоолол хийхийн хамт өмнөх онуудын өгөгдлөөр нөхөн төлбөрийн хөгжлийн гурвалжинг байгуулж дүн шинжилгээ хийхийг ойлгоно;
 - 3.7. Нөөц сангийн тооцооллын үр дүн гэдэгт даатгалын нөөц сангийн улирлын тооцоолол болон актуарын хяналт шалгалтаар даатгагчийн даатгалын нөөц сангийн тооцоололд өгөх үнэлэлт бие даасан хараат бус шинжтэй байхыг ойлгоно;
 - 3.8. Үр дүн болон тооцооллын загварын баталгаажуулалт, тест гэдэгт өмнө нь ашигласан тооцооллын загварын болон бодит нөхцөл байдлын тоон үзүүлэлтийг харьцуулсан шинжилгээ хийх, шаардлагатай тохиолдолд загвар болон аргачлал дээр тохируулга оруулахыг ойлгоно;
 - 3.9. Эрсдэлийн үнэлгээ гэдэгт тухайн тооцооллын загвар, актуарын төсөөлөл нь зах зээлийн өөрчлөлтөд мэдрэмтгий байгаа байдал, холбогдох бусад эрсдэл, тэдгээрийг удирдах арга замын талаарх зөвлөмжийг ойлгоно;
 - 3.10. Зөвлөмж гэдэгт хяналт шалгалтаар цаашид анхаарах, авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээнүүдийн талаар актуарчаас өгсөн зөвлөмжийг ойлгоно;
 - 3.11. Тайлангийн найдвартай болон хязгаарлалтын байдал гэдэгт актуарчийн хийсэн дүгнэлт, тооцооллын үр дүнд итгэж болох найдвартай байдлыг баталгаажуулах бөгөөд тухайн тооцооны үр дүнг гаргахад дутагдалтай, хязгаарлагдмал мэдээлэл, нөхцөл болон бусад зүйлсийг тусгахыг ойлгоно;
 - 3.12. Хавсралтууд гэдэгт санхүүгийн тайланд тусгагдаагүй үр дүн, актуарын тооцоололд ашигласан түүхчилсэн мэдээлэл, эдийн засаг, санхүүгийн зах зээлийн талаарх мэдээллийн эх сурвалж, холбогдох бусад мэдээ, мэдээллийг тайлбар, дугаарлалт бүхий цахим файлаар Хороонд ирүүлэхийг ойлгоно.

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 01 дүгээр сарын
09-ний өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан
“Даатгалын багц дүрэм”-ийн есдүгээр хавсралт

ГАДААД УЛСАД САЛБАР, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРАА НЭЭХ, ТҮҮГЭЭР ДАМЖУУЛАН ДААТГАЛЫН БОЛОН ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ДААТГАГЧ, ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИД ТАВИГДАХ НӨХЦӨЛ, ШААРДЛАГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэ журмын зорилго нь гадаад улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа явуулах даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах нөхцөл, шаардлага, түүнтэй холбоотойгоор үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Гадаад улсад байгуулагдах даатгалын салбар, төлөөлөгчийн газар нь Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооны (цаашид Хороо гэх) хяналт, зөвшөөрлөөр үйл ажиллагаагаа явуулна.

ХОЁР. ГАДААД УЛСАД САЛБАР, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР НЭЭХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1. Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогч нь гадаад улсын нутаг дэвсгэрт салбар нээн ажиллуулахад дараах шаардлага тавигдана. Үүнд:

2.1.1. Үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэрийн хязгаарлалтаа тодорхойлсон, хаяг, байршил нь тодорхой, байнгын ажлын байртай байх;

2.1.2. Салбарын удирдлага, ажилтан, гэрээт ажилтнаар ажиллах этгээд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтад заасан “нийтийн албан тушаалтан” биш байх;

2.1.3. Үйл ажиллагааг хэвийн явуулах тоног төхөөрөмж, програм хангамжтай байх;

2.1.4. Нэгж нь компанийн ерөнхий захиргаа болон бусад нэгжүүдтэйгээ мэдээллийн нэгдсэн нэг сүлжээнд холбогдож, мэдээлэл, тайлагнал дамжуулдаг байх;

2.1.5. Тухайн нутаг дэвсгэрт салбар нээн ажиллуулахтай холбогдсон зах зээлийн судалгаатай байх;

2.1.6. Эрхлэх даатгалын ангилал, төрөл, хэлбэрийг тодорхой тусгасан, салбарын дотоод хяналт болон бусад үйл ажиллагааг зохицуулах журамтай байх.

2.2. Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогч нь гадаад улсын нутаг дэвсгэрт төлөөлөгчийн газар нээн ажиллуулахад энэ журмын 2.1.1, 2.1.3, 2.1.4-д заасан шаардлагыг хангасан байх бөгөөд даатгагч, даатгалын зуучлагчийн төлөөлөгчийн газар нь даатгалын гэрээ байгуулах, даатгалын гэрээг зуучлан борлуулах, даатгалын хохирол үнэлэгчийн төлөөлөгчийн газар нь даатгалын зүйлийн бодит хохирлын хэмжээг тогтоох үйл ажиллагаа эрхлэхгүй.

2.3. Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогч нь гадаад улсад салбар нээх тохиолдолд энэ журмын 2.1-т заасан, төлөөлөгчийн газар нээх тохиолдолд энэ журмын 2.2-т заасан шаардлагыг хангахаас гадна дараах нэмэлт шаардлага тавигдана:

2.3.1. Даатгагч бол Хорооноос баталсан төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг

сүүлийн нэг жилийн хугацаанд хангасан, таваас доошгүй жилийн даатгалын үйл ажиллагааны дадлага, туршлагатай байх ба Хорооноос баталсан “Тохиромжтой этгээдийг тодорхойлох заавар”-ын шаардлагыг хангасан удирдлагатай байх.

2.3.2. Даатгалын мэргэжлийн оролцогч бол гурваас доошгүй жилийн даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааны дадлага, туршлагатай байх ба Хорооноос баталсан “Тохиромжтой этгээдийг тодорхойлох заавар”-ын шаардлагыг хангасан удирдлагатай байх.

2.3.3. Хороо даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны төрөл, журамд заасан эрхлэх даатгалын ангилал, төрөл, хэлбэрээс хамааран шаардлагатай гэж үзсэн нэмэлт нөхцөл, шаардлага тавьж болно.

2.4. Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогч нь гадаад улсад салбар, төлөөлөгчийн газар нээх зөвшөөрөл авахдаа “Даатгалын багц дүрэм”-ийн 1 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 6 дугаар хавсралт “Бөглөх, бүрдүүлэх заавар”-ын дагуу тус журмын 1 дүгээр хавсралт (В) СЗХ04003 маягтын дагуу өргөдлөө гаргаж, 2 дугаар хавсралт (Г)-д дурдсан бүрдүүлэх баримт бичгүүдийг хавсарган Хороонд ирүүлсэн байна:

2.4.1. Энэ журмын 2.3.3-д заасан нэмэлт нөхцөл, шаардлагын дагуу Хороо шаардлагатай гэж үзвэл нэмэлт мэдээлэл шаардаж болно.

2.5. Хороо энэ журмын 2.4-д дурдсан баримт бичгийг хянан үзэж, салбар, төлөөлөгчийн газар байгуулах нь тухайн хуулийн этгээдийн санхүүгийн чадварт сөргөөр нөлөөлөхгүй, үйлчлүүлэгчдэд хохирол учруулахгүй, боловсон хүчин, техник, тоног төхөөрөмж, программ хангамж нь тухайн салбарын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангахаар байна гэж үзвэл зөвшөөрөл хүссэн баримт бичгийг бүрэн гүйцэд бүрдүүлж Хороонд ирүүлсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ.

2.6. Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогч нь салбар, төлөөлөгчийн газрыг татан буулгах, үйл ажиллагааг хязгаарлах, өөрчлөн байгуулах /нэгтгэх, нийлүүлэх, салгах, тусгаарлах, өөрчлөх/ тухай бүрд шийдвэр гаргаж, уг шийдвэрийг гаргасан өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор Хороонд ирүүлж, зөвшөөрөл авсаны үндсэн дээр хэрэгжүүлнэ.

2.7. Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчийн салбар, төлөөлөгчийн газартай холбоотой Хорооны шийдвэр болон зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн баримтыг үндэслэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад салбар, төлөөлөгчийн газрын талаарх тэмдэглэлийг хийж баталгаажуулах бөгөөд даатгалын байгууллагын нэгжийн гэрчилгээг олгоно.

2.8. Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчийн салбар, төлөөлөгчийн газар нээх зөвшөөрлийг дараах үндэслэлээр хүчингүй болгож, тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд ажлын 5 өдрийн дотор энэ тухай тэмдэглэл хийнэ. Үүнд:

2.8.1. Салбар, төлөөлөгчийн газрыг татан буулгах талаар гарсан тухайн даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчийн удирдлагын шийдвэрээр;

2.8.2. Гадаад улсын харьяалах хяналтын байгууллагаас гаргасан шийдвэр;

2.8.3. Хороо нь тухайн даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогч, түүний салбар, төлөөлөгчийн газар санхүүгийн хүндрэлд орсон, холбогдох хууль тогтоомжид нийцээгүй үйл ажиллагаа явуулсан, зөвшөөрөл олгосноос хойш 6 сарын хугацаанд үйл ажиллагаа эрхлээгүй, Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй буюу тухайн салбарын санхүүгийн байдал даатгагчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй гэж үзвэл салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг зогсоох тухай саналаа гадаад улсын харьяалах хяналтын байгууллагад мэдэгдсэний үндсэн дээр олгосон зөвшөөрлөө хүчингүй болгох;

2.8.4. Хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

ГУРАВ. ДААТГАГЧ, ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧООС ГАДААД УЛСАД БАЙГУУЛСАН САЛБАР, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫН ТАЛААР ХОРООНД ТАЙЛАГНАХ

3.1. Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогч нь гадаад улсад салбар, төлөөлөгчийн газар ажиллуулах зөвшөөрлийг авснаас хойш ажлын 10 өдрийн дотор Хороонд салбар, төлөөлөгчийн газрын албан ёсны хаяг, холбоо барих утас, эрх бүхий этгээдийн талаар албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдлийг үндэслэн Хороо даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчийн тухайн салбар, төлөөлөгчийн газрыг нэгдсэн бүртгэлд авч, энэ тухай даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид мэдэгдэнэ.

3.2. Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогч нь салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг компанийн жилийн эцсийн санхүүгийн тайлангийн хамт Хороонд ирүүлнэ.

3.3. Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогч нь салбар, төлөөлөгчийн газрын зөвшөөрөл авахтай холбоотой ирүүлсэн материалд өөрчлөлт орсон тухай бүрд Хороонд мэдэгдэнэ.

ДӨРӨВ. ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

4.1. Хороо гадаад улсад даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхэлдэг Монгол Улсын даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчийн салбар, төлөөлөгчийн газрын бүртгэл хөтөлнө.

4.2. Хороо гадаад улсад байгуулагдсан даатгалын салбар төлөөлөгчийн үйл ажиллагаанд хяналт тавихдаа гадаад улсын даатгалын хяналтын байгууллагатай хамтарч ажиллана.

4.3. Хороо гадаадын хяналтын байгууллагад даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчийн талаар тодорхой мэдээллийг өгч болно.

4.4. Хороо олгосон зөвшөөрөл болон тухайн салбар, төлөөлөгчийн газарт зөвшөөрөл олгохоос татгалзсан шийдвэрээ гадаадын хяналтын байгууллагад албан ёсоор хүргүүлж болно.

4.5. Хороо даатгагчийн төлбөрийн чадварын байдалд байнгын хяналт тавина. Хэрэв төлбөрийн чадвар хангалтгүй, тухайн гадаад улсад явуулж буй бизнесийг удирдаж чадахгүй, хөрөнгийн чадавхи хүрэлцээгүй болсон бол гадаадад тухайн бизнесийн үйл ажиллагаа эрхлэхийг зогсоож болно.

4.6. Хороо гадаад улс дахь даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчийн салбар, төлөөлөгчийн газрын болон төв компанийн тайлан, түүний дотоод хяналтын үйл ажиллагаанд хяналт тавина.

4.7. Хороо даатгалын салбарын санхүүгийн тайлангийн бодитой эсэхэд бие даан шалгалт хийх, эсвэл энэ талаар гадаадын байгууллагатай зөвшилцөх, мөн гадаадын байгууллагад шалгуулах хүсэлтээ тавьж болно.

4.8. Хороо даатгалын салбар, төлөөлөгчид тавигдах шаардлага, авах арга хэмжээ өөрчлөгдсөн бол энэ талаар гадаадын хяналтын байгууллагад мэдээлнэ.

4.9. Хороо хэрэв гадаадын хяналтын байгууллагын хяналт тавих стандарт нь бодитой бус гэж үзвэл гадаадын хяналтын байгууллагатай энэ талаар зөвшилцөнө.

ТАВ. БУСАД

5.1. Хороо энэ журмын хэрэгжилтэд хяналт тавих бөгөөд зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 01 дүгээр сарын
09-ний өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан
“Даатгалын багц дүрэм”-ийн аравдугаар хавсралт

**МОНГОЛ УЛСАД САЛБАР, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРАА НЭЭХ, ТҮҮГЭЭР
ДАМЖУУЛАН ДААТГАЛЫН БОЛОН ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН
ОРОЛЦОГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ГАДААДЫН ДААТГАГЧ,
ГАДААДЫН ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИД
ТАВИГДАХ НӨХЦӨЛ, ШААРДЛАГА**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэ журмын зорилго нь гадаадын даатгалын компани /цаашид “гадаадын даатгагч” гэх/ болон гадаадын даатгалын мэргэжлийн оролцогч компани /цаашид “гадаадын даатгалын мэргэжлийн оролцогч” гэх/ Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа явуулахад тавигдах шаардлага, түүнтэй холбоотой үүсэх харилцааг зохицуулахад оршино.

**ХОЁР. ГАДААДЫН ДААТГАГЧ, ГАДААДЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ САЛБАР,
ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРАА НЭЭХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

2.1. Гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогч нь Хорооноос зөвшөөрсний үндсэн дээр Монгол Улсын нутаг дэвсгэрт салбар, төлөөлөгчийн газраа нээн, түүгээр дамжуулан даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа явуулна.

2.2. Гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогч нь Монгол Улсын нутаг дэвсгэрт салбар, төлөөлөгчийн газраа нээхэд дараах шаардлага тавигдана:

2.2.1. Компанийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5-д заасны дагуу бүртгүүлсэн байх;

2.2.2. Гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчийн хувьд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зэрэглэл тогтоодог байгууллагаас тогтоосон зэрэглэлтэй байх;

2.2.3. Монгол Улсын аль нэг банкны дансанд даатгалын баталгаа хөрөнгө байршуулсан байх ба энэхүү хөрөнгийн доод хэмжээ нь гадаадын даатгагчийн хувьд 1 тэрбум төгрөг, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчийн хувьд 500.0 сая төгрөг байх шаардлагыг хангасан байх;

2.2.4. Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааг зохицуулсан, хууль тогтоомжид нийцсэн журамтай байх;

2.2.5. Өөрийн харьяалагдах болон Монгол улсаас бусад улс оронд даатгалын салбар, төлөөлөгчийн газар байгуулж, уг салбар, төлөөлөгчийн газар тухайн нутаг дэвсгэртээ 2-оос доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх;

2.2.6. Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх хүсэлт гаргагч гадаадын даатгагчийн өөрийн хөрөнгө нь 10 тэрбум төгрөгөөс багагүй, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчийн өөрийн хөрөнгө нь 1 тэрбум төгрөгөөс багагүй байх;

2.2.7. Харьяалагдах орны болон бусад улс орны Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль тогтоомж, түүнтэй холбоотой бусад хууль, журмыг сүүлийн 2 жилийн хугацаанд зөрчөөгүй, уг зөрчлөөс үүдэн нэгжийн зөвшөөрөл хүчингүй болж, төлбөрийн

чадварын болон санхүүгийн хүндрэлд орж байгаагүй;

2.2.8. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд оролцож байгаагүй байх;

2.2.9. Монгол Улсын хууль тогтоомж, Хорооноос баталсан дүрэм, журам, зааврын хүрээнд үйл ажиллагаа явуулах чадвартай байх;

2.2.10. Даатгалын үйл ажиллагааны 3-аас доошгүй жилийн бизнес төлөвлөгөөтэй байх. Гадаадын даатгагчийн хувьд даатгалын зах зээлд нийлүүлэх 1-ээс дээш бүтээгдэхүүнтэй байх;

2.2.11. Салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг хэвийн явуулах ажлын байртай байх;

2.2.12. Гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчийн салбар нь 4-өөс доошгүй, гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчийн төлөөлөгчийн газар нь 2-оос доошгүй орон тооны ажилтантай байх;

2.2.13. Энэ журмын 2.2.12-г заасан ажилтнуудын 50-аас доошгүй хувийг Монгол Улсын иргэдээс бүрдүүлсэн байх;

2.2.14. Даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.10 дахь хэсгийг үндэслэн Хорооноос баталсан зааварт заасан тохиромжтой этгээдийн шаардлагыг хангасан удирдах ажилтантай байх;

2.2.15. Гүйцэтгэх удирдлага нь гадаадын иргэн байх тохиолдолд монгол хэлээр ярьж, бичдэг байх, эсхүл орон тооны орчуулагчтай байх;

2.2.16. Гадаадын даатгагчийн салбар нь ердийн даатгал, урт хугацааны даатгалын алийг эрхлэх, гадаадын даатгалын зуучлагчийн салбар нь давхар даатгал, ердийн даатгал, урт хугацааны даатгалын гэрээний алинд зуучлах талаар чиглэлээ тус тус тодорхойлсон байх;

2.2.17. Хороо гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчийн салбар, төлөөлөгчийн газрын эрхлэх даатгалын ангилал, төрөл, хэлбэрээс хамааран шаардлагатай гэж үзсэн нэмэлт нөхцөл, шаардлага тавьж болно.

2.2.18. Гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчийн салбар нь гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчийн оноосон нэрийн ард “..... даатгалын салбар” гэсэн нэртэйгээр үйл ажиллагаа явуулна.

2.2.19. Гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчийн төлөөлөгчийн газар нь гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчийн оноосон нэрийн ард “.....даатгалын төлөөлөгчийн газар” гэсэн нэртэйгээр үйл ажиллагаа явуулна.

2.3. Гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогч Монгол Улсын нутаг дэвсгэрт салбар, төлөөлөгчийн газар нээх зөвшөөрөл хүсэхдээ дор дурдсан баримт бичгийг монгол, англи хэлээр орчуулан Хороонд ирүүлнэ. Үүнд:

2.3.1. Салбар, төлөөлөгчийн газар нээх зөвшөөрөл хүссэн гадаадын даатгагч, гадаадын мэргэжлийн оролцогчийн хүсэлт;

2.3.2. Гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчийн Төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл түүнтэй адилтгах эрх бүхий удирдлагаас Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газар нээх тухай шийдвэр;

2.3.3. Харьяалах улсын эрх бүхий төрийн байгууллагын Монгол Улсын нутаг дэвсгэрт даатгалын үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрсөн шийдвэр, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг;

2.3.4. Тухайн салбар, төлөөлөгчийн газрыг нээх гэж буй гадаадын даатгагч болон гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчийн хувь нийлүүлсэн хөрөнгө /дүрмийн сан/-ийн хэмжээ,

бүтэц болон үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл бүхий нотлох баримт бичиг;

2.3.5. Гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчийн нээн ажиллуулах гэж буй салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг зохицуулсан журам;

2.3.6. Гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогч Монгол Улсын аль нэг банкны дансанд энэ журмын 2.2.3-т заасан даатгалын баталгаа хөрөнгө байршуулсныг нотлох баримт бичиг;

2.3.7. Өөрийн харьяалагдах улсаас бусад улс оронд даатгалын салбар, төлөөлөгчийн газар байгуулж, үйл ажиллагаагаа 2-оос доошгүй жил тогтвортой явуулсныг нотлох баримт бичиг;

2.3.8. Энэ журмын 2.2.6-д заасан шаардлагыг хангасныг нотлох баримт бичиг;

2.3.9. “Даатгалын багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 7 дугаар хавсралтад дурдсан зөвлөмжийн дагуу боловсруулсан салбарын үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө;

2.3.10. “Даатгалын багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 1 дүгээр хавсралт (Е)-д заасан СЗХ04006 маягтын дагуу гаргасан гүйцэтгэх удирдлага болон бусад боловсон хүчний тодорхойлолт;

2.3.11. Салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаанд ашиглах техник тоног төхөөрөмж, программ хангамжийн жагсаалт, ажлын байрны үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, эсхүл түрээсийн гэрээний хуулбар;

2.3.12. Зөвшөөрөл хүсч буй гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчийн сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлангийн хуулбар;

2.3.13. Гадаадын даатгагчийн хувьд зөвшөөрөл олгохыг хүссэн даатгалын бүтээгдэхүүн тус бүрээр боловсруулсан журам, даатгалын гэрээ, гэрээний баталгааны загвар (даатгалын гэрээ болон гэрээний баталгаанд Иргэний хуулийн 431 дүгээр зүйл болон даатгалын нөхөн төлбөр олгох нөхцөл, түүнийг шийдвэрлэх хугацааг нэмж тусгасан байх);

2.3.14. Гадаадын даатгагчийн хувьд Даатгалын тухай хуулийн 14.2.5, Хорооноос баталсан даатгалын хэмжээ, даатгалын хураамжийн хэмжээг тооцох аргачлалд заасны дагуу тооцоолол хийсэн хураамжийн хувь хэмжээний тооцоолол, танилцуулга;

2.3.15. Гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчийн улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;

2.3.16. Бусад баримт бичиг (Хороо шаардлагатай гэж үзвэл мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдсон эсэх тухай болон компанийн эрх бүхий албан тушаалтны ял шийтгэлтэй эсэх талаар цагдаагийн байгууллагын тодорхойлолт, хэрэв гадаадын иргэн бол уг иргэний харьяалалтай улсын эрх бүхий байгууллагын тодорхойлолтыг шаардаж болно).

2.3.17. Хороо шаардлагатай гэж үзсэн баримт бичгийг нотариатаар гэрчлүүлэн ирүүлэхийг шаардаж болно.

2.4. Гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогч нь энэ журмын 2.2.3-т заасан даатгалын баталгаа хөрөнгийг Монгол Улсын нутаг дэвсгэрт буй аль нэг банкинд байршуулах, эсхүл Монгол Улсын засгийн газар, Монголбанкны бонд хэлбэрээр байршуулна.

ГУРАВ. ГАДААДЫН ДААТГАГЧ, ГАДААДЫН ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИД САЛБАР, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРАА НЭЭХИЙГ ЗӨВШӨӨРӨХ, ЗӨВШӨӨРӨХӨӨС ТАТГАЛЗАХ

3.1. Зөвшөөрөл хүсч гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчоос ирүүлсэн баримт бичгийг холбогдох хууль тогтоомж болон энэхүү журмыг үндэслэн хянаж, шаардлагатай баримт бичгийг шалгаж баталгаажуулсны үндсэн дээр зөвшөөрөх тухай асуудлыг нийтийн болон даатгуулагчийн ашиг сонирхолд хохирол учруулахгүй гэж үзвэл Хорооны хуралдаанаар шийдвэрлэнэ.

3.2. Хороо гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчид салбар, төлөөлөгчийн газраа нээхийг зөвшөөрөх эсэхийг хуанлийн 45 хоногийн дотор шийдвэрлэнэ. Энэ хугацааг салбар, төлөөлөгчийн газар нээх хүсэлт, холбогдох баримт бичгийг үнэн зөв, бүрэн гүйцэд бүрдүүлж Хороонд ирүүлсэн өдрөөс эхлэн тооцно.

3.3. Хороо салбар, төлөөлөгчийн газраа нээхийг зөвшөөрөхөөр шийдвэрлэсэн тохиолдолд энэ журмын 2.2.3-т заасан даатгалын баталгаа хөрөнгийг гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогч нь Хорооны хяналтад байх дансанд түр байршуулах ба энэ тухай мэдэгдлийг Хороо албан бичгээр өгнө.

3.4. Гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогч нь уг албан бичгийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор даатгалын баталгаа хөрөнгийг Хорооны хяналтын дансанд төвлөрүүлж, хуанлийн 10 хоногийн хугацаатай байршуулах ба энэхүү мөнгөн хөрөнгөнд Хороо хүү төлөхгүй.

3.5. Салбараа нээхийг зөвшөөрсөн Хорооны шийдвэрт гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчийн тухайн салбар, төлөөлөгчийн газарт даатгалын ямар ангилал, төрөл, хэлбэрээр зөвшөөрөл олгосныг тусгана.

3.6. Салбар, төлөөлөгчийн газраа нээхийг зөвшөөрсөн Хорооны шийдвэр болон зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн баримтыг үндэслэн гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчийн салбар, төлөөлөгчийн газарт салбар, төлөөлөгчийн газрын гэрчилгээ олгоно.

3.7. Хороо нь гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчийн салбар, төлөөлөгчийн газрын зөвшөөрлийг бүртгэн авч, зохих журмын дагуу нэгдсэн бүртгэлд бүртгэнэ.

3.8. Хороо гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчид Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвшөөрөл олгосон тухайгаа олон нийтэд мэдээнэ.

3.9. Зөвшөөрөл авсан гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогч нь энэ журмын 3.4-т заасан хугацаа өнгөрсний дараа Хорооны хяналтын дансанд түр байршуулсан мөнгөн хөрөнгийг өөрийн харилцах дансанд шилжүүлэх тухай хүсэлтээ албан бичгээр гаргана.

3.10. Хорооноос зөвшөөрөл авсан гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчийн салбар, төлөөлөгчийн газрын компанийн дүрэм, бусад баримт бичигт орсон өөрчлөлтийг Хороо болон бусад холбогдох байгууллагад бүртгүүлнэ.

3.11. Гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогч нь Хорооноос авсан зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойших хугацаанд зөвшөөрөл хүсч Хороонд ирүүлсэн баримт бичигт өөрчлөлт орсон тухай бүрд уг өөрчлөлтийн талаарх мэдээллийг ажлын 10 өдрийн дотор Хороонд ирүүлнэ.

3.12. Хороо дараах үндэслэлээр гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчид салбар, төлөөлөгчийн газраа нээхийг зөвшөөрөхөөс татгалзана:

3.12.1. Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль болон энэ журамд заасан шаардлагыг хангаагүй;

3.12.2. Хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь нотлогдсон;

3.12.3. Гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогч нь олон улсын санхүүгийн зах зээлд гарсан гэмт хэрэгтэй холбогдож шийтгэгдсэн нь тогтоогдсон тухай мэдээлэл ирсэн;

3.12.4. Хорооноос гадаадын даатгагч, гадаадын даатгагчийн мэргэжлийн оролцогчийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдсон байж болохыг тогтоосон;

3.12.5. Бусад хууль, журамд заасан шаардлагыг хангаагүй.

3.13. Гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчид салбар, төлөөлөгчийн газраа нээхийг зөвшөөрөхөөс татгалзсан тохиолдолд Хороо энэ талаарх үндэслэл бүхий тайлбарыг өргөдөл гаргасан гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчид албан бичгээр мэдэгдэнэ.

3.14. Хороо хуурамч баримт бичиг бүрдүүлсэн үндэслэлээр салбар, төлөөлөгчийн газраа нээхийг зөвшөөрөхөөс татгалзсан тохиолдолд 3 жилийн дотор тухайн гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогч, түүний хөрөнгө оруулагчид, гүйцэтгэх удирдлага (гүйцэтгэх захирал, ерөнхий менежер, ерөнхий нягтлан бодогч, эсхүл тэдгээртэй адилтгах албан тушаал)-д ажиллах этгээдээс зөвшөөрөл хүссэн хүсэлтийг дахин хүлээж авахгүй.

ДӨРӨВ. ГАДААДЫН ДААТГАГЧ, ГАДААДЫН ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН САЛБАР, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫН ЗӨВШӨӨРЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ

4.1. Хороо дараах үндэслэлээр гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчийн салбар, төлөөлөгчийн газрын зөвшөөрлийг түдгэлзүүлнэ:

4.1.1. Гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчийн салбар, төлөөлөгчийн газар нь Даатгалын тухай хууль тогтоомж болон энэ журмаар заасан шаардлагыг хангахгүй байгаа нь Хорооны хяналт шалгалтаар тогтоогдсон;

4.1.2. Зөвшөөрөл олгосноос хойш 6 сарын дотор үйл ажиллагаагаа эхлээгүй;

4.1.3. Хорооноос баталсан журамд заасан зохицуулалтын үйлчилгээний хөлс төлөөгүй.

4.2. Зөвшөөрлийг түдгэлзүүлэх хугацааг Хорооны шийдвэрээр тухай бүр тогтоох ба энэ хугацаа нь 6 сараас хэтрэхгүй байна.

4.3. Хороо дараах үндэслэлээр гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчид олгосон салбар, төлөөлөгчийн газрын зөвшөөрлийг хүчингүй болгоно:

4.3.1. Зөвшөөрөл бүхий компани хүсэлт гаргасан;

4.3.2. Зөвшөөрөл бүхий компани татан буугдсан, дампуурсан;

4.3.3. Хүсэлт гаргахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;

4.3.4. Зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;

4.3.5. Зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан Хорооны шаардлагыг биелүүлээгүй.

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 01 дүгээр сарын
09-ний өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан
“Даатгалын багц дүрэм”-ийн арваннэгдүгээр хавсралт

ДААТГАГЧ БОЛОН ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧООС ТАЙЛАН, МЭДЭЭ, ӨРГӨДӨЛ ГАРГАХ ЗААВАР

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэ зааврын зорилго нь ердийн, урт хугацааны, давхар даатгалын компани (цаашид “даатгагч” гэх) болон даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч, даатгалын төлөөлөгч (цаашид “мэргэжлийн оролцогч” гэх)-өөс тайлан, мэдээ, өргөдөл гаргах агуулга, маягтыг тогтооход оршино.

ХОЁР. САНХҮҮГИЙН ТАЙЛАН, МЭДЭЭ ГАРГАХ, ИРҮҮЛЭХ

2.1 Дараах даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогч этгээд (цаашид “даатгалын байгууллага” гэх) нь санхүүгийн нэмэлт тайланг улирал бүр гаргаж, эхний хагас жилийн болон жилийн санхүүгийн тайлангийн хамт Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан хугацаанд цаасаар болон Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ны цахим бүртгэл (FINA программ)-д илгээх, 1 болон 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн хамт дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор цаасаар болон Хорооны цахим бүртгэлд илгээнэ:

- 2.1.1 Ердийн даатгалын компани;
- 2.1.2 Урт хугацааны даатгалын компани;
- 2.1.3 Давхар даатгалын компани;
- 2.1.4 Даатгалын зуучлагч компани;
- 2.1.5 Даатгалын хохирол үнэлэгч компани.

2.2 Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч нь энэ зааврын 2.1-д заасан санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.1-д заасны дагуу дараах байдлаар бэлтгэнэ:

2.2.1 Ердийн даатгагч нь Нягтлан бодох бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Санхүүгийн зохицуулах хорооны хамтран баталсан маягтаар; /Санхүүгийн байдлын тайлангийн Даатгалын нөөц сан хэсэгт “Тусгай нөөц сан” мөрийг нэмж гаргана/

2.2.2 Урт хугацааны даатгагч болон давхар даатгагч нь өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг Нягтлан бодох бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Санхүүгийн зохицуулах хорооны хамтран баталсан маягтаар;

2.2.3 Даатгалын зуучлагч болон даатгалын хохирол үнэлэгч компани нь Нягтлан бодох бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан маягтаар;

2.2.4 Даатгалын зуучлагч нь банк бол Нягтлан бодох бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Монголбанкны хамтран баталсан маягтаар.

2.3 Даатгалын байгууллага нь энэ зааврын хавсралтаар баталсан мэдээллийг энэ зааврын 2.1-д заасан хугацаанд Хороонд цаасаар ирүүлэх болон Хорооны цахим бүртгэлд үнэн зөв илгээсэн нөхцөлд санхүүгийн тайланг бүрэн ирүүлсэнд тооцно.

2.4 Даатгалын байгууллага нь салбар, төлөөлөгчийн газрын санхүүгийн тайлан, санхүүгийн

нэмэлт тайланг нэгтгэж, нэгдсэн тайланг Хороонд ирүүлнэ.

2.5 Даатгалын байгууллага нь эхний хагас жилийн болон жилийн санхүүгийн тайлангийн хамт банкин дахь харилцах, хадгаламжийн хуулгыг ирүүлнэ.

2.6 Ердийн даатгалын компани нь дараах санхүүгийн нэмэлт тайланг улирал бүр гаргаж, энэ зааврын 2.1-д заасан хугацаанд Хороонд ирүүлнэ:

2.6.1 Дүрмийн сангийн хөрөнгийн байршлын тайланг энэ зааврын 1 дүгээр хавсралтаар;

2.6.2 Хөрөнгийн эрсдэлийн тайланг энэ зааврын 2 дугаар хавсралтаар;

2.6.3 Даатгалын нөөц сангийн тайланг энэ зааврын 3 дугаар хавсралтаар;

2.6.4 Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сангийн дэлгэрэнгүй тайланг энэ зааврын 4 дүгээр хавсралтаар;

2.6.5 Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сангийн дэлгэрэнгүй тайланг энэ зааврын 5 дугаар хавсралтаар;

2.6.6 Учирч болзошгүй хохирлын нөөц сангийн дэлгэрэнгүй тайланг энэ зааврын 6 дугаар хавсралтаар;

2.6.7 Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн дэлгэрэнгүй тайланг энэ зааврын 7 дугаар хавсралтаар;

2.6.8 Даатгалын үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайланг энэ зааврын 8 дугаар хавсралтаар;

2.6.9 Даатгуулагчийн дэлгэрэнгүй тайланг энэ зааврын 9 дүгээр хавсралтаар;

2.6.10 Даатгасан даатгалын зүйлийн тайланг энэ зааврын 10 дугаар хавсралтаар;

2.6.11 Давхар даатгалын үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайланг энэ зааврын 11 дүгээр хавсралтаар;

2.6.12 Салбар, төлөөлөгчийн газрын ерөнхий мэдээллийн тайланг энэ зааврын 12 дугаар хавсралтаар;

2.6.13 Холбогдох этгээд болон түүнтэй холбоотой талуудтай хийсэн ажил, гүйлгээний тайланг энэ зааврын 13 дугаар хавсралтаар;

2.6.14 Даатгалын зуучлагч, төлөөлөгчийн шимтгэлийн талаарх тайланг энэ зааврын 14 дүгээр хавсралтаар;

2.6.15 Хүртээмжтэй даатгалын үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайланг энэ зааврын 30 дугаар хавсралтаар.

2.7 Урт хугацааны даатгалын компани нь дараах санхүүгийн нэмэлт тайланг улирал бүр гаргаж, энэ зааврын 2.1-д заасан хугацаанд Хороонд ирүүлнэ:

2.7.1 Санхүүгийн байдлын тайланг энэ зааврын 15 дугаар хавсралтаар;

2.7.2 Орлогын дэлгэрэнгүй тайланг энэ зааврын 16 дугаар хавсралтаар;

2.7.3 Дүрмийн сангийн хөрөнгийн байршлыг энэ зааврын 1 дүгээр хавсралтаар;

2.7.4 Хөрөнгийн эрсдэлийн тайланг энэ зааврын 2 дугаар хавсралтаар;

2.7.5 Даатгалын нөөц сангийн тайланг энэ зааврын 17 дугаар хавсралтаар;

2.7.6 Хувь оролцоотой гэрээний нөөц сангийн дэлгэрэнгүй тайланг энэ зааврын 18 дугаар хавсралтаар;

2.7.7 Хувь оролцоогүй гэрээний нөөц сангийн дэлгэрэнгүй тайланг энэ зааврын 19 дүгээр хавсралтаар;

2.7.8 Хөрөнгө оруулалттай холбоотой гэрээний нөөц сангийн дэлгэрэнгүй тайланг энэ

зааврын 20 дугаар хавсралтаар;

2.7.9 Даатгалын үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайланг энэ зааврын 21 дүгээр хавсралтаар;

2.7.10 Даатгалын нийт хураамжийн орлогын дэлгэрэнгүй тайланг энэ зааврын 22 дугаар хавсралтаар;

2.7.11 Даатгуулагчийн дэлгэрэнгүй тайланг энэ зааврын 23 дугаар хавсралтаар;

2.7.12 Давхар даатгалын үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайланг энэ зааврын 24 дүгээр хавсралтаар;

2.7.13 Нийт төлсөн нэхэмжлэлийн дэлгэрэнгүй тайланг энэ зааврын 25 дугаар хавсралтаар;

2.7.14 Салбар, төлөөлөгчийн газрын ерөнхий мэдээллийн тайланг энэ зааврын 12 дугаар хавсралтаар;

2.7.15 Холбогдох этгээд болон түүнтэй холбоотой талуудтай хийсэн ажил, гүйлгээний тайланг энэ зааврын 13 дугаар хавсралтаар;

2.7.16 Даатгалын зуучлагч, төлөөлөгчийн шимтгэлийн талаарх тайланг энэ зааврын 14 дүгээр хавсралтаар

2.7.17 Хүртгэмжтэй даатгалын үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайланг энэ зааврын 30 дугаар хавсралтаар.

2.8 Давхар даатгалын компани нь дараах санхүүгийн нэмэлт тайланг улирал бүр гаргаж, энэ зааврын 2.1-д заасан хугацаанд Хороонд ирүүлнэ:

2.8.1 Санхүүгийн байдлын тайланг энэ зааврын 26 дугаар хавсралтаар;

2.8.2 Орлогын дэлгэрэнгүй тайланг энэ зааврын 27 дугаар хавсралтаар;

2.8.3 Дүрмийн сангийн хөрөнгийн байршлыг энэ зааврын 1 дүгээр хавсралтаар;

2.8.4 Хөрөнгийн эрсдэлийн тайланг энэ зааврын 2 дугаар хавсралтаар;

2.8.5 Даатгалын нөөц сангийн тайланг энэ зааврын 28 дугаар хавсралтаар;

2.8.6 Даатгалын үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайланг энэ зааврын 29 дүгээр хавсралтаар;

2.8.7 Салбар, төлөөлөгчийн газрын ерөнхий мэдээллийн тайланг энэ зааврын 12 дугаар хавсралтаар;

2.8.8 Холбогдох этгээд болон түүнтэй холбоотой талуудтай хийсэн ажил, гүйлгээний тайланг энэ зааврын 13 дугаар хавсралтаар;

2.8.9 Даатгалын зуучлагч, төлөөлөгчийн шимтгэлийн талаарх тайланг энэ зааврын 14 дүгээр хавсралтаар.

2.9 Даатгалын зуучлагч компани нь дараах санхүүгийн нэмэлт тайланг улирал бүр гаргаж, энэ зааврын 2.1-д заасан хугацаанд Хороонд ирүүлнэ.

2.9.1 Орлогын дэлгэрэнгүй тайланг энэ зааврын 31 дүгээр хавсралтаар;

2.9.2 Орлогын дэлгэрэнгүй тайлан (харилцагч бүрээр)-г энэ зааврын 32 дугаар хавсралтаар;

2.9.3 Салбар, төлөөлөгчийн газрын дэлгэрэнгүй тайланг энэ зааврын 33 дугаар хавсралтаар;

2.9.4 Холбогдох этгээд болон түүнтэй холбоотой талуудтай хийсэн ажил, гүйлгээний тайланг энэ зааврын 13 дугаар хавсралтаар.

2.10 Даатгалын хохирол үнэлэгч компани нь дараах санхүүгийн нэмэлт тайланг улирал бүр гаргаж, энэ зааврын 2.1-д заасан хугацаанд гаргаж Хороонд ирүүлнэ:

2.10.1 Орлогын дэлгэрэнгүй тайланг энэ зааврын 34 дүгээр хавсралтаар;

2.10.2 Даатгалын зүйлийн тайланг энэ зааврын 35 дугаар хавсралтаар;

2.10.3 Салбар, төлөөлөгчийн газрын дэлгэрэнгүй тайланг энэ зааврын 36 дугаар хавсралтаар;

2.10.4 Холбогдох этгээд болон түүнтэй холбоотой талуудтай хийсэн ажил, гүйлгээний тайланг энэ зааврын 13 дугаар хавсралтаар.

2.11 Даатгалын байгууллагын салбар нь дараах санхүүгийн нэмэлт тайланг жилд 2 удаа гаргаж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан хугацаанд харъяалагдах аймаг, нийслэл, дүүргийн орон нутгийн төлөөлөгчид хүргүүлнэ.

2.11.1 Даатгалын компанийн салбар, төлөөлөгчийн газрын даатгалын үйл ажиллагааны тайланг энэ зааврын 37 дугаар хавсралтаар;

2.11.2 Даатгалын зуучлагч компанийн салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны тайланг энэ зааврын 38 дугаар хавсралтаар;

2.11.3 Даатгалын хохирол үнэлэгч компанийн салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны тайланг энэ зааврын 39 дүгээр хавсралтаар.

2.12 Даатгагч нь даатгалын үйл ажиллагаатай холбогдсон товч мэдээллийг дараа сарын 10-ны өдрийн дотор энэ зааврын 40 дүгээр хавсралтын дагуу цахим хэлбэрээр ирүүлнэ.

2.13 Даатгалын зуучлагч нь даатгалын зуучлалын үйл ажиллагаатай холбогдсон товч мэдээллийг энэ зааврын 41 дүгээр хавсралт, даатгалын хохирол үнэлэгч нь даатгалын хохирлын үнэлгээтэй холбогдсон товч мэдээллийг энэ зааврын 42 дугаар хавсралтын дагуу тус тус дараа сарын 10-ны өдрийн дотор цахим хэлбэрээр ирүүлнэ.

2.14 Хорооны орон нутгийн төлөөлөгч нь тухайн орон нутаг дахь даатгалын байгууллагын салбарын тайланг энэ зааврын 2.13-т заасны дагуу хүлээн авч, нэгтгэн жил бүрийн 3 дугаар сарын 1, 8 дугаар сарын 1-ний өдрийн дотор тус тус Хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын асуудал эрхэлсэн нэгжид ирүүлнэ.

2.15 Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагааны орлого /шимтгэлийн орлого/ нь 20.0 сая төгрөг ба түүнээс дээш хэмжээтэй бол даатгалын төлөөлөгч өөрийн орлогын тайланг энэ зааврын 43 дугаар хавсралтын дагуу жилд 2 удаа гаргаж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан хугацаанд Хороонд ирүүлнэ.

2.16 Даатгагч нь энэ зааврын 44 дүгээр хавсралтын дагуу нягтлан бодох бүртгэлд мөрдөх дансны жагсаалтыг боловсруулж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.

ГУРАВ. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

3.1 Хороо даатгалын байгууллагаас энэ зааврын хавсралтын дагуу санхүүгийн нэмэлт тайланг сар бүр гаргаж өгөхийг шаардаж болно.

3.2 Даатгалын компаниас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн зайлшгүй нэмэлт мэдээлэл шаардлагатай болбол Хороо хэзээ ч шаардаж болно.

3.3 Хороо нь энэ зааврын биелэлтэд хяналт тавьж ажиллах бөгөөд зааврыг зөрчсөн этгээдэд Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

“Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчоос тайлан, мэдээ, өргөдөл гаргах заавар”-ын 1 дүгээр хавсралт

**МАЯГТ СЗХ04105. ДААТГАЛЫН КОМПАНИЙН ДҮРМИЙН
 САНГИЙН ХӨРӨНГИЙН БАЙРШИЛ**

Даатгагчийн нэр.....		20...оны ... сарын ...-ны өдөр			
Үзүүлэлт	Мөр/ дугаар	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	Хөрөнгө оруулалт	(төгрөгөөр)	
				Дүн	Эзлэх хувь
Б	В	1	2	3	4
Бэлэн мөнгө	1				
Банкны харилцах (=мөр(3+4+5))	2				
.....банк (дансны дугаар, валют)	3				
.....банк (дансны дугаар, валют)	4				
.....банк (дансны дугаар, валют)	5				
Банкны хугацаагүй хадгаламж (=мөр(7+8))	6				
.....банк (дансны дугаар, валют)	7				
.....банк (дансны дугаар, валют)	8				
Банкны хугацаатай хадгаламж (=мөр(10+11))	9				
.....банк (дансны дугаар, валют)	10				
.....банк (дансны дугаар, валют)	11				
Банкны хадгаламжийн сертификат (мөр12=мөр(13+14+15))	12				
.....банк (дансны дугаар, валют)	13				
.....банк (дансны дугаар, валют)	14				
.....банк (дансны дугаар, валют)	15				
Үнэт цаас (мөр16=мөр(17+18+...25))	16				
Засгийн газрын өрийн хэрэгсэл	17				
Төв банкны үнэт цаас	18				
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	19				
Аймаг, нийслэлийн гаргасан өрийн бичиг	20				
Компанийн бонд	21				
ХБ-ийн I ангиллын хувьцаа	22				
ХБ-ийн II ангиллын хувьцаа	23				
Хөрөнгө оруулалтын сангийн үнэт цаас /нэгж эрх/	24				
Бусад	25				
Санхүүгийн түрээс	26				
Хараат ба хамтын хяналттай, охин компаниудад оруулсан хөрөнгө оруулалт	27				
Үнэт металл, Дериватив	28				
Бусад санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө (=мөр(30+31+32))	29				
... санхүүгийн байгууллага	30				
... санхүүгийн байгууллага	31				
... санхүүгийн байгууллага	32				

Үндсэн хөрөнгө (=мөр(34+35))	33				
Үл хөдлөх хөрөнгө	34				
Бусад үндсэн хөрөнгө	35				
Бусад хөрөнгө (=мөр(37+38+...+41))	36				
Даатгалын авлага	37				
Бусад санхүүгийн ба санхүүгийн бус хөрөнгө	38				
Даатгалын хөрөнгө	39				
Биет бус хөрөнгө	40				
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	41				
НИЙТ ДҮН (=мөр(1+2+6+9+12+16+26+27+28+29+33+36))	42	(=МАЯГТ СЗХ04101-ийн бага 2 мөр 7)	(=МАЯГТ СЗХ04101-ийн бага 2 мөр 29)	(=МАЯГТ СЗХ04101-ийн бага 2 мөр 79-өөс мөр 80-ыг хасна)	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:
 (албан тушаал) (гарын үсэг) (овог нэр)

тамга тэмдэг

ТАЙЛАН ГАРГАСАН ХУГАЦАА: 20...оны...сарын... өдөр

Маягт нөхөх заавар:
Багана "Б"-д дурдсан үзүүлэлт тус бүрийг даатгалын компанид мөрдөх "Нягтлан бодох бүртгэлийн заавар"-г заасан тодорхойлолтод нийцүүлэн нөхнө.
Багана "1", багана "2"-д мэдээллийг бөглөхдөө даатгалын компанид мөрдөх "Нягтлан бодох бүртгэлийн заавар"-ын дагуу багана "Б"-д дурдсан үзүүлэлтийг мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө болон хөрөнгө оруулалт гэж ангилж нөхнө.
Багана "3"-г багана "1" болон багана "2"-т нөхсөн бол эдгээрийн нийлбэрийг, эсвэл багана "Б"-д дурдсан үзүүлэлт нь багана "1" болон багана "2"-г заасан шаардлагыг хангахгүй бол багана "3"-г шууд нөхнө.
Багана "4"-г нөхөхдөө мөр тус бүрийн мөр 42-т эзлэх хувийг гаргаж нөхнө.
Шаардлагатай тохиолдолд мөр нэмж болно.
Хэрэв валютын данс бол тухайн тайлант хугацааны эцсийн өдрийн байдлаарх Монголбанкны ханшаар төгрөгт шилжүүлнэ.

“Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчоос тайлан, мэдээ, өргөдөл гаргах заавар”-ын 2 дугаар хавсралт

МАЯГТ СЗХ04106. ДААТГАЛЫН КОМПАНИЙН ХӨРӨНГИЙН ЭРСДЭЛИЙН ТАЙЛАН

Даатгагчийн нэр.....

20...оны ... сарын ...-ны өдөр

А. ХУВЬЦАА БОЛОН ТҮҮНГЭЙ АДИЛТГАН ТООЦОХ ҮНЭТ ЦААСНААС БУСАД ҮНЭТ ЦААС

(төгрөгөөр)

№	Хувьцаа болон түүнтэй адилтган тооцох үнэт цааснаас бусад үнэт цаас	Мөрийн дугаар	Хэвийн	Хугацаа хэтэрсэн	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу	ДҮН (=бага(1+2+3+4+5+6))
A	Б	B	1	2	3	4	5	6
1	Хувьцаа болон түүнтэй адилтган тооцох үнэт цааснаас бусад үнэт цаас	1						
1.1Үнэт цаасны ангилал	2						
1.2Үнэт цаасны ангилал	3						
2	Хувьцаа болон түүнтэй адилтган тооцох үнэт цааснаас бусад үнэт цаасны нийт дүн (=мөр(2+3))	4						
3	Хувьцаа болон түүнтэй адилтган тооцох үнэт цааснаас бусад үнэт цаасны эрсдэлийн дүн	5	(= мөр4, багана 1-ийн дүнг *0%)	(= мөр4, багана 2-ийн дүнг *5%)	(= мөр4, багана 3-ийн дүнг *25%)	(= мөр4, багана 4-ийн дүнг *50%)	(= мөр4, багана 5-ийн дүнг *100%)	
4	Хувьцаа болон түүнтэй адилтган тооцох үнэт цааснаас бусад үнэт цаасны нэвэр дүн (=мөр(4-5))	6						

Б. ӨМЧЛӨХ БУСАД ХӨРӨНГӨ

(тогтоогч)

№	Өмчлөх бусад хөрөнгө	Мөрийн дугаар	Хэвийн	Хугацаа хэтэрсэн	Хэвийн бүс	Эргэлзээтэй	Мүү	ДҮНН (=бага(1+2+3+4+5+6))
A	Б	B	1	2	3	4	5	6
1	Өмчлөх бусад хөрөнгө	1						
1.1	...хөрөнгө 1	2						
1.2	...хөрөнгө 2	3						
2	Өмчлөх бусад хөрөнгийн нийт дүн (=мөр(2+3))	4						
3	Өмчлөх бусад хөрөнгийн эрсдлийн дүн	5	(= мөр4, багана 1-ийн дүнг *0%)	(= мөр4, багана 2-ийн дүнг *5%)	(= мөр4, багана 3-ийн дүнг *25%)	(= мөр4, багана 4-ийн дүнг *50%)	(= мөр4, багана 5-ийн дүнг *100%)	
4	Өмчлөх бусад хөрөнгийн цэвэр дүн (мөр5=мөр(3-4))	6						(=МАЯГТ СЗХ04101-ийн бага 2 мөр 22)

В. АВЛАГА

(тогтоогч)

№	Авлагын төрөл	Мөрийн дугаар	Хэвийн	Хугацаа хэтэрсэн	Хэвийн бүс	Эргэлзээтэй	Мүү	ДҮНН (=бага(1+2+3+4+5+6))
A	Б	B	1	2	3	4	5	6
1	ДААТГАЛЫН АВЛАГА	1						
1	Даатгалын хураамжийн авлага	2						
2	Буруутай этгэдээс авах авлага	3						
3	Давхар даатгалаас авах авлага	4						
4	Даатгалын авлагын нийт дүн (=мөр(2+3+4))	5						
5	Даатгалын авлагын эрсдлийн дүн	6	(= мөр 5, багана 1-ийн дүнг *0%)	(= мөр5, багана 2-ийн дүнг *5%)	(= мөр 5, багана 3-ийн дүнг *25%)	(= мөр 5, багана 4-ийн дүнг *50%)	(= мөр5, багана 5-ийн дүнг *100%)	
6	Даатгалын авлагын цэвэр дүн (=мөр(5-6))	7						(=МАЯГТ СЗХ04101-ийн бага 2 мөр 12)

II	БУСАД САНХҮҮГИЙН БА САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГӨД БАЙГАА АВЛАГА	8						
1 авлагын төрөл	9						
2 авлагын төрөл	10						
3	Бусад санхүүгийн ба санхүүгийн бус хөрөнгөд байгаа авлагын дүн (=мөр(9+10))	11						
4	Авлагын эрсдлийн дүн	12	(= мөр 11, багана 1-ийн дүнг *0%)	(= мөр 11, багана 2-ийн дүнг *5%)	(= мөр 11, багана 3-ийн дүнг *25%)	(= мөр 11, багана 4-ийн дүнг *50%)	(= мөр 11, багана 5-ийн дүнг *100%)	
5	Бусад санхүүгийн ба санхүүгийн бус хөрөнгөд байгаа авлагын пэвэр дүн (=мөр11-мөр12)	13						(=МАЯГТ СЗХ04101- ийн бага 2 мөр (14+17+18))

Маягт нөхөх заавар:

1. Багана "Б"-д дурдсан үзүүлэлт тус бүрийн даатгалын компанид мөрдөх "Нягтлан бодох бүртгэлийн заавар"-г заасан тодорхойлолгод нийцүүлэн нөхнө.
2. Тухайн хөрөнгийн эрсдэлийн сан байгуулах тохиолдолд "А" хэсгийн мөр "5", "Б" хэсгийн мөр "5", "В" хэсгийн мөр "6" болон мөр "12"-ийг нөхнө.
3. Хөрөнгө тус бүрийн ангиллыг дараах хэлбэрээр ойлгоно:

А. Хувьцаа болон түүнгэй адилтган тооцх үнэт цааснаас бусад үнэт цаасыг хугацааны үзүүлэлтээр дүгнэх хүснэгт

Ангилал	Хэвийн	Хугацаа хэтэрсэн	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу
Хугацааны үзүүлэлт	Үнэт цаас, үнэт цаасны хүүгийн эргэн төлөлт, хуваарьт заасан хугацаандлаа төлөгдөж байгаа.	Үнэт цаас, үнэт цаасны хүүгийн эргэн төлөлт хийгдэлгүй хуваарьт заасан хугацаанаас 30 хүртэл хоног хэтэрсэн.	Үнэт цаас, үнэт цаасны хүүгийн эргэн төлөлт хийгдэлгүй хуваарьт заасан хугацаанаас 31-60 хоног хэтэрсэн.	Үнэт цаас, үнэт цаасны хүүгийн эргэн төлөлт хийгдэлгүй хуваарьт заасан хугацаанаас 61-90 хоног хэтэрсэн.	Үнэт цаас, үнэт цаасны хүүгийн эргэн төлөлт хийгдэлгүй хуваарьт заасан хугацаанаас 91-ээс дээш хоног хэтэрсэн.

Б. Өмчлөх бусад хөрөнгийг хугацааны үзүүлэлтээр дүгнэх хүснэгт

Ангилал	Хэвийн	Хугацаа хэтэрсэн	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу
Хугацааны үзүүлэлт	Өмчлөлд авснаас хойш 30 хүртэл хоногийн дотор борлогдоогүй	Өмчлөлд авснаас хойш 31-60 хүртэл хоногийн дотор борлогдоогүй	Өмчлөлд авснаас хойш 61-90 хүртэл хоногийн дотор борлогдоогүй	Өмчлөлд авснаас хойш 91-120 хүртэл хоногийн дотор борлогдоогүй	Өмчлөлд авснаас хойш 121 хоногоос дээш хугацаанд борлогдоогүй

В. Авлагыг хугацааны үзүүлэлтээр дүгнэх хүснэгт

Ангилал	Хэвийн	Хугацаа хэтэрсэн	Хэвийн бус	Эргэлзээтэй	Муу
Хугацааны үзүүлэлт	Төлөгдөх хугацаа дууссанаас хойш 30 хүртэл хоногийн дотор байгаа	Төлөгдөх хугацаа дууссанаас хойш 31-60 хоногийн дотор төлөгдөөгүй	Төлөгдөх хугацаа дууссанаас хойш 61-90 хоногийн дотор төлөгдөөгүй	Төлөгдөх хугацаа дууссанаас хойш 91-120 хоногийн дотор төлөгдөөгүй	Төлөгдөх хугацаа дууссанаас хойш 121-ээс дээш хоногоор төлөгдөөгүй буюу ашиглан, гэмт, хэргийн улмаас бий болсон авлага

“Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчоос тайлан, мэдээ, өргөдөл гаргах заавар”-ын 3 дугаар хавсралт

МАЯГТ СЗХ04107. ЕРДИЙН ДААТГАЛЫН КОМПАНИЙН НӨӨЦ САНГИЙН ТАЙЛАН

Даатгагчийн нэр.....

20...оны ... сарын ...-ны өдөр
(төгрөгөөр)

№	Даатгалын нөөц сан	Мөр/ дугаар	Нөөц сан					Үүнээс: Даатгалын нөөцийн давхар даатгагчид ногдох хэсэг		
			Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
A	Б	B	1	2	3	4 (=бага(1+2-3))	5	6	7	8 (=бага(5+6-7))
1. Сайн дурын даатгал	Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан	1								
	Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан	2								
	Учирч болзошгүй хохирлын нөөц сан	3								
2. Албан журмын даатгал	Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан	4								
	Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан	5								
	Учирч болзошгүй хохирлын нөөц сан	6								
Тусгай нөөц сан		7	(=МАЯГТ СЗХ04101-ийн бага 1 мөр 74)			(=МАЯГТ СЗХ04101-ийн бага 2 мөр 74)				-
ДҮН (=мөр1+мөр2+...мөр7)		8	(=МАЯГТ СЗХ04101-ийн бага 1 мөр 75)			(=МАЯГТ СЗХ04101-ийн бага 2 мөр 75)	(=МАЯГТ СЗХ04101-ийн бага 1 мөр 32)			(=МАЯГТ СЗХ04101-ийн бага 2 мөр 32)

Жич: Актуар тооцооллыг хавсаргана.

Маягт нөхөх заавар:

1. Багана "Б"-д дурдсан үзүүлэлт тус бүрийг даатгалын компанид мөрдөх "Нягтлан бодох бүртгэлийн заавар"-т заасан тодорхойлолтод нийцүүлэн нөхнө.
2. Мөр "1"-ээс "3"-ийг нөхөхдөө сайн дурын даатгалын хэлбэрт хамаарах нөөц сангийн хэсгийг бичнэ.
3. Мөр "4"-өөс "6"-г нөхөхдөө албан журмын даатгалын хэлбэрт хамаарах нөөц сангийн хэсгийг бичнэ.
4. Багана "5"-аас "8"-ыг нөхөхдөө даатгалын нөхөн төлбөрийн нөөц сангаас давхар даатгагчид ногдох хэсгийг салган нөхнө.

ТАЙЛАН ГАРГАСАН:

.....
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

.....
(овог нэр)

тамга тэмдэг

ТАЙЛАН ГАРГАСАН ХУГАЦАА: 20...оны...сарын... өдөр

“Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчоос тайлан, мэдээ, өргөдөл гаргах заавар”-ын 4 дүгээр хавсралт

МАЯГТ СЗХ04108. ЕРДИЙН ДААТГАЛЫН КОМПАНИЙН УЧИРСАН БОЛОВЧ МЭДЭГДЭЭГҮЙ ХОХИРЛЫН НӨӨЦ САНГИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Даатгагчийн нэр.....

20...оны ... сарын ...-ны өдөр
(төгрөгөөр)

Даатгал/ төрөл	Даатгалын хэлбэр		Мөр/ дугаар	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл (=бага(1+2-3))
А	Б	В	Г	1	2	3	4
1. Сайн дурын даатгал	1.1	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	1				
	1.2	Үүнээс: Ипотекийн даатгал	2				
	1.3	Хөрөнгийн даатгал	3				
	1.4	Үүнээс: Ипотекийн даатгал	4				
	1.5	Авто тээврийн хэрэгслийн даатгал	5				
	1.6	Ачааны даатгал	6				
	1.7	Барилга угсралтын даатгал	7				
	1.8	Газар тариалангийн даатгал	8				
	1.9	Мал амьтдын даатгал	9				
	1.10	Агаарын хөлгийн даатгал	10				
	1.11	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	11				
	1.12	Хариуцлагын даатгал	12				
	1.13	Санхүүгийн даатгал	13				
	1.14	Зээлийн даатгал	14				
	1.15	Итгэлцлийн даатгал	15				
	1.16	Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал	16				
	1.17	Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	17				
	1.18	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	18				
2. Албан журмын даатгал	2.1	Жолоочийн хариуцлагын даатгал	19				
ДҮН (=мөр(1+2+...+19))			20	(=МАЯГТ СЗХ04101-ийн бага 1 мөр 71)			(=МАЯГТ СЗХ04101-ийн бага 2 мөр 71)

“Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчоос тайлан, мэдээ, өргөдөл гаргах заавар”-ын 5 дугаар хавсралт

МАЯГТ СЗХ04109. ЕРДИЙН ДААТГАЛЫН КОМПАНИЙН МЭДСЭН БОЛОВЧ ТӨЛӨӨГҮЙ ХОХИРЛЫН НӨӨЦ САНГИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Даатгагчийн нэр.....

20...оны ... сарын ...-ны өдөр

(төгрөгөөр)

Даатгал/ төрөл	Даатгалын хэлбэр		Мөр/ дугаар	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл (=бага(1+2-3))
А	Б	В	Г	1	2	3	4
1. Сайн дурын даатгал	1.1	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	1				
	1.2	Үүнээс: Ипотекийн даатгал	2				
	1.3	Хөрөнгийн даатгал	3				
	1.4	Үүнээс: Ипотекийн даатгал	4				
	1.5	Авто тээврийн хэрэгслийн даатгал	5				
	1.6	Ачааны даатгал	6				
	1.7	Барилга угсралтын даатгал	7				
	1.8	Газар тариалангийн даатгал	8				
	1.9	Мал амьтдын даатгал	9				
	1.10	Агаарын хөлгийн даатгал	10				
	1.11	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	11				
	1.12	Хариуцлагын даатгал	12				
	1.13	Санхүүгийн даатгал	13				
	1.14	Зээлийн даатгал	14				
	1.15	Итгэлцлийн даатгал	15				
	1.16	Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал	16				
	1.17	Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	17				
	1.18	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	18				
2. Албан журмын даатгал	2.1	Жолоочийн хариуцлагын даатгал	19				
ДҮН (=мөр(1+2+...+19))			20	(=МАЯГТ СЗХ04101-ийн бага 1 мөр 72)			(=МАЯГТ СЗХ04101-ийн бага 2 мөр 72)

ТАЙЛАН ГАРГАСАН:
 (албан тушаал) (гарын үсэг) (овог нэр)

тамга тэмдэг

ТАЙЛАН ГАРГАСАН ХУГАЦАА: 20...оны...сарын... өдөр

“Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчоос тайлан, мэдээ, өргөдөл гаргах заавар”-ын 6 дугаар хавсралт

МАЯГТ СЗХ04110. ЕРДИЙН ДААТГАЛЫН КОМПАНИЙН УЧИРЧ БОЛЗОШГУЙ ХОХИРЛЫН НӨӨЦ САНГИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Даатгагчийн нэр.....

20...оны ... сарын ...-ны өдөр
(төгрөгөөр)

Даатгал/ төрөл	Даатгалын хэлбэр		Мөр/ дугаар	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл (=бага(1+2-3))
А	Б	В	Г	1	2	3	4
1. Сайн дурын даатгал	1.1	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	1				
	1.2	Үүнээс: Ипотекийн даатгал	2				
	1.3	Хөрөнгийн даатгал	3				
	1.4	Үүнээс: Ипотекийн даатгал	4				
	1.5	Авто тээврийн хэрэгслийн даатгал	5				
	1.6	Ачааны даатгал	6				
	1.7	Барилга угсралтын даатгал	7				
	1.8	Газар тариалангийн даатгал	8				
	1.9	Мал амьтдын даатгал	9				
	1.10	Агаарын хөлгийн даатгал	10				
	1.11	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	11				
	1.12	Хариуцлагын даатгал	12				
	1.13	Санхүүгийн даатгал	13				
	1.14	Зээлийн даатгал	14				
	1.15	Итгэлцлийн даатгал	15				
	1.16	Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал	16				
	1.17	Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	17				
	1.18	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	18				
2. Албан журмын даатгал	2.1	Жолоочийн хариуцлагын даатгал	19				
ДҮН (=мөр(1+2+...+19))			20	(=МАЯГТ СЗХ04101-ийн бага 1 мөр 72)			(=МАЯГТ СЗХ04101-ийн бага 2 мөр 72)

ТАЙЛАН ГАРГАСАН:
(албан тушаал) (гарын үсэг) (овог нэр)

тамга тэмдэг

ТАЙЛАН ГАРГАСАН ХУГАЦАА: 20...оны...сарын... өдөр

“Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчоос тайлан, мэдээ, өргөдөл гаргах заавар”-ын 7 дугаар хавсралт

МАЯГТ СЗХ04111. ЕРДИЙН ДААТГАЛЫН КОМПАНИЙН ОРЛОГОД ТООЦООГҮЙ ХУРААМЖИЙН НӨӨЦИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Даатгагчийн нэр..... 20...оны ... сарын ...-ны өдөр (төгрөгөөр)

Даатгал/төрөл	Даатгалын хэлбэр		Мөр/дугаар	Орлогод тооцоогүй хураамжийн нөөц				Үүнээс: Давхар даатгагчид ногдох хэсэг			
	Б	В		Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл (=бага(1+2-3))	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл (=бага(5+6-7))
A			Г	1	2	3	4	5	6	7	8
	1.1	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	1								
	1.2	Үүнээс: Ипотекийн даатгал	2								
	1.3	Хөрөнгийн даатгал	3								
	1.4	Үүнээс: Ипотекийн даатгал	4								
	1.5	Авто тээврийн хэрэгслийн даатгал	5								
	1.6	Ачааны даатгал	6								
	1.7	Барилга утгаралтын даатгал	7								
	1.8	Газар тариалангийн даатгал	8								
	1.9	Мал амьтдын даатгал	9								
	1.10	Агаарын хөлгийн даатгал	10								
1. Сайн дурын даатгал	1.11	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	11								
	1.12	Хариуцлагын даатгал	12								
	1.13	Санхүүгийн даатгал	13								
	1.14	Зээлийн даатгал	14								
	1.15	Итгэцлийн даатгал	15								
	1.16	Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал	16								
	1.17	Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	17								

	Агаарын хөлийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	18							
2. Албан журмын даатгал	Жолоочийн хариуцлагын даатгал	19							
ДҮН (=мөр(1+2+...+19)		20	(=МАЯГТ СЗХ04101-ийн бага 1 мөр 69)	(=МАЯГТ СЗХ04101-ийн бага 1 мөр 69)	(=МАЯГТ СЗХ04101-ийн бага 2 мөр 69)	(=МАЯГТ СЗХ04101-ийн бага 1 мөр 31)	(=МАЯГТ СЗХ04101-ийн бага 2 мөр 31)		

ТАЙЛАН ГАРГАСАН: (албан тушаал) (гарын үсэг) (овог нэр)

тамга тэмдэг

ТАЙЛАН ГАРГАСАН ХУГАЦАА: 20...оны...сарын... өдөр

“Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчоос тайлан, мэдээ, өргөдөл гаргах заавар”-ын 8 дугаар хавсралт

МАЯГТ СЭХ04112. ЕРДИЙН ДААТГАЛЫН КОМПАНИЙН ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Даатгагчийн нэр..... 20...оны ... сарын ...-ны өдөр (төгрөгөөр)

			841007	Шүүхээр шийдвэрлэгдээгүй байгаа нөхөн төлбөр Мал амьтдын даатгал
			841008	Шүүхээр шийдвэрлэгдээгүй байгаа нөхөн төлбөр Агаарын хөлгийн даатгал
			841009	Шүүхээр шийдвэрлэгдээгүй байгаа нөхөн төлбөр Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал
			841010	Шүүхээр шийдвэрлэгдээгүй байгаа нөхөн төлбөр Хариуцлагын даатгал
			841011	Шүүхээр шийдвэрлэгдээгүй байгаа нөхөн төлбөр Санхүүгийн даатгал
			841012	Шүүхээр шийдвэрлэгдээгүй байгаа нөхөн төлбөр Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал

Толгой данс, нэр	Ерөнхий данс	Ерөнхий дансны нэр	Дэд данс	Дэд дансны нэр
			841013	Шүүхээр шийдвэрлэгдээгүй байгаа нөхөн төлбөр Зээлийн даатгал
			841014	Шүүхээр шийдвэрлэгдээгүй байгаа нөхөн төлбөр Итгэлцлийн даатгал
			841015	Шүүхээр шийдвэрлэгдээгүй байгаа нөхөн төлбөр Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал
			841016	Шүүхээр шийдвэрлэгдээгүй байгаа нөхөн төлбөр Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал
			841017	Шүүхээр шийдвэрлэгдээгүй байгаа нөхөн төлбөр Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал
			841018	Шүүхээр шийдвэрлэгдээгүй байгаа нөхөн төлбөр
			841019	Шүүхээр шийдвэрлэгдээгүй байгаа нөхөн төлбөр
			841020	Шүүхээр шийдвэрлэгдээгүй байгаа нөхөн төлбөр
85 Бусдын өмнө өөрийн хөрөнгөөр хариуцсан хариуцлага	8510	Баталгаа, батлан даалтанд хамаарах үүрэг	851001	Баталгаа, батлан даалтанд хамаарах үүрэг
			851002	Даатгалын компаний гаргасан баталгаа
			851003	Урьдчилгаа төлбөрийн баталгаа
			851004	Даатгалын компаний гаргасан батлан даалт
			851005	Векселийн батлан даалт
			851006	Тендерийн батлан даалт
			851007	Гүйцэтгэлийн батлан даалт
			851008	Аккредитивын батлан даалт
			851009	Бусад
	8520	Барьцаанд тавьсан хөрөнгө	852001	Мөнгөн хөрөнгө ба бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хадгаламж
			852002	Зээл, Үнэт цаас, Богино хугацаат хөрөнгө оруулалт
			852003	Авллага
			852004	Борлуулах зориулалттай үл хөдлөх хөрөнгө
			852005	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө
			852006	Барилга, байгууламж
			852007	Үнэт металл
			852008	Урт хугацаат хөрөнгө оруулалт
			852009	Биологийн хөрөнгө
			852010	Биет бус хөрөнгө
852011	Бусад			
86 Барьцаанд авсан хөрөнгө	8610	Барьцаанд авсан хөрөнгө	861001	Барьцаанд авсан хөрөнгө
87 Тэнцлээс хассан хөрөнгө	8710	Тэнцлээс хассан хөрөнгө	871001	Эрдэлийн сангаар хаасан авлага
			871002	Эрдэлийн сангаар хаасан үнэт цаас
			871003	Эрдэлийн сангаар хаасан зээл, факторниг
			871004	Эрдэлийн сангаар хаасан өмчлөх бусад хөрөнгө
			871005	Хуримтлуулж тооцохыг зогсоосон хүү

Толгой данс, нэр	Ерөнхий данс	Ерөнхий дансны нэр	Дэд данс	Дэд дансны нэр
88 Дериватив	8810	Спот,Форвард, Своп, Опцион, Фьючерс, бусад	881001	Гадаад валютын арилжааны авлага
			881002	Гадаад валютын арилжааны өглөг
			881003	Үнэт металлын арилжааны авлага
			881004	Үнэт металлын арилжааны өглөг
			881005	Үнэт цаасны арилжааны авлага
			881006	Үнэт цаасны арилжааны өглөг
89 Хадгалж буй үнэ бүхий зүйл	8910	Хадгалж буй үнэ бүхий зүйл	891001	Компанийн үндсэн баримт бичгүүд
			891002	Даатгалын баталгаа
			891003	Зураг төсөв
			891004	Газрын зураг
			891005	Үнэт цаас
			891006	Гаргасан тусгай үнэт цаас
			891007	Хэрэглэгдэж буй тамга тэмдэг, лац, ломбо, түлхүүр
			891008	Бусад

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 01 дүгээр сарын
09-ний өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан
“Даатгалын багц дүрэм”-ийн арванхоёрдугаар хавсралт

ДААТГАГЧААС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫХАА ТОДОРХОЙ ХЭСГИЙГ БУСДАД ШИЛЖҮҮЛЭХ БОЛОН НЭГТГЭХ ҮЕД ГАРГАХ ӨРГӨДЛИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмаар Санхүүгийн зохицуулах хороо (цаашид Хороо гэх)-оос тусгай зөвшөөрөл авсан даатгалын компани (цаашид Даатгагч гэх) даатгалын үйл ажиллагааныхаа тодорхой хэсгийг бусдад шилжүүлэх болон нэгтгэх үед гаргах өргөдлийг хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

ХОЁР. ӨРГӨДЛИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. Даатгагч даатгалын үйл ажиллагаагаа шилжүүлэх болон нэгтгэх тухай хүсэлт гаргахдаа дор дурдсан бичиг баримтыг бүрдүүлж Хороонд ирүүлнэ.

2.1.1. Дараах мэдээллийг тусгасан өргөдөл:

а/ шилжүүлэх болон нэгтгэх болсон үндэслэл;

б/ шилжүүлж буй болон нэгтгэж байгаа даатгалын компанийн бүртгэлийн нэр, хаяг;

в/ шилжүүлж буй болон нэгтгэж байгаа даатгалын гэрээний тоо, түүний нэр төрөл, хэлбэр;

г/ шилжүүлэг болон нэгтгэлийн тухай дүгнэлт.

2.1.2. Даатгалын үйл ажиллагааг шилжүүлж байгаа болон нэгтгэн авч байгаа талууд дараах асуудлуудаар хоорондоо тохиролцож байгуулсан гэрээ:

а/ шилжүүлж буй болон нэгтгэж байгаа даатгалын үйл ажиллагааны тухай нарийвчилсан мэдээлэл;

б/ даатгалын үйл ажиллагааг шилжүүлэгч болон нэгтгэн авагч талуудын эрх, үүрэг, даатгуулагчийн өмнө хүлээсэн хариуцлага;

в/ даатгалын үйл ажиллагааг нэгтгэн авч байгаа талын хүлээн зөвшөөрсөн нөхцөл шаардлага, тохиролцоо;

г/ даатгалын үйл ажиллагааг шилжүүлэх болон нэгтгэсний дараа шилжүүлэгч болон нэгтгэн авагч талуудын хооронд үүсэх харилцааны эрх зүйн зохицуулалт, маргааныг шийдвэрлэх арга зам.

2.1.3. Энэхүү журмын 2.1.2-г дурдсан гэрээний хавсралтууд:

а/ шилжүүлж буюу нэгтгэж байгаа даатгалын гэрээнүүдтэй холбоотой даатгалын нэхэмжлэл болон нөөц сангуудын үлдэгдлийг тооцсон аргачлал;

б/ шилжүүлж буюу нэгтгэж байгаа үйл ажиллагаанд хамаарах даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах тухай шилжүүлэгч талын санал;

в/ шилжүүлэх болон нэгтгэх үйл ажиллагааны эхлэх, дуусах хугацаа бүхий

төлөвлөгөө;

г/ шилжүүлж буюу нэгтгэж байгаа даатгалын гэрээнүүдийн жагсаалт, үүнд хамаарах давхар даатгалын гэрээнүүд.

2.1.4. Шилжүүлж байгаа даатгалын үйл ажиллагаатай холбоотой актуарын тайлан.

2.1.5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр.

2.2. Хороо шаардлагатай гэж үзвэл энэ журмын 2.1-г дурдсан бичиг баримтуудаас гадна нэмэлт материал шаардаж болно.

2.3. Хороо энэ журмын 2.1, 2.2-г заасан бичиг баримтуудыг бүрэн гүйцэд бүрдүүлж ирүүлсэн өдрөөс хойш ажлын 15 хоногийн дотор шийдвэр гаргана.

2.4. Даатгалын үйл ажиллагааг шилжүүлэх болон нэгтгэх тухай даатгагчийн хүсэлтийг Хороо зөвшөөрөөгүй тохиолдолд энэ тухай үндэслэл тайлбараа шийдвэр гарснаас хойш ажлын 5 хоногийн дотор даатгагчид бичгээр хүргүүлнэ.

2.5. Даатгалын үйл ажиллагааг шилжүүлэх болон нэгтгэх тухай даатгагчийн хүсэлтийг Хороо зөвшөөрсөн тохиолдол даатгагч ажлын 10 хоногийн дотор дор дурдсан зар мэдээллийг үндэсний өдөр тутмын сонин болон цахим хаягаар дамжуулан олон нийтэд хүргүүлнэ:

2.5.1. даатгалын үйл ажиллагаагаа шилжүүлж байгаа даатгагчийн нэр, хаяг;

2.5.2. даатгалын үйл ажиллагааг нэгтгэн авч байгаа даатгалын компанийн нэр, хаяг;

2.5.3. шилжүүлж байгаа даатгалын гэрээний тоо, даатгалын төрөл ангилал;

2.5.4. даатгалын үйл ажиллагааг шилжүүлж байгаа он, сар, өдөр;

2.5.5. шилжүүлж байгаа даатгалын гэрээнүүдтэй холбогдон гарах нэхэмжлэлийг хүлээн авч барагдуулах арга хэлбэр.

2.6. Даатгалын үйл ажиллагааг шилжүүлэх болон нэгтгэх тухай даатгагчийн хүсэлтийг зөвшөөрсөн Хорооны шийдвэрийг даатгалын үйл ажиллагаагаа шилжүүлж байгаа даатгалын компани хүлээн авсан даруй энэ тухай мэдээллийг шилжүүлэгт хамрагдаж буй даатгуулагчдад ажлын 3 хоногийн дотор хүргүүлнэ.

2.7. Даатгуулагч энэ журмын 2.6-д заасан мэдээллийг хүлээн авсны дараа даатгалын үйл ажиллагааг шилжүүлэх болон нэгтгэхийг зөвшөөрөхгүй байгаа бол энэ тухай хариугаа ажлын 5 хоногийн дотор даатгагч компанид мэдэгдэнэ.

2.8. Даатгуулагч даатгалын үйл ажиллагааг шилжүүлэх болон нэгтгэх тухай мэдээллийг хүлээж авсан өдрөөс хойш ажлын 15 хоногийн дотор даатгагчтай байгуулсан даатгалын анхны гэрээгээ дуусгавар болгож болно.

2.9. Даатгуулагч даатгалын гэрээгээ дуусгавар болгохыг хүсвэл даатгагч дараах зарчмыг баримтлан даатгуулагчид буцаан олголт хийнэ. Үүнд:

2.9.1. ердийн даатгалын гэрээний хувьд гэрээний дагуу даатгуулагчаас төлсөн даатгалын хураамжийн орлогоос даатгалд хамаарагдсан хугацааны зардлыг тооцон хасч, үлдэгдлийг даатгуулагчид буцаан олгоно;

2.9.2. урт хугацааг даатгалын гэрээний хувьд даатгуулагчаас төлсөн хураамжийн орлогыг даатгуулагчид буцаан олгоно.

2.10. Даатгалын үйл ажиллагаагаа нэгтгэж байгаа даатгалын компаниуд даатгалын үйл ажиллагааг шилжүүлэх болон нэгтгэж болох тухай Хорооны шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 30 хоногийн дотор дор дурдсан бичиг баримтыг хоорондоо шилжүүлж дуусгана. Үүнд:

2.10.1. энэ журмын 2.1.3-ын “г”-д заасан даатгалын гэрээнүүд;

2.10.2. энэхүү журмын 2.1.3-т дурдсан баримт бичгүүдтэй холбоотой бүх файлууд;

2.10.3. шилжүүлж байгаа болон нэгтгэж буй даатгалын үйл ажиллагаатай холбоотой нөхөн олговор хийвэл зохих нэхэмжлэлийн холбогдох баримт бичиг, файлууд;

2.10.4. шилжүүлж байгаа даатгалын гэрээнүүдтэй холбоотой даатгалын нөөц сангийн үлдэгдэл.

2.11. Даатгалын үйл ажиллагааг шилжүүлсэн болон нэгтгэж авсан даатгалын компаниуд тухайн үйл ажиллагааг бүрэн дууссан талаар хамтарсан тэмдэглэл үйлдэж Хороонд ирүүлнэ.

ГУРАВ. БУСАД ЗҮЙЛ

3.1. Даатгалын үйл ажиллагааг шилжүүлэх болон нэгтгэх тухай даатгагчийн хүсэлтийг зөвшөөрсөн Хорооны шийдвэр гарсан өдрөөс эхлэн тухайн төрлийн даатгалын үйл ажиллагааг шилжүүлж байгаа даатгалын компани энэ төрлийн даатгалын гэрээг дахин шинээр байгуулахгүй.

3.2. Даатгалын үйл ажиллагааг шилжүүлэх болон нэгтгэх үед даатгагчаас даатгуулагчидтай байгуулсан гэрээнүүдэд ямар нэг нэмэлт өөрчлөлт оруулахгүй.

3.3. Энэ журмыг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.

Санхүүгийн зохицуулах хорооны
2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн
25 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

“Даатгалын багц дүрэм”-ийн
арван гуравдугаар хавсралт

ДААТГАГЧИЙН ДАВХАР ДААТГАЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэ журмын зорилго нь даатгагчийн давхар даатгалын төлөвлөгөө, давхар даатгалын төлөвлөгөөний тайлан, тэдгээрт тавигдах шаардлагыг тодорхойлох, биелэлтэд хяналт тавихтай холбоотой үүсэх харилцааг зохицуулахад оршино.

ХОЁР. ДАВХАР ДААТГАЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХАД БАРИМТЛАХ ЗАРЧИМ

2.1 Даатгагч нь давхар даатгалын төлөвлөгөөтэй байх ба давхар даатгалын төлөвлөгөө нь давхар даатгалын стратеги төлөвлөгөө, давхар даатгалын жилийн төлөвлөгөөнөөс бүрдэнэ.

2.1.1 Давхар даатгалын стратеги төлөвлөгөө нь тухайн даатгагчийн давхар даатгалын бодлогыг тодорхойлох үндсэн баримт бичиг байна. Давхар даатгалын стратеги төлөвлөгөөг даатгагчийн бизнес төлөвлөгөө, эрсдэлийн удирдлагын стратеги, андерайтингийн бодлоготой уялдуулан боловсруулна.

2.1.2 Давхар даатгалын жилийн төлөвлөгөө нь даатгагчийн тухайн жилд хэрэгжүүлэх давхар даатгалын бодлогыг тодорхойлох баримт бичиг байна. Давхар даатгалын жилийн төлөвлөгөөг давхар даатгалын стратеги төлөвлөгөө, даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлттэй уялдуулан жил бүр боловсруулна.

2.2 Даатгагч давхар даатгалын төлөвлөгөөг боловсруулахдаа дараах зарчмыг баримтална.

2.2.1 Давхар даатгалын төлөвлөгөөний зорилго, зорилт, хүрэх үр дүн нь тодорхой, биелэгдэхүйц байх;

2.2.2 Даатгагч нь санхүү, төлбөрийн чадварын байдалдаа тохирсон өөрийн хүлээж болох эрсдэлийн дээд хэмжээг тогтоох ба хэрэв даатгалын тохиолдол болоход гэрээгээр хүлээсэн эрсдэлийн хэмжээ нь өөрийн хүлээж болох эрсдэлийн дээд хэмжээнээс давахаар байвал тухайн даатгалын эрсдэлийн хариуцлагыг давхар даатгагчид заавал даатгуулсан байх;

2.2.3 Даатгагч нь давхар даатгагчид шилжүүлэх даатгалын эрсдэлийн хэмжээг тогтоохдоо давхар даатгагч тус бүрийн гэрээний үүргээ биелүүлэх санхүү, төлбөрийн чадварын байдал болон үйл ажиллагааны туршлагыг харгалзан үзэх;

2.2.4 Даатгагч нь даатгалын эрсдэлээ тараан байршуулах ба тухайн давхар даатгагчийн санхүү, төлбөрийн чадварын байдалд тогтмол хяналт тавих;

2.2.5 Давхар даатгалын гэрээний нөхцөл нь даатгуулагчтай байгуулсан даатгалын гэрээний нөхцөлөөс буурахгүй буюу илүү таатай нөхцөлтэй байх;

2.2.6 Даатгагч нь даатгалын эрсдэлээ тэргүүн ээлжид дотоодын давхар даатгагчид шилжүүлэх талаар санал авч хамтран ажиллах;

2.2.7 Хамтран ажиллах давхар даатгагч, давхар даатгалын зуучлагч нь:

2.2.7.1 Хорооноос давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан давхар даатгагч, давхар даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан даатгалын зуучлагч байх;

2.2.7.2 Гадаад улсад байгуулагдаж, харьяалагдах орны зохицуулалтын байгууллагын хяналтад байдаг, Монгол улсын нутаг дэвсгэрээс гадна давхар даатгагч, давхар даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийг, эсхүл түүнийг төлөөлсөн этгээд:

1/ “A.M.Best Company”-ийн “A”-аас дээш;

2/ “Standard and Poors”, “Filtch Group”-ийн “BBB”-ээс дээш;

3/ “Moody’s corporation”-ийн “Baa”-аас дээш

4/ “Rating Agency Expert RA”-ийн “A”-аас дээш

2.2.7.3 Хэрэв даатгагч нь энэ журмын 2.7.2.1 болон 2.2.7.2-т заасан шаардлагыг аль алийг нь хангахааргүй давхар даатгагч, давхар даатгалын зуучлагчтай хамтран ажиллахаар бол тухайн давхар даатгагч, давхар даатгалын зуучлагчийн дэлгэрэнгүй танилцуулга, сонгох үндэслэл, шаардлагыг давхар даатгалын төлөвлөгөөнд тусгах талаар Хороонд мэдэгдэнэ.

ГУРАВ. ДАВХАР ДААТГАЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

3.1 Давхар даатгалын стратеги төлөвлөгөөнд дараах зүйлсийг тусгасан байх шаардлагатай.
Үүнд:

3.1.1 Давхар даатгалын стратеги төлөвлөгөөний зорилго, зорилт

3.1.2 Даатгагчийн хүлээж болох эрсдэлийн дээд хэмжээ болон давхар даатгагчид шилжүүлэх эрсдэлийн хэмжээг тодорхойлох нөхцөл:

- Улирлын шинжтэй үйл ажиллагаа болон хохирол хамгийн өндөр байх үечлэл;
- Эрсдэл төвлөрсөн байдал (Нэг давхар даатгагч болон нэг газарзүйн бүсчлэлд эрсдэлийг төвлөрүүлэхгүй байх);
- Шаардлагатай бусад.

3.1.3 Давхар даатгалын үйл ажиллагааг хариуцах нэгжийн болон ажилтнуудын эрх, үүрэг, хариуцлага, хэрэгжүүлэх үйл ажиллагаа болон холбогдох бусад нэгж, эрх бүхий ажилтнуудтай хамтран хэрэгжүүлэх арга хэмжээ;

3.1.4 Давхар даатгалын үйл ажиллагаанаас үүдэн гарч болох эрсдэлүүдийн тооцоолол, удирдах арга хэрэгсэл;

3.1.5 Давхар даатгалын төлөвлөгөө, үйл ажиллагаанд хийх дотоодын хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа

3.1.6 Хамтран ажиллах давхар даатгагч, давхар даатгалын зуучлагчийг сонгох дотоод үнэлгээ, арга аргачлал;

3.1.7 Факультатив/даатгагч нь даатгуулагчийн өмнө хүлээсэн эрсдэлийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь даатгалын гэрээ тус бүрээр давхар даатгагчтай тохиролцож давхар даатгуулах үйл ажиллагаа/ давхар даатгалын гэрээ байгуулахад баримтлах бодлого.

3.2 Давхар даатгалын жилийн төлөвлөгөөнд дараах зүйлсийг тусгасан байх шаардлагатай.
Үүнд:

3.2.1 Даатгагчийн хүлээж болох эрсдэлийн дээд хэмжээ болон давхар даатгагчид шилжүүлэх эрсдэлийн хэмжээ (Даатгалын хэлбэр, бүтээгдэхүүн тус бүрээр);

3.2.2 Давхар даатгалын үйл ажиллагаанаас үүдэн гарч болох эрсдэлүүдийг тооцсон үр дүн болон эрсдэлүүдийг удирдах арга хэрэгсэл;

- Даатгалын гэрээ болон давхар даатгалын гэрээний нөхцөлийн зөрүүний талаарх мэдээлэл, түүнийг удирдах арга хэрэгслийг тодорхойлсон байдал;
- Даатгалын нөхөн төлбөр олгох болон давхар даатгалын нөхөн төлбөр олгох үйл ажиллагаа нь цаг хугацааны хувьд хоорондоо тохирохгүй бол шийдвэрлэх арга хэрэгсэл;
- Даатгалын нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсгийг бүтэн жилээр тооцоолсон тооцооллын үр дүн;
- Давхар даатгагчийн санхүү, төлбөрийн чадварын байдлын талаарх мэдээлэл, зээлийн эрсдэлийг тооцсон үр дүн.

3.2.3 Давхар даатгалын үйл ажиллагааг хариуцах нэгж болон ажилтны мэдээлэл;

3.2.4 Факультатив давхар даатгалд хамруулах даатгалын хэлбэр, бүтээгдэхүүн, давхар даатгалын хэмжээ;

3.2.5 Хамтран ажиллах давхар даатгагчийг сонгох үндэслэл, тэдгээрт өгсөн үнэлэлт, дүгнэлт, тэдгээрийн дэлгэрэнгүй мэдээлэл, танилцуулга, хариуцах эрсдэлийн хэмжээ, давхар даатгалын гэрээ байгуулсан байдал;

3.2.6 Давхар даатгалын зуучлагчаар дамжуулан гэрээ байгуулсан тохиолдолд давхар даатгалын зуучлагчийг сонгох үндэслэл, дэлгэрэнгүй мэдээлэл, тэдгээрийн хүлээх үүрэг, хариуцлага.

ДӨРӨВ. ДАВХАР ДААТГАЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ТҮҮНИЙ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

4.1 Даатгагчийн төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/ нь давхар даатгалын төлөвлөгөөг баталж, түүний хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтэд үнэлэлт, дүгнэлт өгч ажиллана.

4.2 Даатгагч нь давхар даатгалын төлөвлөгөөг боловсруулах, түүний хэрэгжилтийг хангах тусгайлсан нэгж /цаашид “нэгж” гэх/-тэй эсхүл давхар даатгалын үйл ажиллагаа хариуцах ажилтантай байна.

4.4 Даатгагч нь давхар даатгалын жилийн төлөвлөгөөг жил бүр боловсруулах ба давхар даатгалын стратеги төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд өөрчлөлт оруулах үндэслэл тайлбараа гаргаж, өөрчлөлт оруулах саналаа ТУЗ-д танилцуулна.

4.5 Давхар даатгагчийн санхүү, төлбөрийн чадварын байдал болон давхар даатгалын гэрээнд аливаа асуудал үүссэн, үүсэж болзошгүй болохыг тогтоосон тохиолдолд нэн даруй ТУЗ-д мэдэгдэж, холбогдох арга хэмжээг авч ажиллана.

ТАВ. ДАВХАР ДААТГАЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАГНАЛ, ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

5.1 Даатгагч нь давхар даатгалын стратеги төлөвлөгөөг батлагдсан болон нэмэлт өөрчлөлт орсноос хойш 14 хоногийн дотор, давхар даатгалын жилийн төлөвлөгөөг энэ журмын 5.3-т заасан тайлангийн хамт тухайн жилийн 01 сарын 15-ны тус тус Хороонд ирүүлнэ.

5.2 Хороо нь даатгагчийн давхар даатгалын төлөвлөгөөг хянаж, Хороонд ирүүлсэн өдрөөс хойш ажлын 20 хоногийн дотор даатгагчид хариуг хүргүүлнэ.

5.3 Давхар даатгалын төлөвлөгөөний тайланд давхар даатгалын эрсдэлийн хэмжээ, хураамж, нөхөн төлбөр, давхар даатгалын үйл ажиллагааны үр дүн тодорхой тусгахаас гадна дараах баримт бичгийг хавсаргана. Үүнд:

5.3.1 ТУЗ-ийн давхар даатгалын жилийн төлөвлөгөөний биелэлтэд өгсөн үнэлэлт, дүгнэлт;

5.3.2 Даатгагчийн давхар даатгалын үйл ажиллагаанд хийсэн дотоод хяналтын тайлан, дүгнэлт;

5.3.3 Давхар даатгалын үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын талаар хийсэн ажлын тайлан;

5.3.4 Хамтран ажилласан давхар даатгагчид өгсөн үнэлэлт дүгнэлт, давхар даатгалын гэрээний талаар;

5.3.5 Даатгалын нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсгийн тайлан /Даатгалын хэлбэр, даатгалын бүтээгдэхүүн тус бүрээр/

5.3.6 Хороо шаардлагатай гэж үзсэн бусад мэдээ тайлан, баримт бичиг.

5.4 Даатгагч энэ журмын 1 болон 2 дугаар хавсралтад заасан мэдээ, тайланг үнэн зөв, бүрэн гүйцэд гаргаж, санхүүгийн тайлангийн хамт улирал бүр Хороонд ирүүлнэ.

5.5 Хороо энэ журмын биелэлтэд хяналт тавьж ажиллах бөгөөд журам зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

“Даатгагчийн давхар даатгалын төлөвлөгөөнд тавигдах шаардлага”-ын 1 дүгээр хавсралт

МАЯГТ СЗХ04153.Факультатив давхар даатгалын гэрээний мэдээлэл

Даатгагчийн нэр 20...оны ... сарын ...-ны өдөр

№	Огноо	Даатгалын гэрээний дугаар	Даатгалын бүтэц/гэхүүн	Даатгалын үйлчилгээ	Даатгалын хураамж	Давхар даатгалын хураамж	Давхар даатгал			Даатгалын даатгалын нөхцөл*			Эрсдэлийн хувь***		Хариуцлагын хязгаар****		Шимтгэл/Commitment	Давхар даатгалд ногдох нөөц сангийн хэмжээ	Нийт нөхөн төлбөр	Үүнээс: Давхар даатгач ас төлгөн нөхөн Шүүд төлбөр			
							Шүүд	Дотоодын зүүчлэгч	Гаднадын зүүчлэгч	Хувь тэнцүүлсэн /proportional/ quota surplus share	Хувь тэнцүүлсэн /proportional/ Stop loss	Хувь тэнцүүлэггүй Excess of loss	Даатгач хариуцах хувь	Давхар даатгач хариуцах хувь	Даатгач хариуцах хувь	Давхар даатгач хариуцах хувь							
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	

Маягт нөхөх завар:

* Даатгалын зуучлагчаар дамжсан эсх- даатгалын зуучлагчаар дамжуулсан тохиолдол зуучлагч компанийн нэрийг бичих; Даатгач давхар даатгагчтай шууд гэрээ байгуулсан тохиолдолд багана 8 ("шууд")-г сонгох ю

** Давхар даатгалын нөхцөл- давхар даатгалын гэрээний нөхцөлийг сонгох ю

***Эрсдэлийн хувь хэмжээ- Давхар даатгагчтай quota share, surplus share нөхцөлөөр гэрээг хийсэн тохиолдолд даатгач болон давхар даатгагчид хариуцах хувь хэмжээг бөглөх. Хэрэв хэд хэдэн давхар даатгач оролцох тохиолдолд хариуцах хэмжээг тус бүрээр мөр нэмэх.

****Хариуцлагын хязгаар- Давхар даатгагчтай stop loss, excess of loss нөхцөлөөр давхар даатгалын гэрээг хийсэн нөхцөлд даатгач, давхар даатгагчийн хариуцлагын дээд хязгаарын хэмжээг бичих

ТАЙЛАН ГАРГАСАН: (Албан тушаал) (Гарын үсэг) (Овог, нэр)

тамга гэмдэг

ТАЙЛАН ГАРГАСАН ХУГАЦАА: 20... оны ... сарын... өдөр

ТАЙЛАН ГАРГАСАН: (Албан тушаал) (Гарын үсэг) (Овог, нэр)

“Даатгагчийн давхар даатгалын төлөвлөгөөнд
тавигдах шаардлага”-ын 2 дугаар хавсралт

МАЯГТ СЗХ04154.Гэрээт давхар даатгалын гэрээний мэдээлэл

Даатгагчийн нэр

20...оны ... сарын ...-ны өдөр

Огноо	Нийт хураамж		Давхар даатгалын хураамжийн хураамжийн төлөх нөхцөл		Даатгалын хураамжийн дүн		Давхар даатгалын нийт хураамж		Давхар даатгалын шимтг			Даатгалын нөхцөл***				Эрсдэл хариуцах хувь****		Хариуцлагын хэмжээ*****			Нөхөн төлгөн нөхөн Нийт нөхөн төлбөр			Давхар даатгалын нийт хураамж сангийн нөхцөл				
	Нийт хураамж	Нэг удаа төлөх	Тухай бүр төлөх	Нийт хураамж	Давхар даатгалын хураамж	Давхар даатгалын дүн	Нийт хураамж	Давхар даатгалын хураамж	Шууд	Дотоодын зүүчлэгч	Гадаадын зүүчлэгч	/Sliding scale/	/Loss corridors/	/Profit commission/	quota share	surplus share	Stop loss	Excess of loss	/non-proportional/ catastrophic loss	Даатгагч	Давхар даатгагч	Даатгагч хариуцах дээд хэмжээ	Давхар даатгагч хариуцах дээд хэмжээ	Нийт нөхөн төлбөр	Давхар даатгагчаас төлбөрийн дүн	Нөхөн төлгөн нөхөн	Давхар даатгалын нийт хураамж сангийн нөхцөл	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26			
Нийт дүн*****																												

* Даатгалын зүүчлэгчээр дамжсан эсэх- даатгалын зүүчлэгчээр дамжуулсан тохиолдолд зуучлагч компанийн нэрийг бичих; Даатгагч давхар даатгагчтай шууд гэрээ байгуулсан тохиолдолд багана 9 (“шуд”)–г сонгох ю

** Даатгалын шимтгэлийн нөхцөл- Хэрэв даатгагч шууд давхар даатгалын компанийн гэрээ байгуулсан тохиолдолд тохирох баганад нийт шимтгэлийн хэмжээг бичих

*** Давхар даатгалын нөхцөл- давхар даатгалын гэрээний нөхцөлийг сонгох ю

**** Эрсдэлийн хариуцах хувь- Давхар даатгалыг “quota share”, “surplus share” нөхцөлөөр хийсэн тохиолдолд “эрсдэлийн хариуцах хувь” (багана 20,21) –г харгалзан бөглөнө.

***** Хариуцлагын хэмжээ- Давхар даатгалыг “stop loss”, “excess of loss” нөхцөлөөр хийсэн тохиолдолд “ хариуцлагын хэмжээ”(багана22,23)–г харгалзан бөглөнө. ***** Нийт дүн- тайлант хугацаа гус бүрийн нийт дүнг гаргана.

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 01 дүгээр сарын
09-ний өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан
“Даатгалын багц дүрэм”-ийн арван дөрөвдүгээр хавсралт

ДАМПУУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬ, КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛИАС ГАДУУР ДААТГАГЧИЙГ ТАТАН БУУЛГАХ, ДАХИН ХӨРӨНГӨЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЯВУУЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ний зөвшөөрлөөр хувьцаа эзэмшигчийн хурлын шийдвэрээр даатгагчийг татан буулгах болон даатгагчийг дахин хөрөнгөжүүлэх үйл ажиллагааг зохицуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

ХОЁР. ДААТГАГЧИЙГ ТАТАН БУУЛГАХ

2.1. Даатгалын тухай хуулийн 78.2-г заасны дагуу даатгагчийг татан буулгана.

ГУРАВ. ХОРООНЫ ЗӨВШӨӨРЛӨӨР ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭРЭЭР ДААТГАГЧИЙГ ТАТАН БУУЛГАХ

3.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр даатгагч татан буулгах тухай хүсэлтээ гаргаж байгаа тохиолдолд даатгагч дараах баримт бичгийг эх хувиар нь эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг Хороонд ирүүлнэ:

3.1.1. Даатгагчийг татан буулгах зөвшөөрөл хүсэх тухай албан бичиг;

3.1.2. Даатгагчийг татан буулгахыг зөвшөөрсөн тухай хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхоор баталсан шийдвэр;

3.1.3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас даатгагчийг татан буулгах комиссыг томилсон тухай шийдвэр болон комиссын гишүүнээр томилуулахаар санал болгож буй этгээдийн нэрсийн жагсаалт, тэднийг шаардлагатай ур чадвар, дадлага туршлагатай болохыг нотлох баримт бичиг;

3.1.4. Даатгагчийг татан буулгах болсон үндэслэл, шалтгааны талаарх тайлбар;

3.1.5. Хууль болон гэрээгээр тогтоосон хугацаа нь дуусгавар болоогүй, хүчин төгөлдөр гэрээг хэрхэн шийдвэрлэсэн тухай санхүүгийн болон бусад нотлох баримт бичиг;

3.1.6. Даатгагч татан буулгах зөвшөөрөл хүссэн тухай шийдвэрийг даатгуулагчдад мэдэгдсэн талаар нотлох баримт бичиг;

3.1.7. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж, аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлан;

3.1.8. Татан буулгах төлөвлөгөө;

3.1.9. Шаардлагатай тохиолдолд Хороо даатгагчаас нэмэлт мэдээ мэдээлэл, баримт шаардаж болно.

3.2. Энэ журмын 3.1.8-д заасан татан буулгах төлөвлөгөөнд дараах зүйлийг тусгасан байна:

3.2.1. Даатгуулагч нараас ирүүлсэн нөхөн олговор болон нэхэмжлэлийн шаардлагыг хэрхэн барагдуулах, түүний хугацаа, дараалал. Нэхэмжлэл гаргах хугацаа нь 3 сараас доошгүй, 6 сараас дээшгүй хугацаа өнгөрсөн байх;

3.2.2. Даатгуулагч нарын эрх ашгийг хамгаалах үүднээс даатгагч гэрээний дагуу даатгуулагчдад олгох ёстой нөхөн олговор, хууль болон гэрээгээр тогтоосон хугацаа нь дуусгавар болоогүй, хүчин төгөлдөр гэрээг бүхэлд нь буюу хэсэгчлэн бусад даатгалын компанид хэрхэн шилжүүлэх талаар:

3.2.2.1. Даатгагч хууль болон гэрээгээр тогтоосон хугацаа нь дуусгавар болоогүй, хүчин төгөлдөр гэрээг шилжүүлэхдээ “Даатгалын багц дүрэм”-ийн 12 дугаар хавсралт “Даатгагчаас үйл ажиллагааныхаа тодорхой хэсгийг бусдад шилжүүлэх болон нэгтгэх үед гаргах өргөдлийг хянан шийдвэрлэх журам”-ын дагуу шилжүүлэх ба гэрээг шилжүүлэн авч буй даатгагч Хорооны зөвшөөрөл авсан байна.

3.3. Гэрээний үлдэгдлийг шилжүүлэн авах даатгагч байхгүй тохиолдолд даатгуулагч нэг бүртэй харилцан тохирч, гэрээг байгуулах үеийн төгрөгийн ханшийг бууруулахгүйгээр даатгалын хураамжийг даатгуулагчид буцаан олгож, гэрээний үлдэгдлийг эцэслэн шийдвэрлэсэн байх шаардлагатай.

3.4. Татан буулгах төлөвлөгөөний хэрэгжилтэд Хорооны Ажлын алба хяналт тавина.

3.5. Татан буулгах төлөвлөгөөг хэрэгжүүлж дууссан тухай тайланг Даатгалын тухай хуулийн 79 дугаар зүйлийн 79.3-т заасан татан буулгах комисс гаргаж, Хороонд танилцуулна.

3.6. Даатгагчийг татан буулгах тухай компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор энэ журмын 3.1-д заасан баримт бичгийг бүрдүүлэн Хороонд хандана.

3.7. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр Хороонд хандаж татан буулгах тухай хүсэлт гаргасан даатгагчийг шийдвэр гарсан өдрөөс хойш шинээр даатгалын гэрээ байгуулж болохгүй.

3.8. Даатгагчаас Хороонд ирүүлсэн татан буулгах тухай хүсэлт, баримт бичгийн үнэн зөвийг тэдгээрт гарын үсэг зурсан албан тушаалтан хариуцна.

3.9. Энэ журмын 3.1-д заасны дагуу Даатгагчаас Хороонд хандаж гаргасан хүсэлтийг Хороо ажлын 21 өдрийн дотор хянаж шийдвэрлэнэ.

3.10. Энэ журмын 3.1-д заасан баримт бичгийг бүрэн гүйцэд, үнэн зөв бүрдүүлж Хороонд ирүүлсэн өдрөөс эхэлж шийдвэрлэх хугацааг тооцно.

3.11. Хороо дараах тохиолдолд компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр даатгагчийг татан буулгахаас татгалзана:

3.11.1. Даатгагчийг татан буулгах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр нь хууль тогтоомж зөрчсөн, даатгуулагчийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхөөр бол;

3.11.2. Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт нь Хорооноос баталсан даатгалын компанийн төлбөрийн чадварыг тооцох, түүнд хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулсан холбогдох журамд заасан шаардлагыг хангаагүй;

3.11.3. Даатгуулагчтай байгуулсан гэрээний үлдэгдлийг шийдвэрлэж дуусаагүй бол;

3.11.4. Татан буулгах комиссын гишүүнээр томилуулахаар санал болгож буй этгээд нь ийнхүү ажиллахад шаардлагатай ур чадвар, дадлага туршлагагүй.

ДӨРӨВ. ДААТГАГЧИЙГ ДАХИН ХӨРӨНГӨЖҮҮЛЭХ

4.1. Даатгагчийг дахин хөрөнгөжүүлэх тухай төлөвлөгөөг Дампуурлын тухай хуулийн 23.1-т заасан этгээд гаргаж болно.

4.2. Энэ журмын 4.1-т заасан даатгагчийг дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргаж буй этгээд

дараах баримт бичгийг эх хувиар, эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг Хороонд ирүүлнэ:

4.2.1. Даатгагчийг дахин хөрөнгөжүүлэх гэж буй этгээдийн хөрөнгөжүүлэх тухай хүсэлт, дэлгэрэнгүй анкет;

4.2.2. Даатгагчийг дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө;

4.2.3. Дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр хууль ёсны орлогоос бүрдсэн болохыг нотлох баримт бичиг, гарал үүслийн тодорхойлолт;

4.2.4. Хүсэлт гаргасан этгээдийн өр төлбөртэй эсэхийг тодорхойлсон татварын албаны болон банкны өр барагдуулах албаны тодорхойлолт;

4.2.5. Хөрөнгөжүүлэх гэж буй этгээдийн арилжааны банканд өр төлбөртэй эсэхийг тодорхойлсон Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт;

4.3. Энэ журмын 4.2.2-т заасан дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөнд Дампуурлын тухай хуулийн 24.2-т заасан үйл ажиллагааг тодорхой тусгана.

4.4. Шаардлагатай тохиолдолд Хороо хүсэлт гаргагчаас нэмэлт мэдээ мэдээлэл, баримт шаардаж болно.

4.5. Хороо дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргагчаас ирүүлсэн дахин хөрөнгөжүүлэх тухай хүсэлт болон төлөвлөгөөг зөвшөөрөх эсэх асуудлыг Хороо 30 хоногийн дотор хянаж шийдвэрлэнэ.

4.6. Хороо дараах үндэслэлээр дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөнд зөвшөөрөл өгөхөөс татгалзана:

4.6.1. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх нь даатгуулагчдын эрх ашигт сөргөөр нөлөөлөхөөр бол;

4.6.2. Ирүүлсэн баримт бичиг нь холбогдох хууль, журамд заасан шаардлага хангаагүй.

ДОЛОО. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

7.1. Хороо нь энэ журмын биелэлтэд хяналт тавих бөгөөд зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 01 дүгээр сарын
09-ний өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан
“Даатгалын багц дүрэм”-ийн арвантавдугаар хавсралт

ДААТГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТҮР ЗОГСООХ НӨХЦӨЛ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ноос Даатгалын тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1.1-д заасан даатгагчийн даатгалын тодорхой ангилал, төрөл, хэлбэрийн үйл ажиллагаа эрхлэхийг түр зогсоохтой холбогдон үүссэн харилцааг зохицуулахад оршино.

ХОЁР. ДААТГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТҮР ЗОГСООХ НӨХЦӨЛ

2.1. Хороо дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд даатгагчийн үйл ажиллагааг түр зогсоох даалгавар өгнө.

2.1.1. Даатгуулагчдын болон олон нийтийн эрх ашиг, сонирхолд хохирол учруулахуйц нөхцөл байдал бий болсон;

2.1.2. Хорооноос даатгагчийг төлбөрийн чадваргүй болсон, эсхүл төлбөрийн чадваргүй болж болзошгүй гэж дүгнэсэн;

2.1.3. Даатгалын тухай хуулийн 73 дугаар зүйлд заасны дагуу Хорооноос өгсөн даалгаврыг даатгагч биелүүлээгүй, эсхүл биелүүлэх хугацаа хэтэрсэн;

2.1.4. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зөрчсөн, эсхүл тусгай зөвшөөрлийг хуурамч баримт бичиг бүрдүүлж авсан байж болзошгүй гэдгийг шалгах шаардлагатай болсон;

2.1.5. Даатгалын компанийн хөрөнгө оруулагч, даатгагчийн эрх бүхий албан тушаалтан, компанийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг дангаараа буюу бусад этгээдтэй хамтран эзэмшдэг этгээдийг тус тус тохиромжтой бус этгээд гэж үзсэн;

2.1.6. Даатгагч нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангаа зохих ёсоор хөтлөөгүйгээс болж Хороонд хуурамч мэдээлэл өгсөн;

2.1.7. Холбогдох этгээдийн үйл ажиллагааг шалгах явцад Хороотой хамтран ажиллахаас татгалзсан;

2.1.8. Даатгалын эрсдэлээ хязгаарлах зорилгоор давхар даатгалын төлөвлөгөө хийгээгүй, эсхүл давхар даатгалын төлөвлөгөө нь даатгалын багц дүрэмд заасан шаардлага хангаагүй;

2.1.9. Бизнес төлөвлөгөөг дагаж мөрдөөгүй буюу хамгийн сүүлд баталсан бизнесийн болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны төлөвлөгөөг ноцтойгоор зөрчсөн;

2.1.10. Даатгалын тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу Хорооноос томилогдсон шалгагч даатгагчийн үйл ажиллагааг түр зогсоох тухай дүгнэлт гаргасан;

2.1.11. Хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

ГУРАВ. ДААТГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТҮР ЗОГСООХ ХУГАЦАА

3.1. Даатгагчийн үйл ажиллагааг дараах хугацаагаар түр зогсоох даалгавар өгнө.

3.1.1. Хорооноос тогтоосон хугацаагаар;

3.1.2. Хорооноос өгсөн хугацаатай үүрэг даалгавар болон Хорооноос томилогдсон шалгагчийн тавьсан шаардлагыг биелүүлэх хүртэл.

3.2. Даатгагчийн үйл ажиллагааг түр зогсоох хугацаа нь 6 сар хүртэл байна.

ДӨРӨВ. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

4.1. Энэ журмын биелэлтэд Хорооны Ажлын алба хяналт тавьж ажиллах бөгөөд зөрчсөн этгээдэд Даатгалын тухай хууль болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 01 дүгээр сарын
09-ний өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан
“Даатгалын багц дүрэм”-ийн арванзургаадугаар хавсралт

ДААТГАЛТАЙ ХОЛБООТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТОДОРХОЙЛОХ ЗААВАР

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэ журмын зорилго нь Даатгалын тухай хуульд заасны дагуу даатгалын болон түүнтэй холбоотой үйл ажиллагааг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Даатгагч нь Монгол Улсад болон гадаад улсад гагцхүү даатгалын үйл ажиллагаа болон түүнтэй холбоотой үйл ажиллагаа эрхэлнэ.

ХОЁР. ДААТГАЛТАЙ ХОЛБООТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. “Даатгалын үйл ажиллагаа” гэж Даатгалын тухай хуулийн 4.1.1-д заасан үйл ажиллагааг ойлгоно. Даатгалын гэрээний хугацаа даатгуулагчидтай харилцан тохиролцсон хугацаагаар үргэлжилнэ.

2.2. Ердийн даатгагч нь зөвхөн ердийн даатгалын хэлбэрээр, урт хугацааны даатгагч нь зөвхөн урт хугацааны даатгалын хэлбэрээр үйл ажиллагаа эрхэлнэ.

2.3. Даатгалтай холбоотой үйл ажиллагаанд дараах үйл ажиллагааг хамааруулна:

2.3.1. Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөөр олгогдсон даатгагч даатгалын хэлбэрт хамаарагдах даатгалын бүтээгдэхүүний гэрээ, даатгалын баталгаа боловсруулж гаргах;

2.3.2. Монгол Улсын Иргэний хуулийн 431 дүгээр зүйлд заасны дагуу даатгалын гэрээ байгуулах, гэрээг сунгах, өөрчлөх;

2.3.3. Даатгалын гэрээг бусдад шилжүүлэх, цуцлах;

2.3.4. Даатгалын гэрээнд заасны дагуу даатгалын нөхөн төлбөр төлөх;

2.3.5. Даатгалын эрсдэлийн болон хохирлын судалгаа, шинжилгээ, тойм үнэлгээ хийх;

2.3.6. Хорооноос баталсан журмын дагуу даатгалын нөөц сан байгуулах, хуваарилах;

2.3.7. Даатгалын хураамжийн тооцоолол түүнтэй холбоотой аливаа судалгаа хийх;

2.3.8. Даатгалын бүтээгдэхүүн, эрсдэл тус бүрээр актуарын тооцоололд шаардлагатай нарийвчилсан даатгалын мэдээллийн сан үүсгэж, баяжуулах;

2.3.9. Даатгалын үйл ажиллагааны журам, заавар боловсруулах;

2.3.10. Даатгагчийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан мэдээ гаргах зэрэгтэй холбоотой даатгалын үйл ажиллагаа явуулах;

2.3.11. Даатгалын салбар, төлөөлөгчийн газар нээж, ажиллуулах;

2.3.12. Хорооноос баталсан журамд заасан хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулах;

2.3.13. Даатгалын эрсдэлээ давхар даатгуулах, түүнтэй холбоотой үүсч болох бусад үйл ажиллагаа явуулах;

2.3.14. Даатгалын зөвлөгөө, сургалт явуулах;

2.3.15. Даатгагч хоорондын даатгалын гэрээ шилжүүлэх үйл ажиллагаа;

2.3.16. Даатгалын үйл ажиллагаа явуулахтай холбоотой даатгалын мэргэжлийн

оролцогчид болон бусад хувь хүн, хуулийн этгээдтэй хуулийн дагуу хамтран ажиллах гэрээ, хэлцэл хийх;

2.3.17. Холбогдох хууль, тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад үйл ажиллагаа эрхлэх.

2.3.18. Нийгмийн даатгалын болон иргэний эрүүл мэндийн албан журмын даатгалын үйл ажиллагаа, даатгалын зуучлагч, даатгалын төлөөлөгч, даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа, даатгалын аудитын үйл ажиллагаа нь даатгалын болон түүнтэй холбоотой үйл ажиллагаанд хамаарахгүй.

2.4. Хороо Даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх зорилгоор даатгал, түүнтэй холбоотой үйл ажиллагааны талаарх мэдээлэл, баримт бичгийг даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогч, даатгагч даатгалын мэргэжлийн оролцогчийн холбогдох этгээд болон түүнтэй холбоотой этгээдээс гаргаж өгөхийг шаардаж болно.

ГУРАВ. ДААТГАГЧИЙН БОЛОН ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН ХОЛБОГДОХ ЭТГЭЭДТЭЙ ХОЛБООТОЙ ЭТГЭЭДИЙГ ТОДОРХОЙЛОХ

3.1. Даатгалын тухай хуулийн 65.3, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 34.3-т тус тус заасан “холбоотой этгээд” гэж Даатгалын тухай хуулийн 61.1 болон Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 30.1-д тус тус заасан даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн холбогдох этгээдтэй холбоотой дараах этгээдийг хэлнэ. Үүнд:

3.1.1. Хувь нийлүүлэгч болон хувьцаа эзэмшигч;

3.1.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга;

3.1.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн;

3.1.4. Гүйцэтгэх удирдлага;

3.1.5. Хорооноос холбоотой этгээд гэж үзсэн бусад этгээд.

3.2. Энэ зааврын 3.1.1-д заасан этгээдэд даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч, эсхүл даатгагч байсан болон даатгалын мэргэжлийн оролцогч байсан этгээд, эсхүл тэдгээрийн хараат болон охин компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцааны хяналтын багцыг эзэмшиж буй этгээд, эсхүл эдгээр компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө болон хувьцааны хяналтын багцыг эзэмшиж байсан этгээд хамаарна.

3.3. Энэ зааврын 3.1.2, 3.1.3-т заасан этгээдэд даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч, эсхүл даатгагч байсан болон даатгалын мэргэжлийн оролцогч байсан этгээд, эсхүл тэдгээрийн хараат болон охин компанийн ТУЗ-ийн дарга, гишүүнээр сонгогдон ажиллаж байгаа, эсхүл үүнээс өмнө эдгээр компанийн ТУЗ-ийн дарга, гишүүнээр сонгогдож байсан этгээд хамаарна.

3.4. Энэ зааврын 3.1.4-д заасан этгээдэд даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч, эсхүл даатгагч байсан болон даатгалын мэргэжлийн оролцогч байсан этгээд, эсхүл тэдгээрийн хараат болон охин компанийн гүйцэтгэх захирал, дэд захирал, ерөнхий менежер, ерөнхий нягтлан бодогч зэрэг удирдах албан тушаалд томилогдон ажиллаж байгаа, эсхүл үүнээс өмнө эдгээр компанийн гүйцэтгэх захирал, дэд захирал, ерөнхий менежер, ерөнхий нягтлан бодогч зэрэг удирдах албан тушаалд томилогдон ажиллаж байсан этгээд хамаарна.

ДӨРӨВ. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

4.1. Энэхүү журмыг зөрчсөн буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 01 дүгээр сарын
09-ний өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан
“Даатгалын багц дүрэм”-ийн арвандолоодугаар хавсралт

ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН МЭДЭЭЛЛИЙГ ХЭВЛЭН НИЙТЛЭХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэ журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ноос Даатгалын тухай хууль болон Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд заасан мэдээллийг нийтэд мэдээлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

ХОЁР. ХУУЛЬД ЗААСАН МЭДЭЭЛЛИЙГ НИЙТЭД МЭДЭЭЛЭХ

2.1. Хороо нь Даатгалын тухай хуулийн 20.9, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 11.7-д тус тус заасны дагуу даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан этгээдийн талаар бүртгэл хөтөлж, түүнд гарсан өөрчлөлтийн тухай мэдээллийг Хорооны шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор олон нийтэд мэдээлнэ.

2.2. Хороо нь Даатгалын тухай хуулийн 71.3, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 38.8, 39.5-д тус тус заасны дагуу даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон тухай мэдээллийг Хорооны шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор олон нийтэд мэдээлнэ.

2.3. Хороо нь Даатгалын тухай хуулийн 33.3-д заасны дагуу даатгалын үйл ажиллагаа эрхлэх этгээдийн санхүүгийн тайланг баталгаажуулах эрх бүхий аудиторын бүртгэл хийж, түүнд гарсан өөрчлөлтийн талаар мэдээллийг Хорооны шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор олон нийтэд мэдээлнэ.

2.4. Хороо нь Даатгалын тухай хуулийн 39.3-д заасны дагуу актуарчийн эрх авсан этгээдийн бүртгэл хийж, түүнд гарсан өөрчлөлтийн талаар Хорооны шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор олон нийтэд мэдээлнэ.

ГУРАВ. БУСАД

3.1. Энэ журмын 2.1-2.4-т заасан мэдээллийг Хорооны цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэнэ.

3.2. Хорооноос даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон талаар нийтэд мэдээлснийхээ төлөө тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өмнө хариуцлага хүлээхгүй.

Санхүүгийн зохицуулах хорооны
2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн
25 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт

“Даатгалын багц дүрэм”-ийн
арван наймдугаар хавсралт

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ АВАХ ХҮСЭЛТ ГАРГАХАД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, маягтыг бөглөх, бүрдүүлэх заавар, баримт бичигт тавигдах шаардлагыг тодорхойлоход оршино.

1.2. Энэхүү журамд заасан баримт бичгийн жагсаалтаас гадна Хороо шаардлагатай гэж үзвэл үйл ажиллагааны онцлогтой нь холбогдуулан нарийвчилсан тодруулга болон нэмэлт баримт бичгийг ирүүлэх шаардлага тавьж болох бөгөөд уг шаардлагыг хангасан байна.

1.3. Өргөдөл гаргагч нь тусгай зөвшөөрлийн өргөдлийн маягтыг цаасан хэлбэрээр болон Хорооны цахим хуудас дахь “зөвшөөрлийн систем”-ээр дамжуулан Хороонд ирүүлнэ.

ХОЁР. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ АВАХ ХҮСЭЛТ ГАРГАХАД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

2.1. Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт:

2.1.1. Ердийн болон урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүсэлтийг энэ журмын 3 дугаар хавсралтад заасан заавар болон СЗХ04001 өргөдлийн маягтын дагуу гаргаж, энэ журмын 2 дугаар хавсралт (А)-ын 1-16-д дурдсан баримт бичгүүдийг бүрдүүлж Хороонд ирүүлнэ.

2.1.2. Давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүсэлтийг энэ журмын 3 дугаар хавсралтад заасан заавар болон СЗХ04001 өргөдлийн маягтын дагуу гаргаж, энэ журмын 2 дугаар хавсралт (А)-ын 1-17-д дурдсан баримт бичгүүдийг бүрдүүлж Хороонд ирүүлнэ.

2.1.3. Хороо энэ журмын 2.1.1-2.1.2-д заасны дагуу өргөдөл гаргагчаас ирүүлсэн хүсэлт, баримт бичгүүдийн бүрдэл хангагдсан өдрөөс хойш Даатгалын тухай хууль болон бусад холбогдох хуулийн дагуу хянаж, тусгай зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ.

2.2. Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт:

2.2.1. Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүсэлтийг энэ журмын 3 дугаар хавсралтад заасан заавар болон СЗХ04001 өргөдлийн маягтын дагуу гаргаж, энэ журмын 2 дугаар хавсралт (А)-ын 1-14, 18-20-д дурдсан баримт бичгүүдийг бүрдүүлж Хороонд ирүүлнэ.

2.2.2. Даатгалын зуучлагч нь Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий банк байж болох бөгөөд банк нь даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн

хүсэлтийг энэ журмын 3 дугаар хавсралтад заасан заавар болон СЗХ04001 өргөдлийн маягтын дагуу гаргаж, энэ журмын 2 дугаар хавсралт (А)-ын 1-14, 18-23-д дурдсан баримт бичгүүдийг бүрдүүлж Хороонд ирүүлнэ.

2.2.3. Даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүсэлтийг энэ журмын 3 дугаар хавсралтад заасан заавар болон СЗХ04001 өргөдлийн маягтын дагуу гаргаж, энэ журмын 2 дугаар хавсралт (А)-ын 1-14, 18, 24-25-д дурдсан баримт бичгүүдийг бүрдүүлж Хороонд ирүүлнэ.

2.2.4. Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь иргэн бол энэ журмын 3 дугаар хавсралтад заасан зааврын дагуу СЗХ04002 өргөдлийн маягтыг бөглөж, энэ журмын 2 дугаар хавсралт (Б)-ын 1-4-д дурдсан баримт бичгүүдийг бүрдүүлж Хороонд ирүүлнэ.

2.2.5. Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь хуулийн этгээд бол энэ журмын 3 дугаар хавсралтад заасан зааврын дагуу СЗХ04002 өргөдлийн маягтыг бөглөж, энэ журмын 2 дугаар хавсралт (Б)-ын 1-3, 5-7-д дурдсан баримт бичгүүдийг бүрдүүлж Хороонд ирүүлнэ.

2.2.6. Хороо энэ журмын 2.2.1-2.2.5-д заасны дагуу өргөдөл гаргагчаас ирүүлсэн хүсэлт, баримт бичгүүдийн бүрдэл хангагдсан өдрөөс хойш Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль болон бусад холбогдох хуулийн дагуу хянаж, тусгай зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ.



“Тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт”-ын 1 дүгээр хавсралт (А)

Маягт СЗХ04001

ДААТГАЛЫН БОЛОН ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ, ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ӨРГӨДӨЛ

Тусгай зөвшөөрлийн төрөл, хэлбэрийн мэдээлэл							
1	Өргөдөл гаргасан огноо	Он		Сар		Өдөр	
2	Өргөдөл гаргагч хуулийн этгээдийн нэр						
3	Өмнө нь санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж байсан эсэх	Тийм <input type="checkbox"/> бол үйл ажиллагааны төрлийг бичнэ үү.				Үгүй <input type="checkbox"/>	
4						/5 луу шилжих/	
5	Өмнө нь даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл ирүүлж байсан эсэх	Тийм <input type="checkbox"/> бол /6,7-г бөглөх/ тусгай зөвшөөрлийн төрлийг бичнэ үү.				Үгүй <input type="checkbox"/>	
6						/8 луу шилжих/	
7		Тусгай зөвшөөрөл	олгогдсон <input type="checkbox"/>	олгогдоогүй <input type="checkbox"/>			
8	Даатгалын үйл ажиллагаа	<input type="checkbox"/> Ердийн даатгал /9-г бөглөх/ <input type="checkbox"/> Урт хугацааны даатгал /10-г бөглөх/ <input type="checkbox"/> Давхар даатгал					
	Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа	<input type="checkbox"/> Даатгалын зуучлагч, үүнээс: <input type="checkbox"/> Ердийн даатгалын зуучлагч <input type="checkbox"/> Урт хугацааны даатгалын зуучлагч <input type="checkbox"/> Давхар даатгалын зуучлагч <input type="checkbox"/> Даатгалын хохирол үнэлэгч					
Тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхлэх даатгалын хэлбэрийг сонгоно уу.							
9	<input type="checkbox"/> Ердийн даатгалын хэлбэр	<input type="checkbox"/> Гэнэтийн осол, эмчилгээний даатгал <input type="checkbox"/> Хөрөнгийн даатгал <input type="checkbox"/> Автотээврийн хэрэгслийн даатгал <input type="checkbox"/> Ачааны даатгал <input type="checkbox"/> Барилга угсралтын даатгал <input type="checkbox"/> Газар тариалангийн даатгал <input type="checkbox"/> Мал амьтдын даатгал <input type="checkbox"/> Агаарын хөлгийн даатгал <input type="checkbox"/> Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал <input type="checkbox"/> Хариуцлагын даатгал <input type="checkbox"/> Санхүүгийн даатгал <input type="checkbox"/> Зээлийн даатгал <input type="checkbox"/> Итгэлцлийн даатгал <input type="checkbox"/> Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн					

		даатгал <input type="checkbox"/> Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал <input type="checkbox"/> Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал
10	<input type="checkbox"/> Урт хугацааны даатгалын хэлбэр	<input type="checkbox"/> Хугацаат амьдралын даатгал <input type="checkbox"/> Насан туршийн даатгал <input type="checkbox"/> Хуримтлалын даатгал <input type="checkbox"/> Тэтгэврийн даатгал <input type="checkbox"/> Эрүүл мэндийн даатгал <input type="checkbox"/> Аннуити даатгал
11	<input type="checkbox"/> Албан журмын даатгалын хэлбэр	<input type="checkbox"/> Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал
Тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн мэдээлэл		
12	Хуулийн этгээдийн нэр	Монгол Англи (Хуулийн этгээдийн нэрийг латин үсгээр галиглан бичих)
13	Оноосон нэрд орсон өөрчлөлт /хэрэв өөрчлөгдөж байсан бол/	Нэр _____ Хэзээнээс ____ / ____ / ____ хүртэл ____ / ____ / ____ (Оноосон нэр өөрчлөгдсөн бол өмнөх нэрийг бүтэн бичиж, хэзээнээс хэдий хүртэл тухайн нэр ашиглагдсан талаарх хугацааг он/сар/өдөр дарааллаар бичих)
14	Үүсгэн байгуулагдсан огноо	Он _____ Сар _____ Өдөр _____
15	Хуулийн этгээдийн хэлбэр	<input type="checkbox"/> Хувьцаат компани <input type="checkbox"/> Хязгаарлагдмал хариуцлагатай компани
16	Хөрөнгө оруулалтын хэлбэр	<input type="checkbox"/> Дотоодын хөрөнгө оруулалттай <input type="checkbox"/> Гадаадын хөрөнгө оруулалттай Гадаадын ХО-ын хувь _____
17	Улсын бүртгэлийн дугаар	
18	Регистрийн дугаар	
19	Хаяг байршил	Аймаг/ хот _____
		Сум/дүүрэг _____
		Баг/хороо _____
		Гудамж, байр _____
		Тоот _____
20	Холбоо барих утас	Суурин _____ Гар утас _____ Факс _____
21	Цахим хуудас	
	Цахим шуудангийн хаяг	

	Нийгмийн сүлжээний хаяг				
Банкин дахь харилцах, хадгаламжийн мэдээлэл:					
22	<input type="checkbox"/> Харилцах	Банкны нэр			
		Дансны дугаар			
		Үлдэгдэл /₮/			
	<input type="checkbox"/> Хадгаламж	Банкны нэр			
		Дансны дугаар			
		Үлдэгдэл /₮/			
Хувь нийлүүлсэн хөрөнгийн талаарх мэдээлэл:					
23	Хувьцаа эзэмшигчдийн овог нэр/ оноосон нэр	Хувьцааны тоо (ш), төрлөөр		ХНХ-н хэмжээ (₮)	ХНХ-д эзлэх хувь (%)
		Давуу эрхтэй	Энгийн		
24	Компанийн нэгдлийн оролцогч эсэх	Тийм <input type="checkbox"/> /25-г бөглөх/		Үгүй <input type="checkbox"/> /26 луу шилжих/	
25	Оноосон нэр	Регистрийн дугаар	Үйл ажиллагааны төрөл	Тусгай зөвшөөрөл хүсэгчтэй ямар холбоотой болох	
Удирдлага боловсон хүчинтэй холбоотой мэдээлэл:					
26	ТУЗ-тэй байх эсэх	Үгүй <input type="checkbox"/> /27 луу шилжих/	Тийм <input type="checkbox"/>	Бүрэлдэхүүний тоо	
27	Дотоод хяналтын нэгжтэй байх эсэх	Үгүй <input type="checkbox"/> /28 луу шилжих/	Тийм <input type="checkbox"/>	Бүрэлдэхүүний тоо	
28	Нийт ажилтан, албан хаагчдын тоо				
29	Даатгалын мэргэжлийн боловсон хүчний тоо			Үүнээс даатгалын актуарчийн тоо /даатгалын үйл ажиллагаа эрхлэх бол/	
30	Ажлын байрын мэдээлэл:	Худалдаж авсан <input type="checkbox"/>	Түрээсэлсэн <input type="checkbox"/>	Бусад <input type="checkbox"/>	

<i>Ашиглах техник тоног төхөөрөмж, программ хангамжийн мэдээлэл</i>					
31	Техник, тоног төхөөрөмжийн нэр төрөл	Техникийн үзүүлэлт	Худалдан авсан Түрээсэлсэн /аль нь болохыг бичих/	Тоо ширхэг	Үнэ ₮
32	Программ хангамжийн нэр төрөл	Программын зориулалт	Худалдан авсан Түрээсэлсэн /аль нь болохыг бичих/	Тоо ширхэг	Үнэ ₮
<i>Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтийн төлөвлөлт</i>					
33	Үзүүлэлтүүд		Он	Он	Он
	Нийт хөрөнгө	₮			
	Хувь нийлүүлсэн хөрөнгө	₮			
	Нийт орлого	₮			
	Нийт зардал	₮			
	Ашиг	₮			
34	<i>Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн бол дараах нэмэлт үзүүлэлтүүдийг хүснэгтэд тусгана уу.</i>				
	Нийт даатгалын үнэлгээний дүн	₮			
	Нийт даатгалын хураамжийн орлого	₮			
	Даатгалын нөхөн төлбөрийн хэмжээ	₮			
	Хохирол нөхөлтийн харьцаа				
	Даатгалын бус үйл ажиллагааны орлого	₮			
	Давхар даатгалын үнэлгээний дүн	₮			
	Давхар даатгалын хураамж	₮			
Давхар даатгалаас олгох нөхөн төлбөр	₮				

Монгол улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Даатгалын багц дүрэмд нийцүүлэн даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад шаардагдах баримт бичгийг үнэн зөв бүрдүүлж, хүргүүлэв. Бүрдүүлсэн баримт бичигт ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Манай өргөдөл, баримт бичгийг хүлээн авч, хянан шийдвэрлэж, даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгоно уу.

Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авснаас хойших хугацаанд Монгол улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, болон бусад холбогдох хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажиллах болно.

Өргөдөл гаргасан:

Овог, нэр

албан тушаал

гарын үсэг

огноо

Тамга:



“Тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт”-ын 1 дүгээр хавсралт (Б)

Маягт СЗХ04002

ДААТГАЛЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ӨРГӨДӨЛ

Эрхлэх үйл ажиллагааны мэдээлэл							
1	Өргөдөл гаргасан огноо	Он		Сар		Өдөр	
2	Өргөдөл гаргагчийн овог нэр, оноосон нэр						
3	Өмнө нь санхүүгийн салбарт ажиллаж /үйл ажиллагаа явуулж/байсан эсэх	Тийм <input type="checkbox"/> бол үйл ажиллагааны төрлийг бичнэ үү.				Үгүй <input type="checkbox"/> /5 луу шилжих/	
4							
5	Өмнө нь тусгай зөвшөөрөл авах хүсэлт ирүүлж байсан эсэх	Тийм <input type="checkbox"/> бол /6,7-г бөглөх/ тусгай зөвшөөрлийн төрлийг бичнэ үү.				Үгүй <input type="checkbox"/> /6 луу шилжих/	
6							
7		Тусгай зөвшөөрөл	олгогдсон <input type="checkbox"/>	олгогдоогүй <input type="checkbox"/>			
Тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхлэх сайн дурын даатгалын хэлбэрийг сонгоно уу.							
8	<input type="checkbox"/> Ердийн даатгалын хэлбэр	<input type="checkbox"/> Гэнэтийн осол, эмчилгээний даатгал <input type="checkbox"/> Хөрөнгийн даатгал <input type="checkbox"/> Автотээврийн хэрэгслийн даатгал <input type="checkbox"/> Ачааны даатгал <input type="checkbox"/> Барилга угсралтын даатгал <input type="checkbox"/> Газар тариалангийн даатгал <input type="checkbox"/> Мал амьтдын даатгал <input type="checkbox"/> Агаарын хөлгийн даатгал <input type="checkbox"/> Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал <input type="checkbox"/> Хариуцлагын даатгал <input type="checkbox"/> Санхүүгийн даатгал <input type="checkbox"/> Зээлийн даатгал <input type="checkbox"/> Итгэлцлийн даатгал <input type="checkbox"/> Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал <input type="checkbox"/> Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал <input type="checkbox"/> Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал					
	<input type="checkbox"/> Урт хугацааны даатгалын хэлбэр	<input type="checkbox"/> Хугацаат амьдралын даатгал <input type="checkbox"/> Насан туршийн даатгал					

		<input type="checkbox"/> Хуримтлалын даатгал <input type="checkbox"/> Тэтгэврийн даатгал <input type="checkbox"/> Эрүүл мэндийн даатгал <input type="checkbox"/> Аннуити даатгал			
	<input type="checkbox"/> Албан журмын даатгалын хэлбэр	<input type="checkbox"/> Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал			
9	Өргөдөл гаргагч нь	<input type="checkbox"/> иргэн /10-19-г бөглөх/	<input type="checkbox"/> хуулийн этгээд /20-32-г бөглөх/		
Тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхлэх иргэний мэдээлэл					
10	Овог				
11	Нэр				
12	Регистрийн дугаар				
13	Албан ёсны хаяг байршил				
14	Эрхэлж байгаа ажил, албан тушаал				
15	Ажлын хаяг				
16	Эзэмшсэн мэргэжил				
17	Утасны дугаар				
18	Цахим шуудангийн хаяг				
19	Мэргэжлийн сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэн эсэх	Тийм <input type="checkbox"/>		Үгүй <input type="checkbox"/>	
Тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн мэдээлэл					
20	Хуулийн этгээдийн нэр	Монгол Англи (Хуулийн этгээдийн нэрийг латин үсгээр галиглан бичих)			
21	Оноосон нэрд орсон өөрчлөлт /хэрэв өөрчлөгдөж байсан бол/	Нэр _____ Хэзээнээс ____ / ____ / ____ хүртэл ____ / ____ / ____ (Оноосон нэр өөрчлөгдсөн бол өмнөх нэрийг бүтэн бичиж, хэзээнээс хэдий хүртэл тухайн нэр ашиглагдсан талаарх хугацааг он/сар/өдөр дарааллаар бичих)			
22	Үүсгэн байгуулагдсан огноо	Он		Сар	Өдөр
23	Хуулийн этгээдийн хэлбэр	<input type="checkbox"/> Хувьцаат компани		<input type="checkbox"/> Хязгаарлагдмал хариуцлагатай компани	<input type="checkbox"/> Хадгаламж зээлийн хоршоо
24	Хөрөнгө оруулалтын хэлбэр	<input type="checkbox"/> Дотоодын хөрөнгө оруулалттай		<input type="checkbox"/> Гадаадын хөрөнгө оруулалттай Гадаадын ХО-ын хувь	
25	Улсын бүртгэлийн дугаар				
26	Регистрийн дугаар				
27	Хаяг байршил	Аймаг/ хот			
Сум/дүүрэг					
Баг/хороо					

		<input type="checkbox"/> Хуримтлалын даатгал <input type="checkbox"/> Тэтгэврийн даатгал <input type="checkbox"/> Эрүүл мэндийн даатгал <input type="checkbox"/> Аннуити даатгал			
	<input type="checkbox"/> Албан журмын даатгалын хэлбэр	<input type="checkbox"/> Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал			
9	Өргөдөл гаргагч нь	<input type="checkbox"/> иргэн /10-19-г бөглөх/	<input type="checkbox"/> хуулийн этгээд /20-32-г бөглөх/		
Тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхлэх иргэний мэдээлэл					
10	Овог				
11	Нэр				
12	Регистрийн дугаар				
13	Албан ёсны хаяг байршил				
14	Эрхэлж байгаа ажил, албан тушаал				
15	Ажлын хаяг				
16	Эзэмшсэн мэргэжил				
17	Утасны дугаар				
18	Цахим шуудангийн хаяг				
19	Мэргэжлийн сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэн эсэх	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>		
Тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн мэдээлэл					
20	Хуулийн этгээдийн нэр	Монгол Англи (Хуулийн этгээдийн нэрийг латин үсгээр галиглан бичих)			
21	Оноосон нэрд орсон өөрчлөлт /хэрэв өөрчлөгдөж байсан бол/	Нэр _____ Хэзээнээс ____ / ____ / ____ хүртэл ____ / ____ / ____ (Оноосон нэр өөрчлөгдсөн бол өмнөх нэрийг бүтэн бичиж, хэзээнээс хэдий хүртэл тухайн нэр ашиглагдсан талаарх хугацааг он/сар/өдөр дарааллаар бичих)			
22	Үүсгэн байгуулагдсан огноо	Он		Сар	Өдөр
23	Хуулийн этгээдийн хэлбэр	<input type="checkbox"/> Хувьцаат компани	<input type="checkbox"/> Хязгаарлагдмал хариуцлагатай компани		<input type="checkbox"/> Хадгаламж зээлийн хоршоо
24	Хөрөнгө оруулалтын хэлбэр	<input type="checkbox"/> Дотоодын хөрөнгө оруулалттай	<input type="checkbox"/> Гадаадын хөрөнгө оруулалттай Гадаадын ХО-ын хувь		
25	Улсын бүртгэлийн дугаар				
26	Регистрийн дугаар				
27	Хаяг байршил	Аймаг/ хот			
		Сум/дүүрэг			
		Баг/хороо			

		Гудамж, байр				
		Тоот				
28	Холбоо барих утас	Суурин		Гар утас	Факс	
29	Цахим хуудас					
	Цахим шуудангийн хаяг					
	Нийгмийн сүлжээний хаяг					
Хувь нийлүүлсэн хөрөнгийн талаарх мэдээлэл:						
30	Хувьцаа эзэмшигч \ гишүүд \-ийн овог нэр/ оноосон нэр			ХНХ-н хэмжээ (₮)	ХНХ-д эзлэх хувь (%)	
Удирдлага боловсон хүчинтэй холбоотой мэдээлэл:						
31	Нийт ажилтан, албан хаагчдын тоо					
32	Албан тушаал	Овог	Нэр	Регистрийн дугаар	Харьяала	Мэргэжлийн сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэн эсэх
						Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/>

Монгол улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Даатгалын багц дүрэмд нийцүүлэн даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад шаардагдах баримт бичгийг үнэн зөв бүрдүүлж, хүргүүлэв. Бүрдүүлсэн баримт бичигт ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Манай өргөдөл, баримт бичгийг хүлээн авч, хянан шийдвэрлэж, даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгоно уу.

Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авснаас хойших хугацаанд Монгол улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, болон бусад холбогдох хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажиллах болно.

Өргөдөл гаргасан:

Овог, нэр

албан тушаал

гарын үсэг

огноо

Тамга:



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

“Тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт”-ын 2 дугаар хавсралт (А)

Маягт СЗХ04001

ДААТГАЛЫН БОЛОН ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ, ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ӨРГӨДӨЛД (МАЯГТ СЗХ04001) ХАВСАРГАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо	Албан хэрэгцээнд
1	Компани байгуулах, даатгалын эсхүл даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, эрх бүхий этгээдийн шийдвэр		
2	Улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар		
3	Компанийн дүрмийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, компанийн шинэчилсэн дүрмийн төсөл		
4	Хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгийг хууль ёсны орлогоос бүрдсэнийг нотлох баримт		
5	Хувьцаа эзэмшигч бүрийн ”Даатгалын багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-д заасан СЗХ04005 маягтын дагуу бөглөсөн хувьцаа эзэмшигчийн тодорхойлолт		
6	Компанийн эрх бүхий албан тушаалтан болон даатгалын андеррайтер, актуарчийн иргэний цахим үнэмлэх, мэргэжлийн дипломын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар;		
7	Хорооноос баталсан Тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан баримт бичиг		
8	Ажлын байрны үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, эсхүл түрээсийн гэрээний хуулбар, техник тоног төхөөрөмж, программ хангамжийн талаарх танилцуулга, холбогдох материал		
9	3-аас доошгүй жилийн бизнес төлөвлөгөө		
10	Жилийн эцсийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан / эхлэлтийн тайлан		
11	”Даатгалын багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-д заасан СЗХ04006 маягтын дагуу бөглөсөн компанийн эрх бүхий албан тушаалтан болон мэргэжлийн боловсон хүчний тодорхойлолт		
12	Боловсон хүчин нь тухайн даатгалын хэлбэрээр мэргэшсэнийг нотлох баримт		
13	Дотоод үйл ажиллагааны журмын төсөл		
14	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14.1-д заасан дотоод хяналтын хөтөлбөр		
Ердийн болон урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд 1-14 дугаартай баримт бичгүүдээс гадна дараах баримт бичгүүдийг хавсаргана:			
15	”Даатгалын багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-д заасан СЗХ04004 маягтын дагуу бөглөсөн даатгалын хэлбэрийг бүртгүүлэх өргөдөл, мөн СЗХ04008 маягтын дагуу бөглөсөн 2-оос доошгүй даатгалын бүтээгдэхүүний мэдээлэл		
16	”Даатгалын багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-д тусгагдсан даатгалын бүтээгдэхүүн боловсруулах журмын төсөл.		

Давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд 1-16 дугаартай баримт бичгүүдээс гадна дараах баримт бичгүүдийг хавсаргана:			
17	Давхар даатгагчийн боловсон хүчин нь давхар даатгалын чиглэлээр мэргэшсэнийг нотлох баримт		
Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд 1-14 дугаартай баримт бичгүүдээс гадна дараах баримт бичгүүдийг хавсаргана:			
18	Мэргэжлийн хариуцлагын даатгалын гэрээний төсөл		
19	2-оос доошгүй даатгалын компанитай хамтран ажиллах даатгалын зуучлалын гэрээний төсөл		
20	Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх ажилтны Хороо холбогдох мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулсан тухайн эрхлэх үйл ажиллагааны чиглэлийн мэргэшлийн сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэнийг нотлох баримт		
Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд өргөдөл гаргагч нь банк бол 1-14, 18-20 дугаартай баримт бичгүүдээс гадна дараах баримт бичгүүдийг хавсаргана:			
21	Тус банкиг даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэхэд татгалзахгүй тухай Монгол банкнаас ирүүлсэн баримт бичиг		
22	Даатгалын зуучлагчийн үйл ажиллагааг хариуцах 2-оос доошгүй орон тооны ажилтан бүхий тусгайлсан нэгжийг байгуулсан буюу томилсон тухай шийдвэрийн хуулбар, тухайн нэгжийн танилцуулга болон банкны бүтцийг харуулсан бүдүүвч зураг		
23	Хамтран ажиллах даатгагч бүр дээр даатгалын зуучлагчийн үйл ажиллагаатай холбогдон гарах гүйлгээ хийгдэх тусдаа данс байхыг нотлох баримт		
Даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд 1-14, 18 дугаартай баримт бичгүүдээс гадна дараах баримт бичгүүдийг хавсаргана:			
24	Эрхлэх даатгалын хэлбэрийн хохирлын үнэлгээний чиглэлээр үнэлгээчин нь мэргэшсэн гэдгийг нотлох баримт /Хөрөнгийн үнэлгээний тусгай зөвшөөрлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар/		
25	Сонгосон даатгалын хэлбэрээр хохирлын үнэлгээ хийх судалгаа, мэдээллийн сангийн танилцуулга		
26	Даатгалын хохирол үнэлгээ хийх ажилтны Хороо холбогдох мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулсан тухайн эрхлэх үйл ажиллагааны чиглэлийн мэргэшлийн сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэнийг нотлох баримт		



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

“Тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт”-ын 2 дугаар хавсралт (Б)

Маягт СЗХ04001

ДААТГАЛЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСТАЙ ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ӨРГӨДӨЛД (МАЯГТ СЗХ04002) ХАВСАРГАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо	Албан хэрэгцээнд
1	Даатгагчтай хамтран ажиллах гэрээний төсөл		
2	Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн даатгалын төлөөлөгчийн сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцээнийг нотлох баримт		
Өргөдөл гаргагч нь иргэн бол 1-2 дугаартай баримт бичгүүдээс гадна дараах баримт бичгийг хавсаргана:			
3	Нийгмийн даатгалын дэвтрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар		
4	Өргөдөл гаргагчийн иргэний цахим үнэмлэх		
Өргөдөл гаргагч нь хуулийн этгээд бол 1-2 дугаартай баримт бичгүүдээс гадна дараах баримт бичгүүдийг хавсаргана:			
5	Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тухай эрх бүхий этгээдийн шийдвэр		
6	Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар		
7	Хуулийн этгээдийн дүрмийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, шинэчилсэн дүрмийн төсөл		
	Нийт		

“Тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт”-ын 3 дугаар хавсралт

ДААТГАЛЫН БОЛОН ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ӨРГӨДЛИЙН МАЯГТЫГ БӨГЛӨХ, БАРИМТ БИЧГИЙГ БҮРДҮҮЛЭХ ЗААВАР

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү зааврын зорилго нь даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн өргөдлийн маягтыг бөглөх, тэдгээрт хавсаргах баримт бичигт тавигдах шаардлагыг тодорхойлоход оршино.

1.2. Тусгай зөвшөөрлийн өргөдлийн маягтыг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ны цахим хуудас дахь (www.fgc.mn) “зөвшөөрлийн цахим систем”-д хандаж бөглөнө. Өргөдлийн маягтыг цаасан хэлбэрээр бөглөхдөө Хорооны цахим хуудаснаас маягтыг татаж авна.

1.3. Маягтыг бөглөхдөө техникийн үзүүлэлт, компанийн хэлбэрээс бусад тохиолдолд товчлол хэрэглэхгүй, овог нэр, оноосон нэр, он сар өдрийг бүтэн бичиж, хариулт сонголттой тохиолдолд тохирох нүдэнд “√” тэмдгийг тавина.

1.4. Гадаад улсад үүсгэн байгуулагдсан /гадаад улсад бүртгэлтэй/ хуулийн этгээдийн оноосон нэрийг түүний албан ёсны латин үсгээр бичигдсэн нэр болон Монгол үсгээр галиглан бичсэн нэрээр, регистрийн дугаарыг тухайн улсын бүртгэлийн албанаас олгосон бүртгэлийн дугаараар бичнэ.

1.5. Гадаад улсын иргэний талаарх мэдээллийг оруулахдаа овог нэрийг латин үсгээр бичиж, регистрийн дугаар хэсэгт гадаад паспортын дугаарыг бөглөнө.

1.6. Маягтыг бөглөхдөө шаардлагатай тохиолдолд хүснэгтийн тохирох хэсэгт үндсэн маягтын бүтцийн хүрээнд мөр, багана нэмж болно.

1.7. Маягтад дурдсан мэдээлэл тус бүрийн мөрийн дугаар болон хавсаргах баримт бичгийн жагсаалт дахь харгалзах дугаарын дагуу зааварчилгааг тусгасан болно.

1.8. Өргөдөл, тодорхойлолт гаргагч нь хуулийн этгээд бол тухайн өргөдөл, тодорхойлолт гаргагчийн эрх бүхий албан тушаалтан өргөдөл, тодорхойлолтод овог нэр, албан тушаал, өргөдөл, тодорхойлолт гаргасан огноог бичиж, гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулна. Иргэн бол өөрийн овог нэр, өргөдөл, тодорхойлолт гаргасан огноог бичиж, гарын үсэг зурж баталгаажуулна.

1.9. Өргөдөл, тодорхойлолтын маягтад гадаад валютыг өргөдөл, тодорхойлолт гаргаж буй өдрийн Монголбанкны албан ханшаар төгрөгт шилжүүлэн илэрхийлнэ.

1.10. Бизнес төлөвлөгөөг энэ журмын 4 дүгээр хавсралт “Бизнес төлөвлөгөө боловсруулах зөвлөмж”-ийн дагуу, дотоод үйл ажиллагааны журмыг энэ журмын 5 дугаар хавсралт “Дотоод үйл ажиллагааны журам боловсруулах зөвлөмж”-ийн дагуу, эхлэлтийн тайланг энэ журмын 6 дугаар хавсралтын дагуу тус тус гаргана.

ХОЁР. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ӨРГӨДЛИЙН МАЯГТЫГ БӨГЛӨХ, БАРИМТ БИЧГИЙГ БҮРДҮҮЛЭХ

2.1. Тусгай зөвшөөрлийн өргөдлийн СЗХ04001 маягтыг бөглөх, түүнд хавсаргах баримт бичгийг бүрдүүлэх

2.1.1. Тусгай зөвшөөрлийн өргөдлийн СЗХ04001 маягтыг бөглөх

Тусгай зөвшөөрлийн төрөл, хэлбэрийн мэдээлэл

- 1) Өргөдөл гаргасан огноо: Он, сар өдөр гэсэн дарааллаар тоогоор бичнэ.
- 2) Өргөдөл гаргагч хуулийн этгээдийн нэр: Үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээн дэх оноосон нэрийг бичнэ.
- 3) Өмнө нь санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаагүй бол үгүй гэсэн сонголтыг хийж 5 дугаар мөр лүү шилжинэ.
- 4) 3 дугаар мөрөнд тийм гэсэн хариултыг сонгосон бол 4 дүгээр мөрөнд үйл ажиллагааны төрлийг бичнэ.
- 5) Өмнө нь Хороонд даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн өргөдөл ирүүлж байгаагүй бол үгүй гэсэн сонголтыг хийж, 8 дугаар мөр лүү шилжинэ.
- 6) 5 дугаар мөрөнд тийм гэсэн хариултыг сонгосон бол 6 дугаар мөрөнд өмнө нь хүсэлт ирүүлж байсан тусгай зөвшөөрлийн төрлийг бичнэ.
- 7) 7 дугаар мөрөнд тусгай зөвшөөрөл олгогдсон эсэхээс хамааран тохирох сонголтыг хийнэ.
- 8) Тусгай зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааны төрлийг сонгоно. Үйл ажиллагааны төрлийг сонгохын өмнө Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн тусгай зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах тухай холбогдох хэсгийг уншиж танилцана уу.
- 9) Ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэхээр сонгосон бол 9 дүгээр мөрөөс эрхлэх даатгалын хэлбэрийг сонгоно.
- 10) Урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэхээр сонгосон бол 10 дугаар мөрөөс эрхлэх даатгалын хэлбэрийг сонгоно.
- 11) Даатгалын мэргэжлийн оролцогч нь эрхлэх үйл ажиллагааны төрлийг сонгосны дараа 9, 10, 11 дугаартай мөрүүдээс эрхлэх даатгалын хэлбэрийг сонгоно.

Тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн мэдээлэл

- 12) Оноосон нэр: Монгол – хуулийн этгээдийн нэрийг кирилл үсгээр, бүтэн бичнэ.
Англи – хуулийн этгээдийн нэрийг латин үсгээр галиглан бичнэ.
- 13) Хэрэв хуулийн этгээдийн оноосон нэр өөрчлөгдөж байсан бол өмнөх нэрийг бүтэн бичиж, хэзээнээс хэдий хүртэл тухайн нэр ашиглагдсан талаарх хугацааг он, сар, өдөр гэсэн дарааллаар бичих
- 14) Хуулийн этгээдийн үүсгэн байгуулсан хурлын огноог он, сар, өдөр гэсэн дарааллаар бичнэ.
- 15) Хуулийн этгээдийн хэлбэр: ХК-хувьцааг компани, ХХК- Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн аль нь болохыг сонгоно.
- 16) Хөрөнгө оруулалтын хэлбэрээс тохирох нүдийг сонгож, гадаадын хөрөнгө оруулалттай бол нийт хувьцааны хэдэн хувийг гадаадын хөрөнгө оруулагч
Дотоодын хөрөнгө оруулалттай компани гэдэгт нийт хувьцааг /100 хувь/ Монгол улсын иргэн , Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээд эзэмшдэг,
Гадаадын хөрөнгө оруулалттай компани гэдэгт нийт гаргасан хувьцааны 25 буюу түүнээс дээш хувийг гадаадын хөрөнгө оруулагч эзэмшиж байгаа бөгөөд гадаадын хөрөнгө оруулагч тус бүрийн оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ 100 мянган ам.доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс дээш байх аж ахуй нэгжийг тус тус ойлгоно.
- 17) Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээн дэх улсын бүртгэлийн дугаарыг бичнэ.
- 18) Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээн дэх регистрийн дугаарыг бичнэ.

- 19) Хаяг байршил: Хуулийн этгээдийн одоо байршиж байгаа эсхүл байршихаар гэрээ байгуулсан байрны хаягийг хүснэгтийн дагуу дэлгэрэнгүй бичнэ.
- 20) Холбоо барих утас: Хуулийн этгээдийн холбоо барих суурин, гар утас, факсын дугаарыг бичнэ.
- 21) Цахим хуудас: Хуулийн этгээдийн албан ёсны цахим хуудсыг бичнэ. Цахим шуудангийн хаяг: Хуулийн этгээдийн цахим шуудангийн хаягийг бичнэ.
Нийгмийн сүлжээний хаяг: www.twitter.com, www.facebook.com гэх мэт олон нийтийн сүлжээн дэх хаягийг бичнэ.

Банкин дахь харилцах, хадгаламжийн мэдээлэл

- 22) Дансны төрлийг сонгож, банкны нэр, дансны дугаар, дансны валютын төрлийг бичиж, холбогдох дансны үлдэгдлийг тухайн өдрийн Монголбанкны албан ханшаар тооцон төгрөгөөр илэрхийлнэ.

Хувь нийлүүлсэн хөрөнгийн талаарх мэдээлэл

- 23) Хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч бүрээр хүснэгт дэх мэдээллийг бөглөнө.
 - Хувьцаа эзэмшигчдийн овог нэр/ оноосон нэр хэсэгт хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол түүний оноосон нэрийг, иргэн бол иргэний овог нэрийг бичнэ.
 - Харьяалал хэсэгт хувьцаа эзэмшигчийн харьяалагдах улсыг мөрийн дагуу харгалзуулан бичнэ.
 - Хувьцааны тоо хэсэгт тухайн хувьцаа эзэмшигчийн нийт эзэмшиж буй хувьцааны тоог бичиж, хувьцааны төрлүүдээс сонголтыг хийнэ.
 - ХНХ-н хэмжээ хэсэгт тухайн хувьцаа эзэмшигчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг төгрөгөөр илэрхийлэн, дараагийн хэсэгт энэхүү хөрөнгө нь нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн хэчнээн хувийг бүрдүүлж байгааг зуутын орны /таслалаас хойш 2 орны/ нарийвчлалтайгаар тусгана. /Жишээ нь 50.85 %/
- 24) Компанийн тухай хуулийн 6.13-т заасан компанийн нэгдлийн оролцогч биш бол үгүй гэсэн хариултыг сонгон 26 дугаар мөр лүү шилжинэ.
- 25) 24 дүгээр мөрөнд тийм гэсэн хариултыг сонгосон бол 25 дугаар мөрөнд компанийн нэгдлийн оролцогч бүрийн оноосон нэрийг хуулийн этгээдийн хэлбэрийн хамт оноосон нэр хэсэгт бичиж, регистрийн дугаар, үйл ажиллагааны төрлийг бичнэ.
 - Тусгай зөвшөөрөл хүсэгчтэй ямар холбоотой болох хэсэгт толгой компани, хараат компани, охин компани, зэргэлдээ компани, үүнээс ч илүү үргэлжилсэн хэлхээ холбоонд компанийн нэгдлийн оролцогч гэж бичнэ.

Удирдлага боловсон хүчинтэй холбоотой мэдээлэл

- 26) Даатгалын үйл ажиллагаа эрхлэх бол Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний тоог харгалзах мөрний дагуу бичнэ.
Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх бол Төлөөлөн удирдах зөвлөлтэй байх бол тийм гэсэн хариултыг сонгон, зөвлөлийн бүрэлдэхүүний тоог бичнэ. Үгүй гэсэн хариултыг сонгосон бол 27 дугаар мөр лүү шилжинэ.
- 27) Даатгалын үйл ажиллагаа эрхлэх бол дотоод хяналтын нэгжийн бүрэлдэхүүний тоог харгалзах мөрний дагуу бичнэ.
Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх бол Дотоод хяналтын нэгжтэй байх бол тийм гэсэн хариултыг сонгон, нэгжийн бүрэлдэхүүний тоог бичнэ. Үгүй гэсэн хариултыг сонгосон бол 28 дугаар мөр лүү шилжинэ.

- 28) Нийт ажилтан албан хаагчдын тоо хэсэгт хуулийн этгээдтэй хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллах болон ажиллаж буй нийт ажилтны тоог бичнэ.
- 29) Даатгалын үйл ажиллагаа эрхлэх бол даатгалын андеррайтер, актуарч, даатгалын борлуулалт болон нөхөн төлбөр хариуцсан ажилтан, даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх бол даатгалын зуучлалын борлуулалтын ажилтан, даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх бол хөрөнгийн үнэлгээчин гэх мэт мэргэжлийн боловсон хүчний тоог нэгтгэн гаргаж даатгалын мэргэжлийн боловсон хүчний тоо мөрөнд бичих бөгөөд даатгалын үйл ажиллагаа эрхлэх бол даатгалын актуарчийн тоог бичнэ.
- 30) Ажлын байрны мэдээлэл хэсэгт тухайн ажлын байрыг худалдаж авсан, түрээсэлсэн аль нь болохыг сонгоно.

Ашиглах техник, тоног төхөөрөмж, программ хангамжийн мэдээлэл

- 31) Үйл ажиллагаанд ашиглагдах техник тоног төхөөрөмжийг нэр, төрөл бүрээр түүний хүчин чадал, багтаамж, тоо ширхэг, үнийн талаарх мэдээллийг хүснэгт дэх асуулгын дагуу нөхөх ба тухайн тоног төхөөрөмжийг худалдаж авсан түрээсэлсэн аль нь болохыг сонгоно. Тоног төхөөрөмжийн үнэ нь худалдан авсан өртөг байна.
- 32) Программ хангамжийн зориулалт баганад тухайн программыг ямар зориулалтаар ашиглах талаар бичнэ. Жишээ нь: нягтлан бодох бүртгэл, даатгалын мэдээллийн санд мэдээ өгч, авах, өдөр тутмын мэдээ, мэдээлэл боловсруулах гэх мэт.

Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтийн төлөвлөлт

- 33) Компанийн нийт хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгө, нийт орлого, зардал, цэвэр ашгийн хэмжээг тооцон, дараалсан 3 жилээр тухайн оны дүнг төгрөгөөр илэрхийлэн бичих бөгөөд энэ нь бизнес төлөвлөгөөнд тусгагдсантай ижил байна.
- 34) Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн бол 33, 34 дүгээр мөрөнд үзүүлэлтүүдийг бөглөнө. “Хохирол нөхөлтийн харьцаа” үзүүлэлтээс бусад үзүүлэлтийг төгрөгөөр илэрхийлэх бөгөөд дараалсан 3 жилээр тухайн оны дүнг төлөвлөсөн дүнг бичнэ. Энэ нь бизнес төлөвлөгөөнд тусгагдсантай ижил байна.

2.1.2. Тусгай зөвшөөрлийн өргөдлийн СЗХ04001 маягтын дагуу гаргасан өргөдөлд хавсаргах баримт бичигт тавигдах шаардлага

1. Нэгээс дээш үүсгэн байгуулагч нийлж компанийг байгуулж байгаа бол компани байгуулж, холбогдох тусгай зөвшөөрөл хүссэн үйл ажиллагаа эрхлэх тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр эсхүл Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолын эх хувь, эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, нэг үүсгэн байгуулагчтай бол компани үүсгэн байгуулах шийдвэр, эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбар.
2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, түүний хавсралтын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар.
3. Улсын бүртгэлийн албанд бүртгүүлсэн компанийн дүрмийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
4. Компанийн дүрмийн санд хувьцаа эзэмшигч нарын оруулсан мөнгөн хөрөнгийн эх үүсвэр нь хууль ёсны орлогын эх үүсвэрээс бүрдсэн болохыг нотлох баримт бичиг. Хэрвээ баримт бичгийн эх хувийг хавсаргах боломжгүй бол нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг хавсаргана. /Ногдол ашиг хуваарилсан талаарх шийдвэр, төлбөрийн баримт, дансны хуулга, худалдаж худалдан авах гэрээ, бэлэглэлийн гэрээ, нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, хадгаламжийн дэвтрийн хуулбар гэх мэт/.

5. Өргөдөл гаргагчийн нийт энгийн хувьцааны 10 ба түүнээс дээш хувийг дангаараа болон бусад этгээдтэй хамтран эзэмшдэг этгээд бүр Даатгалын багц дүрэм"-ийн нэгдүгээр хавсралт "Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт"-ийн 3 дугаар хавсралтад заасан зааврын дагуу маягт СЗХ04005-г бөглөж, хувьцаа эзэмшигчийн тодорхойлолтыг гаргана. Тодорхойлолтод хувьцаа эзэмшигчийн иргэний цахим үнэмлэх (хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ), эрхэлж буй ажил, албан тушаалыг нотлох баримтыг хавсаргана. (тухайлбал нийгмийн даатгалын дэвтэр, албан байгууллагын тодорхойлолт гэх мэт..).
6. Компанийн эрх бүхий албан тушаалтан болон мэргэжлийн /даатгалын борлуулалтын ажилтан, даатгалын менежер, даатгалын нөхөн төлбөрийн ахлах ажилтан, даатгалын актуарч, даатгалын андеррайтер гэх мэт/ боловсон хүчний иргэний үнэмлэхийн гэрчлүүлсэн хуулбар. Тэдгээрийн мэргэжлийн /даатгал, санхүү, эдийн засаг болон бусад/ диплом, мэргэшлийн үнэмлэх, гэрчилгээ мөн нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар болон даатгалын байгууллагад ажиллаж байсан бол тус байгууллагын гаргасан тодорхойлолт.
7. Хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох шалгуурт тусгагдсан баримт бичиг.
8. Ажлын байрыг худалдан авсан бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, түрээсэлсэн бол түрээсийн гэрээний хуулбар, техник тоног төхөөрөмж, программ хангамжийн талаарх танилцуулга, холбогдох материал.
9. Энэ журмын 7 дугаар хавсралт "Бизнес төлөвлөгөө боловсруулах зөвлөмж"-ийн дагуу гаргасан 3-аас доошгүй жилийн бизнес төлөвлөгөө.
10. Тусгай зөвшөөрлийн өргөдөл гаргахаас өмнө 1 жилээс доошгүй хугацаагаар үйл ажиллагаа эрхэлж байсан бол жилийн эцсийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан, үйл ажиллагаа эрхэлж байгаагүй бол эхлэлтийн тайлан.
11. Даатгалын багц дүрэм"-ийн нэгдүгээр хавсралт "Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт"-ийн 3 дугаар хавсралтад заасан зааврын дагуу маягт СЗХ04006-г өргөдөл гаргагчийн эрх бүхий албан тушаалтан болон мэргэжлийн боловсон хүчин бүр бөглөж, эрх бүхий албан тушаалтан болон боловсон хүчний тодорхойлолтыг гаргана. Компанийн эрх бүхий албан тушаалтан гэдэгт 84.1-т заасан буюу компанийн дүрэмд заасан эрх бүхий албан тушаалтныг ойлгоно.
12. Эрхлэх даатгалын хэлбэрээр мэргэшсэн буюу өмнө нь даатгалын байгууллагад тухайн даатгалын хэлбэрийн даатгалын бүтээгдэхүүнтэй холбогдох үйл ажиллагааг хариуцан 1-ээс доошгүй жил ажилласан /даатгалын байгууллагын чиглэлээс хамааран даатгалын гэрээг байгуулах, борлуулах, тухайн даатгалын хэлбэрийн хохирлын үнэлгээг хийх гэх мэт/ эсхүл тухайн даатгалын хэлбэрийн болон хөтөлбөрт нь тус даатгалын хэлбэрийн талаарх хичээл багтсан сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэнийг нотлох баримт.
13. Энэ журмын 8 дугаар хавсралт "Дотоод үйл ажиллагааны журам боловсруулах зөвлөмж"-ийн дагуу гаргасан дотоод үйл ажиллагааны журмын төсөл.
14. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14.1 дэх хэсэгт заасны дагуу боловсруулсан дотоод хяналтын хөтөлбөр буюу:
 - сэжигтэй гүйлгээг илрүүлэх, мэдээллийн нууцлалыг хадгалах, Санхүүгийн мэдээллийн алба болон эрх бүхий бусад байгууллагад мэдээлэл өгөх, баримт бичиг шилжүүлэх журам;
 - мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомж болон дээрх журмын хэрэгжилтэд хяналт тавих ажилтныг томилох, чөлөөлөх журам, түүний эрх,

үүрэг;

- хяналт тавих ажилтныг мэргэшүүлэх сургалтад хамруулах төлөвлөгөө, арга хэмжээ

-өөрийн харилцагч, үйлчилгээ, бүтээгдэхүүний мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлж, өндөр эрсдэлтэй харилцагч, үйлчилгээ, бүтээгдэхүүнийг онцгой анхаарахад чиглэсэн арга хэмжээний цогц хөтөлбөр.

Дотоод хяналтын хөтөлбөрийг боловсруулахдаа Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Монголбанкны ерөнхийлөгчийн 2019 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А-26 тоот тушаалаар батлагдсан “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам”, Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан холбогдох гарын авлагуудтай сайтар танилцсан байвал зохино.

15. “Даатгалын багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-д заасан СЗХ04004 маягтын дагуу бөглөсөн даатгалын хэлбэрийг бүртгүүлэх хүсэлт, хавсаргах барим бичгүүд, мөн СЗХ04008 маягтын дагуу бөглөсөн 2-оос доошгүй даатгалын бүтээгдэхүүнд тавигдах шаардлагыг хангасан зах зээлд борлуулах даатгалын бүтээгдэхүүний мэдэгдэл.
16. “Даатгалын багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-д заасан үйлчлүүлэгч, даатгуулагчийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн, судалгаа, хөгжүүлэлт, актуар тооцоолол, дотоод хяналтын үйл ажиллагааг нарийвчлан тусгасан даатгалын бүтээгдэхүүн боловсруулах журам.
17. Давхар даатгалын чиглэлээр мэргэшсэн буюу өмнө нь даатгалын байгууллагад давхар даатгалын үйл ажиллагааг хариуцан 2-оос доошгүй жил ажилласан, эсхүл давхар даатгалын чиглэлийн албан ёсны сургалтад хамрагдаж байсныг нотлох баримт.
18. “Даатгалын багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-д заасан мэргэжлийн хариуцлагын доод хэмжээний хязгаараас багагүй хэмжээний даатгалын үнэлгээтэй мэргэжлийн хариуцлагын даатгалын гэрээний төсөл.
19. Хоёроос доошгүй даатгалын компанитай байгуулах хамтран ажиллах гэрээний төсөл. Хамтран ажиллах гэрээний төсөлд дараах зүйлийг тусгана:
 - Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 26.1 дэх хэсэгт заасны дагуу даатгалын хураамжийн орлогыг даатгагчийн дансанд шуурхай шилжүүлэх ажиллагааны зохицуулалт;
 - хамтран ажиллах даатгагч бүрийн нэр дээр данс нээх талаарх зохицуулалт; /Хэрвээ банк бол/
 - даатгалын хураамж төлөгдсөнөөр даатгалын гэрээ байгуулагдсанд тооцож, даатгалын тохиолдол гарахад даатгалын хураамжийн орлого даатгагчийн дансанд шилжсэн эсэхээс үл хамааран даатгагч даатгуулагчид нөхөн төлбөр олгох талаарх зохицуулалт;
20. Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх ажилтан нь Хороо, холбогдох мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулсан зохион байгуулсан даатгалын зуучлалын сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэнийг нотлох баримт. Энэ нь шалгалтад тэнцсэнээс хойш хоёр жилийн хугацаанд хүчинтэй байна.
21. Банкны тухай хуулийн 6.4-т заасны дагуу даатгалын зуучлагчийн үйл ажиллагааг эрхлэхэд татгалзахгүй тухайгаа мэдэгдэж Монголбанкнаас Хороонд ирүүлсэн албан бичиг.
22. Даатгалын зуучлагчийн үйл ажиллагааг хариуцах 2-оос доошгүй орон тооны ажилтан бүхий тусгайлсан нэгжийг байгуулсан буюу томилсон тухай шийдвэрийн хуулбар, тухайн нэгжийн

танилцуулга болон банкны бүтцийг харуулсан бүдүүвч зураг

23. Хамтран ажиллах даатгагч бүр дээр даатгалын зуучлалын үйл ажиллагаатай холбогдон гарах гүйлгээ хийгдэх данс нээснийг нотлох дансны хуулга, хамтын ажиллагааны гэрээнд тусгасан байдал
24. Эрхлэх даатгалын хэлбэрийн хохирлын үнэлгээний чиглэлээр үнэлгээчин нь мэргэшсэн гэдгийг нотлох баримт – тухайн даатгалын хэлбэр, түүний хохирлын үнэлгээний талаар сургалтад хамрагдсан, тухайн чиглэлээр үнэлгээ хийх эрх, зөвшөөрлийг төрийн эрх бүхий байгууллагаас авсан баримт бичиг, тухайн хэлбэрийн хохирлын үнэлгээгээр ажиллаж байсан туршлагатайг нотлох баримт. Эрхлэх даатгалын хэлбэрээс хамааран эд хөрөнгийн хохирлыг үнэлэх тохиолдолд Хөрөнгийн үнэлгээний тусгай зөвшөөрлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар.
25. Сонгосон даатгалын хэлбэрээр хохирол үнэлгээ хийж гүйцэтгэхэд шаардлагатай судалгааны материал, программ хангамж, мэдээллийн сангийн танилцуулга.
26. Даатгалын хохирол үнэлгээ хийх ажилтны Хороо, холбогдох мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулсан даатгалын хохирол үнэлгээний сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэнийг нотлох баримт. Энэ нь шалгалтад тэнцсэнээс хойш хоёр жилийн хугацаанд хүчинтэй байна.

2.2. Тусгай зөвшөөрлийн өргөдлийн СЗХ04002 маягтыг бөглөх, түүнд хавсаргах баримт бичгийг бүрдүүлэх.

2.2.1. Тусгай зөвшөөрлийн өргөдлийн СЗХ04002 маягтыг бөглөх

Эрхлэх үйл ажиллагааны мэдээлэл

- 1) Өргөдөл гаргасан огноо: Он, сар өдөр гэсэн дарааллаар тоогоор бичнэ.
- 2) Өргөдөл гаргагчийн овог нэр, оноосон нэр: Өргөдөл гаргагч нь иргэн бол овог нэрийг, хуулийн этгээд бол оноосон нэрийг бичнэ.
- 3) Өмнө нь өргөдөл гаргагч хуулийн этгээд нь санхүүгийн салбарт ажиллаж байгаагүй /хуулийн этгээд бол санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаагүй/ бол үгүй гэсэн сонголтыг хийж 5 дугаар мөр лүү шилжинэ.
- 4) 3 дугаарт тийм гэсэн хариултыг сонгосон бол 4 дүгээр мөрөнд эрхэлж байсан үйл ажиллагааны төрлийг бичнэ.
- 5) Өмнө нь Хороонд даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн өргөдөл ирүүлж байгаагүй бол үгүй гэсэн сонголтыг хийж, 8 дугаар мөр лүү шилжинэ.
- 6) 5 дугаарт тийм гэсэн хариултыг сонгосон бол 6 дугаар мөрөнд хүсэлт ирүүлж байсан тусгай зөвшөөрлийн төрлийг бичнэ.
- 7) 7 дугаар мөрөнд тусгай зөвшөөрөл олгогдсон эсэхээс хамааран тохирох сонголтыг хийнэ.
- 8) Тусгай зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааны хэлбэрийг сонгоно.
- 9) Өргөдөл гаргагч нь тохирох сонголтыг хийж, иргэн 10-19 дүгээр мөрийг бөглөнө. Хуулийн этгээд бол 20-32 дугаар мөрийг бөглөнө.

Тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхлэх иргэний мэдээлэл

- 10) Өргөдөл гаргагч иргэний овог буюу иргэний цахим үнэмлэх дээрх эцэг/эх/-ийн нэрийг бичнэ.

- 11) Өргөдөл гаргагч иргэн өөрийн нэрийг бичнэ.
- 12) Өргөдөл гаргагч иргэн өөрийн регистрийн дугаарыг бичнэ.
- 13) Өргөдөл гаргагч иргэн өөрийн оршин суугаа газрын хаягийг улс, аймаг/хот, сум/дүүрэг, баг/хороо, гудамж/байр, тоот гэсэн дарааллаар бичнэ.
- 14) Өргөдөл гаргаж буй өдрийн байдлаар эрхэлж байгаа ажил, ажиллаж буй газар, албан тушаалын талаар бичнэ.
- 15) Ажил эрхэлдэг бол ажлын газрын хаягийг улс, аймаг/хот, сум/дүүрэг, баг/хороо, гудамж/байр, тоот гэсэн дарааллаар бичнэ.
- 16) Өргөдөл гаргагч иргэн нь мэргэжил эзэмшсэн бол эзэмшсэн мэргэжлийн нэрийг бичнэ.
- 17) Өргөдөл гаргагч иргэнтэй холбоо барих утасны дугаарыг бичнэ.
- 18) Өргөдөл гаргагчийн цахим шуудангийн хаягийг бичнэ.
- 19) Өргөдөл гаргагч иргэн нь Хороо, холбогдох мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулсан даатгалын төлөөлөгчийн сургалтад хамрагдаж шалгалтад тэнцсэн бол тийм гэсэн сонголтыг хийж, үгүй бол үгүй гэсэн сонголтыг хийнэ. Энэ нь шалгалтад тэнцсэнээс хойш хоёр жилийн хугацаанд хүчинтэй байна.

Тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн мэдээлэл

- 20) Оноосон нэр: Монгол – хуулийн этгээдийн нэрийг кирилл үсгээр, бүтэн бичнэ.
Англи – хуулийн этгээдийн нэрийг латин үсгээр галиглан бичнэ.
- 21) Хэрэв хуулийн этгээдийн оноосон нэр өөрчлөгдөж байсан бол өмнөх нэрийг бүтэн бичиж, хэзээнээс хэдий хүртэл тухайн нэр ашиглагдсан талаарх хугацааг он, сар, өдөр гэсэн дарааллаар бичих
- 22) Хуулийн этгээдийн үүсгэн байгуулсан хурлын огноог он, сар, өдөр гэсэн дарааллаар бичнэ.
- 23) Хуулийн этгээдийн хэлбэр: ХК-хувьцаат компани, ХХК- Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн аль нь болохыг сонгоно.
- 24) Хөрөнгө оруулалтын хэлбэрээс тохирох нүдийг сонгож, гадаадын хөрөнгө оруулалттай бол нийт хувьцааны хэдэн хувийг гадаадын хөрөнгө оруулагч
Догоодын хөрөнгө оруулалттай компани гэдэгт нийт хувьцааг /100 хувь/ Монгол улсын иргэн , Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээд эзэмшдэг,
Гадаадын хөрөнгө оруулалттай компани гэдэгт нийт гаргасан хувьцааны 25 буюу түүнээс дээш хувийг гадаадын хөрөнгө оруулагч эзэмшиж байгаа бөгөөд гадаадын хөрөнгө оруулагч тус бүрийн оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ 100 мянган ам.доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс дээш байх аж ахуй нэгжийг тус тус ойлгоно.
- 25) Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээн дэх улсын бүртгэлийн дугаарыг бичнэ.
- 26) Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээн дэх регистрийн дугаарыг бичнэ.
- 27) Хаяг байршил: Хуулийн этгээдийн одоо байршиж байгаа эсхүл байршихаар гэрээ байгуулсан байрны хаягийг хүснэгтийн дагуу дэлгэрэнгүй бичнэ.
- 28) Холбоо барих утас: Хуулийн этгээдийн холбоо барих суурин, гар утас, факсын дугаарыг бичнэ.
- 29) Цахим хуудас: Хуулийн этгээдийн албан ёсны цахим хуудсыг бичнэ. Цахим хуудасгүй бол нөхөх шаардлагагүй.
Цахим шуудангийн хаяг: Хуулийн этгээдийн цахим шуудангийн хаягийг бичнэ.

Нийгмийн сүлжээний хаяг: www.twitter.com, www.facebook.com гэх мэт олон нийтийн сүлжээн дэх хаягийг бичнэ.

Хувь нийлүүлсэн хөрөнгийн талаарх мэдээлэл

- 30) Хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч /гишүүн/-ийн овог нэр / оноосон нэрийг бичиж, тухайн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг төгрөгөөр илэрхийлэн, нийт хувь нийлүүлсэн хөрөнгөд түүний хувь нийлүүлсэн хөрөнгийн эзлэх хувийг бичнэ. Эдгээр мэдээллийг хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч бүр бөглөнө.

Удирдлага боловсон хүчинтэй холбоотой мэдээлэл

- 31) Хуулийн этгээдтэй хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж буй нийт ажилтны тоог бичнэ.
- 32) Хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан буюу гүйцэтгэх удирдлага, даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх этгээд албан тушаал, овог, нэр, регистрийн дугаар, иргэний харьяаллыг бичиж, Хороо, холбогдох мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулсан даатгалын төлөөлөгчийн сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэн эсэх тохирох хариултыг сонгоно.

2.2.2.Тусгай зөвшөөрлийн өргөдлийн СЗХ04002 маягтын дагуу гаргасан өргөдөлд хавсаргах баримт бичиг, тавигдах шаардлага

1. Даатгалын төлөөлөгчийн шимтгэл олгох нөхцөлийг хууль тогтоомжид нийцүүлэн тусгасан даатгагчтай хамтран ажиллах бичгээр байгуулсан гэрээний төсөл.
2. Даатгалын төлөөлөгчөөр ажиллах этгээдийн Хороо, холбогдох мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулсан даатгалын төлөөлөгчийн сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцээнийг ноглох баримт, мөн ажил эрхэлдэг бол тухайн этгээдийн нийгмийн даатгалын дэвтрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар.
3. Өргөдөл гаргагч нь иргэн бол иргэний цахим үнэмлэх болон мэргэжил эзэмшсэн бол тухайн мэргэжлийн диплом, гэрчилгээний хуулбар.
4. Өргөдөл гаргагч нь хуулийн этгээд бол даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тухай хуулийн этгээдийн эрх бүхий этгээдийн шийдвэр.
5. Өргөдөл гаргагч нь хуулийн этгээд бол хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар.
6. Өргөдөл гаргагч нь хуулийн этгээд бол хуулийн этгээдийн дүрмийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, шинэчилсэн дүрмийн төсөл.

“Тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт”-ын 4 дүгээр хавсралт

БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨМЖ

Бизнес төлөвлөгөө гэдэг нь компанийн стратеги, зорилтыг тодорхойлж, компанийн үйл ажиллагааг эрхлэхэд түүний бүтэц, зохион байгуулалт, үйлчилгээний шуурхай, найдвартай ажиллагаа, удирдлагын ур чадвар, санхүү, төлбөрийн чадварын үзүүлэлт, үр ашгийг жил тутам сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой цаг хугацаагаар төлөвлөн боловсруулсан баримтыг хэлнэ.

Бизнес төлөвлөгөөг 3-аас доошгүй жилийн хугацаатай боловсруулах бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэсэн байна. Бизнес төлөвлөгөө нь эмх цэгцтэй, ойлгомжтой, бүлэг хэсгүүд нь уялдаа бүхий мэдээлэл нь цаг хугацаандаа, үнэн бодитой, үр дүн нь хэмжигдэхүйц байвал зохино.

1. Бизнес төлөвлөгөөний нүүр хуудсанд дараах зүйлсийг тусган харуулна:
 - 1.1. Хуулийн этгээдийн нэр, хаяг
 - 1.2. Бизнес төлөвлөгөөний нэр
 - 1.3. Хувилбарын дугаар
 - 1.4. Боловсруулсан огноо
 - 1.5. Баталсан шийдвэрийн огноо, дугаар
 - 1.6. Зохиогчийн нэр, хаяг
 - 1.7. Зохиогчийн тэмдэглэл
 - 1.8. Хуулийн этгээдийн удирдлагын нэр, хаяг
2. Компани нь бизнес төлөвлөгөөг өөрийн үйл ажиллагааны онцлогтой уялдуулан дараах асуудлуудыг тусгасан байна. Үүнд:
 - 2.1. Компанийн үйл ажиллагааны зорилго, зорилт
 - 2.2. Компанийн үйл ажиллагаа эрхлэхэд ашигтай байх макро болон микро түвшин дэх боломжит нөхцөлүүд
 - 2.3. Компанийн тайлан тэнцэл, мөнгөн хөрөнгийн урсгал, орлого зарлагын 3-аас доошгүй жилийн төсөөлөл
 - 2.4. Үйл ажиллагаатай холбогдон гарах эрсдэлийг тодорхойлж, түүнийг удирдахад авах арга хэмжээ
 - 2.5. Компанийн засаглалыг боловсронгуй болгох, сайжруулах төлөвлөгөө
3. Бизнес төлөвлөгөө нь дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд:

I. ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ

Энэ бүлэгт тухайн бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэгч нь хэрэгжүүлэх гэж буй бизнес төлөвлөгөөний эрхэм зорилго, зорилт, амжилтын үндэс, учирч болох эрсдэл болон санхүүгийн бусад үзүүлэлтүүдийн тухай товч мэдээллийг багтаана.

Эрхэм зорилго гэдэг нь үйлчлүүлэгч, даатгуулагчдын ямар хэрэгцээг, ямар арга замаар хангах тухай тодорхойлолт юм.

Зорилт гэдэг нь эрхэм зорилтод хүрэхийн тулд шат дараалан хэрэгжүүлэх, хугацаатай, хэмжигдэхүйц бодитой үр дүн буюу хүрэх цэг юм.

II. БИЗНЕСИЙН ТАНИЛЦУУЛГА

Бизнесийн танилцуулга гэдэг нь тухайн компанийн нэр, хаяг, хариуцлагын тогтолцоо, зах зээлийн нөхцөл төлөв байдал, эрхлэх гэж буй даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа, гаргаж буй үйлчилгээ түүнчлэн удирдлага боловсон хүчний хангалт, санхүүгийн чадавх ба байдал бизнес төлөвлөгөө бичих болсон шалтгаан, зорилго зорилтууд түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр, үйл ажиллагааны үр ашиг, борлуулалтын орлого, ашиг зэргийг тусган харуулсан хураангуй тодорхойлолт юм.

Бизнесийн танилцуулга нь дараах үндсэн хэсгүүдээс бүрдэнэ:

1. Компанийн түүх

1.1. Компанийн түүх: Энэ хэсэгт танай компани анх хэдэн онд байгуулагдсан, ямар бизнес эрхэлж байсан, компанийн түүх, ололт амжилтын талаар дурдахаас гадна одоогийн явуулж буй үйл ажиллагаа, бизнесийн чиглэл, бүтээгдэхүүн үйлчилгээ, бүтэц бүрэлдэхүүний талаар бичнэ. Өмнө нь үйл ажиллагаа явуулж байгаагүй бол бичих шаардлагагүй.

1.2. Одоогийн явуулж буй үйл ажиллагаа: Хуулийн этгээд бизнесийн аль салбарт ямар чиглэлээр бүтээгдэхүүн үйлчилгээ эрхэлдэг, одоогийн бизнесийн орчин, эзэмшиж буй тоног төхөөрөмж, барилга байгууламж, хөрөнгө оруулалтын хэмжээ, бүтээгдэхүүн үйлчилгээний тоо хэмжээ, нийлүүлэгч, хамтран ажилладаг байгууллага, харилцагчдын талаарх мэдээллийг бичнэ. Өмнө нь үйл ажиллагаа явуулж байгаагүй бол бичих шаардлагагүй.

1.3 Хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцаа эзэмшилт: Хуулийн этгээдийг хувьцаа эзэмшигчдийн оруулсан мөнгөн хөрөнгийн талаар дэлгэрэнгүй бичнэ.

1.4 Бүтэц зохион байгуулалт, удирдлага, хүний нөөц: Энэ хэсэгт тухайн байгууллагын боловсон хүчний бүтэц, зохион байгуулалт, удирдлагын багийн танилцуулга, тэдний өмнө хийж байсан ажил, ажлын туршлага, одоогийн хариуцан ажилладаг ажлын талаар танилцуулна. Тухайн байгууллагын зохион байгуулалтын бүтцийг схемчлэн зурж болно. Боловсон хүчний талаар одоо компанид нийт хэдэн хүн ажиллах, тэднээс хэд нь үндсэн ажилчин, хэд нь гэрээт ажилчин байх, тэдгээрийн цалин хөлс, ямар ямар чиглэлийн ажил хариуцдаг, ажилчид дотроо газар, хэлтэс, салбар зэрэгт хуваагддаг эсэх талаар бичнэ. Цаашид ажилчдын тоог нэмэгдүүлэх эсэх талаар тодруулна.

2. Зах зээлийн нөхцөл төлөв байдал

Зах зээлийн байдал, хэрэглэгчид, зах зээлд гарч байгаа ерөнхий чиг хандлага, тухайн бизнесийн хууль эрх зүйн орчин, тухайн салбар дахь өрсөлдөгчдийн талаар мэдээллүүдийг багтаана.

2.1 Зах зээл, хэрэглэгч, зах зээлийн ерөнхий чиг хандлага: Энэ хэсэгт зах зээлийн хэмжээ, хэрэглэгчдийн тоо хэмжээ, тухайн хуулийн этгээдийн зах зээлд эзлэх хувь, зах зээлийн өсөлт, ирээдүйн зах зээлийн байдал, зах зээлийн тогтвортой байдал, зах зээлд гарч байгаа ерөнхий чиг хандлагуудыг бичих бөгөөд технологийн хөгжил, байгалийн хүчин зүйлс, хүн амын суурьшилт зэргийг тодруулна.

2.2 Бизнесийн хууль эрх зүйн орчин: Тухайн бизнесийг эрхлэхтэй холбоотой хуулиудыг судалсан эсэх, шаардагдах бичиг баримтыг бүрдүүлж баталгаажуулсан эсэх, хууль эрх зүйн орчинд нийцүүлэн үйл ажиллагаа явуулах арга замыг тодорхой бичнэ.

2.3 Өрсөлдөөн, өрсөлдөгчид: Тухайн зах зээл дээрх ижил төрлийн бизнес эрхэлж байгаа аж ахуй нэгж байгууллагын тоо хэмжээ, нэр, байршил, хүчин чадал, зах зээлд эзлэх хувь, давуу болон сул талуудын талаар дурдана. Компанийн дотоод, гадаад хүчин зүйлсийг судалсан SWOT шинжилгээг хийсэн байвал зохино.

Өрсөлдөгчийн нэр	Байршил	Бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл	Багцын хэмжээ	Бүтээгдэхүүн үйлчилгээний үнэ, хүүгийн хэмжээ	Зах зээлд эзлэх байр суурь
Өрсөлдөгч 1					
Өрсөлдөгч 2					
Өөрийнх					

2.4 Бизнес төлөвлөгөө бичих болсон үндэслэлүүд: Яагаад шинээр үйл ажиллагаа эрхлэх болсон шалтгааныг бичиж, зах зээл, өөрийн хүчин чадлын хэмжээг харгалзан тухайн бизнесийг өргөжүүлэх нөөц, боломжийг тодруулна.

3. Төлөвлөсөн бизнесийн үйл ажиллагаа:

3.1 Бүтээгдэхүүн үйл ажиллагааны төлөвлөгөө: Эрхлэх гэж буй даатгалын хэлбэрийн дэлгэрэнгүй болон үйл ажиллагаа эрхлэн явуулснаар тухайн бүтээгдэхүүн үйлчилгээг ямар хэмжээгээр хүргэх, харилцагч, үйлчлүүлэгчдийн цар хүрээг тодорхойлж, тооцооллыг хийнэ.

3.2 Маркетингийн төлөвлөгөө: Өмнөх бүлэгт хийсэн зах зээл, хэрэглэгчдийн судалгааг үндэслэн боловсруулна. Үүнд зах зээлээ сонгох, бүтээгдэхүүн үйлчилгээг идэвхжүүлэх үйл ажиллагаа орно. Маркетингийн төлөвлөгөө нь маркетингийн иж бүрдлээс бүрдэнэ. Үүнд: Бүтээгдэхүүн (үйлчилгээ), Үнэ (үнийг хэрхэн тогтоох), Байрлал (суваг, хуваарилалт), Идэвхжүүлэлт (зар сурталчилгаа) зэргийг хэрхэн шийдвэрлэсэнэ тодорхойлно.

3.3 Менежментийн төлөвлөгөө: Байгууллагын удирдлага, бүтэц, зохион байгуулалт, удирдах ажилтан бүрийн хариуцлага, ажилчдын нэрс, цалингийн зардлыг тодорхой бичиж, боловсон хүчнийг бэлтгэх, чадваржуулах шаардлага, тэдгээрт хийх сургалтын талаар тодруулна.

3.4 Санхүүгийн төлөвлөгөө: Санхүүгийн төлөвлөгөөнд бизнесийн үйл ажиллагаа явуулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэр, орлого, зардал, ашиг, алдагдлыг тооцож, түүнийг хэрхэн удирдах талаар тусгана. /Даатгалын компани бол даатгалын үнэлгээ, даатгалын хураамж, нөөц сан, нөхөн төлбөр, давхар даатгалын хураамж, даатгалын бус үйл ажиллагааны орлого гэх мэт үзүүлэлтүүдийн тооцооллыг тусгана/

Орлогыг тооцохдоо тухайн орлогыг бүрдүүлэх эх үүсвэр бүрээр тооцож нэгтгэн гаргана.

Зардлыг тооцохдоо бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбогдон гарах, удирдлага зохион байгуулалттай холбогдон гарах, албан татвар хураамж төлөх, хөрөнгө оруулалттай холбогдон гарах, бусад зардал гэх мэтчилэн зардлын зүйл анги бүрээр тооцож, нэгтгэн гаргана.

Мөнгөн урсгалыг тооцохдоо сар бүрийн орж, гарах мөнгөн урсгалыг тооцож, жилээр нэгтгэн гаргана.

Санхүүгийн тайлан баланс зэрэг тоон үзүүлэлтийг бизнес төлөвлөгөөнд тусгахдаа өмнөх онуудын гүйцэтгэлийг ирэх жилийн төлөвлөгөөтэй зэрэгцүүлсэн байдлаар гаргана.

3.5 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө: Шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээ, хугацаа, үүнээс өөрийн хөрөнгийн эх үүсвэрээс оруулж чадах хөрөнгө оруулалтын хэмжээ, хөрөнгө оруулалтыг хаанаас авахаар төлөвлөөд байгаа /банкны зээл, гадаадын хөрөнгө оруулалт, олон улсын байгууллагын тусламж хөрөнгө оруулалт, гадаадын банкнаас авах зээл, хувь нийлүүлэгчдийн хөрөнгө оруулалт/-талаар бичнэ. Хэрэв өглөг авлагатай бол энэ талаар жагсаалт үйлдэж, нарийвчлан тодруулсан байна.

3.6 Эрсдэлийн менежмент /бууруулах арга зам: Бизнес эрхлэхэд олон төрлийн эрсдэл учирч болох бөгөөд техник, санхүү, байгалийн гамшиг, хууль эрх зүй, улс төрийн эрсдэлийг зайлшгүй тооцож өөрийн бизнесийн онцлогт уялдуулан бичнэ. Мөн таны бизнест ямар төрлийн эрсдэл учрах магадлал илүү эсэхийг тодорхойлж, эрсдэлийг доод хэмжээнд байлгах, түүнээс сэргийлэх, бууруулахын тулд та ямар арга хэмжээ төлөвлөснөө бичих нь зүйтэй.

“Тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт”-ын 5 дугаар хавсралт

ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨМЖ

Дотоод үйл ажиллагааны журам нь дараах зарчимд тулгуурлана:

- байгууллагын стратеги, зорилттой уялдсан байх;
- холбогдох хууль тогтоомж, журам, заавар, олон улсын конвенцыг удирдлага болгосон байх;
- санхүү, төлбөрийн чадвар, үр ашиг, удирдлагын ур чадвар, үйлчилгээний шуурхай, найдвартай ажиллагаа зэргийг харгалзан үзсэн байх;
- даатгуулагчийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхгүй байх.

Дотоод үйл ажиллагааны журамд дараах агуулгаар заалтуудыг заавал тусгасан байна:

1. Үйл ажиллагаанд мөрдөх журмын зорилгыг Монгол Улсын Иргэний хууль, Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Компанийн тухайн хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Даатгалын багц дүрмийн хүрээнд даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааны харилцааг зохицуулахад чиглүүлэх;
2. Үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой нийтлэг хэрэглэгддэг нэр томъёонуудын тайлбарыг оруулах;
3. Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд оролцогч талууд бие биедээ харилцан итгэж, үнэн бодит мэдээллээр хангах, хууль дээдлэх, шударга байх үндсэн зарчмуудыг тусгах;
4. Тухайн үйлчилгээг үзүүлж, үйл ажиллагааг явуулахад харилцагчаас бүрдүүлэх шаардлагатай баримтын жагсаалт гаргах;
5. Тухайн үйл ажиллагаа, үйлчилгээг хэрэгжүүлэхэд тавигдах нөхцөл, шаардлага, хүү, хураамж, шимтгэл, барьцаа эд хөрөнгө, батлан даалтын шалгуур үзүүлэлт, харилцагчдын холбогдох гэрээ, хувийн хэрэг зэргийг хэрхэн бүрдүүлж хадгалж, хамгаалах талаар тусгах;
6. Холбогдох хууль журамд заасны дагуу үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгчдэд хуулиар тавьсан шаардлага, тухайн үйл ажиллагааг гүйцэтгэж байгаа ажилтнуудын эрх, үүргийн хэмжээ, хийж гүйцэтгэх, хянаж шийдвэрлэх, батлах хугацаа зэрэг ажилбаруудыг зааж өгөх;
7. Нягтлан бодох бүртгэлийг Хорооноос баталсан нягтлан бодох бүртгэлийн заавар, дансны жагсаалт, маягтын дагуу хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээг тогтоосон хугацаанд гаргах, Хороонд ирүүлж байх, үйл ажиллагаанд учирч болзошгүй аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлж, Даатгалын тухай хууль тогтоомж болон Хорооноос баталсан холбогдох журамд заасан шалгуур үзүүлэлтүүдийг ханган ажиллах;
8. Харилцагчдыг хуурамч мэдээллээр хангах, төөрөгдүүлэх, өөрийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн мэдээллийг нуун дарагдуулах, өөрийн ажил үүрэгтэй холбоотой нийтэд тараагдаагүй мэдээллийг ашиглан ашиг олох, бусдад тараах, харилцагчаас төлбөл зохих үйлчилгээний хөлс болон зардлаас илүү хэмжээний төлбөр шаардахыг хориглох асуудлыг тодорхой заах;

“Тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт”-ын 6 дугаар хавсралт

ЭХЛЭЛТИЙН ТАЙЛАН

Хуулийн этгээдийн нэр	
	(он) / (сар) / (өдөр)
	/төгрөгөөр/

ХӨРӨНГӨ	
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	
Бэлэн мөнгө	
Банкинд байгаа мөнгө	
Дансны авлага	
Бусад санхүүгийн хөрөнгө	
Урьдчилж төлсөн зардал	
Богино хугацаат хөрөнгө оруулалт	
Бусад эргэлтийн хөрөнгө	
Эргэлтийн хөрөнгийн дүн	
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	
Үндсэн хөрөнгө	
Биет бус хөрөнгө	
Урт хугацаат хөрөнгө оруулалт	
Бусад эргэлтийн бус хөрөнгө	
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	
Нийт хөрөнгийн дүн	
ӨР ТӨЛБӨР	
Богино хугацаат өр төлбөр	
Дансны өглөг	
Урьдчилж орсон орлого	
Бусад богино хугацаат өр төлбөр	
Урт хугацаат өр төлбөр	
Урт хугацаат өр төлбөр	
Хойшлогдсон татварын өр төлбөр	
Бусад урт хугацаат өр төлбөр	
Нийт өр төлбөр	
ЭЗДИЙН ӨМЧ	
Өмч	
Нэмж төлөгдсөн капитал	
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	
Тусгай зориулалтын нөөцийн сангууд	
Эздийн өмчийн бусад хэсэг	
Хуримтлагдсан ашиг/алдагдал	
Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	
Нийт өр төлбөр ба эздийн өмч	

.....
(Гүйцэтгэх удирдлагын гарын үсэг)

.....
(овог, нэр)

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд
2019 оны 01 сарын 31-ний өдрийн 4188 дугаарт бүртгэв.*

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА, ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2019 оны 01 сарын 21 өдөр

Дугаар 30/А/14

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Жолоочийн даатгалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.8 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Жолоочийн даатгалын сангаас болон даатгагчаас хохирогчид олгосон нөхөн төлбөрийн мэдээллийг цагдаагийн байгууллагад ирүүлэх, түүнийг ашиглах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Хамтарсан тушаал хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрөөс эхлэн Хууль зүй, дотоод хэргийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/21/22 дугаар хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга /М.Өлзийбат/, Цагдаагийн ерөнхий газрын дарга /С.Баатаржав/, Албан журмын даатгагчдын холбооны гүйцэтгэх захирал /Д.Цэвээнжав/-д тус тус даалгасугай.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГА

С.ДАВААСҮРЭН

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

Ц.НЯМДОРЖ

Санхүүгийн зохицуулах хорооны дарга,
Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны
01 дугаар сарын 21-ний өдрийн 30/А/14 дугаар
хамтарсан тушаалын хавсралт

ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН САНГААС БОЛОН ДААТГАГЧААС ХОХИРОГЧИД ОЛГОСОН НӨХӨН ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЛИЙГ ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГАД ИРҮҮЛЭХ, ТҮҮНИЙГ АШИГЛАХ ЖУРАМ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь жолоочийн даатгалын сан (цаашид “сан” гэх)-гаас болон даатгагчаас хохирогчид олгосон нөхөн төлбөртэй холбоотой мэдээллийг цагдаагийн байгууллагад ирүүлэх, түүнийг ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулна.

ХОЁР. ДААТГАГЧААС ОЛГОСОН НӨХӨН ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ ИРҮҮЛЭХ

2.1. Даатгагч нь хохирогчид олгосон нөхөн төлбөрийн талаарх мэдээллийг энэ журмын 1 дүгээр хавсралтын дагуу гаргаж Цагдаагийн ерөнхий газар болон Албан журмын даатгагчдын холбоо /цаашид “Холбоо” гэх/-нд цахим хэлбэрээр ажлын 3 хоногийн дотор ирүүлэх бөгөөд мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцна.

ГУРАВ. САНГААС ОЛГОСОН НӨХӨН ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ ИРҮҮЛЭХ

3.1. Жолоочийн даатгалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасан үндэслэлээр сангаас хохирогчид нөхөн төлбөр олгох бөгөөд Холбоо нь энэ тухай мэдээллийн бүртгэл хөтөлнө.

3.2. Энэ журмын 3.1-д заасны дагуу хохирогчид олгосон нөхөн төлбөртэй холбоотой мэдээллийг Холбоо нь Цагдаагийн ерөнхий газарт цахим хэлбэрээр ирүүлнэ.

3.3. Холбоо нь хохирогчид олгосон нөхөн төлбөртэй холбоотой мэдээлэл болон даатгагчаас энэ журмын 2.1-д заасны дагуу ирүүлсэн мэдээллийг нэгтгэж, санхүүгийн тайлангийн хамтаар Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлнэ.

3.4. Санхүүгийн зохицуулах хороо нь сангаас хохирогчид олгосон нөхөн төлбөрийн мэдээллийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олон нийтэд мэдээлж болно.

3.5. Холбоо нь зам тээврийн осол, зөрчлийн улмаас хохирогчид олгосон нөхөн төлбөртэй холбоотой мэдээллийг статистик тоон үзүүлэлт байдлаар олон нийтэд мэдээлж болно.

3.6. Энэ журмын 3.2, 3.3-т заасан мэдээллийг энэ журмын 2 дугаар хавсралтын дагуу гаргана.

ДӨРӨВ. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА НӨХӨН ТӨЛБӨРТЭЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЛИЙГ АШИГЛАХ

4.1. Цагдаагийн ерөнхий газар, түүний харьяа алба нь нөхөн төлбөртэй холбогдох мэдээлэл, статистикийн мэдээг үнэ төлбөргүй гаргуулж, ашиглана.

4.2. Цагдаагийн ерөнхий газар, түүний харьяа алба нь статистик мэдээллийг зам, тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор олон нийтэд мэдээлж болно.

ТАВ. ХЯНАЛТ ТАВИХ

5.1. Нөхөн төлбөртэй холбоотой мэдээллийг цагдаагийн байгууллагад гаргаж өгөхөөс татгалзсан, эсхүл хугацаанд нь ирүүлээгүй даатгагч болон санд Жолоочийн даатгалын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

“Жолоочийн даатгалын сангаас болон даатгагчаас хохирогчид олгосон нөхөн төлбөрийн мэдээллийг цагдаагийн байгууллагад ирүүлэх, түүнийг ашиглах журам”-ын 1 дүгээр хавсралт

ДААТГАГЧААС ОЛГОСОН НӨХӨН ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЛИЙН МАЯГТ

Даатгалын компанийн нэр -----
Огноо

№	Даатгалын тохиолдолд буруутай этгээдийн нэр	Жолооны үнэмлэх-ний дугаар	Регистрийн дугаар	Тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаар	Даатгалын тохиолдлын утга	Замын хөдөлгөөний дүрмийн ямар заалт зөрчсөн	Даатгалын тохиолдол болсон газар	Мэргэжлийн байгууллагын үнэлгээ, учирсан хохирлын хэмжээ		Нийт учирсан хохирлын хэмжээ / төгрөгөөр/	Олгосон нөхөн төлбөрийн хэмжээ / төгрөгөөр/
								Амь нас, эрүүл мэнд	Эд хөрөнгө		
1											
2											
3											
4											
5											
6											
	Нийт										

Мэдээ гаргасан:
Ажилтан

/...../

Гарын үсэг
Тамга

Хянасан:
Захирал

/...../

Гарын үсэг

“Жолоочийн даатгалын сангаас болон даатгагчаас хохирогчид олгосон нөхөн төлбөрийн мэдээллийг цагдаагийн байгууллагад ирүүлэх, түүнийг ашиглах журам”-ын 2 дугаар хавсралт

ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОСОН НӨХӨН ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЛИЙН МАЯГТ

Огноо

№	Даатгалын тохиолдлын утга	Цагдаагийн байгууллагаас даатгалын тохиолдолд үзлэг хийсэн эсэх	Нөхөн төлбөр олгосон үндэслэл						Тэврийн хэрсгэлийн нийт дүгээр	Тэврийн хэрсгэлийн нийт дүгээр	Мэргэжлийн байгууллагын үнэлгээ, учирсан хохирол	Нийт учирсан хохирлын хэмжээ /төгрөгөөр/	Олгосон нөхөн төлбөрийн хэмжээ /төгрөгөөр/
			Даатгалгүй этгээл зөрчил гаргасан	Даатгалын гэрээний хугацаа нь дууссан этгээл зөрчил гаргасан	Бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан этгээл тодорхой бус	Даатгагч дамнуурсан	Хууль тогтоомжийг заасан бусад үндэслэл	Тэврийн хэрсгэлийн нийт дүгээр					
1													
2													
3													
4													
	Нийт												

Мэдээ гаргасан:
Холбооны ажилтан

/...../

Гарын үсэг

Тамга

Хянасан:

/...../

Захирал

Гарын үсэг

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд
2019 оны 01 сарын 31-ний өдрийн 4189 дугаарт бүртгэв.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА, ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2019 оны 01 сарын 21 өдөр

Дугаар 29/А/13

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Жолоочийн даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ
НЬ:

1. “Жолоочийн даатгалын баталгааны загвар, түүнийг хэрэглэх журам”-ыг хавсралтаар
баталсугай.

2. Хамтарсан тушаал хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрөөс эхлэн Хууль зүйн сайд,
Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2015 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 73 А/66 дугаар
хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын
албаны дарга /М.Өлзийбат/, Цагдаагийн ерөнхий газрын дарга /С.Баатаржав/, Албан журмын
даатгагчдын холбооны гүйцэтгэх захирал /Д.Цэвээнжав/-д тус тус даалгасугай.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГА

С.ДАВААСҮРЭН

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

Ц.НЯМДОРЖ

Санхүүгийн зохицуулах хорооны дарга,
Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны
01 дүгээр сарын 21-ний өдрийн 29/А/13 дугаар
хамтарсан тушаалын хавсралт

ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН БАТАЛГААНЫ ЗАГВАР, ТҮҮНИЙГ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмаар жолоочийн хариуцлагын албан журмын даатгал /цаашид “даатгал” гэх/-ын баталгааны загвар, түүнийг хэрэглэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

ХОЁР. ДААТГАЛЫН БАТАЛГАА

2.1. Жолоочийн даатгалын мэдээллийн сангаас даатгагчид олгож буй гэрээний дугаарыг жолоочийн даатгалын баталгаа гэж үзнэ.

2.2. Даатгагч нь өөрийн гарын үсэг зурсан даатгалын гэрээг жолоочийн даатгалын мэдээллийн санд бүртгүүлж энэ журмын 2.1-д заасан гэрээний дугаар авна.

2.3. Даатгагч, техникийн хяналтын үзлэг оношлогооны байгууллага, цагдаагийн байгууллагын эрх бүхий албан хаагч, Санхүүгийн зохицуулах хорооны даатгалын хянан шалгагч нь цахимаар болон шалгах төхөөрөмж ашиглан даатгалын гэрээг хүчинтэй, даатгалын баталгаатай эсэхийг жолоочийн даатгалын мэдээллийн сангаас шалгана.

2.4. Даатгуулагч нь даатгалын гэрээ баталгаатай эсэхийг жолоочийн даатгалын мэдээллийн сангаас тодруулж болно.

2.5. Даатгалын гэрээ баталгаатай эсэхийг энэ журмын 2.3-т заасан байгууллага, албан тушаалтан жолоочийн даатгалын мэдээллийн сангаас цахим хэлбэрээр хянан шалгах боломжийг Албан журмын даатгагчдын холбоо бүрдүүлнэ.

ГУРАВ. ДААТГАЛЫН БАТАЛГААНЫ ЗАГВАР

3.1. Даатгалын баталгаа нь дараах арван дөрвөн орон бүхий тоон мэдээллийг агуулсан загвартай байна.

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14

3.2. Даатгалын баталгааны дугаарын эхний 2 тоо нь тухайн оны сүүлийн 2 тоог, 3, 4 дүгээр тоо нь Санхүүгийн зохицуулах хорооноос даатгалын компанид олгосон ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаарын сүүлийн 2 тоог, 5-9 дүгээр тоо нь тухайн даатгалын гэрээг хийсэн даатгагчийн хувийн дугаарыг, 10-13 дугаар тоо нь тухайн даатгагчийн хийсэн, даатгалын зуучлагчийн зуучилсан даатгалын гэрээний жолоочийн даатгалын санд хугацааны дарааллаар эрэмбэлэгдсэн дэс дугаарыг илэрхийлэх ба 14 дүгээр тоо нь даатгалын гэрээний төрлийг заана.

3.3. Даатгалын гэрээний төрлийг заах дугаарлалтын хувьд 1-ийн тоо нь хувь хүн, 2-ын тоо нь аж ахуйн нэгж, 3-ын тоо нь мэргэшсэн жолооч, 4-ийн тоо нь Монгол улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх болон түр хугацаагаар орж ирж байгаа автотээврийн хэрэгслийг эзэмшигч, өмчлөгчтэй хийсэн даатгалын гэрээ болохыг тус тус илэрхийлнэ.

ДӨРӨВ. БУСАД

4.1. Энэ журмын биелэлтэд Санхүүгийн зохицуулах хорооны даатгалын хянан шалгагч, цагдаагийн байгууллагын эрх бүхий албан хаагч нар хяналт тавьж ажиллана.

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд
2019 оны 12 сарын 17-ны өдрийн 4555 дугаарт бүртгэв.*



**МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2019 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 354

Улаанбаатар хот

Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх компанийн дүрмийн сангийн доод хэмжээг 5 тэрбум төгрөг, урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх компанийн дүрмийн сангийн доод хэмжээг 6 тэрбум төгрөг, давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх компанийн дүрмийн сангийн доод хэмжээг 15 тэрбум төгрөгөөр тус тус тогтоосугай.

2. Энэхүү тогтоол Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрөөс эхлэн Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 355 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд
2020 оны 01 сарын 27-ны өдрийн 4673 дугаарт бүртгэв.

САНГИЙН САЙД, САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2020 оны 01 сарын 14 өдөр

Дугаар 5 / 11

Улаанбаатар хот

“Малын индексжүүлсэн даатгалын хамтын эрсдэлийн сангийн хөрөнгө, түүнийг санхүүжүүлэх, зарцуулах журам”-ыг шинэчлэн батлах тухай

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Малын индексжүүлсэн даатгалын хамтын эрсдэлийн сангийн хөрөнгө, түүнийг санхүүжүүлэх, зарцуулах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. Энэхүү тушаал хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрөөс эхлэн Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2015 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 91/110 дугаар хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

Гурав. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар /Б.Доржсэмбэд/-т, Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд тус тус даалгасугай.

САНГИЙН САЙД

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГА

Ч.ХҮРЭЛБААТАР

Д.БАЯРСАЙХАН

Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны
даргын 2020 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн
5 / 11 дүгээр хамтарсан тушаалын хавсралт

МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН ХАМТЫН ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨ, ТҮҮНИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ, ЗАРЦУУЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль /цаашид “Хууль” гэх/-ийн 26.2-т заасан хамтын эрсдэлийн сан /цаашид “хамтын эрсдэлийн сан” гэх/-г бүрдүүлэх, удирдах, хамтын эрсдэлийн сангийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх, нөхөн төлбөр төлөх, хөрөнгийг зарцуулах ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2.Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 13.1-д заасан шаардлага хангасан, хамтын эрсдэлийн санд оролцогч даатгалын компани /цаашид “даатгагч” гэх/-ууд хамтарч хууль болон энэ журмыг хэрэгжүүлэх, мөн хамтын эрсдэлийн санг удирдах, байршуулах, зарцуулахтай холбоотой шийдвэрийг гаргана.

1.3.Даатгагч нь малчин, мал бүхий иргэн, хуулийн этгээдтэй малын индексжүүлсэн даатгал /цаашид “даатгал” гэх/-ын гэрээ байгуулах боломжтой хугацааг борлуулалтын улирал гэж үзнэ.

ХОЁР. ХАМТЫН ЭРСДЭЛИЙН САНГ БҮРДҮҮЛЭХ, УДИРДАХ, ЗАРЦУУЛАХАД БАРИМТЛАХ ЗАРЧИМ

2.1.Хамтын эрсдэлийн санд оролцогч даатгагчдын хамтын эрсдэлийн санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг даатгалын эрсдэлийн хураамжаас актуар тооцооллоор тооцож, жил бүр төвлөрүүлнэ.

2.2.Хамтын эрсдэлийн санг бүрдүүлэх, удирдах, түүнийг зарцуулахдаа дараах үндсэн зарчмыг баримтална.

2.2.1.малын индексжүүлсэн даатгалын тохиолдол болсон үед Хуулийн 8.1.2-т заасан дунд түвшний эрсдэлийг хамтран хариуцаж, эрсдэлээ хуваах зорилгоор уг санг даатгагчид хамтран бүрдүүлэх;

2.2.2.хамтын эрсдэлийн санг бүрдүүлэх, удирдах, түүнийг зарцуулахад хамтын удирдлагыг хэрэгжүүлэх;

2.2.3.хамтын эрсдэлийн сангаас олгох нөхөн төлбөрийг хамтын эрсдэлийн санд оруулсан хөрөнгөд хувь тэнцүүлэн хуваах замаар хамтран хариуцах;

2.2.4.хамтын эрсдэлийн санд төвлөрүүлсэн хөрөнгөд хувь тэнцүүлэн өгөөж хүртэх;

ГУРАВ. ХАМТЫН ЭРСДЭЛИЙН САНГ УДИРДАХ

3.1.Хамтын эрсдэлийн санг оролцогч даатгагчид хамтарч томилсон 3 хүний бүрэлдэхүүнтэй ажлын алба /цаашид “ажлын алба” гэх/ удирдах бөгөөд ажлын албанд Хуулийн 18.1-д заасан давхар даатгалын компани /цаашид “давхар даатгагч” гэх/-ийн төлөөлөл орсон байна.

3.2.Ажлын албыг Хуулийн 22.3.3-т заасны дагуу давхар даатгагчийн гүйцэтгэх захирал нэгдсэн удирдлагаар хангах бөгөөд тус ажлын албаны зардлыг хамтын эрсдэлийн сангийн хөрөнгө

оруулалтын орлогоос санхүүжүүлнэ.

3.3.Хамтын эрсдэлийн сангийн хөрөнгийг Хуулийн 26.1-д заасны дагуу тусгайлсан дансанд байршуулах бөгөөд тус сангийн хөрөнгийг захиран зарцуулах тухай даатгагчдын хамтарсан шийдвэрийг үндэслэн давхар даатгагчийн гүйцэтгэх захирал тусгайлсан данснаас зарцуулалт хийнэ.

ДӨРӨВ. ХАМТЫН ЭРСДЭЛИЙН САНД ХӨРӨНГӨ ТӨВЛӨРҮҮЛЭХ, ТҮҮНИЙГ БАЙРШУУЛАХ

4.1.Даатгагчид энэ журмын 2.1-д заасны дагуу хамтын эрсдэлийн санд төвлөрүүлэх хөрөнгийг даатгалын борлуулалтын улирал дууссанаас хойш хуанлийн 60 хоногийн дотор тус санд бүрэн шилжүүлсэн байна.

4.2.Хамтын эрсдэлийн санд шинээр нэгдэн орох даатгагч нь өмнөх тайлант жилийн эцэст даатгагч бүрийн хамтын эрсдэлийн сангийн хуримтлалд үлдээсэн хөрөнгөтэй тэнцүү хэмжээний хөрөнгийг даатгалын борлуулалтын улирал эхлэхээс өмнө тус санд төвлөрүүлнэ.

4.3.Хамтын эрсдэлийн санд төвлөрүүлбэл зохих хөрөнгийн тооцооллыг ажлын алба гүйцэтгэх ба даатгагчид малын индексжүүлсэн даатгалын борлуулалтыг ажлын албанд үнэн зөв гаргаж өгөх үүрэгтэй.

4.4.Даатгагчид хамтын эрсдэлийн сангийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийхдээ Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэж/ баталсан даатгалын багц дүрэмд заасан ердийн даатгалын компанийн нөөц сангийн хөрөнгөөс хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлагыг мөрдөнө.

4.5.Даатгагчид хамтын эрсдэлийн сангийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийхдээ дараах ангилал, хувь хэмжээг баримтална. Үүнд:

Хөрөнгийн ангилал	Хөрөнгө оруулах дээд хязгаар /Хамтын сангийн нийт хөрөнгөнд эзлэх хувиар/
1. Засгийн газраас гаргасан өрийн хэрэгсэл	100%
2. Банкны хадгаламж	100%
3. Монгол Улсын Хөгжлийн банкны үнэт цаас	20%
4. Арилжааны банкнаас гаргасан нэрийн сертификат	10%

4.6.Хамтын эрсдэлийн сангийн хөрөнгийг банкны хадгаламж хэлбэрээр байршуулсан тохиолдолд нэг банкинд нийт мөнгөн хөрөнгийн 35-аас дээшгүй хувийг байршуулах зарчмаар даатгагчдын хамтарсан шийдвэрээр сонгосон 3-аас доошгүй банкинд тараан байршуулна.

4.7.Хамтын эрсдэлийн сангийн хөрөнгөөр худалдан авч болох өрийн хэрэгсэл нь хугацааны хувьд дараах нэмэлт шаардлагын аль нэгийг хангасан байна:

4.7.1.холбогдох хууль тогтоомж, үнэт цаас гаргах тухай шийдвэрт заасан хугацаа эсхүл үлдэгдэл хугацаа нь 6 сар ба түүнээс богино байх;

4.7.2.энэ журмын 4.7.1-д заасан шаардлагыг хангаагүй бол тухайн өрийн хэрэгслийг хүссэн цагтаа худалдах боломжтой идэвхитэй зах зээлтэй байх;

4.8.Хамтын эрсдэлийн сангийн хөрөнгөөр худалдан авах банкны хадгаламжийн сертификатын хугацаа нь 6 сараас доош байна.

4.9.Нэг банкинд хадгалуулсан хадгаламж болон тухайн банкны гаргасан хадгаламжийн сертификатын нийлбэр нь хамтын эрсдэлийн сангийн нийт хөрөнгийн 35 хувиас илүүгүй байна.

4.10.Хамтын эрсдэлийн сангийн хөрөнгөөр худалдан авсан санхүүгийн хэрэгслийн багцад багтаж буй санхүүгийн хэрэгслийн нийт жигнэсэн дундаж хугацаа /ЖДХ/ нь 184 өдрөөс илүүгүй байна. ЖДХ гэж сангийн багцад байгаа өрийн хэрэгсэл тус бүрийн дуусах хугацаа эсхүл сангийн

эзэмшилд байх хугацааг сангийн багцад байгаа тухайн хөрөнгийн хувийн жингээр жигнэж тооцсон дундаж хугацаа байна.

ТАВ. ХАМТЫН ЭРСДЭЛИЙН САНГААС НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОХ

5.1. Даатгагчид хамтын эрсдэлийн сангаас нөхөн төлбөр олгох асуудлыг дараах байдлаар хамтран шийдвэрлэнэ:

5.1.1. даатгалын тохиолдол болсон эсэхийг Хуулийн 6.3 дахь хэсэгт заасны дагуу статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын албан ёсны мэдээлэлд үндэслэн тогтооно;

5.1.2. хамтын эрсдэлийн сангаас нөхөн төлбөр олгох тухай шийдвэрийг даатгагчид хамтран гаргах бөгөөд тус шийдвэрийг гаргахдаа сум бүрийн малын хорогдлын мэдээллийг гаргасан, шалган баталгаажуулсан эрх бүхий этгээдийн албан ёсны баталгаа, баримтыг үндэслэнэ;

5.1.3. Хуулийн 22.3.1-д заасан нэгдсэн бүртгэлийн мэдээллийг үндэслэнэ;

5.1.4. даатгагчдын борлуулсан даатгалын гэрээ, баталгааны мэдээллийг үндэслэнэ;

5.1.5. хамтын эрсдэлийн сангаас нөхөн төлбөр олгох тухай шийдвэрт даатгагч тус бүрийн даатгуулагчдад олгох нөхөн төлбөрийн хэмжээг заасан байна;

5.1.6. хамтын эрсдэлийн сангаас нөхөн төлбөр олгох үйл ажиллагааг давхар даатгагчийн гүйцэтгэх захирал, ажлын алба зохион байгуулна;

5.1.7. хамтын эрсдэлийн сангаас нөхөн төлбөр олгох шийдвэр гарснаас хойш ажлын 3 хоногийн дотор даатгагч тус бүрт ногдох нөхөн төлбөрийг тэдгээрийн арилжааны банкин дахь дансанд шилжүүлнэ;

5.1.8. даатгагчид даатгалын нөхөн төлбөрийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор даатгуулагчдад олгоно.

5.2. Давхар даатгагчийн гүйцэтгэх захирал даатгалын нөхөн төлбөрийг олгож дууссанаас хойш ажлын 7 хоногийн дотор тайланг гаргаж, Хороо, даатгагч, давхар даатгагчийн Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/-д хүргүүлнэ.

ЗУРГАА. ХАМТЫН ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ҮЛДЭГДЭЛ, ТҮҮНИЙГ ХУВААРИЛАХ

6.1. Давхар даатгагчийн гүйцэтгэх захирал хамтын эрсдэлийн сангийн хөрөнгийн үлдэгдлийн тайланг сар бүр гаргана. Тухайн тайланг гаргахдаа түүний хөрөнгийг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад заасны дагуу бодит үнэ цэнээр нь илэрхийлнэ.

6.2. Хамтын эрсдэлийн сангийн хөрөнгийн үлдэгдлийг даатгагчдын тус санд оруулсан хөрөнгөд хувь тэнцүүлэн тооцох ба дараах зарчмыг баримтална:

6.2.1. хамтын эрсдэлийн сангийн хөрөнгө нь даатгагч бүрээс төвлөрүүлсэн хөрөнгө болон хөрөнгө оруулалтын орлогын нийлбэртэй тэнцүү байх бөгөөд хамтын эрсдэлийн сангийн хөрөнгийн үлдэгдэл нь тус сангийн хөрөнгөөс олгосон болон олгохоор тооцсон нөхөн төлбөрийг хассан дүнтэй тэнцүү байна. Энд хөрөнгө оруулалтын орлогоос энэ журмын 3.3-т заасан зардлыг хасаж тооцно;

6.2.2. хамтын эрсдэлийн сангийн хөрөнгийн үлдэгдэл, түүний хуваарилалтын тооцоог ажлын алба гүйцэтгэж, давхар даатгагчийн гүйцэтгэх захирал хянана. Хамтын эрсдэлийн сангийн хөрөнгийн үлдэгдлийн тайлан болон хуваарилалтын тооцоог даатгагчдад хүргүүлнэ;

6.2.3. даатгагчид хамтран энэ журмын 6.2.2-т заасан тайлан, тооцоог хянаж

баталгаажуулна;

6.3.Тайлант жилийн эцэст хамтын эрсдэлийн сангаас хамгийн бага хөрөнгийн үлдэгдэл хуваарилагдсан даатгагчид ногдох хөрөнгийн 80 /наян/ хувьтай тэнцүү хэмжээний хөрөнгийг даатгагч бүр хамтын эрсдэлийн сангийн хуримтлалд үлдээх ба энэхүү хөрөнгийг даатгагчийн учирч болзошгүй хохирлын нөөц санд бүртгэнэ.

6.4.Даатгагчдад хуваарилагдсан хөрөнгийн учирч болзошгүй хохирлын нөөц санд бүртгэсэн хөрөнгөөс бусад хэсэг нь даатгагчийн ашиг байна.

6.5.Даатгагч нь малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаа эрхлэхийг зогсоосон тохиолдолд тайлант жилийн эцэст хуваарилагдсан хөрөнгийн үлдэгдлийг хамтын эрсдэлийн сангаас буцаан татах эрхтэй. Даатгагчийн буцаан татсан хөрөнгийн учирч болзошгүй хохирлын нөөц санд бүртгэгдсэн хөрөнгийг Хорооноос баталсан даатгалын багц дүрэмд заасан ердийн даатгалын компанийн нөөц сангийн холбогдох журмын дагуу зарцуулна.

ДОЛОО. ХАМТЫН ЭРСДЭЛИЙН САНД ТАВИХ ХЯНАЛТ

7.1.Хамтын эрсдэлийн сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад давхар даатгагчийн ТУЗ-өөс томилогдсон аудитор хяналт тавина.

7.2.Аудитор нь хамтын эрсдэлийн сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад хийсэн шалгалтын дүгнэлтээ Хороо болон давхар даатгагчийн ТУЗ-д тухай бүр хүргүүлнэ.

7.3.Хамтын эрсдэлийн сангийн бүрдүүлэлт, байршуулалт, зарцуулалт болон оролцогч даатгагчид, ажлын алба, давхар даатгагчийн ТУЗ, гүйцэтгэх захирал, аудитын үйл ажиллагаанд Хороо хяналт тавьж, шаардлагатай гэж үзвэл газар дээрх хяналт шалгалтыг гүйцэтгэнэ.

НАЙМ. ХАРИУЦЛАГА

8.1.Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль, Даатгалын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд
2020 оны 01 сарын 27-ны өдрийн 4674 дугаарт бүртгэв.

САНГИЙН САЙД, САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2020 оны 01 сарын 14 өдөр

Дугаар 6 / 10

Улаанбаатар хот

“Малын индексжүүлсэн даатгалын хураамжийн хэмжээг тооцох журам”-ыг шинэчлэн батлах тухай

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийг үндэслэн
ТУШААХ нь:

Нэг. “Малын индексжүүлсэн даатгалын хураамжийн хэмжээг тооцох журам”-ыг хавсралт
ёсоор баталсугай.

Хоёр. Энэхүү тушаал хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрөөс эхлэн Сангийн сайд,
Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2015 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 78/90 дугаар
хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

Гурав. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн яамны Санхүүгийн хяналт,
эрсдэлийн удирдлагын газар /Б.Доржсэмбэд/-т, Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын алба
/Т.Жамбаажамц/-нд тус тус даалгасугай.

САНГИЙН САЙД

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГА

Ч.ХҮРЭЛБААТАР

Д.БАЯРСАЙХАН

Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны
даргын 2020 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн
6 / 10 дугаар хамтарсан тушаалын хавсралт

МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ТООЦОХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Даатгалын тухай хуулийн 7.2, Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль /цаашид “Хууль” гэх/-ийн 9.1-д заасан малын индексжүүлсэн даатгалын хураамж /цаашид “даатгалын хураамж” гэх/-ийн хэмжээг тооцоход энэхүү журмыг мөрдлөг болгоно.

ХОЁР. ДААТГАЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХЭМЖЭЭ

2.1. Хуулийн 18.1-д заасан давхар даатгалын компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс Хуулийн 21.2.6-д заасны дагуу баталсан даатгалын гэрээний хавсралтад нэгж малын үнэлгээний жишиг хэмжээг тусгасан байна.

2.2. Энэ журмын 2.1-д заасан малын үнэлгээний жишиг хэмжээг Хуулийн 4.1.7-д заасан даатгалын нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох, Хуулийн 9.1-д заасан даатгалын хураамжийг тооцоход ашиглана.

ГУРАВ. ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ

3.1. Даатгалын хураамж гэж Хуулийн 9.1.1-д заасан даатгуулагчийн төлөх хураамж буюу Хуулийн 8.1.2-т заасан эрсдэлийн дунд түвшин дэх хураамжийг ойлгоно.

3.2. Даатгалын хураамж нь дараах хэсгүүдээс бүрдэнэ:

3.2.1. даатгалын эрсдэлийн хураамж;

3.2.2. даатгалын нэмэлт хураамж;

3.3. Даатгалын эрсдэлийн хураамж нь давхар даатгалын хураамж болон Хуулийн 4.1.13-т заасан хамтын эрсдэлийн санг бүрдүүлэх хураамжийн нийлбэрээс бүрдэнэ.

3.4. Даатгалын нэмэлт хураамжид даатгалын үндсэн үйл ажиллагааны зардлууд болон даатгагчийн хариуцах даатгалын зуучлагч, төлөөлөгчийн шимтгэл, татвар хураамж, даатгагчийн ашиг хамаарна.

3.5. Хуулийн 9.1.2-т заасан Засгийн газрын төлөх хураамж буюу Хуулийн 8.1.3-т заасан эрсдэлийн дээд түвшин дэх давхар даатгалын хураамжийн хэмжээг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

ДӨРӨВ. ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ТООЦОХ

4.1. Даатгалын хураамжийн хэмжээг малын төрөл тус бүрээр Хуулийн 7 дугаар зүйлд заасан босго үзүүлэлтэд үндэслэн Хуулийн 9.3-т заасны дагуу даатгагчид хамтран тогтооно.

4.2. Даатгалын хураамжийн хэмжээг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/ эсхүл гадаад улсын даатгалын зохицуулах байгууллага, мэргэжлийн холбоо, нийгэмлэгээс зөвшөөрөл олгосон эрх бүхий актуарч тооцно.

4.3. Даатгалын хураамжийн хэмжээг тогтооход дараах зарчмыг баримтална:

4.3.1. даатгалын хураамжийн хэмжээ нь даатгагч, даатгуулагчийн эрх, ашигт нийцсэн байх;

4.3.2. Хуулийн 8.1.2-т заасан эрсдэлийн дунд түвшин дэх даатгалын хохирлыг нөхөн төлөхөд хүрэлцээтэй байх;

4.3.3. даатгалын үйл ажиллагаа явуулахад даатгагчийн зардлыг нөхөхүйц байх;

4.3.4. даатгалын хураамжийн хэмжээ нь харьцангуй тогтвортой байх;

4.3.5. малын хорогдолд нөлөөлөх хүчин зүйлсийн нөлөөллийг бүрэн тусгасан байх;

4.4. Даатгалын хураамжийн хэмжээг дараах байдлаар тооцно:

4.4.1. даатгалын хураамжийн хэмжээг тооцоходоо малын индексжүүлсэн даатгалын 5 болон түүнээс дээш жилийн статистик мэдээлэлд үндэслэнэ;

4.4.2. даатгалын хураамжийн хэмжээг тооцоход ашиглах Хуулийн 4.1.6-д заасан даатгалын хамрах хугацаанд гарч байсан малын хорогдлын тухай тоон мэдээлэл нь үндэсний статистикийн төв байгууллагын албан ёсны мэдээлэл байна;

ТАВ. ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ХЯНАХ

5.1. Даатгагчид хамтран тогтоосон хураамжийн хэмжээг албан бичгээр Хороо болон төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

5.2. Хороо даатгагчдын ирүүлсэн хураамжийн хэмжээг хянаж саналаа албан бичгээр хүргүүлнэ.

ЗУРГАА. БУСАД

6.1. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль, Даатгалын тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд
2020 оны 03 сарын 23-ны өдрийн 4737 дугаарт бүртгэв.



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2020 оны 03 сарын 11 өдөр

Дугаар 114

Улаанбаатар хот

Даатгалын зах зээлийн ёс зүйн
журмыг батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.3, 6.2.4, Даатгалын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Даатгалын зах зээлийн ёс зүйн журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тогтоолын 1-д заасан журам хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн өдрөөс Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 209 дүгээр тогтоолоор баталсан “Даатгагчийн болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааг зохистой явуулах ёс зүйн журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ЁС ЗҮЙН ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь даатгалын зах зээлд оролцогчдын үйл ажиллагаандаа баримталбал зохих ёс зүйн хэм хэмжээ, түүний хэрэгжилтэд хяналт тавих, хариуцлага тооцохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журам нь Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

1.3. Энэ журамд дурдсан даатгалын зах зээлд оролцогчид даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй хувь хүн, хуулийн этгээд, тэдгээрийн ажилтнууд, хувьцаа эзэмшигчид хамаарна.

1.4. Даатгалын зах зээлд оролцогч нь өөрийн чиг үүрэг, үйл ажиллагааны цар хүрээ, онцлогийг харгалзан энэхүү журамд нийцсэн мэргэжлийн ёс зүйн дүрмийг дотооддоо батлах ба хэрэгжилтийг хангах, хариуцлага тооцохтой холбогдсон харилцааг зохицуулсан байна.

ХОЁР. ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛД ОРОЛЦОГЧИЙН БАРИМТЛАХ ЁС ЗҮЙН ТУЛГУУР ЗАРЧИМ

2.1. Даатгалын зах зээлд оролцогч нь дараах мэргэжлийн ёс зүйн үндсэн зарчмыг баримталж ажиллана. Үүнд:

2.1.1. хууль, шударга ёсыг дээдлэх;

2.1.2. ил тод байх;

2.1.3. даатгуулагч, даатгалын тохиолдлын хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;

2.1.4. даатгуулагчид шуурхай үйлчлэх;

2.1.5. шударга өрсөлдөөнийг эрхэмлэх;

2.1.6. даатгалын зах зээлд оролцогчийн эрх ашиг, нэр хүндэд хүндэтгэлтэй хандах;

2.1.7. даатгалын салбарын мэргэжлийн нэр хүндийг эрхэмлэх, дээшлүүлэх.

ГУРАВ. ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛД ОРОЛЦОГЧИЙН БАРИМТЛАХ ЁС ЗҮЙН ТҮГЭЭМЭЛ ХЭМ ХЭМЖЭЭ

3.1. Даатгалын зах зээлд оролцогч нь хууль, шударга ёсыг дээдлэх зарчмын хүрээнд дараах шаардлагыг хангаж ажиллана. Үүнд:

3.1.1. Даатгалын тухай хууль тогтоомж, журам, дүрэм, зааврыг чанд мөрдөн ажиллахын зэрэгцээ үйлчилгээний болон харилцааны өндөр соёлтойгоор ажиллахыг эрхэмлэнэ;

3.1.2. Хорооноос явуулж буй бодлого шийдвэрийн арга хэмжээнүүдийг олон нийтэд гуйвуулан хүргэхгүй байх;

3.1.3. Компанийн болон даатгуулагчийн талаарх мэдээ, материалын нууцыг Даатгалын тухай хуулийн 81.2, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 43.2 дахь хэсэг болон бусад

хуулиар зөвшөөрснөөс бусад нөхцөлд хувийн болон бусад этгээдийн ашиг сонирхлын үүднээс ашиглаж, задруулахгүй байх ;

3.1.4. даатгалын зах зээлд оролцогчоос гаргасан мэдээлэл, товхимол, зар сурталчилгаа болон түүнтэй адилтгах бусад баримт бичиг нь олон нийтийг төөрөгдүүлсэн буюу худал мэдээлэл агуулаагүй байх;

3.1.5. аливаа ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх;

3.1.6. ажилтнууд нь өөрийн компани, түүний удирдлага болон төрийн эрх бүхий байгууллага, үйлчлүүлэгч, олон нийтийн хоорондын харилцаанд сөргөөр нөлөөлж болзошгүй аливаа үйлдэл гаргахгүй байх;

3.1.7. удирдлага болон ажилтнууд нь хувьдаа болон холбоотой этгээдэд ашиг хонжоо олох зорилгоор албан тушаалаа урвуулан ашиглахгүй байх;

3.1.8. даатгагч, даатгалын хохирол үнэлэгчийн ажилтан нь сонирхлын зөрчил үүсэж болзошгүй иргэн, хуулийн этгээдийн даатгалын нөхөн төлбөрийг хариуцан гүйцэтгэх, хохирлыг үнэлэхээс сайн дураараа татгалзах.

3.2. Даатгалын зах зээлд оролцогч нь ил тод байх зарчмын хүрээнд дараах шаардлагыг хангаж ажиллана. Үүнд:

3.2.1. энэ журмын 1.4-т заасан дотоодын мэргэжлийн ёс зүйн дүрмийг өөрийн цахим хуудсанд байршуулсан байх;

3.2.2. Үнэн зөв мэдээлэлд тулгуурлан шийдвэр гаргах, даатгагчаа чөлөөтэй сонгох боломжийг харилцагчдад олгох;

3.2.3. ажил төрлийн холбогдолтой мэдээллийг нуун дарагдуулах замаар аливаа шийдвэр гаргахад саад учруулахгүй байх;

3.2.4. энэ журмын 3.1.4-т заасныг үл харгалзан олон нийтэд мэдээлэл тараасан бол тухайн хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан нь өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлж, нэн даруй залруулах.

3.3. Даатгалын зах зээлд оролцогч нь даатгуулагч, даатгалын тохиолдлын хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх зарчмын хүрээнд дараах шаардлагыг хангаж ажиллана. Үүнд:

3.3.1. даатгалын гэрээний стандарт, нөхцөлийг боловсруулахдаа талуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг харилцан хүндэтгэх;

3.3.2. үйлчлүүлэгчтэй харилцахдаа хүнд суртал гаргах, аашилж зандах, айлган сүрдүүлэх, дарамтлах, тэдгээрийн мэдлэг, мэдээллийн дутмаг байдлыг ашиглан хууран мэхлэх, нөхөн төлбөр олгохоос үндэслэлгүйгээр зайлсхийх зэрэг үйлдэл гаргахгүй байх;

3.3.3. даатгагч, даатгалын зуучлагчийн ажилтан болон даатгалын төлөөлөгч нь даатгуулагчидтай даатгалын гэрээ байгуулахдаа тэдний эрх, үүргийн талаар тайлбарлаж, нөхөн төлбөр олгох болон олгохгүй байх нөхцөлийг мэдэгдэх, гэрээний ач холбогдлыг нь танилцуулах, хэрэв даатгалын тохиолдол гарсан талаар үйлчлүүлэгч хандсан бол зөвлөх, туслах зэргээр мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх;

3.3.4. аливаа үйлчилгээ үзүүлсний төлөө даатгуулагч, түүнийг төлөөлж буй этгээдээс шан харамж авах, өгөх, шаардах зэргээр даатгалын салбарын нэр хүндийг унагах, шударга бус үйлдэл гаргахгүй байх.

3.4. Даатгалын зах зээлд оролцогч нь даатгуулагчид шуурхай үйлчлэх зарчмын хүрээнд дараах шаардлагыг хангаж ажиллана. Үүнд:

3.4.1. даатгалын нөхөн төлбөр олгохдоо хууль тогтоомж болон гэрээнд заагаагүй аливаа шаардлага, хязгаарлалт тавихгүй байх;

3.4.2. даатгалын хохирол үнэлэгч, даатгагч нь даатгалын тохиолдол бий болсон нөхцөлд хохирлын хэмжээг бодитой, үнэн зөв тогтоох, даатгагч нь нөхөн төлбөрийг тогтоосон хэмжээнээс бууруулахгүйгээр даатгуулагч болон хохирогчид бүрэн, шуурхай олгоно.

3.5. Даатгалын зах зээлд оролцогч нь шударга өрсөлдөөнийг эрхэмлэх зарчмын хүрээнд дараах шаардлагыг хангаж ажиллана. Үүнд:

3.5.1. шударга өрсөлдөөнийг эрхэмлэх бөгөөд өрсөлдөгчийн талаар нэр хүндийг нь гутаасан худал мэдээлэл, сурталчилгаа явуулахгүй байж харилцан хүндэтгэлтэй хандах;

3.5.2. даатгалын зах зээлд оролцогчийн эрх ашигт үл нийцэх үйл ажиллагаанд нэр төр, эрх мэдэл, албан тушаалаа ашиглан аливаа хувь хүн, хуулийн этгээдэд давуу тал олгох, хөнгөлөлт үзүүлэх, өөрийн эрх мэдлийг хэтрүүлэн ашиглах, хуурамч бичиг баримт үйлдэхгүй байх;

3.5.3. даатгалын хураамжийн хэмжээг үндэслэлгүйгээр бууруулах, нэмэхээс зайлсхийх.

3.6. Даатгалын зах зээлд оролцогч нь даатгалын зах зээлд оролцогчийн эрх ашиг, нэр хүндэд хүндэтгэлтэй хандах зарчмын хүрээнд дараах шаардлагыг хангаж ажиллана. Үүнд:

3.6.1. даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, хүргээмжийг нэмэгдүүлэх, даатгалын ач холбогдлыг олон нийтэд таниулах, даатгуулагчдын даатгалын мэдлэгийг дээшлүүлэх, итгэлийг нэмэгдүүлэх зорилгоор даатгалын зах зээлд оролцогчид санаачилгатайгаар хоорондоо хамтарч ажиллах, мэдээлэл солилцохыг эрмэлзэнэ;

3.6.2. бусад даатгалын зах зээлд оролцогчийн талаар нэр хүндийг нь гутаасан худал мэдээлэл, сурталчилгаа явуулахгүй байж харилцан хүндэтгэлтэй хандана.

3.7. Даатгалын зах зээлд оролцогч нь даатгалын салбарын мэргэжлийн нэр хүндийг эрхэмлэх, дээшлүүлэх зарчмын хүрээнд дараах шаардлагыг хангаж ажиллана. Үүнд:

3.7.1. ажилтнуудын мэргэжлийн болон ёс зүйн боловсролд анхаарч, мэргэшүүлэх сургалтад тогтмол хамруулдаг байх;

3.7.2. өөрийн эзэмшсэн мэргэжил, мэдлэг, ур чадвар, дадлага туршлага дутагдалтай гэж үзвэл даатгалын үйлчилгээнээс сайн дураараа татгалзах;

3.7.3. даатгалын салбарын үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж, мэдээлэлтэй байнга танилцаж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгох;

3.7.4. өөрийн байгууллагыг төдийгүй даатгалын салбарыг төлөөлж байгаа гэдэг зарчмыг үйлчлүүлэгч болон бусад талуудтай харилцахдаа баримтлах.

ДӨРӨВ. ХАРИУЦЛАГА

4.1. Энэхүү журмын ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн байж болзошгүй талаар иргэд, байгууллагаас гомдол, мэдээлэл ирүүлсэн, эсхүл хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээнд нийтлэгдсэн тохиолдолд Хорооноос холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хянана.

4.2. Даатгалын зах зээлд оролцогч нь энэхүү журамд заасан ёс зүйн хэм хэмжээ болон журмын 1.4-т заасан ёс зүйн дүрмийг дагаж мөрдөөгүй бол холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.